

ГАРЧИГ

ЕРӨНХИЙ ХЭСЭГ 4

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
6

1.1 Хүн ам зүй.....	6
1.1.1. Хүн ам, өрхийн тоо, түүний өсөлт бууралт	6
1.1.2. Хүн амын өсөлт	8
1.2. Эдийн засаг, нийгмийн байдал	9
1.2.1. Аж үйлдвэр	9
1.2.2. Дотоодын нийт бүтээгдэхүүн.....	10
1.2.3. Барилга, тээвэр	12
1.2.4. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт	14
1.2.5. Боловсрол, соёл, урлаг:.....	18
1.2.6. Эрүүл мэнд.....	18
1.2.7. Соёл урлаг	19
ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ОНЦЛОГ 20	

2.1. Өмнөговь аймгийн газрын гадарга, физик газарзүйн байдал **Error! Bookmark not defined.**

2.1.1. Физик газарзүй	20
2.1.2. Газрын гадарга.....	20
2.2. Цаг уур.....	22
2.2.1. Дулааны горим	24
2.2.2. Чийгийн горим.....	28
2.2.3. Салхины горим	31
2.3. Хөрс, Ургамалшлын байдал	33
2.3.1. Ургамлын чийг, дулааны хангамж	33
2.3.2. Хөрсөн бүрхэвч	40
2.3.3. Ургамлан нөмрөг	43
2.3.4. Ургамал газар зүйн мужлалт	44
2.4. Амьтны аймаг	48
2.5. Ландшафт, байгалийн бүс, бүслүүр.....	48
2.6. Цөлжилт	50

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ НУТАГ ДЭВСГЭРИЙН ЦОГЦОЛБОР НӨХЦЛИЙН
МУЖЛАЛ 52

3.1. Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужууд	52
3.2. Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужуудын онцлог.....	53
3.2.1. Говийн Алтайн уулсын муж.....	53
3.2.2. Алтайн өвөр говийн цөлийн муж.....	61
3.2.3. Дорнод говийн цөлөрхөг муж	73
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР АШИГЛАЛТЫН БАЙДАЛ82	

4.1. Малын төрөл, тоо толгой.....	82
4.1.1. Эрчимжсэн мал аж ахуйн судалгаа, одоогийн байдал.....	83
4.2. Бэлчээр, бэлчээрийн газрын төлөв байдал.....	86
4.2.1. Бэлчээрийн газрын улирлын хувиарлалт	86

4.2.2. Бэлчээрийн ангилал, ургамлын хэв шинж	86
4.3. Бэлчээрийн газрын нөөцөд гарсан өөрчлөлт	91
4.3.1. Бэлчээрийн газрын талхлагдал ба талхлагдлын зэрэглэл	92
4.4. Бэлчээрийн усан хангамжийн өнөөгийн байдал	95
4.5. Газар тариалан	97
4.5.1. Газар тариалангийн зориулалт бүхий газрын өнөөгийн байдал.....	97
ТАВДУГААР БҮЛЭГ. ХҮН АМ, СУУРЬШЛИЙН БҮС НУТАГ	101
5.1. Хот тосгон бусад суурин газрын ангилалын газрын өнөөгийн байдал	101
5.2. Даланзадгад хотын инженер-геологийн нөхцөл, ул хөрсний геотехникийн	103
шинж чанарын үнэлгээ	103
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР	107
6.1. Зам, шугам сүлжээний газрын өнөөгийн байдал	107
6.2. Агаарын тээврийн газрын хөгжил	110
6.3. Төмөр замын газрын хөгжил.....	110
6.4. Харилцаа, холбоо	111
6.5. Эрчим хүч, дулаан хангамжийн байдал.....	111
ДОЛООДУГААР БҮЛЭГ. ОЙН САН БҮХИЙ ГАЗАР	116
7.1. Ой сан бүхий газрын өнөөгийн байдал	116
7.2 Ойн бүс.....	118
7.2.1. Ойн сангийн үндсэн үзүүлэлт	120
7.2.2. Заган ой, насны анги, бүлэг.....	121
7.2.3. Заган ойн ойн зохион байгуулалт	125
7.3. Ойн сангийн таксацын дундаж үзүүлэлт	126
7.4. Ойн хэв шинж	128
7.5. Ойн сангийн экологи эдийн засгийн үнэлгээ	130
7.6. Ойн сангийн өөрчлөлт	130
7.6.1. Ойн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлт.....	132
7.7. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	133
НАЙМДУГААР БҮЛЭГ. УСАН САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ САВ ГАЗРУУДЫН ТӨЛӨВ	134
БАЙДАЛ	134
8.1. Усны сан бүхий газар.....	134
8.2. Усны сав газрууд	136
8.2.1. Усны сав газрын ашиглалт, хамгаалалт	143
8.3. Гидрогеологийн нөхцөл, гүний усны судалгаа	147
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, АМРАЛТ ЗУГААЛГЫН БҮС НУТГИЙН	157
ЕРӨНХИЙ БАЙДАЛ	157
9.1. Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал.....	157
9.2. Өмнөговь аймгийн түүх соёлын дурсгалт газрууд	162
9.2.1. Түүх, соёлын дурсгалт үзмэрүүдийн хамгаалалтын талаар мэдээлэл	163
9.3. Зочид буудлын талаарх мэдээлэл	164
9.4. Шинээр аялал жуулчлалын бааз байгуулах бололцоотой газрууд.....	170

АРАВДУГААР БҮЛЭГ. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР 172

10.1. Тусгай хэрэгцээний газар ашиглалтын өнөөгийн байдал	172
10.1.1. Тусгай хамгаалалттай газар.....	172
10.1.2. Улсын тусгай хэрэгцээний бусад газрууд.....	172
АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ . УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, АШИГТ МАЛТМАЛЫН СУДАЛГАА 175	
11.1. Уул уурхай, үйлдвэрийн газрын хэтийн төлөв.....	175
11.1.1. Уул уурхай	175
11.2. Уул уурхайн ордууд, дэд бүтэц	179
11.2.1. Дэд бүтцийн байдал	179
11.2.2. Уул уурхайн ордууд.....	180
11.3. Геологи, ашигт малтмалын судалгаа.....	184
11.3.1. Геологийн тогтоц	184

ЕРӨНХИЙ ХЭСЭГ

Газар нь байгаль, дэлхийн үүсэл хөгжлийн дүнд бий болсон байгалийн бүх баялгийг өөртөө агуулсан сав шимийн цогц учир түүний ашиглалтын хэм хэмжээ нь өөрийнх нь унаган чадавхи, бодит нөхцөл, нөөцөөр тодорхойлогддог.

Аймаг, орон нутгийн бие даасан тогтвортой хөгжлийг хангахад байгалийн нөөц баялгийг экологид сөрөг нөлөөлөлгүйгээр ашиглах нь юу юунаас чухал. Үүнийг шийдвэрлэхэд газрын нөхцөл, нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, газрын экологийн чадавхид тохирсон үйл ажиллагааг явуулах, нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу байгалийн баялгийг газраар дамжуулан эдийн засгийн салбаруудаар ээлж дараатайгаар эргэлтэнд оруулах, оновчтой хувиарлаж, урт хугацааны туршид үр ашигтай тогтвортой ашиглуулах явдал юу юунаас чухал байна.

Монгол Улс 1990 оны эхээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нэгдэж, экологид тулгуурласан нийгэм-эдийн засгийн хөгжлийн жишгийг хүлээн зөвшөөрсөн орон учраас газар болон газраас үндэстэй байгалийн нөөцийг экологийн элдэв төрлийн доройтолгүй ашиглах үндэсний хэмжээний бодлогыг хэрэгжүүлж байна. Үүнийг хэрэгжүүлэх нэг гол нөхцөл нь эдийн засгийн хөгжлийн бүсчлэлийн ерөнхий бүдүүвчтэй уялдсан салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлж, түүнд шаардлагатай газрын хэмжээ, байршлыг оновчтой тогтоож, газрыг урт хугацааны туршид экологийн болон эдийн засгийн хувьд үр ашигтай ашиглах явдал юм. Газрын харилцааны өнөөгийн нөхцөлд үүнийг хэрэгжүүлэх механизм нь аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө юм.

Ажлын даалгаварт заасанчлан энэхүү ажлын зорилго нь Өмнөговь аймгийн бэлчээрийн ба эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, хүн амын хотжилт ба нутагшил суурьшил, дэд бүтэц, аялал жуулчлал, амралт, сувилал зэрэг тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэхэд шаардагдах газрын нөхцөл, нөөц, төлөв байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, газрыг үр ашигтай оновчтой ашиглах, эзэмших, бүсийн экологи-эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хадгалан бие даан хөгжих боломжийг газар зохион байгуулалтын төлөвлөлтийн аргаар нээн харуулахад оршино.

Газрын суурь судалгааны үр дүнд Өмнөговь аймгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийг бодитойгоор илрүүлэх, газрыг зориулалтын дагуу урт хугацааны туршид тогтвортой ашиглах, ашиглалтын зориулалт бүрт нийцсэн ашиглалт-хамгаалалтын горимыг тогтоох, ашиглалтын зориулалтыг шинэчлэхэд үүсэх экологи-эдийн засгийн үр ашгийг тооцоход шаардлагатай мэдээлэл цуглуулсан юм. Үүнд:

1. Өмнөговь аймгийн байгаль цаг уур, онцлог нөхцөл
2. Ландшафт, тойргууд
3. Аймгийн тухай ерөнхий ойлголт
4. Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал,

5. Хүн амын тоо, өсөлт, шилжилт хөдөлгөөн
6. Хөдөө аж ахуйн газрын ашиглалтын одоогийн байдлын судалгаа
7. Ойн сан бүхий газар ашиглалтын одоогийн байдлыг судалгаа
8. Усан сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал
9. Хот суурины газар, суурьшлийн бүсийн төлөв байдал,
10. Зам шугам сүлжээний газрын одоогийн байдал
11. Тусгай хэрэгцээний газрын судалгаа
12. Өмнөговь аймгийн аялал, жуулчлал, амралт зугаалгын газрын одоогийн байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ
13. Өмнөговь аймгийн газар нутаг дээрхи ашигт малтмалын судалгаа тэдгээрийн хайгуул, ашиглалтын одоогийн байдал зэрэг хүчин зүйлсийн мэдээллийг оруулсан болно.

Энэ зорилгын хүрээнд бүс нутгийн газрын нэгдмэл сангийн ашиглалт хамгаалалтын одоогийн байдал, цаашид төлөвлөлтийн үе шатуудаар хэрхэн яаж өөрчлөгдөх, газрын доройтлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, доройтолд орсон газруудыг нөхөн сэргээх зэрэг үндсэн асуудлыг шийдэхэд түлхэц өгөх юм.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

Улс орны нийгэм-эдийн засгийн хөгжил, хүн ам, аж ахуйн нэгж байгууллагын амьдрал, үйл ажиллагаа газар болон түүний нөөц баялагтай салшгүй холбоотой учраас бүс нутгийн газар ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг зохиохдоо нийгэм эдийн засгийн голлох үзүүлэлтүүд, тэдгээрийн хөгжлийн төвшинтэй уялдуулах шаардлагатай байдаг.

Өмнөговь аймаг нь 165,0 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, 15 сум, 58 багтай. Аймгийн төв нь Даланзадгад хот.

Өмнөговь аймаг нь Монгол улсын хамгийн өмнөд хэсэгт оршдог бөгөөд урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Баянхонгор, баруун хойд хэсгээр Өвөрхангай, хойд талаараа Дундговь, зүүн талаараа Дорноговь аймгуудтай тус тус хиллэн оршино.

Аймгийн төв Даланзадгад хот нь Улаанбаатар хотоос 560 км зайтай. Монгол улсын хэмжээнд хамгийн том 165,0 мянган кв.км нутаг дэвсгэртэй ба хүн амын суурьшил сийрэг 3,4 квадрат километр нутагт 1 хүн, 13,2 квадрат километр нутагт 1 өрх ноогдон хүн ам суурьшиж байна.

1.1 Хүн ам зүй

1.1.1. Хүн ам, өрхийн тоо, түүний өсөлт бууралт

Аймгийн нийт суурин хүн ам 58555, өрх 18788 байна. Нийт хүн амын 31,2 хувийг 0-15 насны хүүхэд, 63,1 хувийг 16-59 насны, 5,7 хувийг 60 ба түүнээс дээш насны хүн ам эзлэж байна.


Хүснэгт № 1.1. Аймгийн өрх, хүн амын тоо

Сумын нэр	Өрх	Хүн ам
Баяндалай	675	2148
БаянОвоо	576	1723
Булган	666	2187
Гурвантэс	1384	4465
Мандал-Овоо	522	1687
Манлай	714	2522
Номгон	820	2624
Ноён	420	1388
Сэврэй	614	2009
Ханбогд	1590	4712
Ханхонгор	698	2113
Хүрмэн	540	1644
ЦогтОвоо	515	1644
Цогтцэцэий	2128	6108
Даланзадгад	6926	21581
Дүн	18788	58555

Хүснэгт № 1.2. Хүн ам байршилаар

Сумдын нэр	Нийт хүн ам	Үүнээс										
		Эрэгтэй	Эмэгтэй	Аймгийн төвд			Сумын төвд			Хөдөөд		
				Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Даланзадгад	21581	10409	11172	21581	10409	11172	0	0	0	0	0	0
Баяндалай	2148	1078	1070				548	265	283	1600	813	787
Баян-Овоо	1723	848	875				746	390	356	977	458	519
Булган	2187	1093	1094				1050	565	485	1137	528	609
Гурвантэс	4465	2230	2235				2536	1262	1274	1929	968	961
Мандал-Овоо	1687	848	839				5270	188	339	1160	660	500
Манлай	2522	1246	1276				947	475	472	1575	771	804
Ноён	1388	738	650				470	316	154	918	422	496
Номгон	2624	1363	1261				1037	570	467	1587	793	794
Сэврэй	2009	1008	1001				0	0	0	2009	1008	1001
Ханбогд	4712	2373	2339				3317	1682	1635	1395	691	704
Ханхонгор	2113	1078	1035				777	380	397	1336	698	638
Хүрмэн	1644	810	834				457	216	241	1187	594	593
Цогт-Овоо	1644	832	812				660	255	405	984	577	407
Цогтцэцэй	6108	3175	2933				5380	2776	2604	728	399	329
Дүн	58555	29129	29426	21581	10409	11172	18452	9340	9112	18522	9380	9142

Үүнээс аймгийн төвд нийтдээ 21581, эрэгтэй 10409, эмэгтэй 11172. Сумын төвд нийтдээ 18452 хүн байна гэж бүртгэгдсэнээс эрэгтэй 9340, эмэгтэй 9112 байна. Харин хөдөөд нийтдээ 18522 хүн тоологдсоноос эрэгтэй 9380, эмэгтэй 9142 байна гэж тус тус бүртгэгдсэн байна.




Зураг № 1.1. Хүн ам байршилаар

1.1.2. Хүн амын өсөлт

Хүснэгт № 1.3. Хүн амын өсөлт /2003-2013/

Д/д	Сумдын нэр	2003	2005	2007	2009	2011	2013
1	Даланзадгад	15,308	15,954	15,176	17,946	19,397	21,581
2	Баяндалай	2,360	2,338	2,313	2,316	2,229	2,148
3	Баяновоо	1,569	1,539	1,539	1,574	1,658	1,723
4	Булган	2,433	2,430	2,322	2,395	2,281	2,187
5	Гурвантэс	3,376	3,524	3,807	4,034	4,408	4,465
6	Мандал-Овоо	2,166	2,004	2,001	1,954	1,784	1,687
7	Манлай	2,449	2,431	2,510	2,450	2,460	2,522
8	Ноён	1,468	1,390	1,298	1,318	1,321	1,388
9	Номгон	3,045	3,009	3,075	2,869	2,736	2,624
10	Сэврэй	2,423	2,309	2,237	2,191	2,088	2,009
11	Ханбогд	2,451	2,659	2,974	3,154	3,948	4,712
12	Ханхонгор	2,931	2,542	2,507	2,376	2,236	2,113
13	Хүрмэн	1,951	1,910	1,731	1,796	1,665	1,644
14	Цогт-Овоо	1,761	1,672	1,662	1,666	1,634	1,644
15	Цогтцэций	2,130	2,155	2,147	2,642	4,042	6,108
ДҮН		47,821	47,866	47,299	50,681	53,887	58,555




Зураг № 1.2. Хүн амын өсөлт

Хүснэгт № 1.4. Хүн амын өсөлт /хүйсээр/

Сумдын нэр	2003		2013		Зөрүү		Хувь%	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Даланзадгад	7,316	7,992	10,409	11,172	3,093	3,180	29.7	28.5
Баяндалай	1,165	1,195	1,078	1,070	-87	-125	-8.1	-11.7
Баяновоо	775	794	848	875	73	81	8.6	9.3
Булган	1,201	1,232	1,093	1,094	-108	-138	-9.9	-12.6
Гурвантэс	1,684	1,692	2,230	2,235	546	543	24.5	24.3
Мандал-Овоо	1,091	1,075	848	839	-243	-236	-28.7	-28.1
Манлай	1,219	1,230	1,246	1,276	27	46	2.2	3.6
Ноён	724	744	738	650	14	-94	1.9	-14.5
Номгон	1,533	1,512	1,363	1,261	-170	-251	-12.5	-19.9
Сэврэй	1,211	1,212	1,008	1,001	-203	-211	-20.1	-21.1

Ханбогд	1,215	1,236	2,373	2,339	1,158	1,103	48.8	47.2
Ханхонгор	1,469	1,462	1,078	1,035	-391	-427	-36.3	-41.3
Хүрмэн	972	979	810	834	-162	-145	-20.0	-17.4
Цогт-Овоо	847	914	832	812	-15	-102	-1.8	-12.6
Цогтцэций	1,058	1,072	3,175	2,933	2,117	1,861	66.7	63.5

Аймгийн хүн амын 50.3 хувийг эмэгтэйчүүд, 49.7 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Хүн амын 49.7 %- нь эрэгтэй байна.




Зураг№ 1.3. Хүн амын өсөлт /хүйсээр/

1.2. Эдийн засаг, нийгмийн байдал

1.2.1. Аж үйлдвэр


Өмнөговь аймгийн аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал:

Өмнөговь аймгийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 61 хувь нь уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт, 31 хувь нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт, 8 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт ногдож, үүнийг 2009 оныхтой харьцуулахад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 8 пункт, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 1 пунктээр буурч, харин боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд эзлэх хувийн жин 9 пунктээр нэмэгдсэн байна.



Зураг№ 1.5. Аж үйлдвэрийн салбарын бүтэц


Боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарын борлуулалт 218005.6 болж 2012 оныхоос 47135.8 сая төгрөг буюу 1.27 дахин өссөн байна.




Зураг№ 1.6. Боловсруулах аж үйлдвэрийн борлуулалт сая.төг

1.2.2. Дотоодын нийт бүтээгдэхүүн


Өмнөговь аймгийн ДНБ, оны үнээр 516.2 тэрбум төгрөг байна. Өмнөговь аймгийн ДНБ-ий улсын дунд эзлэх хувь нь 2014 оны эхний байдлаар 2.9 хувь болж өссөн байна.



Зураг№ 1.7. Өмнөговь аймгийн ДНБ, улсын дүнд эзлэх хувь



Зураг№ 1.8. Хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувь




Зураг№ 1.9. Аж үйлдвэр барилгын салбарын ДНБ-д эзлэх хувь

Улсын хэмжээнд ДНБ-д аж үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувь 2014 оны эхний байдлаар 33.9 хувийг эзэлж байна. Төвийн бүсийн ДНБ-д аж үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувь 2013 онд 30.3 хувь болж өмнөх оноос 4.1 пунктээр, Аймгийн хувьд 64.9 хувь болж өмнөх оноос 4.8 пунктээр өссөн байна.

Хүснэгт № 1.7. Өмнөговь аймгийн ДНБ, оны үнээр салбараар, сая. төг

Төрөл \ Он	2005	2010	2011	2012	2013
Өмнөговь аймгийн ДНБ	41185.9	222585.3	313820.5	336655.4	516224.7
Хөдөө аж ахуй	19151.4	32052.3	32637.3	50835.0	72787.7
Аж үйлдвэр, барилга	20551.8	166493.8	216850.0	202329.9	335029.8
Үйлчилгээ	1482.7	24039.2	64333.2	83490.5	108407.2

Аймгийн ДНБ-ийг салбараар авч үзвэл, 2013 онд 72.8 тэрбум төг буюу 14.1 хувийг хөдөө аж ахуйн салбар, 108.4 тэрбум төг буюу 21.0 хувийг үйлчилгээний салбар, 335.0 тэрбум төг буюу 64.9 хувийг аж үйлдвэр, барилгын салбар бүрдүүлж байна.



Зураг № 1.9. Өмнөговь аймгийн ДНБ-ний бүтэц

Өмнөговь аймгийн ДНБ-ий 2005 онд 47.0 хувийг хөдөө аж ахуйн салбар, 4.0 хувийг үйлчилгээний салбар, 49 хувийг аж үйлдвэр, барилгын салбар эзэлж байсан бол 2013 онд 14.0 хувийг хөдөө аж ахуйн салбар, 21.0 хувийг үйлчилгээний салбар, 65 хувийг аж үйлдвэр, барилгын салбар эзлэх болж, үйлчилгээний салбарын эзлэх хувь 26 пунктээр, харин хөдөө аж ахуйн салбар 33 пунктээр буурч, аж үйлдвэр барилгын салбар 16 пунктээр өссөн байна.

1.2.3. Барилга, тээвэр

2014 оны эхний байдлаар тээврийн байгууллага болон хувь хүмүүсийн тээврийн орлогын мэдээг авч мэдээлсэн бөгөөд тээврийн орлого 12752.9 сая төгрөгт хүрч урьд оноос 62 хувиар буюу 20843.9 сая төгрөгөөр буурсан байна. Орон нутагт хийгдсэн барилгын компаниудын 2013 оны барилга угсралт, их засварын ажил нь 23943.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь өнгөрсөн оноос 5 дахин буюу 19247.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 1.8. Барилга угсралт их засварын ажлын улирлын гүйцэтгэл

Барилга байгууламжийн төрлөөр	Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Гүйцэтгэл
Шинэ барилга, өргөтгөл, шинэчлэл-бүгд	1	мян.төг	23943560.3
Орон сууцны барилга-Угсармал	2	мян.төг	2691386
Орон сууцны барилга-Тоосгон	3		1853265.2
Орон сууцны барилга-Бусад	4	мян.төг	0
Орон сууцны бус барилга-Үйлдвэрийн	5	мян.төг	356000
Орон сууцны бус барилга-Эмнэлэг	6	мян.төг	3710000

Орон сууцны бус барилга-Сургууль, соёлын	7	мян.төг	300000
Орон сууцны бус зориулалттай/	8	мян.төг	3971000
Орон сууцны бус барилга- Авто зам	9	мян.төг	9191909.1
Барилга угсралт, их засварын ажил-бүгд	10	мян.төг	24299022.7
Нийт ажиллагчид-Бүгд /дундаж тоо/	11	тоо	438
Барилгын ажиллагчид /дундаж тоо/	12	тоо	400
Үүнээс: инженер техникийн ажилтан /дундаж тоо/	13	тоо	110
Мэргэжлийн ажилчид /дундаж тоо/	14	тоо	290
Аж ахуйн нэгжийн нийт ажиллагсадын цалингын сан	15	мян.төг	807523.8
Барилгын ажиллагсадын-цалингын сан	16	мян.төг	600908.8
Дүн		мян.төг	71725213.9

Хүснэгт№ 1.9. Авто тээврийн тээвэрлэлтийн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012	2013	2013/2012
Ачаа эргэлт	мян.тн.км	658004	208615	31.7
Тээсэн ачаа	мян.тн	1352.8	727.1	53.7
Зорчигч эргэлт	мян.хүн.км	38267.1	87567	228.8
Үүнээс: дотоодод	мян.хүн.км	38267.1	87567	228.8
Тээсэн зорчигч	мян хүн	111.8	233.4	208.4
Үүнээс: дотоодод	мян хүн	111.8	233.4	208.4
Тээврийн орлого	сая.төг	33596.8	12752.9	38.0
Тээврийн ажиллагсад	хүн	440	346	78.6



Зураг№ 1.10. Тээврийн салбарын орлогын хэмжээг оноор харьцуулсан байдал

Холбооны салбарт ажил үйлчилгээ хэвийн явагдаж тарифын орлого 232.1 сая төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 15.9 сая төгрөгөөр буюу 7.4 хувиар өссөн байна.

Хүснэгт№ 1.10. Холбооны газрын мэдээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012 ны	2013 оны		2013 /2012
		энэ үед	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Тарифын орлого	мян.төг	216115.4	289560.2	232067.8	107.4
Үүнээс: хүн амын	мян.төг	55043	173736.1	121615.2	220.9
Ажиллагсдын тоо	хүн	23	23	22	95.7
Телефон цэг	тоо	1336	1744	1076	80.5
Радио цэг	тоо	0	0	0	
Таксофоны тоо	тоо	6	6	6	100.0

Цахилгаан мэдээ	ширхэг	34	34	4	11.8	
Үүнээс	Гарсан	ширхэг	14	14	3	21.4
	Дамжуулсан	ширхэг	9	9	0	0.0
	Орсон	ширхэг	11	11	1	9.1

1.2.4. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Мал аж ахуйн үйлдвэрлэл

Аймгийн эдийн засгийн нэг гол салбар нь хөдөө аж ахуй, үүний дотор мал аж ахуй голлох байр эзэлдэг. 2014 оны эхний байдлаар нийт 1.6 сая толгой мал тоолуулсан. Өмнөговь аймаг нь дэлхийн улаан номонд багтдаг 2 бөхт тэмээний өлгий нутаг бөгөөд мөн онд нийт 101,0 мянган тэмээн сүрэг тоолуулж тоогоороо улсдаа төдийгүй дэлхийд тэргүүлэх байр эзэлж байна.


Аймгийн хэмжээнд 5173 малчин өрх, 140 гаруй мянгат малчинтай болж түүний дотроос хамгийн олон малтай өрхөөр Булган сумын харъяат, улсын сайн малчин Ч.Одбаяр 2305 толгой мал тоолууллаа.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Хүснэгт № 1.11. Малын тоо

Сумдын нэр	2012	2013	2013/2012
Баяндалай	124361	138201	111.1
Баяновоо	75368	89577	118.9
Булган	87519	110534	126.3
Гурвантэс	126318	143640	113.7
Мандал-Овоо	74118	93002	125.5
Манлай	102618	117787	114.8
Номгон	172465	197239	114.4
Ноён	81593	92895	113.9
Сэврэй	104662	119881	114.5
Ханбогд	123291	126003	102.2
Ханхонгор	103148	127966	124.1
Хүрмэн	91297	106674	116.8
Цогт-Овоо	50690	61866	122.0
Цогтцэций	53312	65741	123.3
Даланзадгад	48493	62258	128.4
ДҮН	1419253	1653264	116.5

Нийт малын өсөлтийн 71.2 хувийг ямаан сүрэг, 21.8 хувийг хонин сүрэг, үлдсэн 7.0 хувийг бод малын өсөлт эзэлж байна.



Зураг№ 1.11. Малын өсөлтийн хувь

Мал сүргийн 10.6 хувийг бод мал, 89.4 хувийг бог мал эзлэж байна. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийг авч үзвэл өмнөх оноос адуу, үхэр сүргийн хувьд эзлэх хувь нь хэвээр, тэмээн сүргийн хувьд 0.7 хувиар буурч, хонин сүрэг 0.1 хувиар, ямаан сүргийн хувьд нийт сүргийн бүтцэд эзлэх хувь нь өнгөрсөн онтой харьцуулахад 0.5 хувиар тус тус өсч, ямаан сүргийн нийт сүрэгт эзлэх хувь нь өндөр хэвээр байна.

Хүснэгт№ 1.12. Түүхий эд бэлтгэлт, нийлүүлэлт

Сумдын нэр	Тэмээний ноос		Хонины ноос		Ноолуур		Тэмээний шир	
	Нийт бэлтгэсэн	Зах зээлд нийлүүлсэн	Нийт бэлтгэсэн	Зах зээлд нийлүүлсэн	Нийт бэлтгэсэн	Зах зээлд нийлүүлсэн	Нийт бэлтгэсэн	Зах зээлд нийлүүлсэн
	тн	тн	тн	тн	тн	тн	ширхэг	ширхэг
Баяндалай	0.4	0.4					82	80
Баяновоо	21.7	21.7	31.6	31.6	14.4	14.4	460	460
Булган	17.7	17.7	40.6	40.6	18.5	18.5	128	128
Гурвантэс	21.86	21.86	9.6	8.8	66.54	66.5	374	369
Мандал-Овоо	74.4	74.4	25.1	25.1	17.6	17.6	800	800
Манлай	43.5	41.4	42.4	34.4	21.1	21.1	496	496
Номгон	28.3	28.3	25.7	24.3	50.1	50.1	360	354
Ноён	0	0	0	0	0	0	141	141
Сэврэй	35.3	35.3	24.1	24.1	37.9	37.9	200	200
Ханбогд	95	95	38	38	20.3	20.3	1069	1018
Ханхонгор	22.5	22.5	33.6	33.5	33.5	33.5	33.5	528
Хүрмэн	32.3	32.3	78.9	67.5	68.3	68.3	549	549
Цогт-Овоо	32.7	32.7	18.1	17.9	15.1	15.1	344	344
Цогтэций	7.9	7.9	18.5	18.4	629.2	629.2	89	89
Даланзадгад	7.2	7.2	20.8	20.8	10.1	10.1	146	146
ДҮН	440.8	438.7	407.0	385.0	1002.7	1002.6	5271.5	5702.0

Хүснэгт№ 1.13. Арьс ширний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Сумдын нэрс	Адууны шир		Үхрийн шир		Нэхий		Ямааны арьс	
	Нийт бэлтгэсэн	Зах зээлд нийлүүлсэн	Нийт бэлтгэсэн	Зах зээлд нийлүүлсэн	Нийт бэлтгэсэн	Зах зээлд нийлүүлсэн	Нийт бэлтгэсэн	Зах зээлд нийлүүлсэн
	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг	ширхэг
Баяндалай	244	244	234	158	3002	3002	8856	8832
Баяновоо	401	401	62	62	3190	3190	4940	4940
Булган	139	139	88	88	2915	2915	3169	3169
Гурвантэс	100	98	23	13	1145	1038	13826	13092

Мандал-Овоо	190	190	34	34	2990	2990	3900	3900
Манлай	444	444	119	110	3977	3754	5052	4690
Номгон	370	370	304	298	3704	3685	11345	11345
Ноён	48	48	11	11	745	745	5119	5119
Сэврэй	218	218	56	48	2335	2335	9654	9654
Ханбогд	457	434	415	410	5059	4609	7052	6633
Ханхонгор	414	414	110	110	6175	6175	11929	11929
Хүрмэн	195	195	42	42	2981	2881	8293	8141
Цогт-Овоо	104	104	32	32	1759	1759	2663	2663
Цогтцэций	152	152	34	34	1221	1221	1455	1455
Даланзадгад	127	127	152	152	2775	2775	5796	5796
ДҮН	3603.0	3578.0	1716.0	1602.0	43973.0	43074.0	103049.0	101358.0

Газар тариалан

Газар тариалангийн салбарт нийт 166.7 га талбайд тариалалт хийсний 73.4 га талбайд төмс, 53.5 га талбайд хүнсний ногоо, 39.7 га талбайд тэжээлийн ургамал тариалснаас 657.7 тн төмс, 599.8 тн хүнсний ногоо, 262.8 тн тэжээлийн ургамал хураажээ.

Нийт 18.43 га-д жимс жимсгэнэ тариалж 4.7 тонн ургац хураасан. Үүнээс: Чацаргана 16.9 га-д 15824 бут, Ранетка 1.3 га-д 120 бут, Үхрийн нүд 0.08 га-д 205 бут тариалсан байна. Аймгийн хэмжээнд нийт 4265.6 тн хадлан, 519 тн гар тэжээл бэлтгэн нөөцөлсөн байна.

Аймгийн хэмжээгээр 4265.8 тонн хадлан, 28.5 тонн таримал тэжээл, 519.5 тонн гар тэжээл, 16.4 тонн даршны ургамал 1329.6 тонн хужир шүү, 46.7 тонн төмс, ногооны хаягдал хураан авч бэлтгэсэн байна.

Хүснэгт № 1.15 Тариалсан талбай, хураасан ургацын мэдээ


Сумдын нэрс	Төмс /тонн/		Хүнсний ногоо /тонн/		Тэжээлийн ургамал /тонн/		Нийт дүн	
	Тариалсан талбай	Хураасан ургац	Тариалсан талбай	Хураасан ургац	Тариалсан талбай	Хураасан ургац	Тариалсан талбай	Хураасан ургац
Баяндалай	2.92	54.4	1.45	14.98	8.85	74.0	13.22	143.38
БаянОвоо	3.0	21.0	1.51	4.8	1.1	8.5	5.61	34.3
Булган	12.14	107.6	14.24	241.9	7.5	30.0	33.88	379.5
Гурвантэс	8.7	66.5	4.30	42.8	3.2	34.0	16.2	143.3
МандалОвоо	1.6	23.8	0.445	3.25	0.9	4.0	2.95	31.05
Манлай	2.4	18.0	3.02	22.81	3.8	32.9	9.22	73.71
Ноён	4.7	39.5	3.1	29.0	3.0	12.0	10.8	80.50
Номгон	0.6	4.5	0.83	2.0	0.08	0.11	1.51	6.61
Сэврэй	2.0	10.0	0.3	3.0	0.3	0.0	2.6	13.0
Ханбогд	1.5	4.0	1.8	3.0	0.0	0.0	3.3	7.0
Ханхонгор	13.6	122.4	2.4	26.4	5.0	40.8	21.02	189.60
Хүрмэн	2.5	15.0	1.7	13.04	2.0	1.5	6.2	29.54
ЦогтОвоо	1.5	15.0	0.5	6.0	0.0	0.0	2.0	21.0
Цогтцэций	4.0	60.0	4.6	74.7	1.0	15.0	9.6	149.7
Даланзадгад	12.3	96.0	13.3	112.1	3.0	10.0	28.6	218.1
ДҮН	73.46	657.7	53.51	599.8	39.7	262.81	166.71	1520.3



Зураг№ 1.12. Хураасан ургац суулийн 6 жилээр харьцуулсан байдал

Хүснэгт№ 1.14. Өөрийн хүчээр бэлтгэсэн өвс, гар тэжээлийн мэдээ

Сумдын нэрс	Өвс /тонн/			Гар тэжээл /тонн/			Нийт бэлтгэсэн өвс тэжээл	
	2012	2013	2013-2012	2012	2013	2013-2012	2012	2013
Баяндалай	225.0	171.6	73.6	12.0	14.8	123.3	237.0	186.4
Баян-Овоо	180.0	297.01	165.0	3.0	12.7	423.3	183.0	309.7
Булган	357.0	376.0	105.3	81.0	45.3	55.9	438.0	421.3
Гурвантэс	475.0	402.97	84.8	110.0	10.1	9.2	585.0	413.1
Мандал-Овоо	136.0	143.50	105.5	60.0	4.1	6.8	196.0	147.6
Манлай	582.8	576.5	98.9	150.0	161.2	107.5	732.8	737.7
Ноён	193.0	239.1	123.9	95.3	88.6	93.0	288.3	327.7
Номгон	80.0	132.0	165.0	12.0	0.5	4.2	92.0	132.5
Сэврэй	0.0	379.2	0.0	0.0	20.2	0.0	0.0	399.4
Ханбогд	2.8	5.7	201.8	0.4	0.0	0.0	3.2	5.7
Ханхонгор	611.8	536.7	87.7	120.0	76.0	63.3	731.8	612.7
Хүрмэн	67.0	194.6	290.4	20.0	14.7	73.5	87.0	209.3
Цогт-Овоо	335.0	283.6	84.7	95.0	37.1	0.0	430.0	320.7
Цогтцэцэий	0.0	262.0	0.0	0.0	2.8	0.0	0.0	264.8
Даланзадгад	20.0	265.2	1326.0	4.0	30.9	772.5	24.0	296.1
ДҮН	3265.4	4265.6	130.6	762.7	519.0	68.0	4028.1	4784.6



Зураг№ 1.13. Өөрийн хүчээр бэлтгэсэн өвс, гар тэжээл

1.2.5. Боловсрол, соёл, урлаг:

Аймгийн хэмжээгээр ерөнхий боловсролын 19 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 390 бүлэгт өдрийн ангийн 10421 сурагчид хамрагдан суралцаж байна. Бүх суралцагчдын 93.0 хувь буюу 9684 суралцагч 12 жилийн хөтөлбөрөөр хичээллэж байна. Нийт суралцагчдын хүйсийн харьцаа 50.3 байна.

Өмнөговь аймагт цэцэрлэгийн тоо 25 байна.



Зураг№ 1.15. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын тоо /2014 оны эхний байдлаар/

Өмнөговь аймагт ЕБС-ийн тоо 19, МСҮТ 1 байна.

1.2.6. Эрүүл мэнд

Аймгийн хэмжээгээр эрүүл мэндийн байгууллага 73 ажиллаж байгаагаас улсын төсвийн эмнэлэг 19, өрхийн эмнэлэг 3, хувийн эмнэлэг 19, эмийн сан 28 тус тус ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарт 147 их эмч, 319 дунд мэргэжилтэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн 2391 байгууллагад 2013 оны эцэст орны тоо 19.8 мянгад хүрсэн байна. Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг 16, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг 34, сум дундын эмнэлэг 39, сумын эмнэлэг 271, хувийн эмнэлэг 1019, өрхийн эмнэлэг 223, эмийн сан 789 ажиллаж байна.

Хүснэгт № 1.15. Эрүүл мэндийн байгууллагын тоо

Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага	Тоо
Клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, төв	16
Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	34
Сум дундын эмнэлэг	39
Сумын эмнэлэг	271
Хувийн эмнэлэг	1019
Өрхийн эмнэлэг	223
Эмийн сан	789

1.2.7. Соёл урлаг

Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн тоо 1962.3 мянга болж өссөн байна.

Өмнөговь аймагт сүм хийдийн тоо 3 байна. Мөн буддын шашны сүм хийдийн тоо 2 байна.

Хүснэгт № 1.16 Соёл урлагийн зарим үзүүлэлтүүд

Он	Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн тоо, мян. хүн			Музейн үзэгчдийн тоо, мян. хүн			Сүм хийдийн тоо		
	Улсын дүн	Төвийн бүс	Өмнөговь аймаг	Улсын дүн	Төвийн бүс	Өмнөговь аймаг	Улсын дүн	Төвийн бүс	Өмнөговь аймаг
2000	493.7	106.7	5.4	200.6	39.8	10.3	122	-	-
2005	993.2	309.2	8.5	343.8	42.9	10.6	240	52	1
2010	1936.6	415.9	16.5	416	58.3	10.7	234	31	3
2011	1974.9	462.6	16.2	517.4	67.6	7.3	327	53	3
2012	1476.8	423.4	15.0	598.6	72.9	8.1	338	49	3
2013	1962.3	371.0	20.7	598.6	103.6	19.2	322	47	3

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ОНЦЛОГ

2.1. Өмнөговь аймгийн газрын гадарга, газарзүйн байдал


2.1.1. Газарзүй

Өмнөговь аймгийн нийт нутаг дэвсгэр нь Алтайн өвөр говь, Галба-Ууш-Долоодын говь, Онги, Таац, Умардын говийн гүвээт-Халхын голын гэсэн ай савуудад хамрагддаг байна. Аймгийн нутаг дэвсгэр ерөнхийдөө говь, цөлөрхөг хээр зонхилсон байх ба Говь Гурван Сайхан уулын Байгалийн нөөц газар, Загийн ус Байгалийн цогцолборт газар, Говийн бага (А, Б) Дархан цаазтай газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газрууд байна.

Аймгийн нутаг төв хэсэгтээ хамгийн өндөрлөг буюу далайн түвшнээс дээш 2800м, бусад хэсэгтээ нам дор газар буюу д.т.д 1090м орчим өндөрт өргөгдсөн байна.

Монгол орон өргөргийн дагуу сунаж тогтсон, хойноосоо урагш чиглэлд байгалийн эрс тэс онцлог бүхий уулын тайга, өндөр уул, ойт хээр, нугат хээр, хээр, хуурай хээр, цөлжүү хээр, заримдаг цөл, умардын цөл, жинхэнэ цөл, говь цөл гэсэн бүс бүслүүрүүд оршдог.

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр хуурай хээр, цөлийн хээр, умардын цөл, заримдаг цөл, цөл, жинхэнэ цөл гэсэн бүс бүслүүрт ямар нэгэн хэмжээгээр хамрагдаж байна.



Зураг№ 2.1. Байгалийн бүс бүслүүр

2.1.2. Газрын гадарга

Тус аймгийн нутгийн баруун тал, төв хэсэг рүү Говийн Алтайн нурууны салбар уулс түрж ордгоос аймгийн нутгийн баруун болон төв хэсэг нь нилээд уулархаг байдалтай юм. Аймгийн нутгийн зүүн хойт хэсэгт орших Шанхай Өгөөмөрийн жижиг уул, нуруудыг

оруулаад, нийт уул нуруудын эзлэх талбай аймгийн бүх нутгийн 18%-ийг эзэлнэ. Энэ байдлаас үзэхэд аймгийн нутаг нь ерөнхийдөө талархаг байдалтай байна.

Талархаг гадаргуутай нутаг нь дотроо: жижиг уулс, цав толгод, ухаа гүвээ талархаг газар, хотос хонхортоо хужир марзтай тойром, жижиг довцог элс, манхан бүхий нам дор газар гэсэн хоёр хэсэгт хуваагдах бөгөөд жижиг уулс, цав толгод ухаа гүвээ бүхий талархаг газар нь аймгийн нутгийн зүүн хойт хэсэгт, өндөр уулсын бэл дагуух нутгуудыг хамарч аймгийн нийт нутгийн 56%-ийг эзэлнэ. Харин хотос хонхортоо хужир марзтай тойром, жижиг довцог элс, манхан бүхий нам дор газарт аймгийн нутгийн хойт хэсгээр түрж орж ирэх Олон нууруудын хөндийн төгсгөл болох Онгийн голын адаг, Улаан нуурын сав дагуух нутаг болон Борзон Галбын говь, тэрчлэн Нэмэгт уулын ар хоолой, Ингэн сэвстэй, Цайлангийн говийг дайрч улсын хилийн дагуу үргэлжлэх Алтайн өмнөт говийн зүүн үзүүр болох нам дор газар нутгууд орно.

Нам дор газрууд нь аймгийн нутгийн 26%-ийг хамарна. Аймгийн газар нутгийн гадаргуугийн энэхүү онцлог шинж нь аймгийн байгаль цаг уурын нөхцөлд зохих ёсны нөлөөг үзүүлдэг. Тухайлбал тус аймгийн баруун өмнөт талын нам дор нутгуудад намрын хүйтрэлт нилээд аажуу орж, хавар эрт дулаардаг бол уулархаг нутаг, түүний дотор Гурвансайханы нуруу дагуух нутгуудад намар эрт хүйтэрч, хавар хожуу дулаардгаас хүйтний улирал харьцангуй урт болдог байна.

Тус аймгийн нутгийн уул нурууд нь баруунаасаа зүүн тийш чиглэсэн тогтоцтой, урт сунгуу хэлбэртэй юм. Мөн уул нурууд нь хоорондоо элсэн довцог, манхан хужир марзтай хотос, тойром элбэгтэй нарийн хөндий хоолойнуудаар зааглагдана. Түүнчлэн хойноосоо урагш үелэж зэрэгцсэн байрлалтай болно.

Уул нуруудын өндөр нь хойноосоо урагшлах тутам намсаж ирдэг онцлогтой. Жишээ нь: Гурвансайханы Дундсайхан нь 2825 м, Зүүнсайхан 2815 м, Баруунсайхан 2613 м өндөртэй байхад Нэмэгт уул 2768 м, Сэврэй 2631 м-ийн өндөртэй, мөн тус нуруунаас өмнө орших Гост, Ноён уулын өндөр 2517 м-2397 м болж намсаж ирдэг байна. Дээрх уул нурууд нь далайн түвшнээс дээш өргөгдсөн байдлаараа ялгагдаад зогсохгүй, мөн гадаргынхаа онцлогоор хоорондоо эрс ялгагддаг.

Гурвансайханы уулс хавтгай хяртай, уулын хэсэгтээ хад чулуу багатай, уулт-хээрийн өвс ургамал сайтай байхад түүнээс урагш орших уул нурууд нь хад хясаа ихтэй шовх оройтой, цөл хээрийн бутлаг ургамал зонхилох шинжтэй болдог. Мөн уулсын энгэр, бэл нь гүн жалга, сайраар ихээхэн хэрчигдсэн байдаг. Энэ нь уг газруудыг улам бартаархаг болгож ашиглагдах нөхцөл боломжийг нь хүндрүүлдэг байна.

Гурвансайханы уулсын өвс ургамал сарлаг, бог мал, адуу мэтийн олон төрлийн малд тохиромжтой байхад түүнээс урагш орших уулуудад өвс ургамал нь цөлийн шинжтэй байхын дээр хад чулуу ихтэй ямаа бог малаас бусад малд ашиглагдах боломж нь мууддаг байна.

Ийм байдал Гурвансайханы нурууны зүүн үзүүрт орших дурьдсан уул нуруудаас нилээд алслагдан орших Шанхай, Цэций, Их-Уул зэргийн уулууд орох бөгөөд эдгээр

уулсын өндөр нь 1700-1800 метрээс ихгүй юм. Эдгээр уулсын томоохон нь Шанхайн уул юм.

Шанхайн уул нь дотроо олон салбар оройтой болохын дээр жалга, сайраар үлэмж хэрчигдсэн, хажуу бэлээрээ хайр, чулуун хурдас элбэгтэй болно. Ер нь гүн хавцал, жалга, гуу сайраар ихээхэн хэрчигдсэн байх нь говийн уулсын нийтлэг шинж нь болдог байна.

Аймгийн нутгийн ихэнх хувийг цав толгод, ухаа гүвээ бүхий талархаг газар эзэлдэг. Цав толгод нь бөөн бөөнөөрөө болон мөн өөр хоорондоо нарийн хөндий хоолойгоор тусгаарлагдан зааглагдсан байдаг ба хур тунадасны нөлөөгөөр үүссэн жалга гуу, хуурай сайраар ихээхэн шигүү хэрчигдсэн байх нь олонтоо ажиглагддаг. Мөн гадарга нь өвс ургамалгүй шахам чулуугаар хучигдсан байх нь ч үзэгддэг. Гэвч эдгээр газруудад өвөл, хаврын цагт нөмөр газар ихтэй, толгодуудын хоорондох дэрс түнх, дов товцогтой хонхор хотгоруудад усны эх үүсвэр элбэгтэй байдаг нь мал аж ахуйд нэн тохиромжтой юм. Цав толгод бүхий газар аажмаар намсаж ухаа гүвээрхэг талархаг газарт шилжих бөгөөд хааш хаашаага хэдэн арван км-ээр үргэлжилдэг.

Мөн орчныхоо нам дор газруудаас нилээд өргөгдсөн дэнж дэвсэг болж харагдах нь цөөнгүй үзэгддэг ийм газруудад нь усны эх үүсвэр ховор байдгаас мал аж ахуйд ашиглах бололцоо муутай, ашиглалт багатай бэлчээрт гол төлөв ордог байна. Харин Хөндий, Хоолойн хотос хонхор дагасан нам дор газрууд нь усан хангамжаар бусад газруудаас ямагт илүү байдгаараа онцлог юм.


Аймгийн нутаг дэвсгэрийн эдгээр олон хэв шинж нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа түүний бүтэц бүрэлдэхүүнд ч зохих нөлөө үзүүлж иржээ. Тухайлбал Говь Гурвансайхан, Сэврэй, Ноёнбогд, Номгон, Тост, Нэмэгт, Гилбэнт зэрэг уулархаг нутгууд ямаа, сарлаг, адуунд тохиромжтой байхад Галба, Зээмэг, Борзон, Заг сүүж, Ухаа гүний говиуд нь тэмээнд жинхэнэ тохиромжтой нутаг юм.

Тус аймгийн нутагт нийтдээ 32.2 мян.га талбайг элс эзэлж байна. Үүний 40 орчим хувийг нүүдэг элс эзэлдэг. Сэврэй сумын Хонгорын элсэн уул нь 180-д км урт, зарим газартаа 20 км өргөн юм. Аймгийн газрын гадаргуугийн өндөршилтийн зургаас үзэхэд далайн түвшнээс дээш 1000 метр хүртэл өргөгдсөн нутаг 5321.7 м.га, 1000-1400 метрт 8633.0 мян.га, 1400-1800 метрт 2074.9 мян.га, 1800-2400 метрт 468.2 мян.га, 2400 метрээс дээш өргөгдсөн нутаг 18.5 мян.га байна. Өөрөөр хэлбэл нийт нутгийн дийлэнх хувийг далайн түвшнээс дээш 1000-1400 метрт өргөгдсөн жижиг уул, толгод, ухаа гүвээ, тэгшивтэр гадаргуутай нутаг эзэлж байна.

2.2. Цаг уур

Монгол орны экосистем янз бүр байх нь газар орчмын бүрхэвчийн олон янз байдлыг бий болгох үндэс болдог. Байгалийн бүс бүслүүр бүрт ойн бүрхүүл, гол, нуур, мөнх цас мөсөн гол зэрэг гадаргын усны нөөц байрладаг. Эдгээр газрын гадаргын олон янз байдлыг зайнаас тандсан хиймэл дагуулын мэдээгээр тодорхойлж зураглах, мөн олон хугацааны мэдээгээр өөрчлөлтийг судлах туршлага нэгэнт дэлхий нийтийн хэрэглээ болоод байгаа билээ. Манай орны хувьд ч орон зайн хувьд бага ялгах чадвартай (1км) NOAA төрлийн цуврал хиймэл дагуулын NDVI буюу ургамлын нормчилсон индексийн

мэдээгээр газрын бүрхэвчийг 1992, 2002 оны байдлаар зураглаж Монгол орны хэмжээгээр өөрчлөлтийг үнэлсэн байдаг (С.Хөдөлмөр нар 1996). Энэхүү судалгаагаар гадаргын ус болон мөнх цас, мөсөн гол 31-36 хувиар, ойн бүрхүүл 26 хувиар буурсан харин элс, ургамалгүй газар, цөлийн хээр 46-64 хувиар нэмэгдсэн гэсэн үр дүн гарсан байдаг (С.Хөдөлмөр нар 1996).



Зураг № 2.2. Өмнөговь аймгийн өндөршлийн зураг


Дэлхийн бусад газар нутгуудаас ялгарах уур амьсгалын гол онцлог нь Монгол оронд агаарын температурын хэлбэлзэл их, хур тунадас бага ордог, өргөргийн дагуу агаарын температур, хур тунадасны өөрчлөлт асар их байдагтай холбоотой юм.

Тухайн газар орны уур амьсгалын ерөнхий төлөв буюу горимийг хамгийн багадаа 30 жил буюу түүнээс урт цуваатай цаг уурын мэдээний дунджаар илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл уур амьсгалын горим нь тухайн газар орны цаг агаарын ерөнхий шинж нь жилийн аль сард ямар байх вэ гэдгийг илэрхийлдэг. Уур амьсгал судлалаас гардаг бас нэг үзүүлэлт бол дээрх 30 жилийн дундаж үзүүлэлтүүдийг орон зайн тархацыг зураг хэлбэрээр харуулдаг. Уур амьсгалын мэдээлэлд агаарын температур, хур тунадас, чийгшил, салхины хурд зэрэг цаг уурын үзүүлэлтүүдийг оруулдаг. Тухайн газар орны уур амьсгалд газрын гадаргуугийн өндөршил, газар зүйн өргөрөг, түүнд ойрхон байгаа ус бүхий гадарга, ургамал бүрхэвч, салхины зүг чиг чухал нөлөө үзүүлдэг.

2.2.1. Дулааны горим

Жилийн дундаж агаарын температур: Агаарын хоногийн дундаж температур 10 сарын сүүлээс 0⁰ градусаас доош орж хүйтрэх ба 3 сарын 25-аас дулаарч эхэлдэг буюу 215-240 хоног нь 0⁰ градусаас дээш дулаан байдаг байна.

Жилийн дундаж агаарын температур нилээд дулаан буюу 3.8⁰C–аас 7.2⁰C градусын хооронд хэлбэлздэг. Тухайлбал, аймгийн зүүн, зүүн өмнөд хэсэгтээ илүү дулаан байдаг байна. Жилийн дундаж температурын хувьд Номгон, Цогтцэций, Сэврэй, Булган, Баян-Овоо, Ханбогд сумуудад хамгийн дулаан буюу 5⁰C-аас их ба Даланзадгадад 4.5⁰C байдаг байна. Агаарын температурын жилийн явцыг харахад 1 дүгээр сард хамгийн хүйтэн, 7 дугаар сард хамгийн дулаан байдаг Монгол орны уур амьсгалын ерөнхий зүй тогтол давтагдаж байна (зураг 2.3.).



Зураг № 2.3. Сумдын жилийн дундаж агаарын температур


Малын амьдрах чадамж цаг агаар, уур амьсгалын нөхцлөөс хамааралтай байдаг болохоор цаг агаарын үзүүлэлтийн хэлбэлзэл малын дулаан солилцоо, амьдралын үйл ажиллагаанд шууд нөлөөлж түүний үр дагавар нь ашиг шимийн өөрчлөлтөөр илэрнэ. Мал маллагааны уур амьсгалын өртөнгийн судалгаанд жил, сарын дунджаас илүү хамгийн их бага өөрөөр хэлбэл хэлбэлзлийн мэдээ чухал. Иймд энд агаарын температурын үнэмлэхүйн их, бага утгыг авч үзлээ (2.1-р хүснэгт).

Хүснэгт№ 2.1. Агаарын температурын олон жилийн дундаж утгууд

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Даланзадгад													
Дундаж	-14.7	-10.7	-2.8	6.4	14.3	19.5	21.4	19.6	13.5	5.0	-5.0	-12.2	4.5
Үнэмлэхүй их	11.1	14.7	20.6	29.0	33.8	35.2	37.9	36.5	32.4	27.9	20.1	12.6	37.9
Үнэмлэхүй бага	-40.8	-38.2	-31.7	-20.2	-11.1	-4.3	2.7	0.5	-9.7	-21.9	-35.8	-42.3	-42.3
Сайхан													
Дундаж	-13.7	-10.1	-2.3	7.2	15.2	20.5	22.6	20.6	14.3	5.6	-4.2	-11.3	5.4
Үнэмлэхүй их	5	12.4	20.4	31.6	36.4	37.8	40.2	39.0	39.7	30.1	23.7	15.2	40.2
Үнэмлэхүй бага	-39.6	-38.9	-36.1	-17.3	-10.6	-3.6	4.8	-0.7	-14	-27.2	-32.7	-38.9	-39.6
Гурвангэс													
Дундаж	-12.7	-9.3	-3.0	5.9	13.4	18.9	20.8	19.0	13.0	4.6	-4.4	-10.6	4.6
Үнэмлэхүй их	7.8	11.0	17.8	27.4	32.1	35.8	40.9	34.3	31.6	23.9	15.8	12.2	40.9
Үнэмлэхүй бага	-33.0	-32.0	-26.7	-17.4	-10.7	2.3	4.5	3.2	-5.4	-18.7	-25.0	-30.5	-33.0
Цогт-Овоо													
Дундаж	-16.1	-12.1	-3.7	5.7	14.0	19.5	21.8	19.8	13.2	4.2	-6.2	-14.0	3.8
Үнэмлэхүй их	6.9	13.4	20.2	29.6	34.1	37.1	40.2	39.5	35.0	26.8	22.8	13.8	40.2
Үнэмлэхүй бага	-37.0	-35.5	-28.7	-16.3	-7.6	0.1	5	4.7	-8.6	-16.7	-28.3	-34.8	-37.0
Ханбогд													
Дундаж	-11.7	-7.4	-0.7	8.6	16.5	21.9	24.3	22.1	16.1	7.7	-2.4	-8.8	7.2
Үнэмлэхүй их	13.1	15.6	24.3	32.1	36.5	39.0	41.3	39.0	35.2	26.8	17.7	7.7	41.3
Үнэмлэхүй бага	-31.1	-27.6	-23.3	-21.4	-15.1	-10.2	-3.1	6.5	-3.1	-22.0	-21.0	-27.5	-31.1
Цогтцэций													
Дундаж	-15.1	-10.3	-3.7	5.6	13.4	19.4	21.7	19.1	13.1	4.8	-4.4	-11.3	4.4
Үнэмлэхүй их	0.2	6.3	13.2	21.7	34.8	38.7	40.2	31.7	25.5	22.4	8.6	4	40.2
Үнэмлэхүй бага	-37	-32.7	-26.1	-19.7	-7.7	4.4	3.9	0.8	-7	-16.2	-30.7	-36.2	-37
Ноён													
Дундаж	-12.5	-10	-3.9	6.2	14.3	18.9	20.7	18.6	12.6	4.1	-3.4	-11.4	4.5
Үнэмлэхүй их	7.1	8.9	14.8	28.9	30.5	32.4	32.4	32.6	27.2	19.9	10.3	4.7	32.6
Үнэмлэхүй бага	-32	-29.5	-23	-18.2	-12	0.4	2.7	1.8	-7.4	-14.8	-24.7	-30.7	-32.0

Дээр өгүүлсэнчлэн тухайн газар орны уур амьсгалын ерөнхий төлөв буюу горимийг хамгийн багадаа 30 жил буюу түүнээс урт цуваатай цаг уурын мэдээний дунджаар илэрхийлдэг. Уур амьсгал судлалаас гаргах шаардлагатай бас нэг үзүүлэлт бол орон зайн тархац юм. Өмнөговь аймгийн сумдын хувьд өндөрлөг газраа хүйтэн, нам дор газраа илүү дулаан байдаг ерөнхий зүй тогтол хадгалагдаж байна.

Жилийн доторх хуваарилалтын хувьд Монгол орны нийт нутгийн цаг агаарын хуваарилалтын нэгэн адил 1 дүгээр сард хамгийн хүйтэн, 7 дүгээр сард хамгийн дулаан байна. Ерөнхийдөө Өмнөговь аймаг манай орны хамгийн дулаан өвөл болдог газрын нэг. 1 дүгээр сарын агаарын дундаж температур -11.7°C -с -16.8°C -ын хооронд хэлбэлзэнэ.



Зураг № 2.4. 7-р сарын агаарын температурын орон зайн тархац

Жилийн хамгийн дулаан буюу 7-р сард $20.7-24.9^{\circ}\text{C}$ хооронд байгаа энд нутагт харьцангуй халуун зун болдгийг илэрхийлж байна.


Харин агаарын үнэмлэхүйн бага температурын хамгийн хүйтэн утга Даланзадгад хотод -42.3°C , хамгийн дулаан утга Сэврэй, Номгон сумдад -30.0°C хүрч хүйтэрч байсан байна. Эндээс харахад сарын дундаж, үнэмлэхүйн бага температурын хувьд ч Даланзадгадад нэлээд хүйтэн өвөл тохиолдох бөгөөд зөвхөн 1 дүгээр сарын дундаж температур л гэхэд зарим сумдаас $1-4^{\circ}\text{C}$ -аар хүйтэн байдаг байна.

Мөн 1964 оны 2 дугаар сарын 10-нд Баяндалайд -41.5°C , 1968 оны 1 дүгээр сарын 28-нд Мандал-Овоод -40.0°C хүрч хүтэрсэн нь Өмнөговь аймгийн нутагт ажиглагдсан хүйтний туйл болжээ.



Зураг№ 2.5. 1-р сарын агаарын температурын орон зайн тархац

Харин үнэмлэхүйн их температур Ханбогдод хамгийн халуун буюу 41.3⁰С, хамгийн багадаа Ноёнд 32.6⁰С, харин Даланзадгадад 37.9⁰С хүрч халж байжээ. 7 сарын орон зайн тархцын зургаас харахад уулын өндөрлөг хэсэгтээ сэрүүн, нам газраа сэрүүвтэр, говьдоо дулаан зун болно.




Зураг№ 2.6. Агаарын дундаж, үнэмлэхүй температурын сарын явц

Ер нь тухайн газар орны уур амьсгалд газрын гадаргуугийн өндөршил, өргөрөг, усан орчин, ургамлан бүрхэвч, салхины зүг чиг чухал нөлөө үзүүлдэг буюу Говь Гурван Сайхан уулсын эргэн тойрныхоо нутаг, ялангуяа Даланзадгад хотын уур амьсгал, цаг агаарт маш их нөлөөтэй байна.

Аливаа нэг үйл ажиллагааны төлөвлөлт хийхэд тухайн газар орны уур амьсгалын горимыг заавал тусгах шаардлагатай болдог. Ийм учраас уур амьсгалын өөрчлөлт дэлхий нийтийн байгаль орчны эн тэргүүний асуудал болж улс орон бүр одорхой ажил хийж байна. Өөрөөр хэлбэл ямарч үйл ажиллагаа орон зай, цаг хугацааны дотор явагдаж л байгаа бол тухайн газар орны уур амьсгалд зохицох шаардлагатай гэсэн үг.

Уур амьсгалын судлалаас гаргах шаардлагатай бас нэг үзүүлэлт олон жилийн явц юм. Цаг агаарын мэдээний хамгийн урт цуваа бүхий Даланзадгад цаг уурын станц дээр 1961-2013 онуудад хэмжсэн мэдээгээр олон жилийн явцыг жил, сараар гаргалаа. Даланзадгад орчимд сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд агаарын жилийн дундаж температур 2.43°C -р нэмэгдсэн байна. Энэ нь Монгол орны хэмжээн дэх өөрчлөлтөөс арай илүү байна (Монголын Үндэсний Илтгэл, 2010).



Зураг № 2.7. Даланзадгад хот орчмын агаарын жилийн дундаж температурын олон жилийн явц

Судалгааны бүс нутгийг уур амьсгалыг өөр бусад газартай харьцуулж үзэх мөн цаг уурын станц байхгүй буюу уур амьсгалын төлөв байлыг олон жилийн явцыг харуулах хангалттай мэдээ байхгүй сумдын уур амьсгалд гарч байгаа өөрчлөлтийг гаргахын тулд Монгол орны 69 станцын 1961-2011 оны агаарын температурын олон жилийн өөрчлөлтийн хандлагын шугаман регрессийг тооцож, абсолют өөрчлөлтийн орон зайн тархалтыг гаргалаа. Үүнд цэгэн мэдээллийг интерполяцлахдаа Co-kriging аргаар тооцож, үр дүнг үзүүлээ. Эндээс харахад Өмнөговь аймгийн нутгаар $1.4-2.4^{\circ}\text{C}$ -аар дулаарсан ба Даланзадгадад 2.4°C -аар, бусад нутгаар $1.4-1.8^{\circ}\text{C}$ -аар дулаарсан байна.

2.2.2. Чийгийн горим

Жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалтын тооцооны үр дүнг харвал нам өргөргийн нутгаар буюу говь цөлийн бүсэд жилдээ арав хүрэхгүй см хур тунадас орох бөгөөд заримдаа энд хэдэн жил ч бороо орохгүй тохиолдол бий. Энэ нь агаарт агуулагдаж буй усны уурын тоо хэмжээ бага байдагтай шууд холбоотой юм. Оронзайн тархацын хувьд Хангайн нуруу, Хөвсгөл, Хэнтийн уулсаар 300-400 мм, Монгол Алтайн болон ойт хээрийн бүсэд 250-300 мм, хээрийн бүсэд 150-250 мм, говь цөлийн бүсэд 50-150 мм орчим хур тунадас унана.

Монгол орны газарзүйн өргөргийн дагуух хур тунадасны тоо хэмжээ газарзүйн нам өргөргөөс өндөр өргөрөг рүү шилжих тусам эрс ихэсдэг байна. Энэ нь газарзүйн өндөршилтэй шууд холбоотой бадаг. Жишээлбэл, 7 сард хойд өргөргийн 42 градусын бүслүүр дээр 31 мм, өргөргийн 46 градусын бүслүүр дээр 52 мм, өргөргийн 50 градусын бүслүүр дээр 96 мм хур тунадас тус ордог байна. Энэ зүй тогтол жилийн хамгийн хүйтэн 1-р сард мөн жилийн нийлбэр үед ч гэсэн хадгалагдаж байна.

Хур тунадасны 85% орчим нь жилийн дулаан улиралд /VI-IX сард/ үүнээс зөвхөн 7, 8 дугаар сард 50-60% нь орно.

Намрын анхны цас 10 сарын 1-2 дугаар арав хоногт орж, сүүлийн цас 4 сарын 2 дугаар арав хоногийн дунд үеэр орж хайлдаг буюу жилийн 110-150 хоногт цасан бүрхүүлтэй байдаг. Цасан бүрхүүлийн зузаан 10-15 см хүрнэ.


Тунадасны гуравны нэг хувь нь зөвхөн 7 сард, 66 хувь нь 5-8 сард, 9 хувь нь 9 сард 6 хувь нь 5 сард унана. Нэгэнт 10 сарын 1-2 дугаар арав хоногт цас орж эхлэн 4 сарын 2 дугаар арав хоногийн дунд үеэр сүүлийн цас ордог болохоор үлдсэн 20 хүрэхгүй хувийн тунадас өвөл цас хэлбэрээр унана (2.2-р хүснэгт).

Хүснэгт № 2.2. Сумдын сарын нийлбэр тунадас


Сумдын нэр	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Нийлбэр
Даланзадгад	1.2	1.6	3.1	4.9	11.0	22.0	33.5	33.5	11.3	4.3	2.3	1.4	130.1
Булган	2.5	1.7	4.4	6.8	12.0	16.5	26.4	27.6	12.3	5.4	4.3	2.5	122.4
Гурвантэс	0.7	1.3	3.2	3.3	5.5	12.5	31.1	27.0	12.0	3.5	1.0	0.8	102.0
Цогт-Овоо	0.8	1.2	1.5	3.9	7.8	14.2	29.3	24.4	10.9	3.8	2.1	1.2	101.1
Ханбогд	1.2	1.1	2.8	3.2	7.6	11.8	23.8	29.4	7.6	3.5	1.6	0.7	94.4
Цогтцэций	0.9	0.4	0.9	3.6	5.4	13.9	22	26.6	8.3	2.1	1	1	86.1
Ноён	0.8	0.6	2.2	4.0	3.6	20.6	27.2	31.0	8.3	2.9	2.3	0.4	103.9
Баян-Овоо	0.2	0.2	0.3	2.5	0.7	5.9	27.4	18.5	6.3	1.1	0.1	0.0	63.2

Мөн сумдаас Даланзадгад, Булган, Манлай, Ноён, Гурвантэс, Цогт-Овоо сумдад унах хур тунадасны хэмжээгээр илүү чийглэг буюу 100мм-ээс их, харин Баян-Овоо, Номгон, Хүрмэн сумдад жилд 63-79мм хур тунадас унах ба хамгийн хуурай, гандуу байдаг байна.

Зураг № 2.8. Смдын сар, жилийн нийлбэр тунадас



Өмнөговь аймгийн нутгаар хур тунадасны хэмжээ сүүлийн 50 гаруй жилд хэрхэн өөрчлөгдөж буйг үзүүлэхийн тулд Өмнөговь аймгийн Даланзадгад цаг уурын станц дээр 1961-2013 онуудад хэмжсэн мэдээг ашиглаж тооцоо хийлээ. Тооцооны үр дүн буюу сүүлийн 50 орчим жил бүрийн нийлбэр хур тунадасны өөрчлөлтийн явцын графикийг шугаман трендийн аргаар илэрхийлэхэд нийтдээ 13 мм-ээр буурсан байна (2.7-р зураг). Энэ зургаас харахад Даланзадгад орчмын хур тунадас 1960-д оны эхнээс 1970-д оны эхэн хүртэл буурч, дараа нь 1970-д оны дунд үеэс 1990-д оны эхэн хүртэл мөн буураад 1 жил өссөн боловч дахин 2009 он хүртэл эрчимтэй буурсан харагдаж байна.



Зураг № 2.9. Даланзадгад орчмын хур тунадасны олон жилийн явц

Өвөл, зуны болон байгаль, цаг уурын хамгийн тохиромжтой нөхцөлд мал амьдрах хэвийн нөхцөл бүрдэж ашиг шим, удамшлын чадамж дээд зэргээр илэрдэг. Тэгэхээр байгаль, цаг уурын тохиромжтой нөхцөл өөрчлөгдөх нь малын бие мах бодид сөргөөр нөлөөлж дарамт болсноос тарга хүч, ашиг шим нь муудах ялангуяа энэ нөлөө малын бие мах бодийн зохицон дасах чадварын хэмжээнээс хэтэрвэл үхэж хорогддог байна (Төмөржав, 2004, Туваансүрэн нар, 1996). Агаарын температурын халуун хүйтэн болон цасан бүрхүүл жилийн туршид бэлчээрийн маллагаанд байгаа монгол малын бэлчээрлэх нөхцөл болдог байна.

Өмнөговь аймгийн тунадасны өөрчлөлтийн хэмжээг Монгол орны өөр бусад хэсэгт өөрчлөгдсөн байдалтай харьцуулж үзлээ. Судалгаанаас харахад Өмнөговь аймгийн нутаг хур тунадас алаг цоог өөрчлөгдсөн буюу Булган, Ханбогд сумдын орчмоор 11-31 мм-ээр нэмэгдсэн бол бусад хэсэгт 7-20 мм-ээр буурсан байна.

Монгол орны газар зүйн өргөргийн дагуух хур тунадасны тоо хэмжээ газарзүйн нам өргөргөөс өндөр өргөрөг рүү шилжих тусам эрс ихэсдэг. Энэ нь газарзүйн өндөршилтэй шууд холбоотой. Энэ зургаас харахад Өмнөговь аймгийн Ханбогд суманд хур тунадасны хэмжээ олон жилийн туршид 31 мм-ээр нэмэгдсэн байхад Даланзадгадад 20 мм-ээр буурсан байна.

2.2.3. Салхины горим

Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, агаарын даралт, тухайн нутгийн физик газар зүйн нөхцлөөс ихээхэн шалтгаалдаг.

Монгол орны тал хээр, говь, цөлийн бүс нь салхи ихтэй байдаг. Жилийн дундаж салхины хурд энэ бүс нутагт 4-6 м/с. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгийн уулс хоорондын хөндийд 1-2 м/с, бусад нутгаар 2-3 м/с орчим байдаг. Тус орны 250 хот суурин орчимд хийсэн цаг уурын хэмжилтийн мэдээгээр нутгийн дөрөвний нэг орчимд нь жилийн дундаж салхины хурд 4.0 м/с-ээс их. Ихэнхдээ баруун, баруун хойд, хойд зүгийн салхи зонхилох боловч газрын хотгор гүдгэрийн нөлөөгөөр орон нутгийн ялангуяа уул-хөндийн салхи элбэг тохиолдоно. Монгол орны нутгийн 41.3%-ийг эзлэх говь-цөлийн бүсэд сул шороо элбэг, салхи ихтэй тул шороон шуурга олонтаа тохиолдоно. Энэ бүс нутагт жилдээ 30-100 өдөр, Монгол элсний өмнөд захад жилдээ 120 өдөр шороо хийснэ.


Өмнөговь аймгийн сумдын хувьд салхи ихтэй, газрын гадарга нь сул шороо ихтэй байдгаас шороон шуурга үүсэх магадлал маш их байдаг. Өөрөөр хэлбэл, нийт сумдад жилд 19-55 хоног шороон шуурга ажиглагддаг байна (2.3.-р хүснэгт).

Хүснэгт № 2.3. Сумдын шороон шуургатай өдрийн тоо

Сумдын нэр	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Нийлбэр
Ноён	2	2	6	6	6	3	2	2	3	3	4	3	42
Гурвантэс	1	3	5	8	6	2	1	2	1	2	3	3	37
Хүрмэн	1	1	3	4	5	2	0	0	0	2	2	2	22
Баяндалай	2	2	3	5	5	2	2	2	2	2	2	2	31
Сэврэй	2	2	3	4	5	1	1	0	0	2	2	2	24
Ханхонгор	2	3	7	9	10	4	3	2	3	4	4	4	55
Цогтцэций	1	2	4	7	6	4	1	1	1	2	2	2	33
Даланзадгад	2	2	4	5	4	2	1	1	1	1	3	1	27
Номгон	1	1	2	5	5	1	1	0	0	1	1	1	19
Булган	5	5	5	7	5	2	1	2	1	2	7	7	49
Манлай	2	2	3	9	8	3	2	1	2	2	2	3	39
Цогт-овоо	2	4	6	11	11	4	4	2	2	2	3	2	53
Мандал-овоо	1	3	4	5	6	3	1	1	1	2	2	2	31
Баян-овоо	2	2	4	5	6	2	0	0	0	0	2	3	26
Ханбогд	3	2	5	6	8	4	3	2	1	2	3	2	41

Өмнөговь аймгийн нутгаар салхины сарын дундаж хурд хаврын улиралд тогтмол их ажиглагддаг ба жилийн дундаж утга 2,6-5,5 м/с-ийн хооронд хэлбэлзэх буюу дунджаар 3,5 орчим м/с, салхины хамгийн их хурд 23-40 м/с хүрдэг бол 15 м/с-ээс их салхитай өдөр дунджаар 18 өдөр тохиолддог нь салхи шуурга ихтэйг илэрхийлж байна. Даланзадгад

станцад 4-5-р сард салхины хамгийн их хурд 40 м/с хүрдэг бол хүчтэй салхитай өдрийн тоо 29 хоног ажиглагддаг байна (2.4.-р хүснэгт). Өмнөговь аймгийн хувьд Булган суманд хамгийн их шуургатай буюу жилд дунджаар 68 хоног хүчтэй салхитай байдаг байна.



Зураг№ 2.10. Салхины дундаж болон хамгийн их хурд, м/с


Хүснэгт№ 2.4. Салхины хурд, хүчтэй салхитай өдөр

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
	Даланзадгад												
Салхины дундаж хурд	2.5	3	4	5.2	5	4.1	3.5	3.3	3.3	3.2	3.2	2.5	3.6
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-ээс дээш)	2	2	3	5	6	2	2	0	1	1	3	2	29
Салхины хамгийн их хурд	32	34	28	40	40	28	28	24	24	40	40	34	40
	Цогт-Овоо												
Салхины дундаж хурд	3.1	3.4	4.3	5.2	4.9	4.4	3.9	3.5	3.6	3.6	3.8	3.3	3.9
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-ээс дээш)	1	1	3	5	6	2	1	1	1	1	1	1	24
Салхины хамгийн их хурд	34	28	34	34	28	28	24	20	24	28	34	34	34
	Булган												
Салхины дундаж хурд	6.3	5	4.7	5.4	4.8	3.7	3.3	3.1	3.5	4.6	6.6	7.2	4.8
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-ээс дээш)	8	6	6	8	6	2	2	2	2	4	10	10	68
Салхины хамгийн их хурд	28	34	40	40	34	24	24	28	28	34	40	40	40
	Гурвантэс												
Салхины дундаж хурд	2.6	3	4	5.4	5.1	4.3	3.7	3.6	3.5	3.4	3.5	2.8	3.7
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-ээс дээш)	1	1	3	5	4	1	1	0	0	1	2	1	20
Салхины хамгийн их хурд	34	28	34	40	40	34	24	20	28	24	40	40	40
	Ханбогд												
Салхины дундаж хурд	4	4	4.4	5.4	5	4.1	3.6	3.1	3.4	4	4.6	4.5	4.2
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-ээс дээш)	3	3	2	4	5	2	2	1	1	1	3	1	28
Салхины хамгийн их хурд	34	28	40	34	28	34	28	34	24	24	34	24	40
	Цогтцэций												
Салхины дундаж хурд	4.4	4.5	5.3	6.2	6.7	5.6	5.2	4.7	4.5	4.4	4.5	4.6	5.0
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-ээс дээш)	0	0	1	1	1	0	0	0	0	1	1	1	6
Салхины хамгийн их хурд	16	17	20	20	18	18	16	14	14	16	18	16	20

	Ноён												
Салхины дундаж хурд	3.6	3.6	4.7	5.5	5.4	4.4	4.1	3.9	3.9	3.3	4.7	3.3	4.2
Хүчтэй салхитай өдөр (15 м/с- ээс дээш)	1	1	2	2	3	1	0	0	0	1	2	1	14
Салхины хамгийн их хурд	18	20	18	20	24	16	14	14	20	16	20	20	24

Салхины чиглэл: Салхины чиглэл нь тухайн газар орны хотгор гүдгэрийн онцлогоор голчлон тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл уулархаг орон нутагт жилийн хүйтэн улиралд хүйтэн агаар өндөрлөг газраасаа нам газар луугаа чиглэн урсах хүндийн хүчний салхи зонхилох ба жилийн дулаан улиралд шатлуур багатай нам даралтын оронд салхины чиглэл тогтворгүй болох хандлага ажиглагдана.

Өмнөговь аймгийн нутагт газрын хотгор гүдгэрийн онцлогоос болоод уулын хавцал дагуу баруун, зүүнийбаруун хойдын салхи ажиглагдана. Салхины чиглэлийн тухайд баруун хойдын салхины давтагдал жилийн турш бусад чиглэлийн давтагдлаас давуу байдаг онцлогтой. Баруун хойдын салхины давтагдал өвөл хамгийн их 60 гаруй хувь хавар, намар адилхан 22-28 орчим хувь, харин зун хамгийн бага буюу 15 орчим хувь байна. Тэгэхдээ салхины хурдаас харахад зүүн ба зүүн хойдын хүчтэй салхи гарах магадлал бага байна (2.11.-р зураг).



Зураг№ 2.11. Даланзадгад станцын салхины зүгийн байдал

2.3. Хөрс, Ургамалшлын байдал

2.3.1. Ургамлын чийг, дулааны хангамж

Хөрсний дулааны гол эх үүсвэр нь нарны энерги юм. Энэ нь 1см² талбайд босоогоор минут бүрд буух цацрагийн хэмжээгээр илрэх бөгөөд ойролцоогоор 1,946 калори дулаан юм. Хөрсний дулааны горим нь түүний дулааны шинж чанараас шалтгаална.

Ургамлын ургах энергийн эх булаг дулаан нь навчин дахь шим бодисын нийлэгжилт, үрийн ургах, жигд цухуйх, ногоон масс үүсэх, үндэс, цэцэглэлт, үр жимс тогтох, ургац боловсроход шийдвэрлэх нөлөөтэй.

Үр ургах үеэс эхлээд ургац боловсрох хүртэл нийлбэр дулааны хэмжээгээр таримлууд адилгүй. Жишээ нь: буудай 1600-2200⁰С; хөх тариа 1700-2100⁰С; хошуу будаа 1900-2300 ⁰С ;

төмс 1300-3000⁰С; чихрийн манжин 2400-3700⁰С; цагаан будаа 3000-4500⁰С; хөвөн 3500-5000⁰С дулаанд сайн ургана. Тэжээлийн горим, цаг уурын нөхцөл, ургалтын хугацаа, газар нутгийн резьефийг хамааруулан шинжиж байх хэрэгтэй.

Температурын хэлбэлзэл ихтэй байх нь ургамлын өсөлт хөгжилд муу нөлөөтэй. Тохиромжтой дулаан нь бусад хүчин зүйлүүдийг тааламжтай болгоно. Дулаан дутагдалтай байх нь өсөлт, хөгжилтйг удаашруулдаг. Хэт их дулаан ба халалт ургамлын ферментийн үйл ажиллагаа, фотосинтезийг зогсоож, ургалт зогсох төдийгүй үхэхэд хүргэнэ.

Агаарын болон хөрсний температурын нөхцөлөөр ихээхэн өвөрмөц, жилийн агаарын температур -1-2с байдаг ба хамгийн дулаан нь болох 7,8-р хангайд агаарын температур 15-20с, Говьд 22-28с, Хөвсгөл орчимд 9,6,-9,7с байдаг. Ааарын температур маш их хэлбэлзэлтэй бөгөөд жилийн хамгийн их хэлбэлзэл 86-90с, хоногийн агаарын температурын хэлбэлзэл мөн их бөгөөд хавар 3,4-р сар, намар 9-р сард хамгийн их нь 20-27с хүрдэг.

Агаарын температурын +5с –аас дээш үргэлжлэх хугацааг ургамал ургалтын бүрэн хугацаа гэж үздэг. Энэ хугацаанд өвөлжих ба үр тариа, олон наст өвс тариалах боломж илүүтэй юм.

+10с-аар дээш дулаантай хоногийн тоог ургамал ургалтын тохиромжтой дундаж хугацаа гэнэ. Энэ хугацаанд наранцэцэг, чихрийн манжин, хүнсний ногоо, буурцагт үр тарианы тарималууд сайн ургана.

+15с дээш хоногийн тоог дулаанд дуртай ургамлын ургалтын хугацаа гэнэ. Энд эрдэнэ шиш, хөвөн, усан үзэм зэрэг ургамлууд сайн ургана.

Ургамал ургалтын хугацаанд үргэлжлэл манай орны бүс бүрд харилцан адилгүй байдаг бөгөөд Их нууруудын хотгорт буюу Өмнөговь аймгийн нутагт +5с-ээс дээш дулаан байх хугацаа 5-р сарын 7-нд эхэлж, 10-р сарын 7-нд дуусч, 153 хоног үргэлжилдэг байна. Харин +10с-ээс дээш дулаан байх хугацаа 5-р сарын 25-нд эхэлж, 9-р сарын 20-нд дуусч, 118 хоног үргэлжилдэг байна.

Хаврын эцсийн хүйтрэлт орой, намрын эхний хүйтрэлт эрт болдог учир таримлыг зөв сонгон тариалах, эсвэл цочир хүйтрэлтээс хамгаалах, хүлэмжийн тариалан эрхлэх, хучлага +6 хэрэглэх аргыг өргөн нэвтрүүлэх нь чухал байдаг.

Доктор Ph.D Б.Жамбаажамц “Хөдөө аж ахуйн уур амьсгалын нөөц” (1983) номондоо Монгол орны газар нутгийг +10С-ээс дээшхи идэвхитэй температурын 80%-ийн хангамжтай нийлбэрээр нь:

- <1250с бол хүйтэн бүс
 - 1250-1750с бол сэрүүн бүс
 - 1750-2250с бол сэрүүвтэр бүс
 - 2250-2750с бол дулаавтар бүс
 - >2750с бол дулаан бүс
- гэж ангилсан байна.

Түүнчлэн ургамлын чийг хангамжийн бүсийг ургамлын чийгийн 80%-ийн хангамжаар тооцоолсон хуурайн зэргийг гаргахдаа:

<1.0 бол чийглэг

1.1-2.5 бол чийглэгдүү

2.6-4.0 бол хуурайдуу

4.1-5.5 бол хуурай > 5.5 бол нэн хуурай гэж тус тус хязгаарлан ангилсан байна.

Дээрх үзүүлэлтүүдийг 7-р сарын агаарын дундаж температур, хур тунадас, ууршилт, дутагдал чийгийн мэдээтэй хам боловсруулан Монгол орны хэмжээгээр ургамлын дулааны болон чийгийн хангамжийн зургийг боловсруулж, бүс бүслүүр бүрийн уур амьсгалын статистик үзүүлэлтүүдийг тодорхойлсон (2.5. ба 2.6.-р хүснэгт) байна. (Монгол улсын Үндэсний атлас).

Хүснэгт№ 2.5. Монгол орны ургамлын дулаан хангамжийн нөхцөл

Код	Дулааны бүслүүр	Дэд бүслүүр	Тухайн нөхцөлд тариалах боломжтой бүлэг таримал	+10с-аас дээш темп-н нийлбэр, °С	+5с-аас дээш темп-н нийлбэр, °С	7-р сарын дундаж темп, оС	Цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа/өдөр/	Таримал ургамал ургах хугацаа /өдөр/	Байгалийн ургамал ургах хугацаа /өдөр/
1	Хүйтэн	Нэн хүйтэн	Дулаалгатай ба хагас дулаалгатай таримал	< 400	< 720	< 8	< 45	< 20	< 90
2		Хүйтэн	Ургах хугацаа богино, эрт болцтой хүнсний ногоо	400-1000	720-1325	8 – 13	45 – 70	20 – 55	90 – 115
3		Хүйтэвгэр	Эрт болцтой таримал	1000-1400	1325-1730	13 – 15	70 – 90	55 – 80	115 – 135
4			Эртэвтэр болцтой таримал	1400-2000	1730-2230	15 – 19	90 – 110	80 – 115	135 – 160
5	Сэрүүн	Сэрүүн	Дунд болцтой таримал	2000-2600	2230-2940	19 – 22	110 – 140	115 – 150	160 – 190
6			Хожуувтар болцтой таримал	2600-3000	2940-3345	22 – 23	140 – 160	150 – 175	190 – 200
7			Хожуу болцтой таримал	> 3000	> 3345	> 23	> 160	> 175	> 200

Хүснэгт№ 2.6. Монгол орны ургамлын чийг хангамжийн нөхцөл


Код	Чийгшлийн бүс	Чийг хангамжийн дэд бүс	Агаарын чийгшлийн үзүүлэлт				Ургамлын чийг хангамж, %
			P/d	P/f	f/P	P	
1	Чийг хүрэлцээтэй	Илүүдэл чийгтэй, чийгтэй	>0.45	>1.00	<1.00	>580	>100
2	Чийг хүрэлцээгүй	Чийгтэйвтэр	0.35-0.45	0.77-1.00	1.00-1.28	460-580	80 – 100
3		Гандуувтар	0.25-0.35	0.55-0.77	1.28-1.80	340-460	55 – 80
4		Гандуу, нэн гандуу	0.15-0.25	0.33-0.55	1.80-3.00	220-340	30 – 55
5	Чийг багатай	Хуурайвтар, хуурай	0.05-0.15	0.12-0.33	3.00-4.50	105-220	10 – 30
6		Нэн хуурай	<0.05	<0.12	-	<105	< 10

Энэхүү статистик мэдээнд тулгуурлан боловсруулсан зургаас Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрээр таслан дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэж, ургамлын дулааны болон чийгийн хангамжийн бүс, дэд бүслүүрийн Өмнөговь аймгийн нутгаар эзлэх хувийг 7 ба 8-р хүснэгтүүдээр харууллаа.

Ургамлын дулаан хангамжийн хувьд Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр бүхэлдээ сэрүүн бүсэд хамаарагдах ба нутгийн баруун болон төв хэсэгт байрлах уулархаг газраар буюу Тост, Сэдрэй, Ноён, Говь Гурван сайхан уулсаар (9%) дунд болцтой таримлыг 115-150 хоног тариалах боломжтойн дээр үлдсэн 91 хувьд хожуувтар болон хожуу болцтой таримал тариалахад 150-аас олон хоног ургах боломжтой байна.



Зураг№ 2.12. Өмнөговь аймгийн ургамлын дулаан хангамжийн байдал




Зураг № 2.13. Өмнөговь аймгийн ургамлын дулаан хангамжийн байдалын тойрог

Хүснэгт № 2.7. Өмнөговь аймгийн ургамлын дулаан хангамжийн байдал

Код	Дулааны бүс	Дэд бүслүүр	Тухайн нөхцөлд тариалах боломжтой бүлэг таримал	Талбай, км.кв	Эзлэх хувь, %
5	Сэрүүн	Сэрүүн	Дунд болцтой таримал	15621.76	9.5
6			Хожуувтар болцтой таримал	92148.45	55.8
7			Хожуу болцтой таримал	57384.18	34.7

Ургамлын чийг хангамжийн бүс, дэд бүслүүрийн хувьд Өмнөговь аймгийн нийт нутаг чийг багатай бүсэд хамрагдаж байгаа бөгөөд орон зайн тархалтын хувьд уулархаг нутгаар хуурайвтар, хуурай (9%), харин бусад нутгаар нэн хуурай дэд бүсэд хамрагдаж байна.



Зураг № 2.14. Өмнөговь аймгийн ургамлын чийг хангамжийн байдал

Өмнөговь аймгийн уулархаг нутгаар чийг багатай хэдий ч дулааны хувьд сэрүүн бүслүүр давхцаж байгаа учраас дундаас хожуу болцтой таримал болон байгалийн ургамал ургах нөхцөлийг бүрэлдүүлж байна.

Хүснэгт № 2.9. Сар бүрийн агаарын дундаж температур [°C]

Он	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Дундаж
1961	-15.5	-9.0	-2.8	9.2	13.5	20.2	21.5	18.3	12.8	3.5	-5.3	-14.5	4.33
1962	-18.2	-12.2	-4.0	3.3	13.0	18.5	19.5	19.8	13.7	4.5	-7.5	-8.2	3.52
1963	-14.7	-10.3	1.1	4.0	15.3	20.5	20.8	20.1	13.8	4.0	-4.3	-12.5	4.82
1964	-17.1	-23.0	-3.0	8.6	15.6	19.5	20.3	19.2	12.0	3.5	-3.6	-12.5	3.29
1965	-13.8	-9.5	-3.0	5.5	14.6	20.1	20.5	20.0	14.0	6.7	-4.3	-13.2	4.80
1966	-13.2	-7.1	-1.3	5.1	13.6	18.7	20.3	19.1	13.6	4.7	-4.8	-17.2	4.29
1967	-15.6	-12.5	-2.3	6.1	16.5	19.1	20.7	20.5	12.7	4.5	-10.2	-19.2	3.36
1968	-21.0	-19.5	-2.5	6.2	13.5	20.5	22.0	17.7	11.3	3.2	-3.6	-11.0	3.07
1969	-19.8	-15.3	-3.7	6.2	16.1	18.7	19.5	16.7	12.1	5.2	-7.3	-15.5	2.74
1970	-16.5	-11.0	-8.6	4.6	14.0	19.5	23.1	21.5	11.2	5.3	-7.1	-13.3	3.56
1971	-13.0	-11.6	-5.1	7.1	14.1	17.1	21.0	18.8	12.1	4.7	-4.5	-16.0	3.73
1972	-14.7	-15.0	-0.1	6.7	16.0	20.0	22.3	20.6	12.0	4.3	-4.5	-11.2	4.70
1973	-13.7	-11.2	-2.5	7.1	12.2	19.8	20.6	18.0	13.3	3.3	-3.6	-11.3	4.33

1974	-14.3	-12.5	-5.2	7.1	14.5	19.5	20.8	19.6	12.2	1.7	-3.5	-17.5	3.53
1975	-12.0	-9.6	-1.5	5.1	12.5	19.5	20.0	20.7	15.2	5.3	-3.7	-14.6	4.74
1976	-12.5	-6.0	-5.2	4.5	12.5	18.0	19.2	18.0	14.1	6.5	-7.7	-13.2	4.02
1977	-20.0	-11.6	-1.5	6.0	12.0	17.6	20.2	20.1	14.2	6.2	-5.7	-10.0	3.96
1978	-13.5	-10.5	-2.6	8.2	14.1	20.7	20.1	20.0	14.7	4.0	-3.7	-9.5	5.17
1979	-12.2	-4.6	-2.9	5.1	13.9	18.9	20.4	19.9	12.7	7.9	-6.8	-9.9	5.20
1980	-14.6	-11.4	-5.1	3.6	14.1	20.3	23.1	18.4	13.2	4.1	-1.2	-12.3	4.35
1981	-17.1	-10.7	-0.3	8.7	13.3	20.1	23.4	18.0	14.5	0.6	-8.9	-12.2	4.12
1982	-12.1	-9.0	-0.9	7.5	14.2	18.4	21.9	18.9	13.9	8.3	-4.5	-12.4	5.35
1983	-13.8	-13.0	-2.4	4.1	16.0	18.6	20.9	18.6	13.5	5.9	-3.1	-11.5	4.48
1984	-17.1	-15.2	-4.3	5.7	15.6	18.9	21.0	18.4	13.4	5.8	-5.5	-16.9	3.32
1985	-13.7	-11.4	-6.8	6.7	14.3	20.4	19.4	19.9	12.1	6.6	-6.9	-13.9	3.89
1986	-13.1	-12.0	-2.4	4.5	16.7	20.8	21.0	19.7	12.4	3.4	-8.6	-12.0	4.20
1987	-11.7	-6.7	-5.3	9.4	14.3	18.6	21.3	19.2	15.0	2.1	-4.5	-9.8	5.16
1988	-14.7	-12.4	-6.0	5.5	13.2	20.6	22.7	20.5	13.2	5.4	-2.5	-10.6	4.58
1989	-12.0	-9.4	-2.4	8.3	14.8	19.3	21.4	20.4	12.8	6.7	-6.3	-7.8	5.48
1990	-14.9	-8.4	-0.2	4.3	14.2	17.5	21.2	19.6	14.1	8.4	-2.2	-10.0	5.30
1991	-13.0	-8.8	-2.7	4.1	14.1	19.5	22.5	21.7	13.7	5.5	-3.6	-12.1	5.08
1992	-13.2	-10.4	-3.3	8.1	14.7	19.9	22.0	19.8	13.5	2.6	-4.8	-11.2	4.81
1993	-14.5	-6.3	-0.3	4.7	13.7	19.1	20.0	17.3	14.3	5.9	-7.9	-13.9	4.34
1994	-12.3	-8.5	-3.0	9.1	14.6	20.2	21.6	20.9	12.9	2.7	-0.3	-11.1	5.57
1995	-13.1	-8.1	-1.8	4.6	11.8	19.2	22.3	20.6	14.0	7.0	-2.7	-11.2	5.22
1996	-15.4	-10.9	-4.7	6.2	14.6	18.9	21.7	19.2	14.7	6.3	-6.9	-8.5	4.60
1997	-13.2	-8.1	2.2	7.9	15.3	19.9	22.7	21.6	12.2	5.8	-4.5	-10.2	5.97
1998	-16.1	-6.6	-2.0	10.7	14.2	19.5	22.5	19.4	17.1	7.5	-0.5	-8.5	6.43
1999	-12.0	-7.2	-3.5	8.9	15.1	22.0	24.5	21.6	13.4	5.7	-2.6	-9.7	6.35
2000	-16.8	-10.1	-0.5	6.8	15.7	21.1	25.0	19.7	16.1	3.4	-7.1	-8.6	5.39
2001	-13.2	-8.5	-0.7	7.7	15.1	21.4	24.1	21.5	16.5	7.3	-3.1	-14.6	6.13
2002	-9.2	-5.4	-0.3	6.0	15.3	22.4	24.6	23.6	14.1	3.8	-5.0	-14.1	6.32
2003	-13.9	-9.2	-1.9	6.8	13.6	19.7	21.4	19.2	15.4	4.9	-6.9	-11.9	4.77
2004	-13.6	-6.3	-1.5	11.4	15.2	19.4	23.3	19.8	14.4	5.5	-4.3	-11.5	5.98
2005	-15.7	-18.1	-2.0	8.7	14.2	21.3	24.6	21.1	15.6	6.8	-2.4	-14.9	4.93
2006	-12.8	-9.3	-0.3	6.8	14.1	20.0	22.1	23.2	15.4	9.1	-2.2	-12.4	6.14
2007	-11.9	-2.7	-2.2	6.8	16.6	23.3	22.6	20.9	15.9	4.3	-3.3	-12.5	6.48
2008	-17.3	-12.5	1.6	8.9	13.7	19.7	23.7	21.1	15.9	6.5	-1.9	-12.3	5.59
2009	-13.4	-7.1	-0.6	10.5	15.8	20.3	23.9	22.2	15.0	7.3	-6.7	-12.3	6.24
2010	-15.8	-11.2	-3.8	2.7	14.4	22.7	25.7	20.9	15.6	6.6	-1.9	-10.5	5.45
2011	-20.6	-9.4	-4.4	8.1	13.4	21.4	23.0	22.9	11.8	7.6	-2.9	-14.1	4.73
2012	-17.9	-13.3	-3.3	8.9	16.2	20.5	22.1	21.5	14.1	5.1	-6.4	-14.2	4.46
2013	-12.5	-10.3	2.6	6.9	16.9	20.3	22.5	21.7	15.6	6.5	-3.3	-9.2	6.48

Хүснэгт № 2.10. Даланзадгад станцын хур тунадасны нийлбэр, 1961-2013

Он	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийлбэр
1961	1.2	0	4.8	0.7	29.5	4.4	12	34.6	29.3	9.9	7.1	1.6	135.1
1962	1.5	2.1	9.7	7.6	1.4	19.9	59.1	57.2	7.3	0.1	0.6	0.1	166.6
1963	0.4	0.4	6.1	5.2	20.9	1	51.3	23.5	12	0.1	1.8	0.9	123.6
1964	2	7.2	13.9	2.8	11	10.3	37.2	43.5	12.4	11.5	0	2.4	154.2
1965	1.5	0	3.5	39.7	4.5	6.8	20.9	4	0.3	1.6	0.7	0.7	84.2
1966	0.7	0.3	0	1.7	20.6	21.2	18.8	61.9	23.2	1.3	0.6	0.8	151.1
1967	1.2	0.2	0.1	3	30.8	6.1	63.6	13.4	0	0	8.5	0.6	127.5
1968	1	0.2	0.3	0	3.7	40.2	12.1	11.7	36.2	1.6	2.2	2.7	111.9
1969	0.8	1.6	1.1	17.4	5.3	39.4	100	28.8	25.3	0	0	1	221.1
1970	1.2	0.5	2.2	9	7.9	8.4	6.6	27.8	29.3	0.2	0.5	0	93.6
1971	1.3	0.1	1.4	0	10.6	26.2	28.8	59.6	3.8	0.1	4.3	0.9	137.1
1972	3.6	0.6	1.2	0.3	9.1	28.6	1.9	6.4	5.6	3.4	7.9	0.1	68.7
1973	3.5	0.6	5.1	0.2	23.8	13.3	13.1	72.3	16.7	1.7	0.7	2.4	153.4
1974	0	1.1	1.7	1.1	13.7	29.6	54.3	26.4	2.2	3.8	0	1.6	135.5
1975	0	0.6	0.7	6.3	8.7	12.6	49.7	52.8	13.3	0	0	0.2	144.9

1976	0	0.9	2.1	13.4	4.7	21	45.1	28.5	6.6	1.6	0.4	1.3	125.6
1977	1.5	7	3	0.5	30	77.5	69.9	17.9	21.2	5.3	1.7	0.2	235.7
1978	3	2.1	1.8	1	10.1	1.3	33.8	24.5	0.5	0.9	0.1	0	79.1
1979	2.5	1	1.1	0	0.4	71.4	44.1	32.2	9	1.2	5.4	0	168.3
1980	0	0	1.6	15.1	28.4	15.2	5.5	76.5	0	1.9	2.9	1.1	148.2
1981	2.2	0.2	7.4	0	9	14.6	29.3	39.9	5.3	10.1	2.6	1.3	121.9
1982	0.2	0	0.1	2.5	2.2	6.4	20.6	28.2	8.3	1.1	1.9	5.1	76.6
1983	3.4	0.6	3.8	5.2	3.3	19.6	54.6	50.2	31	39.1	1.5	0.2	212.5
1984	0	1.8	0.4	3.6	11.6	6.4	18.6	12.5	12.7	0.1	3.6	3	74.3
1985	0.2	0.7	1.9	10.8	1	6.3	36.7	8.5	19	0	3.1	0.3	88.5
1986	1.9	2.5	5.2	1.2	0.8	9.1	46.1	14.9	37	6.2	3.3	4.1	132.3
1987	4.1	0	4.2	2.6	17	17	24.2	11.1	13.9	20.9	1.1	0.7	116.8
1988	1.4	1.1	1.4	0.2	12.4	1.7	21.1	31.5	6.3	5.5	0	0.4	83
1989	0.5	0	3.4	6.8	3.2	3.5	29.4	14.5	7	3.5	1.2	0.9	73.9
1990	3	0.2	13.4	4.9	21.6	6.4	47.7	23.7	1.4	2.9	0	0.4	125.6
1991	0.4	2.5	10.6	8.5	1.6	37	5.2	58.3	6.5	0.9	0	4	135.5
1992	1.9	1.6	1.6	1.1	15.2	10.5	14.7	16.9	1.7	1.4	7.5	0	74.1
1993	0.4	2.2	1.4	8.1	0.3	40.4	54.9	37.4	16.1	0	5.7	2.7	169.6
1994	0	2.3	1.7	1	23	40.7	57.1	16	7.8	5.7	4.7	0	160
1995	0	1.5	8.4	3.9	7	11.8	23.5	55.3	16.3	3.9	5	0.2	136.8
1996	2.9	0.2	2.5	5.9	1.5	26.5	55.1	68.1	2.9	6.3	2.9	0.7	175.5
1997	1	0.5	0.6	0.3	0.3	35.7	75.4	17.3	17.1	2.9	6	0	157.1
1998	4.3	10.8	4.9	8.5	6.4	11.8	36.8	29.9	0.5	8.7	0.4	0	123
1999	0.6	0.6	1.1	4.6	13.8	10.5	26.1	54	44.8	0	1.2	0.8	158.1
2000	1.3	2.2	0	2.9	10	9.9	13.9	56.9	2	4.6	0.9	0	104.6
2001	1	0.9	1.8	0.6	6.9	14.2	21.3	13.9	10.6	22.4	0.9	0.3	94.8
2002	0	0	5.8	5.6	7.2	8.6	16.8	7.6	3.4	1.3	1.7	17.4	75.4
2003	3.4	1	0.3	4	54	16.1	35.9	34.5	7.8	4.1	6.3	0.8	168.2
2004	0.6	3	2.7	0	4.5	57	29.2	20.8	8.4	1.8	0.4	6.9	135.3
2005	0	2.9	0.7	0	14.3	3.2	2.6	25.9	0.6	1	0	0.4	51.6
2006	3.5	0.4	0.8	0	7.9	6.2	41.7	3.3	18.9	0	5.7	0.6	89
2007	0.8	8.1	7.4	6	1.6	4.6	42.9	48.2	6.5	10.3	2.3	3.9	142.6
2008	2.2	0.6	15.5	7.3	4.1	17.5	6.3	58.9	4.2	5.9	0.6	11.9	135
2009	0.5	0	3.6	4.1	7.6	5	12.1	3.7	0	6.1	3.6	1.5	47.8
2010	4.6	4.5	1	10	36.6	12.2	23.6	6.2	62.5	11	7.1	4.5	183.8
2011	2.8	6.5	3.8	0	8	45	3.4	15.8	31.4	7.1	6.3	5	135.1
2012	0.4	3.5	7.5	2.4	6.8	20.2	77.8	11.0	30.4	11.5	9.2	5.9	186.6
2013	0.6	0.7	0.0	0.0	0.8	29.1	36.0	39.1	11.9	3.8	2.2	0.2	124.4

2.3.2. Хөрсөн бүрхэвч

Монгол орны хөрсөн бүрхэвч бүрэлдэн тогтох явц Евро-азийн бусад муж нутгийн ижил төрлийн хөрснөөс нилээд ялгаатай бөгөөд энэхүү ялгаа нь 1-рт чулуулгийн биохимийн өгөршил, шавар үүсэх үйл явц удаашралтай, 2-рт бодисын биологийн эргэлтийн явц удаашралтай, 3-рт бодисын биологийн эргэлтийн явцад ялгарсан химийн элементүүд геохимийн шилжилтэнд хялбар ордог, 4-рт хөрс үүсвэрийн үйл явцын улирлын ялгаа эрс, тэс, 5-рт бүх хөрс удаан хугацаагаар гүн хөлддөг учраас хасах температурт явагдах хөрсний үйл явцын хувийн жин их, 6-рт хөрс нь нимгэн ялзмаг давхаргатай, хөнгөн механикийн бүрэлдэхүүнтэй, сайр чулуун хучаастай, 7-рт хээрийн хөрс үе үе нэвт норж чийглэгддэг 8-рт хээр, цөлөрхөг хээр, цөлийн хөрсөн дэх хялбар уусах давс, гөлтгөнийн хуримтлал, мараалаг шинж байхгүй, 9-рт ихэнх хөрсөнд ялзмагийн бодисоос фульвохүчил зонхилж, наанги шороо, ялзмаг бага учраас хөрсний шингээх чадвар бага, 10-рт сайр чулуурхаг хөнгөн механик бүрэлдэхүүнтэй хөнгөн шавранцар, элсэнцэр, элсэрхэг хөрс зонхилох учраас ус нэвтрүүлэх чадвар сайтай боловч ус барих чадвар муу, 11-рт жилийн хамгийн чийгтэй үе хамгийн дулаан үе давхацдаг нь биологийн идэвхитэй үеийн хугацаа богино, эрчимтэй байх нөхцлийг бүрдүүлдэг зэрэгт оршино

Монгол орны хээрийн бүсийн төв ба зүүн хэсэгт эртний цэвдгийг ул мөр болох элсэн линзүүд нилээд тааралддаг нь тухайн бүсдээ нилээд өвөрмөц цэвдгийн үлдмэл шинж юм. Хээрийн хар хүрэн ба хүрэн хөрсний нилээд хэсэг нь гүндээ мараалаг шинжтэй болж үе давхаргын нягтрал ихсэж, босоо призм ба самарлаг хэлбэрийн бүтэцтэй болдог нь өмнөх үеэс уламжлагдсан марааны шинж юм. Монгол орны хөрсөн бүрхэвчинд нийтлэг ажиглагдах өвөрмөц онцлог нь салхины нөлөө юм. Салхины нөлөөгөөр говь нутагт хайрга чулуун хучаас тогтсон байхад хээрийн ба цөлөрхөг хээр, цөлийн бүсэд элсний хуримтлал нилээд тархсанаас гадна сүүлийн жилүүдэд цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор энэ үзэгдэл нилээд тэлж байна. Хөрсний эдгээр шинж чанар нь хөрсний ашиглалтанд зохих ёсоор нөлөөлж, төлөвлөлтийн онцлог нөхцлийг шаардана. Тухайлбал үлдмэл нугын шинжтэй хөрс газар тариаланг хөгжүүлэхэд илүү ач холбогдолтой байхад мараалаг хөрсийг усжуулахдаа усалгааны горимыг нарийн тохируулах, элсэн ба элсжсэн хөрсийг сайжруулах, ашиглалтыг нарийн зохицуулах, зэрэг тусгай арга хэмжээ авах шаардлагатай байдаг учраас газар төлөвлөлтөнд зайлшгүй анхаарах хэрэгтэй юм.

Өмнөговь аймгийн хувьд нутаг дэвсгэрийн газрын гадаргын хотгор гүдгэр харилцан адилгүй байдгаас шалтгаалан хөрс үүсгэгч эх чулуулаг өөр өөр байна. Аймгийн ихэнх нутагт гол төлөв дөрөвдөгчийн галавын хурдсууд зонхилон тархах бөгөөд эдгээрийн тогтоц, байршил, морфологи шинж, физик-химийн шинжийг нь үндэслэн

1. Эллювийн хурдас
2. Деллювийн хурдас
3. Эллюви-деллювийн хурдас
4. Аллювийн хурдас
5. Проллювийн хурдас
6. Эоловийн хурдас гэж ангилдаг.

Эллювийн хурдас нь уулархаг гадаргаар ихэвчлэн тогтворжих бөгөөд анх байсан газраа ямар нэгэн өөрчлөлтөд ороогүй хурдсууд хамрагдана. Эллювийн хурдас тус аймгийн Говь гурван сайхан, Сэврэй, Нэмэгт, Тост зэрэг уулс болон говийн жижиг ухаа толгодоор

тархана. Эллювийн хурдас дээр тогтворжсон хөрс нимгэн үе давхаргатай байдаг ба зарим тохиолдолд эх чулуулаг (хөрс үүсгэгч хурдас) нь ил гарсан байх бөгөөд ихэнх тохиолдолд карбонатлаг, шүлтлэг орчинтой байна.

Деллювийн хурдас. Аймгийн нутгаар их хэмжээний нутгийг хамран тархах ба ялангуяа уулын ар, өвөр хажуу, хормой бэл, тэдгээрийн хоорондох хөндийгөөр тархана. Энэ хурдас үүссэн нөхцлийн хувьд эллювийн хурдсаас өөр нөхцөлд гулсалт, шилжилтийн үр дүнд нам дор газар хуримтлагдсан хөрс багтдаг.

Эллюви- деллювийн хурдас. Ийм төрлийн хосолмол хурдас гол төлөв уулархаг гадаргаар үүсэх бөгөөд мөн жижиг дов толгодын цөлөрхөг хээрийн гүйцэт бус хөгжилтэй бор, цайвар бор, уулын сулавтар хөгжилтэй хөрсний дэд хэв шинжүүд эллюви- деллювийн хурдас дээр тогтворжсон байдаг.

Аллювийн хурдас. Энэ хурдасны гарал үүсэл нь дээрх хурдсуудаас өөр байдаг. Энэ хурдас усны нөлөөгөөр үүсч, чулуурхаг хэсгүүд нь бөөрөнхий, хурц ирмэггүй байх бөгөөд нам дор, чийглэг газраар ихэвчлэн үүснэ. Тус аймгийн Онгийн голын дагуу тархана.

Проллювийн хурдас. Энэ хурдас нь уулсын хоорондох нарийн хөндийгөөр цас борооны усны нөлөөгөөр урсдаг, гуу жалга, сайрын үелсэн тогтоцтой хөрсний төрөл зүйл хамрагдана.


Эоловийн хурдас. Эоловийн хурдас тус аймгийн бараг бүх нутгаар тархах ба ихэвчлэн салхины нөлөөгөөр үүссэн газрын гадаргын өнгөн хэсгийн элсэн хуримтлалыг хэлнэ.

Эх газрын эрс тэс уур амьсгал, Төв азийн цөлүүдийн нөлөө энэ бүхэн тус аймагт хөрс бүрэлдэн тогтох өвөрмөц нөхцлийг бий болгож хөрсөн бүрхэвчийн газарзүйн тархалтанд нөлөөлснөөс Монголын өмнөд хагаст цөлөрхөг хээрийн ба цөлийн хөрс зонхилж, хуурай хээрийн хөрс нутгийн хойт хэсэг болон өндөр уулсаар зурвасхан тархжээ.

Өмнөговь аймгийн хөрс нь хөрс-газарзүйн мужлалтаараа Говийн их мужийн Хойт говийн мужийн Говь Алтайн ба Нууруудын хөндийн, Дундговийн Замын-Үүдийн район, Өмнөт говийн мужийн Өмнөговийн ба Алтайн өвөр говийн районуудад тус тус багтаж байна.

Хүснэгт№2.11. Өмнөговь аймгийн хөрсний төрөл (га-гаар)

№	Сумын нэр	Нийт талбай, га	Уулын цайвар хүрэн	Уулын цөлөрхөг хээрийн бор	Уулын цөлийн бор саарал	Цайвар хүрэн хөрс	Цөлөрхөг хээрийн бор хөрс (Заримдаг цөлийн бор хөрс)	Цөлөрхөг хээрийн цайвар бор хөрс (Заримдаг цөлийн цайвар бор хөрс)	Цөлөрхөг хээрийн бор хөрс (Заримдаг цөлийн хужирлаг нугаг бор хөрс)	Цөлийн бор саарал хөрс	Цөлийн гөлтгөнөг бор саарал	Шал шалархуу хөрс	Аллюийн нугын хөрс	Эловийн элс	Нугын хужирт элс
1	Баяндалай	1066060	141659	120346	41033	46486	75533	229392	4913	285406	20937	9922		84014	6419
2	БаянОвоо	1116080		12868	349841		141405		33276	575193					3497
3	Булган	752596	53250	5160		33665	230943	312336				19197		88344	9701
4	Гурвантэс	2803381		183336			98865	1142185	196745	972027		41921		168302	
5	Даланзадгад	47079	483				40276								6320
6	МандалОвоо	649214					232251	370360					12644	580	33379
7	Манлай	1244048		163366			921907		31328	87740				39707	
8	Номгон	1846865		46866	732709		38448	109	6807	883287				138639	
9	Ноён	1057645		113969	79769		4133	236013		501859	72565	15241		33234	862
10	Сэврэй	816370	68151	119310			29012	485693						102663	11541
11	Ханбогд	1498867		4369	254547		260581			911966				67404	
12	Ханхонгор	989617	29229	193351	31550	5054	661797	405		455				12008	55768
13	Хүрмэн	1265482	11265	68466	206598	32572	141389	264514		479738				50124	10816
14	ЦогтОвоо	655811		247083			241801	98313				68614			
15	Цогтцэций	728932		287115			415713		25193	801				110	
Дүн		16538047	304037	1565605	1696047	117777	3534054	3139320	298262	4698472	93502	154895	12644	785129	138303



Зураг №2.15. Өмнөговь аймгийн хөрсний зураглал

2.3.3. Ургамлан нөмрөг


Монгол орон өргөн уудам нутагтай төдийгүй хөвч тайга, хангай, говь хосолсон байгалийн олон янзын цогцолборт олон мянган зүйлийн дээд ургамал ургадаг. Монгол нутгийн ургамлын аймгийн судалгаа эрт дээр үеэс эхлэн харьцангуй сайн судлагдсан түүхтэй.

Өмнөговь аймгийн нутаг нь Монгол орны байгалийн үндсэн бүс бүслүүрийн хувьд цөлөрхөг хээр (говь), цөлийн бүсэнд байрладаг.

Ургамал газар зүйн мужлалаар олон нуурын хөндийн цөлөрхөг хээр, Дорнод говийн цөлөрхөг хээр, Алашаа говийн цөлийн, Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, Алтайн өвөр говийн (цөлийн) тойрог гэсэн 5 тойрогт хамрагдана.

Тус аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны хувьд хамгийн өргөн уудам нутгийг хамарсаны зэрэгцээ манай улсын говийн үндсэн төрхийг дагнан хамарч байдаг цөөхөн аймгийн нэг юм.

Нутгийн ихээхэн хэсэг нь говь, хээржсэн цөлийг илэрхийлж, өндөр уул, говийн жижиг толгод, элсэн манхан, элсэрхэг довцог, өргөн уужим сайр, сул элс ихтэй. Хэдийгээр Алтайн өвөр говийн баян бүрдүүдтэй харьцуулахад жижиг боловч цөөн хэдэн баян бүрдийн шинж агуулсан Хар толгойн худаг, Гурван тэс, Тээгийн худаг, хэд хэдэн “Улаан нуур” нэрт устай газар, хүйтний булаг, Баян гол болон Зулганайн хөндий зэрэг нутгуудад бэлчээрийн ургамалшлын өвөрмөц тогтоц бүхий зэгс, дэрс, сухай, тооройн төгөл бүхий баян бүрд байдаг.



Зураг№2.16. Өмнөговь аймгийн ургамал газар зүйн мужлал

2.3.4. Ургамал газар зүйн мужлалт

Олон нуурын хөндийн цөлөрхөг хээрийн тойрог

Алтай (Монгол ба Говийн), Хангайн завсрын томоохон газрыг хамардаг. Ус, чийгт газрын биоценоз говийн экосистемд маш чухал байрыг эзлэнэ. Тэнд цөлийн ба цөлийн хээрийн (хээржсэн цөл) бүс дагуу тохиолдох гүйцэд тогтворжоогүй довцог элсэн манхны загт (*Haloxylon ammodendron*), хөндийн карбонаттай элсэнцэр бор хөрст газрын монгол өвс-тэсэгт, тэсэг-хазаар өвс-монгол өвст (*Stipa glareosa*, *S.gobica*, *Cleistoines Songorica*, *Krascheninnikvia ceratoides*), хоолой дагаж давсархаг бор хөрстэй, хотсын бударганат (зарим зүйл *Kalidium*), мараат хөрстэй газрын олон наст бударганат цөлийн (*Salsola passerine*, *Reaumuria Soongurica*, *Anabasis brevifolia*, *Allium polyrrhizum*, *Artemisia pectinata*) шинжтэй фитоценоз давамгайлж байдаг.

Өмнөговийн экосистемийн хувьд ус, чийглэг биотоп: уулсын амнаас эх аван урсах гол, горхи, цөлжсөн хээр, говьд ундрэн гарах намагжсан булаг, түүний задгайран урсах хэсэг, борооноос үүсэх тойром, шанд нуурлаж тогтсон задгай уснаас бүрдэнэ. Түүнээс гадна баруунаас зүүнээ үргэлжилсэн их нуруунуудын өмнөд бэлээс урагш Монгол Улсын хил хүрэх өргөн хотгоруудад бага, дунд олон давсархаг нуур, цөөрөм, баян бүрдэрхүү газрууд байдаг нь эзгүй уужим газрын сээртэн амьтанд ихээхэн ач холбогдолтой юм. Энэ нь бүс нутгийн экосистемийн ургамлын гарцын хамгийн их нягтралтай газруудын нэг юм. Ялангуяа эргээрээ зэгс, усны дээд ургамалтай урсгал ус, нуур нь хавар, намрын цагт олон зүйл ус намгийн шувуу дайрч өнгөрөх, түр буух, зун үлдэж, үүрлэж өндөглөх боломж олгоно. Тийм биотопод хоолойн гүний тойром, Баян төхөмийн нуруу, Улаан нуур, Талын толгойн хоолой, түүнээс баруун хойш чигт үргэлжлэх чийглэг, ундрага, булаг шанд бүхий хоолой, их ба бага булаг, Онгийн гол, Баян гол, Нүцгэний гол орно.

Дорнод говийн цөлөрхөг хээрийн тойрог

Уулсын хормой бэл, элсэрхэг нутгуудтай хил залган, түрж орох маягаар хээржсэн цөлийн биоценоз бүрэлдүүлжээ. Цөлөрхөг хээрийн бүлгэмдэлд уул толгодын бэл, тал нутгийн хөнгөн шавранцар, элсэн бор хөрстэй газрын баглуур-монгол өвст (*Stipa glareosa*, *Anabasis brevifolia*, *Allium polyrrhizum*), Говь Алтайн нурууны уулс хоорондох хотгор ухаа гүвээт тал нутгийн хазаар өвс-монгол өвст хээрийн, хөнгөн шавар, цайвар хүрэн хөрстэй *Cleistogenes squarrosa*, *Artemisia* бүхий умрын хувилбар, элсэнцэр бор хөрстэй *Stipa gobica*, *S. Glareosa*, *Cleistogenes songoria* зонхилсон өмнөдийн хувилбар илэрч байдаг. Мөн Говь алтайн хаяа уулсын хөнгөн шавранцар ба элсэнцэр бор хөрстэй газрын баглуур-таана-монгол өвст (*Stipa glareosa*, *S. gobica*, *Allium polyrrhizum*, *Anabasis breifolia*) хээр түрж ордог.

Дорнод говийн цөлөрхөг хээрийн биоценозод мал онцгой холбогдолтой. Ялангуяа зэрлэг тууртан, гэрийн малын хооронд бэлчээрийн давхцал өрсөлдөөн хүчтэй явагддаг. Нэгэнт хүний ивээлд байгаа болохоор мал бэлчээрийн аль идэмж сайтай, ус ундаатай хэсгийг эзлэн байрших боловч зэрлэг тууритан амьтад хур тунадас элбэгтэй, бэлчээрийн шүүслэг ургамалтай жилүүдэд алслан нүүдэллэж (гол нь метаболизмын усанд дулдуйдан) бэлчээр тавиун болно. Харин зудтай өвөл, гантай зуны улирал бэлчээрлэгч хөхт амьтдад хүнд, хэцүүгээр нөлөөлдөг тул бэлчээрийн менежментийн асуудалд зэрлэг тууритан амьтдыг заавал тооцон оруулах шаардлагатай. Энэ тойрогт ус онцгой ач холбогдолтой.

Алашаа говийн цөлийн тойрог.

Аймгийн хэмжээнд элсэн толгой, манхан, сул элст хоолой, хотос (говь) элсэн дов толгод бүхий газар элбэг.

Өвс ургамалгүй юмуу зарим газрууд нь *Psammochloa villosa* ургасан довцог, дэл элс хэлбэртэй газрууд их тохиолдоно. Элсэрхэг нутгийн биотоп цөлжсөн хээртэй зах нийлэн өргөн уудам эзгүй нутгийг эзлэн энд тэнд цоохортон оршино. Тийм элсэрхэг нутгууд голцуу уулс хоорондын болоод жижиг нуур, уст хоолой даган байрлах ба тэнд туулахад хэцүү манхан элс, томоохон элсэн толгой, довцог, дов сондуул, үргэлжилсэн сул элс

хэлбэрээр тааралдана. Харин монгол орны говь бол дэлхийн хэт хуурайсаг бүсүүдийн нэг бөгөөд Төв Азийн цөлүүдийн мөн элсэрхэг хөрстэй өргөн сайрууд, хэсэгхэн чулуурхаг хээрүүд элсэрхэг биотопод хамрагдана.

Чулуурхаг хээр нь ургамал бүрхэвч багатай, нимгэн хучаас жижиг чулуун бүрхүүл дороо элсэн суурьтай байдаг. Ургамалжилтын хувьд заримдаг сөөгөнцөр (бор бударганат ба баглуурт) бударганат бэлчээр зонхилдог. Загт бэлчээр багавтар тархсан бөгөөд чулуурхаг, үетэн-бударганат бэлчээр өргөн тархжээ. Томоохон хотгоруудын ёроолоор сийрэг таруу заг, бударгана ба хармаг ургасан довцог элстэй. Дэрстэй газрууд бага. Хадлан огт байхгүй. Энэ районд Алтайн цаад говийнхонтой адил баянбүрдүүд байдаггүй юм.

Говь Алтайн уулын цөлөрхөг хээрийн тойрог.

Энэ нь Говийн Алтайн уулсын шилийн салбарласан систем ба тэдгээрийн хоорондох тууш хотгоруудыг багтаана. Говийн уулсын биоценозын бүрдэл нь Тост, Ноён Богд, Сэврэй, Зөөлөн, Гурвансайхан, Баянбор зэрэг уул, нурууд түүний салбар уулсад өндрийн хуваарилалтаар тод илэрнэ.

Хөрс, ургамалжилтын ерөнхий байдлыг авч үзвэл Говь Алтайн уулсын хүрэн хөрстэй чулуусаг хээрийн алаг өвс-ерхөгт (*Agropyron erisfutum*, *Stipa Krylovii*, *Artemisia frigida*, *Astragalus laguroides*, *Potentilla sericea*, *Heteropappus altaicus*), хааяа ерхөг-хялганат хээр зонхилно. Түүнээс гадна уулсын бэл хормойгоор цөлийн хээрийн бүсийн нам ба өндөр цав толгод, нам уулс, уулс хоорондын хотгор хийгээд уулсын хормойн сайраар чулуурхаг бор хөрстэй газарт монгол өвс-бударгана, бударгана-монгол өвст хээр (*Ajania fruiticulosa*, *Anabasis brevifolia*, *Kochia prostrata*, *Ptilagrostis pelliotii*, *Caragana leucophloea*, *S.Pygmaea*, *Stipa gobica*, *S.glareosa*) ихээхэн байр суурь эзлэнэ. Толгодын бэлийн шарилж-монгол өвст хээрээр уулын бэл хормойн цайвар хүрэн хөрстэй газрын *Ajania achilleoides*, *Caragana Leucophloea*, *Agropyron cristatum*, *Arenaria capillaries*, *Kochia prostrata* гэх мэт чулуусаг ургамал, хайргархаг цайвар хөрстэй нутагт *Stipa govica*, *Artemisia frigida*, *A.caespitosa* зэрэг ургамал давамгайлна. Мөн ухаа гүвээг нутгийн элсэн ба элсэнцэр бор хөрстэй, харгана-монгол өвст хээр ч бий.

Говь-Алтайн уулын цөлөрхөг хээрийн тойрогт уулын хээр говийн уулсыг даган байх өөрийн өвөрмөц онцлогтой биоценозуудыг бүрдүүлдэг. Яагаад гэвэл тэр нутгийн олонхи уулс эгц цавчим, амууд хавчиг учраас уул хоорондын хээр хэсэгхэн газарт задгайрч, энд тэнд дэвцэг байдлаар илэрнэ. Харин зоо нурууны гадаад хормойгоор тодрох уулын хээр нь элсэрхэг нутгуудтай залгалдан хол ойр харьцангуй алслана. Энэ фитоценоз бол завсрын бүсийн шинжтэй тул говийн уулсын ба хээржсэн цөлийн төрхийг илэрхийлсэн ургамлын бүлгэмдэл, амьтны аймгийн бүрдэлтэй. Уулын хээрийн бүлгэмдэл нь (хуурай хээрсэг) уул хоорондын болон үе үе илрэн гарах дэвцгүүд, гуу жалга, сайраар хэрчигдсэн боловч зун намартаа хэт хуурайсаг болдгоос дөрвөн улирлын ихэнх хугацаанд ургамлан бүрхэвч тачир байдаг. Өвөл хаврын цагаар уулын хээрийн жалга, судаг, хотгор гүдгэрт цас хунгарладаг, оройтож хайлдаг, уулс хооронд салхи багатай, харьцангуй

дулаан тул эрт ногоордог. Тиймээс ургамал идэшт амьтад босоо бүслүүрийн дагуу уруудан шилжиж бэлчээрлэх таатай орчныг бүрдүүлдэг билээ.

Алтайн өвөр говийн тойрог

Нэмэгт, Тост уулаас баруун тийш аймгийн хилийн дээс хүртэлх (Баянхонгор аймагтай) хэсэгхэн газар энэ тойрогт хамрагддаг.

Тус тойргийн баруун өмнөд хэсгээрээ ИГДЦ газартай, өмнөд хэсэг нь улсын хил хүрдэг.

Элэгдэж намссан, эмх замбараагүй тогтоцтой, бөөн бөөн бэсрэг уулс, тэдгээрийн хооронд өргөн цайдам хөндийгөөр тусгаарлагдсан цав толгод энэ тойргийн онцлог юм. Цав толгодын ургамал нэн ядмаг ихэвчлэн монгол өвс, багмэгэр зонхилон ургадаг. Толгодын хоорондхи хөндий хоолойг хармагт цөл эзэлдэг. Багавтар шал, нам газраар улаан бударгана, баглуурт цөл тархсан бөгөөд нэлээд уудам талбайг хотирт цөл түгээмэл тархсан байдаг.

Тус тойргийн хойт талаар Ингэн хөөврийн говь орших бөгөөд энэ уудам хоолойн эргэн тойрноор гуу жалга, сайр сапарга, эрэг мөргөцгөөр хэрчигдсэн байдаг.

Эхийн зулагнай, Тооройн шанд зэрэг ус булаг, бүрдүүдэд багавтар талбайг эзлэн тооройн төгөл цөөн тооны жигд ургана. Энэ нь эдгээр ургамлын ургаж буй хамгийн зүүн өмнөд нутаг юм.

Дээрх булаг шандын зах, зарим том сайрын хажуугаар сухай, заг ургасан элсэн дов сондог элбэгтэй. Уг тойрогт тэсэг, шар мод, алтгана зэрэг сөөг сөөгөнцөр ургамал ургадаг.

Тус аймагт Хазаар өвс-Хялганат, Таана-Хялганат, Заримдаг сөөг-Хялганат Хялгана-Заримдаг сөөгт, Хялгана-Загасгалт гэх цөлийн ургамалжилт мөн Хотирт, Шармодот, Загт, баглуурт, Борбударганат, Баглуурт, Монгол бүйлст, зэрэг жинхэнэ цөлийн болон хэт гандуу цөлийн ургамалжилт багтдаг юм байна.

Хүснэгт №2.12. Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн эзлэх талбай, хувь

Д/д	Бүс, бүслүүрийн нэр	Талбай (км ²)	Эзлэх хувь
1	Өндөр уулын бүслүүр	56394.0	3.6
2	Уулын тайгын бүслүүр	70492.5	4.5
3	Ойт хээрийн (хангайн) бүс	238108.0	15.2
4	Хээрийн бүс	535743.0	34.2
5	Говийн бүс	366561.0	23.4
6	Цөлийн бүс	299201.5	19.1
Дүн		1566500.0	100.0

Тус аймаг нь Говийн болон Цөлийн бүсд хамаарагдах бөгөөд Говийн бүс нь хээрийн бүсийн урдуур баруунаас Их Нууруудын хотгор, Нууруудын хөндийг дамжин зүүн тийш зурвас байдлаар үргэлжилж улсын хил хүрнэ. Говийн бүсийн хойт хилийг манай ард түмэн тарваганы тархалтын өмнөд хилээр зааглан маш оновчтой тогтоож ирсэн уламжлалтай. Говийн бүсэд бүслэг байдлаар илрэх цөлжүү хээр, заримдаг цөлийн ландшафтууд багтана. Ландшафтын эдгээр дэд хэвшинжүүд нь нийлээд говийн ландшафтыг бүрдүүлж байгаа бөгөөд хээрийн ба цөлийн аль алины шинжийг давхар хадгалсан онцлогтой. Иймд говь нь өргөн, явцуу 2 утгаар илрэх гандуу нутгийн ерөнхий нэр боловч түүнийг орчин үед цөлийн ландшафтын хойгуур байгалийн бие даасан бүсийг үүсгэх завсрын шинжтэй ландшафтын өвөрмөц хэвшинж гэж үзвэл зохино. (Д.Даш, 1992). Говийн бүс нь олон улсын ландшафтын ангилалаар заримдаг цөлтэй утга давхцана.

Иймд говийн бүс нь цөлжүү хээр, заримдаг цөлийн гэсэн 2 дэд бүсээс бүрдэх ба нутгийн зүүн хэсэгт х.ө.-ийн 44° 30' - аас 46° -ийн хооронд өргөргийн бүс тод илэрч энэ нь баруун тийш Нууруудын хөндий, Их Нууруудын хотгороор дамжин Тагнын нурууны өвөр бэл хүрч төгсөнө. Говийн бүсийн цөлжүү хээр, заримдаг цөлийн дэд бүсүүд нь Говь-Алтайн нурууны ар, өвөр хажуу дагуу өндрийн бүсчлэл үүсгэдэг. Говийн бүс нь нийт нутгийн 23.4 хувь буюу 366561.0 км² талбайг хамрах бөгөөд дэд бүсүүдээр авч үзвэл цөлжүү хээр 9.1 хувь, заримдаг цөл 14.3 хувийн харьцаатай байна. Уур амьсгалын хувьд хуурай, гандуу жилдээ 100-200 мм хур тунадас унана. Хөрсөн бүрхэвч нимгэн, амьтан, ургамлын зүйлийн тоо бусад бүсээс харьцангуй цөөн. Энд монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*), хар сүүлт (*Gazella subgutturosa*), жороо тоодог (*Chlamydotis undulata*), тас (*Aegypius mnachus*) зэрэг амьтад, цагаан харгана (*Capreolus bungei*) зэрэг үлдвэр ургамал элбэг тохиолдоно.

Цөлийн бүс нь дотроо хээржүү цөл, жинхэнэ цөл, хэт гандуу цөл гэсэн 3 дэд бүсээс бүрдэх бөгөөд үндсэндээ х.ө.-ийн 44° 30' -аас урагш улсын хил хүртэлх нутаг хамрагдана. Гэвч Говь-Алтайн ба Говь Тянь Шанийн салбар уулс уг бүсэд байрладгийн улмаас нэлээд нутаг нь говийн ба хээрийн бүсэд орно. Харин Баруун хуурайн хотгор бол хотгорын бүсчлэлээр цөлийн бүс илэрдэг өвөрмөц нутаг. Цөлийн бүсийн зүүн зах нь Гурван баяны хоолой дагуу нутгийн гүн рүү түрж улмаар энд Хянганы нуруунаас зүүн тийш тод илрэх уртрагийн бүсчлэлийн нөлөөнд ордог. Талбайн хувьд цөлийн бүс нь нийт нутгийн 19.1 хувь буюу 299201.5 км² нутаг дэвсгэрийг хамрах ба үүний 6.2 хувийг хээржүү цөл, 9.2


хувийг жинхэнэ цөл, 3.7 хувийг хэт гандуу цөл тус тус эзэлнэ. Цөлийн бүсийн уур амьсгал нэн эрс тэс, жилд дунджаар 50-100 мм, хааяа түүнээс ч бага тунадас унана. Бэлэрхэг дундаж, нам уулс, цав толгод, ухаа гүвээ, шал тойром, хөндий хотгор ээлжлэн солигдсон эртний амьтан, ургамлын олдворыг агуулсан нэн өвөрмөц тогтоцтой. Цөлийн бүс нь хулан адуу (*Equus hemionus*), хавтгай тэмээ (*Camelus bactrianus*), мазаалай баавгай (*Ursus arctos gobiensis*), замба гүрвэл (*Stellia stoliczkanus*) зэрэг дэлхийд ховордсон амьтад, элдэв навчит улиас (*Populus diversifolia*), улаан тулам (*Incarvillea potaninii*), монгол мөнх харгана (*Ammopiptanthus mongolicus*), хонхот харгана (*Halimodendron halodendron*) зэрэг үлдвэр, унаган ургамлаар баялаг.

2.6. Цөлжилт

Орчин үед хүн төрөлхтний өмнө тулгарч байгаа нэг аюул бол хүний үйл ажиллагаа ба уур амьсгалын өөрчлөлтийн явцад улам бүр эрчимжиж байгаа цөлжилтийн процесс юм. Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ийн конвенцоор цөлжилт гэж “хуурай хуурайвтар, чийг дутмаг бүс нутагт янз бүрийн хүчин зүйлс, түүний дотор уур амьсгалын өөрчлөлт, хүний аж ахуйн үйл ажиллагааны улмаас газрын доройтол болох явц” гэжээ. Газар гэсэн ойлголтонд хөрс, ус, ургамал ба бусад биомасс мөн түүнчлэн системийн дотор явагдаж буй экологийн болоод гидрологийн процессыг багтаасан газрын биобүтээмжит системийг хэлж байна.

Тус аймгийн хувьд цөлжилтийн антропоген хүчин зүйлийн гол нь малын хөлөөр бэлчээр талхлагдах явц юм. Мэдээж энд бас уул уурхайн үйл ажиллагаа, авто тээвийн хөдөлгөөн гэх зэрэг техноген элэгдэл орно.

Цөлжилтийн өнөөгийн байдал Монгол орон дэлхийн бөмбөрцгийн энэ бүстээ хамгийн хуурай уур амьсгалтай нутгийн нэг бөгөөд хур тунадас, ууршицын харьцаа 0.04-0.78-ын хооронд хэлбэлздэг зөвхөн тайгын болоод өндөр уулын тагийн бүслүүрт л 0.65-аас дээш байдаг, цөлжилтөнд амархан өртөж болох нутаг юм. Иймээс цөлжилтийн асуудал манай орны хувьд онцгой өвөрмөц байгалийн гамшгийн нэг бөгөөд зарим мэдээллээр Монгол орны бэлчээрийн 70 орчим хувь ямар нэг хэмжээгээр цөлжилтөнд өртсөн байна.



Зураг №2.18. Монгол орны цөлжилт, газрын доройтлын байдал, 2006 он

Монгол нутаг одоо цагт явагдаж байгаа цөлжилтийн уур амьсгалын хүчин зүйл нь ургамал ургалтын хугацааны агаарын температурын өсөлт, үүнээс уламжлан дэвсгэр гадаргын ууршиц эрс нэмэгдэж байхад түүнийг дагаад хур тунадасны хэмжээ зохих хэмжээгээр /ууршицын алдаглыг нөхөх хэмжээнд/ нэмэгдэж чадахгүй, харин ч ихэнх нутагт буурч байгаа, ургамлыг халууны дарамтанд оруулах хэт халуун өдрийн тоо нэмэгдэж байгаа, жилийн дулаан улиралд ордог хур борооны дотор аадар хур борооны эзлэх хувийн жин хориод хувиар нэмэгдсэн, хур борооны нийт үргэлжлэх хугацаа богиноссон, цасан бүрхүүл эрт арилж ургамал ургахаас өмнө хөрс нүцгэн байдаг хоногийн тоо ихэссэн, үүнээс үүдээд өнгөн хөрсний сул элс, шороо салхинд хийсэх буюу шороо шуурах потенциал боломж нэмэгдсэн зэрэг олон хүчин зүйлийг тоочиж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ НУТАГ ДЭВСГЭРИЙН ЦОГЦОЛБОР НӨХЦЛИЙН МУЖЛАЛ


3.1. Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужууд

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийг геологийн бүтэц, уур амьсгал, хотгор гүдгэр, ус зүй, хөрс ба ургамалшил, амьтны аймгийн хам бүрдэл, тэдгээрийн хоорондын ялгаа, харилцан үйлчлэлийн ижил төстэй нөхцлүүдээр нь 3 муж, 5 тойрог болгон мужилсан ба, түүнд тохирсон газар ашиглалтын бодлогыг тодорхойлон улмаар байгаль нийгмийн зохистой тэнцлийг хангахад энэхүү мужлалын ач холбогдол, зорилго оршино.

Тус аймгийн нутаг дэвсгэрийн ландшафт бүрэлдэхэд Говь Алтайн нуруу болон түүнээс салбарлах нам өндөрлөгт уулс, цав толгодууд, говь нутгийн халуун дулаан уур амьсгал чухал нөлөөтэй юм. Муж, тойргийн хуваарилалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт №3.1. Аймгийн нутаг дэвсгэрийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн ялгаа

Мужийн нэр	Тойргийн нэр	Талбай /га/
Говийн Алтайн уулсын муж	Их, Бага Богдын уулсын тойрог /Г-5/	285362.4
	Гурвансайхны уулсын тойрог /Г-6/	2237586.4
Алтайн өвөр говийн цөлийн муж	Алтайн өвөр говийн тойрог /Г-8/	4660120.5
Дорнод говийн цөлөрхөг муж	Дорнод говийн хойд хэсгийн тойрог /Г-9/	3263476.8
	Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог /Г-10/	6091501
Бүгд		16538047



Зураг №3.1. Монгол орны байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужлалын ялгарал

3.2. Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужуудын онцлог

3.2.1. Говийн Алтайн уулсын муж

Говийн Алтайн уулсын муж нь Их, Бага Богдын уулсын тойрог (Г-5), Гурвансайханы уулсын тойрог (Г-6) гэсэн 2 тойрогт хуваагдана (зураг3.1.).

Их, Бага Богдын уулсын тойрог /Г-5/ нь Өмнөговь аймагт уг тойргийн урд үзүүр буюу шувтаргын багахан хэсэг орно. Энэ тойргийн томоохон уулууд болох Их богд, Бага богд, Арц богд гэх Гурванбогд бөгөөд эдгээрээс Гурван Богдын гурав дахь уул болох Арц Богд уулын үзүүр хэсэг нь тус аймгийн баруун хойд хэсэгт багахан талбайг эзэлнэ. “Арц богд” нь зүүн талдаа нилээд намссан харин өмнө зүгтээ эгц урт, налуу байдалтай байна. Түүний хамгийн өндөр Их баян уул нь 2086 метр үнэмлэхүй өндөртэй юм. Энд Их Богдынхтой адил эрс эгц хажуунууд үгүй боловч Арц богдын ар хажуу нь нилээд эгц, өвөр хажуу нь маш урт налуу тул жижиг толгодтой, аажим уналттай ташуу тал газрын төрх байдалтай.

Гурвансайханы уулсын тойрог /Г-6/ нь тус аймгийн нутагт бүхлээрээ багтах ба Говийн Алтайн уулсын гол үндсэн хэлхээний зүүн үргэлжлэл нь Гурван сайханы нуруу юм. Энэхүү нуруу нь баруун талдаа Хутаг нуурын хотгороос эхлээд зүүн талдаа Хөрх уулыг оруулан нийтдээ 500 гаруй км урт үргэлжлэх Говь-Алтайн нурууны системд багтана. Энэхүү уулсын хойд ба урд талаар түүний дагуу хөндийнүүд зэрэгцэн орших бөгөөд зарим газраа уулсын хоорондох өргөн хотгорууд байдалтай байна. Гадаргын хувьд ихэвчлэн зүүн урагшаа налуу боловч зарим газраа орон нутгийн чанартай өмнөхийн эсрэг байдалтай налууунууд бас үзэгдэнэ.

Гурван сайханы нуруунд Баруунсайхан, Дунд сайхан, Зүүн сайхан гэдэг гурван гол нуруунаас гадна энэхүү системд бас хэд хэдэн нуруу, уул, хярыг хамруулах хэрэгтэй тухайлбал, Хаалга, Баян бор нуруу, Баян цагаан зэрэг зэрэгцэн орших хэд хэдэн уулсыг хамруулж үзэж болно. Эдгээр уулс нь баруун хойд талдаа Арц богдын нуруунаас элс болон давслаг жижиг нуурууд бүхий өргөрөгийн дагуу оршилттой уулсын хоорондох өргөн хотгороор тусгаарлагдана. Гурван сайханы уулархаг мужийн Зүүн сайханы нуруу нь 2346 метр өндөртэй байна. Эдгээр уул нь өмнө зүг 1450 метрийн өндөрт орших Баянтөхөмийн хотгор руу, хойд зүг “Нууруудын хөндий”-ийн үргэлжлэл болох хотгор руу уналтай байна.

Гурван сайханы уулсын гадаргын хэлбэр зүйн өвөрмөц онцлог гэвэл уулт тогтолцооны төвөөс тал бүр тийш тектоник гүн хагарал салбарлаж, элгэн хадат эгц хавцал үүсгэх бөгөөд уулсын цэрд - палеогены тэгшрэлийн гадарга хадгалагдаж үлдсэн явдал юм. Жишээ болгон Ёлын амыг нэрлэж болно. Гурвансайханы уулст “бэл” их тархаж уулын хажууг бэлийн хурдас тал дунд өнгөртөл хучсан байдаг.

Эндээс баруун тийш Нэмэгт, Сэврэй, Зөөлөн зэрэг уулс орших бөгөөд эндхийн уул өргөрөгийн дагуу суналттай, гадарга удаан хугацаанд элэгдэлд орж ихээхэн хэрчигдсэний дээр тектоник хагаралд өртөгдөн эвдэрч хавцал, хөндий зэргийг элбэг үүсгэжээ. Уулсын ар хажуу налуу, бусад говийн уулсын адил бэлийн хурдас ихээхэн тархаж уулс хоорондох хотост элсэн тарамцаг нилээд газрыг хамарсан байна.

Гурван Богд, Гурван сайханы хоорондох хөндийн хэлбэрийн хотгор нь бараг өргөрөгийн дагуу суналтай хэдэн арван км газар үргэлжилсэн томоохон буурц хотгор юм. Энэ буурц хотгорын ёроолд хужир марцат бага шиг хотгор ихээхэн тархасны дээр давст нуурууд элбэг байна. Түүний хамгийн том нь Нэмэгтийн нурууны ар хоолойд орших давст нуур юм. Хөндий хэлбэрт хотгорын хойд урд захаар хормой, бэлийн хурдаст налуу тал газар ихээхэн талбайг эзлэх бөгөөд түр урсгалт хуурай сайраар гадаргын байдал шигүү хэрчигдсэн нь онцлог юм. Энд элсэн тарамцаг нэн түгээмэл бөгөөд салхины олон жилийн давтагдах чиглэлийн дагуу нүүж үргэлж хөдөлгөөнтэй байдаг.

Энэ мужид жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ 100 орчим мм, 80%-ийн хангамжтай жилийн нийлбэр тунадасны хэмжээ 30-60 мм байдаг.

Энэ мужийг Их, Бага Богдын болон Гурвансайханы гэсэн 2 тойрог болгон хувааж үздэг бөгөөд харин уур амьсгалын нөхцлийн хувьд төдий л ялгаа багатай. Энд уур амьсгалын босоо бүслүүрээс болж уулын өндөр намаас хамааран хур тунадас, температурын утга өөр өөр байж болох юм. Энд тухайн орон нутгийн ургамалжилт, амьтны аймгийн байдлаар илүү тод илэрнэ. Энд говийн эмзэг экосистемийг хамгаалах, ховор, нэн ховордсон амьтан ургамлыг хамгаалахад илүү анхаарах шаардлагатай болно.

Уур амьсгалын хувьд далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн говийн уулс, тэдгээрийн хоорондох молцог элс бүхий хөндийнүүд нь ерөнхийдөө говийн шинж төрхийг агуулна. Энд 1 дүгээр сарын дундаж агаарын температур -20°C , 7 дугаар сарынх $20 - 25^{\circ}\text{C}$ орчим байна. Говь-Алтайн уулсын шувтрага, ялангуяа өвөр талаараа жилийн аль ч улиралд үүнээс дулаан байдаг. Үнэмлэхүй хамгийн их температурын утга $35 - 38^{\circ}\text{C}$, дулааны улирлын 50 орчим хоногт агаарын температур $+30^{\circ}\text{C}$ -аас их байдаг. Хоногийн дундаж агаарын температур хавар 4 дүгээр сүүлчээс эхлэн $+10^{\circ}\text{C}$ -ийн заагийг давж дулаарах бөгөөд намар уг заагийг бүр 9 дүгээр сарын сүүлчээр давж сэрүүсдэг энэ үе нь 5 дугаар сар буюу 150 хоног үргэлжилдэг. Энэ хугацааны температурын нийлбэр нь 2240-2840иС болдог. Хаврын сүүлчийн цочир хүйтрэл 5 дугаар сарын 10-даарч дуусч, намрын анхны цочир хүйтрэл 9 дүгээр сарын 20-доор эхэлдэг. Энэ мужид жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ 100 орчим мм, 80%-ийн хангамжтай жилийн нийлбэр тунадасны хэмжээ 30-60 мм байдаг. Энэ мужийг Их, Бага Богдын болон Гурвансайхны гэсэн 2 тойрог болгон хувааж үздэг бөгөөд харин уур амьсгалын нөхцлийн хувьд төдий л ялгаа багатай. Энд уур амьсгалын босоо бүслүүрээс болж уулын өндөр намаас хамааран хур тунадас, температурын утга өөр өөр байж болох юм. Энд тухайн орон нутгийн ургамалжилт, амьтны аймгийн байдлаар илүү тод илэрнэ. Энд говийн эмзэг экосистемийг хамгаалах, ховор, нэн ховордсон амьтан ургамлыг хамгаалахад илүү анхаарах шаардлагатай болно.

Ургамал нөмрөг. Ургамалжилтын хувьд нэлээд өвөрмөц, газрын гадаргын байдлыг дагаж хэвшлүүд нь өөрчлөгдөнө. Уул, тал, хотгор хөндий хосолсон учир ургамлын аймгийн хувьд ч нэлээд баян. Энэ мужийн бүх нутагт байгаа бэсрэг уулс, гүвээ, дов толгодын хажуу, дунд зэргийн өндөрлөг уулсын хажуугийн доод хэсэг, уулсын бэлийн дагууд болоод уулс хоорондын хотгор хонхорууд, хоолойнууд, түүнчлэн мужийн өмнөд хэсгийн уулс бүхэлдээ цөлийн ургамалжилтаас бүрдэнэ. Энд гол төлөв өдлөг хялгана-баглуур-

таанат цөл, эсвэл өдлөг хялгана-бор бударгана-таана, хөмөлт цөл тохиолдоно. Уулсын хажуу, бэл, “хуруудын” дагуу, тэгш талархаг гадаргаар бор бударганат цөлөрхөг хээр, хотгор, хотос хоолойн ёроол дагаж баглуурт, бор бударганат- баглуурт, тэсэгт цөл тааралдана. Мужийн хойд хэсэгт тэгш талархаг газраа өдлөг хялгана-баглуурт, өдлөг хялгана-ортууз-баглуурт, өдлөг хялгана-таанат, дан өдлөг хялганат цөлөрхөг хээртэй; өмнөд хэсгийн нууруудын чулуурхаг, хайргархаг хормой, хажуугаар улаан бударганат, хойрогт, хотирт, намхан загт цөл, тэгш талархаг газраар нь тэсэг-тогторгонот цөлтэй. Түүгээр ч барахгүй мужийн зүүн өмнөд хэсэгт элсэрхэг-сайргархаг тэгш талархаг газраар хармагт цөл тааралдана. Уулсын хажуу, хормой бэл дагуу элсжсэн хайргархаг- чулуурхаг газраар тэсэг-өдлөг хялганат хотир (нохой шээрэн)-өдлөг хялганат цөлөрхөг хээр, мөн харгана, буйлс, заг, зээргэнэ оролцсон сөөгт цөл маш их газар тархсан байна. Хөндий, хотос, хотгорын ёроолоор шаварлаг хужир марцтай байх бөгөөд тэнд гоолиг шар бударгана, улаан бударгана, бор бударганын шигэнгэтэй юмуу Зүүнгарын улаан бударгана, хар бударгана, бор бударгана, гоолиг шар бударгана оролцсон бударганын (луулийн овгийн сөөгүүдтэй) говь, гоолиг бударганат хөвсгөр марц, мараат хотгор, эсвэл ердийн нүцгэн шал тойром байдаг. Уулс хоорондын хотгор дагасан багахан элсэн манх, довцгоор бор шаваг, бунгийн харгана, сөөгөн шимэрс, хар суль зэрэг элссэг сөөг зонхилон ургах юмуу эсвэл сийрэгхэн заган шугуйтай байна. Томоохон сайруудын адагт хурсан элсэн сондог дагаж хужирлаг хөрстэй байх бөгөөд тэнд сухайн шугуй, томоохон загийн бутнууд, ганц нэг юмуу хэсэг хэсэгхэн тооройн моднууд, хармагт довнууд, Төв-Азийн лавай, зогдоргоно, дэрс, шагшуурга зэрэг ургамал ургадаг. Ийм газруудад ямагт булагтай, эсвэл хөрсний ус өнгөцхөн илэрдэг буюу задгайрдаг тул баянбүрдтэй байдаг.

Гурвансайханы хэсэгхэн газарт уулын хээр тохиолддог юм. Эдгээр нуруудын ар хажуугийн ам, хавцлуудад улиас, хус цөөн модтой төгөл юмуу ганц нэгээр ургахаас гадна бас тошлог навчит бургас, удвал навчит тавилгана, тарих тавилгана, дунд тавилгана, монгол чаргай, том үрт чаргай, хар үрт чаргай, ганц цэцэгт чаргай, өргөст нохойн хошуу, алтайн далан хальс зэрэг умардын чийгсэг сөөгүүд ургадаг юм. Дундаж өндөртэй бусад бүх уулсаар уулын дээд хэсгийн чулуурхаг хажууг дагаж крыловын хялгана, өлчир шарилж, саман ерхөг зонхилсон үетэн-агьт хуурай хээр тохиолдоно. Мөн уулын хуурай хээрт арц хэсэг хэсгээр толботсон ширэнгэ үүсгэнэ. Бас монгол бүйлээс, бунгийн харгана, бариулт бүйлээс, сөөгөн зогдор өвс, тангад зогдор өвс зэрэг хуурайсаг сөөгүүд тааралдана. Говийн Алтайн уулсын муж нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 5.02%-ийг эзэлнэ. Энэ мужид одоогоор 710 зүйл бүртгэгдсэний дотор 114 зүйл модлог, сөөглөг (мужийн ургамлын 16.06%) ургамал, 596 зүйл өвслөг (83.94%) ургамал байна. Модлог, сөөглөг ба цөөн наст өвслөг ургамлын зүйлийн тоо харьцаагаараа Монгол-Алтайн тойрогтой тун ойролцоо, нарийн олон наст өвслөг ургамлын зүйлийн тоогоор түүнээс нэлээд цөөн юм. Экологийн бүлгүүдэд хувааж үзвэл:

- хуурайсаг ургамал 118 зүйл (16.62%),
- хуурайсуу-чулуусаг-145 зүйл (20.42%),
- чийгсүү-хуурайсаг-66 зүйл (9.3%),

- чийгсэг 60 зүйл (8.45%),
- намагсаг 3 бүлгийн ургамал-46 зүйл (6.47%),
- уссаг-11 зүйл(1.55%),
- хүйтсэг 3 бүлгийн ургамал 78 зүйл (10.98%),
- чийгсүү-хүйтсүү-чулуусаг ургамал 65 зүйл (9.16%),
- давссаг 4 бүлгийн ургамал 93 зүйл (13.10%), элссэг-28 зүйл (3.95%) байна.

Үүнээс үзвэл энд хуурайсаг ургамал давамгайлж хүйтсэг ба давссаг, элссэг, чулуусаг ургамал багагүй чухал үүрэгтэй нь тодорхой харагдаж байна.

Бэлчээрийн хувьд Гурвансайханы уул нь чулуурхаг хар хүрэн хөрстэй, чулуусаг алаг өвс-ерхөг, хялганат бэлчээртэй, өвөл-хавар бог мал, адуунд тохиромжтой, 6.0 ц/га тэжээлийн нөөцтэй, 300-350 кг/га тэжээлийн нэгжтэй.

Их Шанхайн нуруу, Их номгон уулсаар цөлөрхөг хээрийн бор хөрстэй баглуур-жигжиг хялганат, цөлөрхөг хээр ба цөлийн, цөлөрхөг хээрийн чулуурхаг бор хөрстэй бударгана-жигжиг хялганат, жигжиг хялгана, бударганат цөлийн бэлчээртэй, бог мал, тэмээнд тохиромжтой. 1.5-2.0 ц/га нөөцтэй, 60-90 кг/га тэжээлийн нэгжтэй.

Хотос хонхор газруудаар мараа ба цөлөрхөг хээрийн давсархаг бор хөрстэй олон наст-бударганат бэлээр бог мал, тэмээнд тохиромжтой. 2.0 ц/га нөөцтэй, 140-160 кг/га тэжээлийн нэгжтэй.

Хөрсөн бүрхэвч. Энэ мужид цөлийн болон, цөлөрхөг хээрийн, хээржүү цөлийн хөрс ихэнх нутгаар тархах ба бүс дундын нугат намгийн хөрс маш бага хувьтай, Шал, элсэн хөрс 3 орчим хувьтай тархаж байна. Хээржүү цөлийн бор/хээржүү цөлийн сайр чулуурхаг бор 12.1%, Цөлөрхөг хээрийн бор Хөрс үүсгэгч эх чулуулгийн хурдас нь элюви, делювийн хурдас бөгөөд голдуу элсэнцэр механикийн бүрэлдэхүүнтэй байх боловч өндөр уулсын хэсгээр тархсан хүрэн хөрсний хэв шинжүүд хөнгөн болон дунд шавранцар механикийн бүрэлдэхүүнтэй байдаг.

Хүснэгт № 3.2. Говийн Алтайн уулсын мужийн хөрсний нөөц

Д/д	Хөрсний нэр	Г-5		Г-6		Мужийн дүн	
		га	%	га	%	га	%
1	Нуур	1184.0	0.0	1640.8	0.1	2824.8	0.0
2	Уулын нугат хээрийн болон уулын нугын	41039.3	1.1		0.0	41039.3	0.7
3	Уулын хуурай хээрийн бүдүүн ялмагт/уулын нугат хээр	2.6	0.0		0.0	2.6	0.0
4	Уулын хар хүрэн/уулын нимгэн хар шороон	24862.3	0.6		0.0	24862.3	0.4
5	Уулын хүрэн/уулын хар хүрэн	151011.8	3.9	26619.4	1.2	177631.3	2.9
6	Уулын карбонаттай цайвар хүрэн/ уулын нимгэн цайвар хүрэн	421656.3	10.9	243434.2	10.9	665090.5	10.9
7	Уулын цөлөрхөг хээрийн нимгэн бор/сайрын	310339.9	8.1	114410.6	5.1	424750.4	7.0
8	Уулын хээржүү цөлийн нимгэн бор/сайрын	116591.5	3.0		0.0	116591.5	1.9

9	Уулын хээржүү цөлийн нимгэн бор саарал/сайрын		0.0	98961.2	4.4	98961.2	1.6
10	Толгодын карбонатгүй хар хүрэн/нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	11447.3	0.3		0.0	11447.3	0.2
11	Сайр чулуурхаг цайвар хүрэн	17104.2	0.4	9610.7	0.4	26714.9	0.4
12	Толгодын цөлөрхөг хээрийн бор	144286.7	3.7	247692.0	11.1	391978.7	6.4
13	Толгодын хээржүү цөлийн бор/хээржүү цөлийн нимгэн сайр чулуурхаг бор	219657.5	5.7	99327.0	4.4	318984.5	5.2
14	Толгодын бор саарал/нимгэн бор саарал	15726.7	0.4	3829.6	0.2	19556.3	0.3
15	Ердийн цайвар хүрэн/сайр чулуурхаг цайвар хүрэн	77411.2	2.0	25560.2	1.1	102971.4	1.7
16	Цөлөрхөг хээрийн бор	241685.4	6.3	462781.1	20.6	704466.5	11.6
17	Цөлөрхөг хээрийн бор/сайрын болон элсэн хучаастай бор	39253.5	1.0	56349.5	2.5	95603.0	1.6
18	Цөлөрхөг хээрийн сайр чулуурхаг бор	383614.5	10.0	242122.5	10.8	625736.9	10.3
19	Цөлөрхөг хээрийн мараалаг бор/хужирлаг нугат бор	46652.9	1.2	86631.8	3.9	133284.6	2.2
20	Хээржүү цөлийн бор/хээржүү цөлийн сайр чулуурхаг бор	686410.9	17.8	50701.6	2.3	737112.5	12.1
21	Хээржүү цөлийн бор/элсэн хучаастай бор болон хээржүү цөлийн мараалаг бор	88235.6	2.3	238947.4	10.7	327182.9	5.4
22	Хээржүү цөлийн мараалаг бор/шалархуу болон хагас бэхэжсэн элс		0.0	12483.6	0.6	12483.6	0.2
23	Элсэн хучаастай бор/элсэн хучаастай сийрэг бор	431582.9	11.2	62782.1	2.8	494365.0	8.1
24	Хужирлаг нугат бор/нугын хужирлаг		0.0	2283.7	0.1	2283.7	0.0
25	Цөлийн бор саарал/мараалаг цөлийн бор саарал	19968.9	0.5	30098.4	1.3	50067.2	0.8
26	Цөлийн гөлтгөнөт мараалаг бор саарал ба хужирлаг бор саарал	65769.7	1.7	70435.1	3.1	136204.8	2.2
27	Цөлийн элсэн хучаастай бор саарал ба цөлийн гөлтгөнөт бор саарал	2527.3	0.1	392.0	0.0	2919.3	0.0
28	Сайрын болон цөлийн бор саарал	32424.2	0.8	37271.6	1.7	69695.8	1.1
29	Нугын хужир/хужирлаг нуга	51326.6	1.3		0.0	51326.6	0.8
30	Алловийн нугын хужирлаг ба Аллювийнүелсэн тогтоцтой	1978.6	0.1		0.0	1978.6	0.0
31	Хужир марааны бүрдэл	12227.7	0.3		0.0	12227.7	0.2
32	Нугын иж бүрдэл	24754.6	0.6		0.0	24754.6	0.4
33	Хужир болон хужирлаг нугат бор	15274.4	0.4		0.0	15274.4	0.3
34	Хужир болон хагас бэхэжсэн элс	67111.9	1.7	14070.8	0.6	81182.7	1.3
35	Шал шалархуу	18393.4	0.5		0.0	18393.4	0.3
36	Шалархуу хагас бэхэжсэн элс	22535.9	0.6	1801.9	0.1	24337.8	0.4
37	Хагас бэхэжсэн элс	49677.9	1.3		0.0	49677.9	0.8
38	Хөдөлгөөнт элс	227.6	0.0	876.1	0.0	1103.8	0.0
	Дүн	3853955.4	100.0	2241114.6	100.0	6095070.0	100.0

Ан амьтан. Энэ мужид нийтдээ 4 ангийн 172 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 26.4 % нь оршин амьдардаг байна.

Хүснэгт № 3.3. Говийн Алтайн уулсын мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амтан	Бүгд
Баг	5	12	1	1	-	-	19
Овог	12	26	5	1	-	-	44
Зүйл	49 (35.2%)	116 (27.9%)	10 (47.6%)	19 (16.6%)	“		172 (26.4%)

Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтанд бичив.

Дэлэнтэн. Энэ мужид 5 баг, 12 овгийн 49 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн 35.2 % болж байна. Хөхтөн амьтнаас Говь алтайн нурууны үндсэн шинжийг илэрхийлэх дэлдэн зараа /Hemiechinus auritus/, үхэр огодой (Ochotona

pallasi), гозоорой зурам (*Citellus alaschanicus*), халтар зурам (*Citellus erythrognus*), хүмж барагчин (*Alticola barakshin*), хул чичүүл (*Meriones unguiculatus*) зэрэг зүйлүүдээс гадна (Банников, 1954) хад асгатай уулс, түүний хөндийгөөр том соотон багваахай (*Plecotus austriacus*), хонгор догтынх (*Nyctalus noctula*) тархсан. Уулын хээр, хээржсэн цөл, хад бартаатай толгодоор бор туулай (*Lepus tolai*), орог зусаг (*Phodopus Campbell*), элссэг зусаг (*Phodopus roborocskii*), хөх шишүүхэй (*Cricetulus baradensis*), хадны барагчин (*Alticola argentatus*), шаргал чичүүл (*Meriones meridianus*), гэрийн хулгана (*Mus musculus*), шивэр алагдаага (*Allactaga sibirica*) тааралдахын хамт элсэрхэг нутгуудад говийн алагдаага (*Allactaga bullata*), элсч савагдаахай (*Dipus sagitta*) зэрэг мэрэгчидтэй. Махчтангаас мануул мий (*Felis manul*), цоохондой мий (*Felis lybica*), цоохор ирвэс (*Uncia uncia*), шарнад цөөвөр (*Cuon alpinus*), халздай дорго (*Metes meles*), нохой зээх (*Gulo gulo*), суусар булга (*Martes foina*), солонго үен (*Mustela altaica*), өмхий үен (*Mustela eversmanni*), эрэн хүрэн (*Vormela peregusna*) тархан амьдарна. Сүүлийн жилүүдэд саарал чонын тоо олширч зэрлэг туруутан амьтдын хэвийн өсөлтөнд сөргөөр нөлөөлөхийн хамт ирвэсний тэжээлийн гол өрсөлдөгч боллоо. Харин дорго, нохой зээх тохиолдлын чанартай үзэгдэнэ. Гурван Сайхан зэрэг уулсын хөндий дагаж хулан адуу (*Equus hemionus*), хар сүүлтий (*Gazella gutturosa*) цөөнгүй нэвтрэх бөгөөд сүүлийн жилүүдэд цагаан зээр олноороо орж ирэх болжээ. Тус нурууны өндөр уулын хяраар янгир ямаа (*Capra sibirica*), бэсрэг уулсаар аргаль хонь (*Ovis ammon*) тархсан байдаг.

Ан агнуурын тухай Монгол улсын хууль, тогтоомж, Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг Олон улсад худалдаалах тухай конвенцийн 1.2-р хавсралт, Монгол улсын ба Байгаль хамгаалах Олон улсын холбооны Улаан номонд орох зэргээр эрх зүйн хувьд ямар нэг хэмжээгээр хамгаалатанд авсан шарнад цөөвөр, цоохор ирвэс, шилүүс мий, мануул мий, цоохондой мий, хар сүүлтий, янгир ямаа, аргаль хонь гэсэн 8 зүйл дэлэнтэн энэ мужид тэмдэглэжээ. Эдүүгээ шарнад цөөвөр үндсэндээ утсан гэж үздэг.

Шувуу. Говийн Алтайн уулсын мужид 12 баг, 26 овгийн 119 зүйл шувуу оршин амьдарна. Энэ нь Монгол орны шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 28.6 %-ийг эзэлнэ. Эдгээрээс тус мужид суурин амьдардаг 31 зүйл, нүүдлийн өндөглөдөг 62, дайрч өнгөрдөг 26 зүйл шувуу бий. Их, Бага Богд уулсын тойрог, Гурван сайхан уулсын тойргийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүн хоорондоо бараг адил. Энэ мужийн суурин шувуудаас ёл, алтайн хойлог бусдаас ховор болжээ. Харин Гурвансайхан ууланд урьд ховор тааралддаг байсан цасны хажир бүргэд сүүлийн жилүүдэд суурин амьдарч, элбэгших хандлагатай болж, харин өл шувуу хамгийн элбэг байсан Ёлын амнаас дайжин бусад газруудад тархан амьдрах болсон байна. Говийн Алтайн уулсын мужид тэмдэглэгдсэн шувуудаас цасны хажир бүргэд, алтайн хойлог, хулан жороо зэрэг 3 зүйлийг Монгол улсын улаан номонд бүртгэжээ. Говийн Алтайн уулсын муж нь олон зүйлийн махчин шувууд нэг дор тохиолдох өвөрмөгц нутаг юм. Тухайлбал энд сохор элээ, үүрсээ харцгай, морин харцгай, шунгаач харцгай, шилийн сар, тарважи- бүргэд, бахим бүргэд, цармын бүргэд, ёл, дэлт бүргэд, ухаа хажир бүргэд, цасны хажир бүргэд, тас, идлэг шонхор, зээрд шонхор, начин шонхор зэрэг махчин шувууд зэрэгцэн амьдарна.


Мөлхөгчид. 5 овгийн 10 зүйл мөлхөгч тэмдэглэгдсэнээс төмөр гүрвэл, цоохор хонин гүрвэл, могой гүрвэл, рашааны могой, бамбай хоншоорт могой зэрэг амыдыг тус мужийн нутаг дэвсгэрт өргөн тархсан, элбэг зүйлүүдэд тооцов. Харин замба гүрвэл, монгол гүрвэл, говийн гүрвэл, нарийн могой, сум могой зэрэг мөлхөгчид тус мужийн нутаг дэвсгэрт алаг цоог тархалттайн зэрэгцээ тоо толгойн хувьд ч төдийлэн өндөр биш юм. Улаан номонд орсон 1 зүйл /нарийн могой/ бий.

Хоёр нутагтан. Энэ тойргийн Их Богд зэрэг уулсын зарим газраар хөдөөлөх нүүдлийн үед монгол бах тааралдах нь бий.

Загас. Энэ мужид загас байхгүй.

Ландшафтын онцлог. Гурвансайханы уулсын тойрогт Гурвансайханы нуруу, Баянцагаан, Баянборын нуруу, Зөөлөн, Сэврэй, Гилбэнт, Нэмэгт зэрэг уулс бүхлээрээ багтах тул тэдгээрийн байршил, өндөр намын онцлогоос хамаарч ландшафтын босоо бүсшил, тэдгээрийн харилцан солигдолт ихээхэн онцлог байдлаар илэрнэ. Эдгээр онцлогийг бүрдүүлэгч уулс нь дэвсгэр нутгийн бараг тал хувийг эзлэх ба энд босоо бүслүүрийн ерөнхий шатлалын харьцангуй доод түвшинд хамаарах уулын хуурай хээрээс авахуулаад уулын цөл хүртэлх ландшафт тархсан байна. Зарим өндөр уулын ноён оргил дагуу уулын хээр тохиолдоно. Говь-Алтайн салбар уулсад хамаарах уулс нь ихэвчлэн 2400-2800 м-ийн хооронд өргөгдсөн бөгөөд Дунд Сайхан, Зүүн Сайханы нурууны ноён оргил нь бусдаас илүү өндөр уулын төрхтэй. Бусад уулс нь өндрийн хувьд ойролцоо, дундаж уулсын ангилалд багтах уулс юм. Эдгээр уулсаас Дунд, Зүүн Сайханы уулс нь нэгэн түвшинд өндөр өргөгдсөн олон тооны оргилуудтай байхад бусад уулсад арай өөр буюу ихэвчлэн ганц гол өндөрлөгөөс тал бүр тийшээ намссан шинжтэй байдгаар ялгагдана. Энэ нь ландшафтын хуваарилалтад онцгой нөлөөлж түүний орон зайн тархалт нь энэ онцлогийн дагуу хуваарилагдана. Тухайлбал, ургамалжилтын хувьд зүүнээс баруун тийш буюу Зүүн Сайханаас Нэмэгт хүртэлх чиглэлд умардын хүйтсэг ургамлын эзлэх хувь эрс багасаж бүр үгүй болдог бол энэ чиглэлд Төв Азийн цөлийн хуурайсаг төлөөлөгчид эрс нэмэгдцэг байна. Нөгөө талаар Зүүн Сайхан ууланд цогцолборт газрын нийт ургамлын аймгийн 70% (204 зүйл), Баруун Сайханд 52.2% (152 зүйл), Зөөлөнд 26.2% (76 зүйл), Нэмэгтэд 20.3% (68 зүйл) тус тус тархдаг (Л.Чимэдрэгзэн, 1997) байна. Иймд хээржүү Цөлийн дэд бүсэнд орших Гурвансайхан, Зөөлөнгийн нуруунд 2450 м-ээс дээш уулын хээр, 2200 (2300)-2400 (2500) м-т уулын хуурай хээр, 2000 (2100)-2200 (2300) м-т уулын цөлжүү хээр, 1800-2200 м-т уулын заримдаг цөлийн ландшафт тус тус тархдаг байна. Тэгвэл жинхэнэ цөлийн дэд бүсэд орших Нэмэгт, Гилбэнт зэрэг уулсад уулын хээрийн ландшафт огт ялгарахгүй бөгөөд уулсын ихэнхийг заримдаг цөлийн ландшафт эзэлнэ. Уулсын бэл, хормой бүхэлдээ жинхэнэ цөлийн ландшафттай.

Зураг № 3.3. Говийн Алтайн уулсын мужийн хөрс



Зураг № 3.4. Говийн Алтайн уулсын мужийн газар ашиглалт

3.2.2. Алтайн өвөр говийн цөлийн муж

Алтайн өвөр говийн цөлийн муж нь Баруун хуурайн хотгорын тойрог (Г-7), Алтайн өвөр говийн тойрог (Г-8) гэсэн 2 тойрогт хуваагдах бөгөөд тус аймгийн нутаг дэвсгэрт Г-8 тойрог л хамаарна.

Алтайн өвөр говийн тойрог /Г-8/ Гадаргын төрх байдлын хувьд Алтайн ар говьтой төстэй боловч нам уул нилээд байна. Нам уулсын хооронд ухаа гүвээт тал, цав толгод голлон орших ба тэдгээр нь говийн элэгдэлд орж хар бараан өнгөтэй болжээ. Энд жинхэнэ цөлийн ландшафт зонхилох тул элс, элсэн тарамцаг нилээн байна. Элсэн тарамцаг нь уулсын зах, хотгор газраар элбэг байх ба салхины үйл ажиллагаагаар ихээхэн хөдөлгөөнтэй байна. Энэ тойрог орон нутгийн чанартай тектоник хагарал нэн ихтэй эртний герциний бүтцэд багтана. Цав толгодын гадарга ихээхэн элэгдэж жинхэнэ сархиа үүсгэхээс гадна цав толгодын хоорондох бага шиг хотгороор дунд болоод шинэ төрмөлийн эриний сэвсгэр хурдас /элс, шавар, элсэнцэр/ тархах ба суурь чулуу ил гарах явдал олонтоо тохиолдоно. Түр зуурын хур борооны нөлөөгөөр үүссэн шугаман элэгдлийн ул мөр болох сайр хэдэн арван км үргэлжилнэ. Түүнчлэн нуур - алювийн болон дан бэлийн хурдаст тал газар нилээд түгээмэл байна. Алтайн өвөр говийн уулсын хамгийн том нь Аж богдын нуруу болно. Аж богдын нурууг Тамчын даваа орчмоос салбарладаг гэж үздэг. Аж Богдын бүлэг нуруу нь зүн урагш чиглэсэн бөгөөд хойд талдаа Хөвчийн нуруу, мөн талдаа жинхэнэ Аж богдын нуруунаас бүрэлдсэн байна. Хөвчийн нуруу нь Цагаан голын эхэн дэх Бугын давааны нам онь хөтлөөр гол нуруунаас тусгаарлагдсан байна. Түүний хамгийн өндөр цэг нь 3693 м байх бөгөөд Аж богдын ноён оргил Мөнх цаст уул

нь 3761 метр өндөр юм. Энэ хоёр уулын хооронд намхан боловч тодорхой харагдах “ Шар хөтөл” гэдэг онь орших бөгөөд түүний үнэмлэхүй өндөр нь 1725 метр байна.

Эдрэнгийн нурууг Аж богдын зүүн өмнөх үргэлжлэл гэж үзэж болно. Эдрэнгийн нуруу нь 250 км орчим урттай шулуун шугаман байдалтай үргэлжлэх бөгөөд уг суналын дагуу / Монгол Алтайн гол нуруутай зэрэгцээ оршиж / өөрийн салбар уулсаар дамжин Алтайн өмнөх говийн ухаа, гүвээнүүдэд тархана. Энэхүү нурууны хоёр талаар уулсын хоорондох говийн хотгорууд орших бөгөөд уулсын оргилуудын өндөр нь баруун талдаа 600 метр, зүүн талдаа 100- 200 метр нөдөр байна. Эдрэнгийн нуруу нь зүүн хэсэгтээ говийн олон тооны өндөрлөг толгод дотор тархаж замхрана. Эдрэнгийн нуруу нь ихээхэн эвдэгдсэн нуруу бөгөөд тус тусдаа орших уулс, далан зэрэгт тасарч хоорондоо нэгэн өндөр бэл, уулын хормойн налуу тавцангуудаар холбогдсон учир холоос харахад нэгэн бүтэн нуруу шиг үзэгдэнэ. Энэ нурууны хамгийн өндөр нь 2042 метрт хүрнэ.

Говийн Тэнгэр уулын нурууд зэрэгцээ хоёр эгнээ нуруунаас бүрэлдэнэ. Тэдгээрийн дотор Атас уул / 2702 м / уг эгнээний баруун захын уул гэж тооцогдоно. Түүнээс зүүн тийш 30 - аад км урт , 2100 гаруй метр өндөр Чингэс уул ойрхон оршино. Цаашлахад Зараа Хайрхан, Их Хавцгайн нуруу гэсэн хэдэн намхан шилүүд байдаг ба тэдгээрийн үнэмлэхүй өндөр 1500 - 1700 метр орчим юм. Хоёрдох эгнээ нь баруун хэсэгтээ 1600 - 1700 метр өндөртэй намхан шилийн байдалтай байснаа чиглэл нь өөрчлөгдөж зүүн урагшаа сунаж тогтсон Хөх Төмөртийн нуруунд шилжинэ. Тэр нуруу 2000 - аад метр хүртэл өргөгдсөн бөгөөд зүүн тийшээгээ хоёр салаалан урд талын салаа Хөх усны нурууны үргэлжлэл дээр Алтайн өмнөх говийн томхон уулын нэг Цагаан Богд уул оршино. Түүний гол оргил 2380 метр хүрдэг бол зэрэгцээ бусад хэдэн шил арай нам юм.

Хоёрдох эгнээ нуруудын урд талаар баруун хэсэгт нь урагшаа хэвгий бага шиг бэгэлцэг оршдог бөгөөд түүний урд захаар Булган хушуу, Хатан суудлын хяр зэрэг 1600 - 1750 метр өндөр бага нурууд байна. Эдгээрээс урагшаа Наран Сэвэстийн нуруу гэдэг 70 орчим км урт нуруу үргэлжлэх боловч харьцангуй өндөр нь 200 метр хүрэхгүй тул намхан юм.

Говь Тэнгэр уулын нурууд гадаргын дүрс хэлбэрийн хувьд Байтагийн бүлэг нуруудтай ойролцоо буюу эгц, чулуурхаг хажуутай, шовх орой хяртай бөгөөд нарийхан гүн хавцлаар зүсэгдсэн байна. Харин Атас, Цагаан Богд зэрэг томхон уулсын оройн хэсэгт эртний элэгдлийн гадарга хадгалагдаж оргилын орой тэгш хавтгай болжээ. Эндээс урагш Тост, Ноён уул зэрэг бага шиг уулс говийн Алтайн баруун урд төгсгөлд орших бөгөөд Алтайн цаадах говийн томхон уулт тарамцгийн нэг салбар юм. Эндэхийн уулсын гол онцлог бол түр урсгалтай хуурай сайраар гадарга нь нэн их хэрчигдэж бартаатай болсон явдал болно. Ялангуяа уулсын өмнөд хажуугаар сайр маш олноор үүссэн байх ба урт нь хэдэн арван км хүрнэ. Орон нутгийн чанартай тектоник хагарал элбэг учир уулсын төвөөс тал бүр тийш тархсан хөндийн маягийн хавцал нь дээрхи уулсын нэгэн адил түгээмэл юм.

Монгол Алтайн Аж Богдын нуруу, Говийн Тянь - Шаны нуруудын хооронд Хонин усны говь, Ажийн тал, Шар хоолойн тал, Хар сарын хөндий, Цэнхэрийн хоолой гэсэн нэртэй хэсэг хотгор үргэлжлэнэ. Эдгээр хотгор дотор цав толгод, жижиг шил тархсан

боловч Баруун хуурайн хотгорынхоос цөөн бөгөөд харьцангуй өндөр нь төдий л их биш юм. Жишээ нь: Арслан Хайрхан, Давхар Хар, Улаан гозгор, Загт сайрын хар, Өндөр гэх шилүүд 50- 100 метр орчмын харьцангуй өндөртэй байна. Нам газруудын үнэмлэхүй өндөр мөн янз бүр байна. Хамгийн нам түвшинд байгаа нь Цэнхэрийн хоолой болно /700м/. Тэдгээрийн гадарга чулуурхаг бөгөөд сайраар багагүй хэрчигдсэнээс гадна шал тойром цөөнгүй үзэгдэх ба 1500 метр хүртэл өндөршинэ.

Уур амьсгалын хувьд энэ мужийн уулс нь далайн түвшнээс дээш 1000 орчим метр өргөгдсөн, уулсын хоорондох хөндийд цөлийн шинж илүү тод илэрсэн харьцангуй дулаан, хур чийг хомс нутаг юм. Жилийн дундаж агаарын температур 2-6°C орчим байдаг. Харин Бага хуурайн тойрогт арай сэрүүвтэр 2-4°C орчим байна. 7 дугаар сарын дундаж температур +25°C орчим байдаг бөгөөд жилийн 60 гаруй хоногт нь агаарын температур 30°C-аас дээш гардаг. Хоногийн дундаж агаарын температур +10°C-ын заагийг 4 дүгээр сарын сүүлчээр давж дулааран 10 дугаар сарын эхний хагас хүртэл үргэлжилнэ. 10°C-аас дээших идэвхитэй температурын нийлбэр 2800° буюу Монгол орны хамгийн их дулаан хуримтлагддаг газарт хамаарна. Хаврын эцсийн цочир хүйтрэл 4 дүгээр сарын 27-ны үеэр тохиолдох бөгөөд намрын анхны хүйтрэл 10 дугаар сарын 1-ны үеэр ажиглагддаг. Намар орсон бороо нь ургамлын ургацыг тэтгэдэг бөгөөд орой сөл татардаг.

Хур тунадас туйлын бага, жилийн нийлбэр тунадасны хэмжээ дунджаар 50-60 мм, 80%-ийн хангамжтай жилийн нийлбэр тунадас 30 мм-ээс хэтэрдэггүй байна. Харин Монгол Алтайн нурууны өмнөх Баруун хуурайн хотгорын тойрогт хүйтэн улиралд орох цасны хэмжээ Алтайн өвөр говийнхоос арай ахиу 10 дугаар сард 4-6 мм хур тунадас унадаг (Алтайн өвөр говьд 2-4 мм), зарим жил нимгэн цасан бүрхүүл тогтдог зэргээс шалтгаалан арай сэрүүвтэр байдаг байна.

Ургамал нөмрөг. Ургамалжлын хувьд авч үзвэл зонхилох нь их сийрэг ургамлан бүрхэвчтэй чулуут цөлийн хэвшинжид хамаарна. Монгол-Алтайн нурууны өврийн 1500-1800 м өндөртэй хажууг дагаж цөлийн бор хөрстэй нарийн зурвас газраар хээржүү цөл тохиолдоно. Энд зонхилох хэвшинж нь сайрын хялгана, хөмүүл оролцсон баглуурт цөл байна. Үүнээс урагшлаад цөлийн бор саарал хөрстэй газраар (баруун хэсэгтээ 80-120 км, зүүн хэсэгтээ 150 км өргөн бүс үүсгэж) сөөгт жинхэнэ цөл тохиолдоно. Энд зонхилж загт, хармагт, хааяа хотирт буюу нохой шээрэнт, зээргэнэт цөлийн хэвшлүүд гол байрыг эзэлнэ. Толгод, бэсрэг уулсын хормойн талархаг газраар голдуу баглуурт, шар модот цөл тааралдана. Алтайн өвөр говийн өмнөх хэсгийг хамран тохиолдох хэт хуурай цөлд *Haloxylon ammodendron*, *Nitraria sphaerocarpa*, *Ephedra Przewalskii*, *Reaumuria soongarica*, *Ilijinia Regelii* голлож, хааяа *Zygophyllum xanthoxylon*, *Sympegma Regelii*, *Anabasis brevifolia* бага хэмжээгээр бүлгэмдэл үүсгэгчээр тохиолдоно. Энэ тойрогт нэг ч ургамалгүй, зөвхөн сайр дагасан цөөн хэдэн ургамал ургадаг үнэмлэхүй цөл ч багахан хэсэг газраар тааралдана. Өндөр уул, нуруудад бэл, хажуугийн доод хэсгээр эхлэн цөлийн, уулын хээрийн, бушилзын бүслүүр илэрнэ. Цөлийн бүслүүрт уулын хормойгоор нь шар модот, баглуурт жинхэнэ цөлийн хэвшил байснаа дээшлээд тэсэгт хээржүү цөл болж солигдоно. Уулын хээрийн бүслүүрийг өдлөг хялганат, ерхөгт ботуульт дэд бүслүүр,

бушилзын бүслүүрийг хээржүү бушилзат нуга, чийгжүү бушилзат болон хүйтсүү чулуусаг элдэв өвст нугын дэд бүслүүр гэж ялгаж болдог байна.

Энэ муж ургамлын зүйлийн бүрдлийн хувьд их ядмаг гэж үздэг. Хэрэг дээрээ Алашаа говиос арай илүү юм. Учир нь хэд хэдэн уул, бас баянбүрдтэй учраас нэг талаас Монголын говийн (*Haloxylon ammodendron*, *Zygophyllum xanthoxylon*, *Ephedra Przewalskii*, *Nitraria sphaerosarpa*), зүүнгар-умард говийн (*Reaumuria soongarica*) зүйлүүд зонхилогчийн үүрэгтэй тохиолдохоос гадна тухайн иж бүрдлийн зүйлүүд (баянбүрдийн ургамлууд: тоорой, *Sophora alopecuroides*, *Lycium ruthenicum*, *Sphaerophysa salsula*, урал чихэрөвс, *Cynanchum sibiricum*), Казакстан-Тураны (*Artemisia sublessingiana*) зүйлүүд байдаг юм.

Алтайн өвөр говийн муж Монгол улсын нутгийн 5.72%-ийг эзэлдэг нилээд сайн судлагдсан нутаг юм. Энд одоогоор 326 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 67 зүйл модлог сөөглөг (тойргийн ургамлын 20.56%), 259 зүйл өвслөг ургамал (79.44%) байна.

Модлог, сөөглөг ургамлын тоогоор Алашаа говь, Зүүнгарын говийн ойролцоо, заримдаг сөөг, сөөгөнцрийн тоогоороо Зүүнгарынхаас цөөн юм. Өвслөг ургамлынхаа тоогоор Дорноговь, Зүүнгарын тойрогтой ойролцоо байна. Экологийн бүлгүүдэд хувааснаас үзвэл :

- хуурайсаг ургамал 75 зүйл (23.01%)
- чийгсүү-хуурайсаг 25 зүйл (7.67%)
- хуурайсуу- чулуусаг 64 зүйл (19.63%)
- чийгсүү-чулуусаг 8 зүйл (2.45%)
- хүйтсүү-чулуусаг 1 зүйл (0.31%)
- давссаг 4 бүлгийн ургамал 97 зүйл (29.76%)
- элссэг 17 зүйл (5.21%)
- нуга, намгийн 33 зүйл (10.12%)
- усны 6 зүйл (1.84%) байна.

Эндээс харахад жинхэнэ цөлийн ургамлаас гадна баянбүрдийн ба уулын цөлийн ургамал чухал үүрэгтэй нь тодорхой юм.

Алтайн өвөр говийн тойргын баруун урд хэсэг Номин, Шаргын говийн хотгор сайр, чулуурхаг цөл бэлчээрт тохиромжгүй, 0.5-1.5 ц/га тэжээлийн нөөцтэй, 15- 20 кг/га тэжээлийн нэгжтэй. Тэмээнд тохиромжтой.

Тойргийн баруун хойт хэсгээр цөлийн бор саарал хөрстэй загт бэлчээр, цөлийн чулуурхаг бор саарал хөрстэй чулуурхаг бударганат бэлчээртэй, бог мал, тэмээнд тохиромжтой. 1.5-2 ц/га тэжээлийн нөөцтэй.

Тойргийн зүүн, зүүн өмнөд хэсгээр марзлаг бор саарал хөрстэй хармагт тал, хотгор газрын бэлчээр, цөлөрхөг хээрийн бор хөрстэй баглуур-жигжиг хялганат цөлөрхөг хээр, цөлийн хээрийн бэлчээртэй. 1.5-2 ц/га тэжээлийн нөөцтэй, 80-90кг/га нэгжтэй.

Хөрсөн бүрхэвч. Эндхийн хөрсөн бүрхэвчийн 90 гаруй %-д цөлийн болон уулын цөлөрхөг хээрийн, хээржүү цөлийн, толгодын бор саарал хөрс тархах ба шал, хад асга, элсэн хөрс 4 орчим хувийг эзэлж байна. Нам хотосуудаар жинхэнэ хужир хөрсүүд тархаж,

хотгорын захаар нугархаг, намгархаг хөрс тогтжээ. Энд элсэн хөрс мэр сэр тааралдах ба молцог элсний хэв шинжтэй.

Цөлийн бор саарал хөрсний ургамлан бүрхэвч маш сийрэг үүнээс шалтгаалан энэ хөрсний үржил шим, агро үйлдвэрлэлийн чадавхи үлэмж муу, усны элэгдлийн нөлөөгөөр гадарга нь ихээхэн атираажиж, өнгөндөө гандаасан хучаас тогтсон байдаг.

Хүснэгт № 3.4. Алтайн өвөр говийн цөлийн мужийн Г-8 тойргийн хөрсний нөөц

Д/д	Хөрсний нэр	Г-8	
		га	%
1	Нуур	3440.98	0.02
2	Уулын нугат хээрийн болон уулын нугын	14331.21	0.10
3	Өндөр уулын бүдүүн ялзмагт/ уулын нугат хээр	42395.50	0.30
4	Уулын хурай хээрийн бүдүүн ялзмагт/ уулын нугат хээр	4456.35	0.03
5	Уулын хүрэн /уулын хар хүрэн	101477.80	0.73
6	Уулын карбонаттай цавар хүрэн/ уулын нимгэн цавар хүрэн	166270.42	1.19
7	Уулын цөлөрхөг хээрийн нимгэн бор/сайрын	394504.87	2.82
8	Уулын хээржүү цөлийн нимгэн бор/сайрын	751473.50	5.37
9	Уулын хээржүү цөлийн нимгэн бор саарал/сайрын	333374.46	2.38
10	Толгодын цөлөрхөг хээрийн бор	29113.95	0.21
11	Толгодын хээржүү цөлийн бор/ хээржүү цөлийн нимгэн сайр чулуурхаг бор	156093.51	1.12
12	Толгодын бор саарал/нимгэн бор саарал	1712764.37	12.24
13	Цөлөрхөг хээрийн бор	27820.98	0.20
14	Цөлөрхөг хээрийн бор/ сайрын болон элсэн хучаастай бор		0.00
15	Цөлөрхөг хээрийн сайр чулуурхаг бор	21525.16	0.15
16	Хээржүү цөлийн бор/ хээржүү цөлийн сайр чулуурхаг бор	667112.54	4.77
17	Хээржүү цөлийн бор/ элсэн хучаастай бор болон хээржүү цөлийн мараалаг бор	180869.80	1.29
18	Хээржүү цөлийн мараалаг бор/ шалархуу болон хагас бэхэжсэн элс	22518.12	0.16
19	Хээржүү цөлийн гөлтгөнөт бор	54174.79	0.39
20	Элсэн хучаастай бор/ элсэн хучаастай сийрэг бор	199420.91	1.43
21	Цөлийн бор саарал/ мараалаг цөлийн бор саарал	321989.59	2.30
22	Цөлийн мараалаг бор саарал/ сайр чулуурхаг бор саарал	267328.53	1.91
23	Цөлийн гөлтгөнөт бор саарал/ мараалаг бор саарал	628424.32	4.49
24	Цөлийн гөлтгөнөт мараалаг бор саарал ба хужирлаг бор саарал	1564146.75	11.18
25	Цөлийн элсэн хучаастай бор саарал ба цөлийн гөлтгөнөт бор саарал	974924.84	6.97
26	Хэт хуурай цөлийн борзон/ шалархуу	2562141.57	18.32
27	Хэт хуурай цөлийн мараалаг борзон	146638.95	1.05
28	Сайрын болон цөлийн бор саарал	1139271.12	8.14
29	Сайрын болон хэт хуурай цөлийн бор саарал	989450.00	7.07
30	Нугын хужир /хужирлаг нуга	19922.47	0.14
31	Алловийн нугат намгийн/ Алловийн нугын хужирлаг		0.00
32	Алловийн нугын/ Алловийн нугын давсархаг	5098.59	0.04
33	Алловийн нугын хужирлаг ба Алловийнүелсэн тогтоцтой	3500.23	0.03
34	Хужир марааны бүрдэл	2872.33	0.02
35	Нугын иж бүрдэл	11512.51	0.08
36	Хужир болон хагас бэхэжсэн элс	174587.87	1.25
37	Шал шалархуу	12811.60	0.09
38	Шалархуу хагас бэхэжсэн элс	66601.17	0.48
39	Хагас бэхэжсэн элс	167538.57	1.20
40	Хөдөлгөөнт элс	45053.46	0.32
41	Хад асга	655.65	0.00
42	Мөнх цас мөсөн гол, эх чулуулгийн илэрц		0.00
	Дүн	13987609.34	100.00

Ан амьтан. Энэ мужид нийтдээ 5 ангийн 221 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 33.9 % нь оршин амьдардаг байна.

Хүснэгт № 3.5. Алтайн өвөр говийн цөлийн мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амтан	Бүгд
Баг	7	15	1	1	2	-	26
Овог	17	35	6	1	3		62
Зүйл	64 (46.0%)	133 (32.0%)	16 (76.1%)	2 (33.6%)	7 (4.1%)		222 (34.1%)

Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтанд бичив.

Дэлэнтэн. Энэ мужид 7 баг, 16 овгийн 64 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 46.0 % болж байна. Үүнээс далавчтан 7 /эндхийн дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 10.9 % /, туулайтан 3 /4.69 %/, мэрэгчтэн 33 /51.5 %/, махчтан 16 /25.0 %/, туурайтан 6 /9.3 %/ зүйл байна.

Энэ мужийн дэлэнтэн амьтдын үндсэн цөмийг Төв ба Дундад Азийн гаралтай говь, цөлийн зүйлүүд /дэлдэн зараа, сахалт багваахай, том соотон, хонгор бүрэнхийч, борхон тусаахай, говьсог сарсаахай, умардын сарсаахай, хожуу сарсаахай, дагуур огодой, үхэр огодой, боролзон туулай, гозоорой зурам, хул чичүүл, шаргал чичүүл, сухайн чичүүл, морин цөцүүл, орог зузга, элссэг зузга, бордуу шишүүхэй, бүрдийн шишүүхэй, хөх шишүүхэй, зээрд сохдой, хадны барагчин, хөхөвтө ов, шарга овол, тангад овол, гэрийн хулгана, шивэр алагдаага, давжаа алагдаага, Өмнөговийн алагдаага, говийн алагдаага, монголжин даахай, Зүүнгар даахай, элсний тажигдаахай, өөхлөг тажигдаахай, соотон алагдай, тавруу атигдаахай, элсч савгадаахай, мазаалай баавгай, хярс үнэг, шар үнэг, түвд үнэг, өмхий үен, эрээн хүрэн, мануул мий, цоохондой мий, хар сүүлтий, хулан адуу, хавтгай тэмээ, янгир ямаа, аргаль хонь г.м./ бүрдүүлдэг.

Энэ муж бол Монгол төдийгүй дэлхий дахинаа ховор, сонинд тооцогдох олон зүйл дэлэнтэн амьтдын унаган нутаг мөн. Одоогийн байдлаар ямар нэг хэмжээгээр ховордсон юмуу зөвхөн энэ мужийн нутаг дэвсгэрт тархсан дэлэнтэний 20 зүйл /гозоорой зурам, Азийн минж, ойн унтаахай, сухайн чичүүл, зүлгийн оготно, элсний тажигдаахай, өөхлөг тажигдаахай, соотон алагдай, тавруу атигдаахай, шарнад цөөвөр, мазаалай баавгай, цоохор ирвэс, цоохондой мий, шилүүс мий, мануул мий, хулан адуу, тахь адуу, хар сүүлтий, янгир ямаа, аргаль хонь/ энэ мужид тэмдэглэжээ. Энэ нь Монгол орны нийт дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 14.4 %, мужийн хэмжээнд авч үзвэл 31.2 %- ийг тус тус эзэлж байгаа юм. Эндээс үзвэл Алтайн өвөр говийн цөлийн муж нь дэлэнтний асар үнэ цэнэтэй генофондыг өдгөө хадгалан үлдсэн дэлхийн цөөн нутгийн нэг мөн. Эдгээрээс Азийн минж, ойн унтаахай, шарнад цөөвөр, мазаалай баавгай, цоохор ирвэс, цоохондой мий, шилүүс мий, мануул мий, хулан адуу, тахь адуу, хар сүүлтий, янгир ямаа, аргаль хонь зэрэг 13 зүйл амьтан хүний дамын болон шууд нөлөөнөөс /их төлөв агнуураас/ болж ховордсон ажээ. Бусад 7 зүйл нь байгалийн аясаар ховор тохиолдох амьтан болно.

Баруун хуурайн хотгорын ба Алтай өвөр говийн тойргууд нь дэлэнтэн амьтны зүйлийн бүрэлдэхүүнээр өөр хоорондоо нилээд ялгаатай. Тухайлбал гозоорой зурам,

азийн минж, ойн унтаахай, сухайн чичүүл зэрэг дэлэнтэн Монгол орны хувьд зөвхөн Баруун хуурайн хотгорын тойрогт оршин амьдардаг. Харин нэн ховор, ховорт тооцогддог Төв Азийн унаган амьтад болох элсний тажигдаахай, өөхлөг тажигдаахай, соотон алагдай, шарнад цөөвөр, мазаалай баавгай, тахь адуу зэрэг 6 зүйлийн дэлэнтэн зөвхөн Алтай өвөр говийн тойрогт тархжээ.

Баруун хуурайн хотгорын нутагт хамаарах Булган голын савын улсын хил орчмын багахан зурвас нутаг бол Монголд Азийн минж тархсан цорын ганц нутаг юм. /Их нуурын хотгорт нутагшуулсныг эс тооцвол/. Энд одоо 26 бүл, 104- ISO толгой минж байна. Булган голын эрэг дагуу хамгийн тохиромжтой хэсгийн 1-1.5 км тутамд нэг бүл байршдаг.

Мазаалай баавгай энэ зууны хорь, гучаад онд Алтайн өвөр говийн баруунтаа орших Аж богдын зүүн үзүүрээс зүүн зүгт Тост, Нэмэгт уул, хойшоо Ээж хайрхан, Захуй, Зармангийн баянбүрд, Эдрэнгийн нуруунаас өмнө зүгт улсын хил хуртэлх уудам нутагт тархаж байв. 1996 оны байдлаар, зүүнээ Сэгс Цагаан богд, баруунаа Баруун Тооройн нуруу, хойш Зараа, Буурын хар уулын хооронд буюу тархацынхаа тэн хагасаас бага нутагт тохиолдох төдий болжээ. Мазаалай баавгай одоогийн байдлаар Сэгс цагаан богд, Шар хулсны нуруу, Төмөртэйн хөх нуруу, Атас Ингэс уулын хавиар байршина. Шар хулс, Цагаан тохой, Цагаан бургас, Замын бэлгих, Хөшөөт зэрэг булаг шандын ойролцоох хад бартаат намхан уулсаар гүйдэлтэй. Зүүнээ Тост уул, баруунаа Майхан булаг, Хар хайрхан, хойшоо Эдрэнгийн нуруу хүртэл тохиолдлоор үзэгдэнэ. Жараад онд 15-20 толгой, далаад оны дундуур 20 гаруй, наяд оны эхээр 25-30, наяд оны сүүлээр 50-60, ерээд оны эхээр 30 гаруй толгой байжээ.

Шарнад цөөврийг дөчөөд онд Сэгс Цагаан Богд, Эдрэнгийн нуруу, Суман хаданд үзсэн мэдээ байдаг. Сэгс Цагаан Богдод 1967 онд хэд хэдэн удаа үзэгдсэн гэснээс өөр шарнад цөөврийг Алтай өвөр говийн тойрогт үзсэн, олдсон тухай үнэмшилтэй мэдээ байхгүй.

Алтайн өвөр говийн тойргийн Захуй, Зарман, Зуун мод, Зулганай, Шар хулс, Ламын тоорой, Нарийн тооройн булаг, Долооны хоолой, Бутлуур тоорой, Эхийн гол зэрэг газраар цоохондой мий /*Felis lybica*/ тархсан ажээ. Захуйн баян бүрдийн орчим хийсэн судалгаагаар 24 км² талбайд 4-5 цоохондой мий ноогдох нягтшилтай байна /Мөнхцаг нар, 2002/.

Алтайн өвөр говийн цөлийн мужийн хоёр үндсэн тойргийн нутаг дэвсгэрт хулан адуу харьцангуй өргөн тархалттай бөгөөд байнга нутагшин амьдрана. Баруун хуурайн хотгорын тойрог буюу Говийн шим мандлын дархан газрын “Б” хэсэгт 1500 толгой, Алтайн өвөр говийн тойрог буюу тус дархан газрын “А” хэсэгт 500 толгой хулан бий гэж үздэг.

Хавтгай тэмээний /*Camelus bactrianus ferus*/ тархац сүүлийн 40 жилд эрс хумигдан, өдгөө Эдрэнгийн нурууны өвөр бэлээс урагш, баруунаа Шивээт улаан, зүүнээ Хөх төмөртийн нуруу, урагшаа улсын хилийн хооронд 30 мянган ам. км нутагт тохиолдоно. Судалгааны дүнгээс үзвэл хавтгай тэмээ 1943 онд хамгийн цөөн буюу 300, 1959-1960 онд 400-500, 1974 онд 900 орчим болжээ. 1975-1976 оны судалгаагаар 400, 1980-1982 онд 500-

800 толгой байв. 1982- 1989 онд жил бүр нөөцийн үнэлгээ тогтоосноос үзэхэд, 555-480 байснаа, сүүлийн дөрвөн жилд улам цөөрч, 1993 оны байдлаар 320 болсон мэдээтэй байна.

Баруун хуурайн хотгорын тойрог буюу Говийн шим мандлын дархан газрын “Б” хэсгийн 580.7 км², Алтайн өвөр говийн тойрог буюу тус дархан газрын ”А” хэсгийн 2937,5 км² талбайд тус тус аргаль хонь нутагшин амьдардаг.

Хар сүүлтий нь Алтайн өвөр говийн цөлийн мужид өргөн тархсан туурайтан юм/. Энэ зүйл Алтайн өвөр говийн тойрогт Бага Богдын зүүн үзүүрээс Говийн Алтай, Монгол Алтайн нурууны өмнө тулах бэлээр Хөвчийн нуруу хүртэл үргэлжилж, Зүүн гарын говийг хамран Булган гол, улсын хил хүртэлхи нутагт тархсан. Энэ зааг хязгаар нь ялангуяа тухайн жилийн цаг уур, хүний үйл ажиллагаанаас шууд шалтгаалан 50-100 км-ийн хэлбэлзлэлтэй байдаг. Дэлхэц нутгийн доторхи Аж богд, Атас, Ингэс, Цагаан богд, Нэмэхт, Гост, Говийн Алтайн нуруу, Арц Богд, Гурван сайхан, Зөөлөнгийн нуруу, Хөрхийн нурууны салбар уулсын байц хад, өндөр уулсаар байршдаггүй. Зүүн гарын говьд 1000 га-д 0.3-9.3 толгой нягтшилтай 12.0 мянга, Аж Богдын ар, өвөр говь, Эдрэнгийн нуруу, Захуй Зармангийн говьд 1000 га-д 0.2-9.1 толгой ногдох 10.0 мянга, Алтайн өмнөх говьд 1000 га-д (ГИДГ-ын "А" хэсэг) 0.1-4.0 толгой ногдох 2.4 мянган толгой хар сүүлтий бий гэж үздэг /Амгалан, 2000/.

Шувуу. Энэ мужийн нутаг дэвсгэрт нийт 15 баг, 35 овгийн 133 зүйл шувуу бүртгэгдсэн байна. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлнэ /71 зүйл буюу энэ мужийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 53.3 %/. Энэ мужид шонхор хэлбэртний багаас 23 зүйл /17.3%/, хөгчүү хэлбэртний багийн 16 зүйл /12.0 %/, галуу хэлбэртний 6 зүйл /4.5 %/ тус тус оршин амьдарна. Тус мужийн Баруун хуурайн хотгорын тойргийн Булган, Үенч, Бодонч голын сав нутаг нь нүүдлийн шувуудын дайрч өнгөрөх, зусч өндөглөх нэг түшиц газар учир ялангуяа ус намгийн амьдралтай шувуудын зүйлийн бүрэлдэхүүнээр Алтайн өвөр говийн тойргоос илүү баялаг.

Ан агнуурын тухай Монгол улсын хууль, тогтоомж, Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг Олон улсад худалдаалах тухай конвенцийн 1.2-р хавсралт, Монгол улсын ба Байгаль хамгаалах Олон улсын холбооны Улаан номонд орох зэргээр эрх зүйн хувьд ямар нэг хэмжээгээр хамгаалатанд авсан 27 зүйл шувуу /гангар хун, явлаг сар, сохор элээ, саарал цагаан элэгт, морин харцгай, шилийн сар, тарважи бүргэд, хан бүргэд, цармын бүргэд, ёл, дэлт бүргэд, ухаа хажир бүргэд, тас, идлэг шонхор, эгэл шонхор, шууман шонхор, хайргууна шонхор, начин шонхор, алтайн хойлог, жороо тоодог, хүүрзгэнэ, шар шувуу, орволоого ууль, савагт ууль, хотны бүгээхэй, хулан жороо, уран шувуу тус мужийн нутаг дэвсгэрт оршин амьдардаг.

Мөлхөгчид. Алтайн өвөр говийн цөл нутаг нь мөлхөгчдийн зүйлийн бүрэлдэхүүнээр хамгийн баялаг муж болно. Энд 6 овгийн 16 зүйл буюу манай орны мөлхөгчдийн зүйлийн бүрэлдэхүүний 76.1 % нь тэмдэглэгджээ. Мужийн хоёр тойрог мөлхөгчдийн зүйлийн бүрэлдэхүүнээр өөр хоорондоо нилээд ялгаатай. Тухайлбал Баруун хуурайн хотгорын тойрогт тойрмын хонин гүрвэл, толбот гүрвэл зэрэг Дундат Азийн

гаралтай зүйлүүд бий. Харин Алтайн өвөр говийн тойрогт говийн махир хуруут гүрвэл, нохой гүрвэл, говийн гүрвэл, загалт гүрвэл, монгол гүрвэл, тэмээн сүүл могой, нарийн могой зэрэг жинхэнэ Төв Азийн цөлийн гаралтай амьтад оршин амьдардагаараа өмнө дурьдсан тойргоос ялгаатай. Харин цоохор хонин гүрвэл, төмөр гүрвэл, замба гүрвэл, могой гүрвэл, рашааны могой, сум могой, бамбай хоншоорт могой нь тус мужийн 2 тойргийн нутаг дэвсгэрт нийтлэг тархсан зүйлүүд болно. Говийн махир хуруут гүрвэл, тойрмын хонин гүрвэл, толбот гүрвэл, тэмээн сүүл могой, нарийн могой зэрэг зүйлүүд нь Монгол улсын Улаан номонд орсон ховор амьтад юм. Мөн тэмээн сүүл могой Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн 2-р хавсралтанд орсон байдаг.

Хоёр нутагтан. Алтайн өвөр говийн тойргийн нутагт багтах Төхөмийн нуур, Захуй-Зармангийн баян бүрд, Хонгорын гол, Сэрүүн булаг, Эхэн задгай зэрэг газруудад монгол бах оршин амьдарна. Баруун хуурайн хотгорын тойргийн Булган, Үенч голын сав, Зүүнгарын говийн зарим баян бүрдээр ногоон бах тархжээ.

Загас. Энэ мужийн Баруун хуурайн хотгорын тойргийн голд 2 баг, 3 овгийн 7 зүйл загас тархжээ. Энэ нь манай орны загасны нийт зүйлийн бүрэлдэхүүний 4.1 % болно. Эдгээрээс 3 зүйл загас нь /шивэр сугас, шар хэлтэг, алгана/ агнуурын ач холбогдолтой. Загасны дийлэнх зүйлүүд Булган голд байдаг. Харин Алтайн өвөр говийн тойрог үндсэндээ загасгүй юм.

Ландшафтын онцлог. Баруун хуурай нь эрт төрмөлийн эриний дунд үед тогтсон синклиналь хотгор юм. Энэ бүсэд эрт төрмөлийн эртний үеийн атриат суурь дээр девоны галавын бялхмал чулуулгийн давхарга, карбоны эх газрын хурдас тус тус нийцээгүй байдалтайгаар оршино.

Энэ хотгорын төв нь Үенч, Бодонч голуудын адагт орших далайн төвшнөөс дээш 1050-1100 метрийн үнэмлэхүй өндөртэй хужир мараат гадарга юм. Уг хотгорт Шарын хотгорынх шиг уулын хормойгоос аажим намссан хэвгий бэл төдий л хөгжөөгүй байна. Гэхдээ хотгорын төвөөс алсад орших том нуруудын хормой хүртэл ландшафтын босоо бүсшил тод илэрдэг. Хотгорын төв хэсэгт орших хужир мараат ландшафт Шарын хотгорыг бодвол хавьгүй том талбайг эзлэх ажээ. Хужир мараат ландшафтын дунд худаг, булаг шандын аль нь ч үгүй боловч Үенч, Бодонч голууд уг хотгорын зах руу ирж замхрах тул үүний нөлөөгөөр ургамал бүрхэвч сайтай байдаг. Гэхдээ уг хотгорын дотоод хэсгүүд хоорондоо нэлээд ялгаатай юм. Үенч, Бодонч голуудын адгаар элсэн хуримтлал мэр сэр бий. Энд бүрхэвч ба молцог элсний хэв шинж зонхилно. Эдгээрээс Халзан уулын өвөр хэсгийн элс, Бодонч голын адгийн элс, Луудай худгийн элс нэлээд том талбайг эзлэх ажээ.

Хужир мараат хотгорыг тойроод хэт хуурай цөлийн ландшафт тархсан байна. Энэ бол хөрс, ургамалжилтын хувьд ландшафтын биеэ даасан дэд хэвшинжийг үүсгэнэ. Цөлийн бор саарал хөрстэй Туран-Зүүнгарын цөлийн үетэн-заримдаг сөөгөнцөрт ургамалшил бүхий өмнөд цөлийн ландшафт уг хотгорын төвийг эргэн тойрон бүсэлж оршино. Хотгорын хамгийн өндөрлөг хэсэг болон уулын доод хажуу бэл хормойгоор Туран-Зүүнгарын ургамал ургасан умард цөлийн ландшафт бүрэлдэн тогтжээ.

Алтайн өвөр говийн тойрог (Г-8)-т Алтайн нурууны өвөр бэлээс улсын хил хүртэл үргэлжлэх уудам нутаг бөгөөд баруун талдаа Говь хонин уснаас зүүн үзүүр нь Борзон говь хүрнэ. Энэ нь монголын хамгийн эзгүй зэлүүд бөгөөд ус, ундаагаар ховор, хүрэлцэн очиход бэрхшээлтэй бөглүү цөл нутаг юм.

Хотгор гүдгэрийн хувьд энэ нь хад чулуурхаг уулс, түүний уудам бэл, тэдгээрийг тусгаарлан орших хотгоруудаас бүрдэх өвөрмөц нутаг юм. Иймд тус мужийн баруун хэсэгт Аж Богд; Эдрэнгийн нуруу, Суман хайрхан, Атас богд, Чингис богд зэрэг дундаж, нам уулс, Алаг нуурын хотгор, Захуй, Зарман, Номин, Шаргын говь зэрэг хотгорууд дараалан орших ажээ. Энэ хэсэгт хамгийн өндөр Атас богд уул 1700 м хүрдэг бол нам цэг нь 700 м-т оршино. Эдгээр уул нурууд нь цөлийн төрх байдалтай. Маш их асга хадархаг, хэрчигдэж зүсэгдсэн, хад чулуунууд нь цөлийн наранд түлэгдэж харласан байна. Уулсын хормой асар зузаан бэлийн хурдсанд шигдэн орсон байдаг.

Алтайн өвөр говь нь монгол орны хамгийн хуурай нутаг болно. Жилд дунджаар 20-75 мм хур тунадас унах ба зарим жил огт хур тунадас унадаггүй. Зуны улирал маш халуун, 7 сарын үнэмлэхүй их температур 40°C, хөрсний гадаргад 60°C хүрдэг. Ууршилт асар их. Гадаргын ус ховор тул газар доорх усны ач холбогдол нэн их. Захуй, Зарман, Нарийн тооройн баянбүрд хүн малын хэрэгцээнд, Талын мэлтэс, Цагаан бургас, Шар хулс зэрэг баянбүрд нь зэрлэг амьтны усан хангамжид зориулагдан ашиглагдаж байдаг.

Алтайн өвөр говьд уур амьсгалын нөхцлөөс шалтгаалан хөрсөн бүрхэвч бараг тогтоогүй. Ялангуяа Эдрэнгийн нуруунаас урагших хэсэгт хэт хуурай цөлийн борзон хөрс тархана. Хөрсний гадарга сайраар их хэрчигдсэнээс гадна гөлтгөнө ихтэй болж сэвсгэр бамбалзуур төрх байдалтай болдог. Түүнээс гадна хөрсний гадаргууг цөлийн наранд түлэгдсэн гялалзсан хар хайрга чулуу энд тэндгүй битүү хуяг хучигдсан байдаг.


Ургамалжилтын хувьд туйлын ядуу. Зөвхөн нутгийн хойт хэсгээр буюу Алтайн нурууны өвөр хил залгаа нутгаар баглуурт цөл түүнээс урагших нутгаар сийрэг бут сөөгтэй чулуут цөл ноёрхоно. Хамгийн үржил шимгүй хотгор, хоолойгоор Төв Азийн цөлийн өвөрмөц ургамлууд хүртэл хатуу ширүүн нөхцөл даахаа больж дан ганц нэг наст ургамал-хуш хамхаг зонхилсон цөлөөр солигдоно. Мөн энд огт ургамалгүй уудам нутаг ч байдаг. Баянбүрдийн орчим нутаг нь марцлаг нуга түүнийг хүрээлсэн заг, сухай, хармаг, дэрст, элсэн хуримтлал, тооройн төгөлөөс бүрдэнэ.

Алтайн өвөр говийн зүүн хойт хэсэг нь Ингэн хөөврийн хотгор бөгөөд эндхийн ус цуглуулах талбайн төгсгөл нь болдог. Иймд Ингэн хөөврийн хотгор нь далайн түвшнээс дээш 696 м өндөр өргөгдсөн манай орны 2 дахь нам цэг юм.

Ногоон цав, Гурилын говь, Ингэн хөөврийн хотгор нь цэрдийн галавын үед далай, тэнгис байсан өвөрмөц орчин учраас хурдас чулуулагт нь янз бүрийн өнгийн элсэнцэр, элсэн чулуу, наанги шаварлаг хурдсын зузаалаг голлоно. Энэ нь орчин үед цөлийн гандуу хуурай уур амьсгалын нөлөөгөөр элэгдэн эвдэрч явар цонж, элдэв сонин дүрс, гуу жалга, ганга зэрэг мөргөцгийг үүсгэсэн нь олонтой. Нөгөө талаар гадарга нь өндөрлөг цэгүүдээс буусан хуурай сайруудад түмэнтэй хэрчигдэж улам бартаажсаны зэрэгцээ цөлийн

гандааст автаж хар өнгөтэй болсон хайрга, чулуугаар бүрхмэл юм. Иймд энэ нутаг нь Алтайн өвөр говийн чулуут цөл / гаммада I- ийн зүүн төгсгөл хэсэг болно.

Баянбүрдийн ландшафт нь ихэвчлэн тоорой, жигдийн төгөл ой, зэгс, сухайн ширэнгийг молцог элс, нүцгэн манхан тойрон хүрээлж орших тул ландшафтын эмзэг хослолоос бүрдэх өвөрмөц орчныг үүсгэдэг Баянбүрдүүд нь Алтайн өвөр говийн цөл нутагт ус булаг ундарч, ургамал мод дэлгэрч, ан амьтан цугласан өвөрмөц орчныг бүрдүүлж байдаг. Тэдгээрийг дурьдвал Говь Хонин ус, Элгэн, Элст мянган, Хадат мянган, Захуй, Зарман, Замын билгэх, Шар хулс, Цагаан бургас, Лам нарын тоорой, Хатан суудал, Цагаан булаг, Эхийн гол, Талын билгэх, Зуунмод, Өлзийт, Хуцын шанд, Зулганай, Наран даац, Хөвд, Хуршууд, Эрдэнэбулаг, Баянбулаг зэрэг болно.



Зураг № 3.7. Алтайн өвөр говийн цөлийн мужийн газар ашиглалт

3.2.3. Дорнод говийн цөлөрхөг муж

Дорнод говийн цөлөрхөг муж нь Дорнод говийн хойт хэсгийн тойрог (Г-9), Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог (Г-10) гэсэн 2 тойрогт хуваагдана.

Гадаргын хувьд ухаа гүвээт тал, цав толгод, хотгор нам газар гол суурийг эзлэх бөгөөд говийн зүүн хэсэгт байгаа уулс харьцангуй намхан, өндөр нь 1300-1800 метрээс үл хэтэрнэ.

Дорнод говийн хойт хэсгийн тойрог / Г — 9 / нь баруун талдаа Говийн Алтайн Хүрх, Гурван Богдын нурууд, Нууруудын хөндий, хойт ба зүүн хойт талдаа Монголын дорнод талаар хүрээлэгдэн урд тал нь улсын хилтэй нийлнэ.

Гадаргын тогтоцын хувьд Дорнод говь нь Алтайн өмнөх болон ар говиос ялгаатай, харин Монголын дорнод талтай төстэй гэж болно. Учир нь ухаа гүвээт тал ихэнх нутгийг эзлэнэ. Ийм тал говийн бүсийн хойт ихэнх хагасыг хамрахын зэрэгцээ өмнөд хагаст ч дайралдана. Маш налуу хажуутай, ил гарсан хад чулуу бараг байхгүй ухаа гүвээний хооронд их, бага янз бүрийн хэмжээтэй хотос, тал газар байх бөгөөд түүнд хужир марц цөөнгүй тохиолдоно. Зарим хотос хэдэн арав буюу зуун хавтгай дөрвөлжин км талбайтай байна. Жишээ нь: Мандалговиос баруун урагших Тугалын бүлээний говь, зүүн тийших Сумангийн говь, урагших Хайрхан говь гэх мэт хотос тийм томхон хэмжээтэй байдаг. Ийм ухаа гүвээт талын дунд энд тэнд ганц нэг буюу хэсэг толгод товойж харагдана. Тэдгээрийн хажуу бэл голдуу налуу мөлгөр боловч хааяа эгц бөгөөд хадархаг хажуутай толгод байдаг. Зарим толгод оорцог уулын байдалтай ч байна. Тийм уулс ихэвчлэн боржин болон боржингийн төрлийн чулуулгаас тогтсон бүтэцтэй байна.

Дорнод говийн хотгор / депресси / нь Дорноговь аймгийн төв Сайншандаас баруун урагш Өлгий хийдийг дамжин түүнээс цааш 100 км үргэлжлэх урт хотгор юм. Энэхүү хотгор нь 106- 108 градусын уртрагийн хооронд Дорнод Монгол руу орно. Тус хотгор нь нэг тийш налуу биш, харин тусгаар салангид орших хэд хэдэн нам газарт хувиарлагдах тул тэдгээрийн төв рүү чиглэсэн налуутай байна. Хотгорын үнэмлэхүй өндөр нь 700 - 1000 метр юм. Түүний ёроол нь зарим газар бүрмөсөн нүцгэн , заримдаа заг, бударгана бүхий хужир бүрд болон тойрмуудтай байна. Мөн ургамлаар бэхлэгдсэн элс, бага хэмжээний жижиг толгод болон үлдэгдэл толгойнуудтай хэсэг газар тохиолдоно. Хамгийн нам газруудад нь жижиг нуурууд үзэгдэнэ.

Дорнод хотгор / депресси / газар нь Дундад Халхын ухаа гүвээ толгодот тал газрын зүүн хагасаас урагш орших бөгөөд хаана ч хялбар танигдах 250 км газар зүүн хойшоо сунасан асар том хотгор юм. Түүний баруун үзүүр нь говийн Сайн усны хотгорт, зүүн үзүүр нь Чойбалсан хотоос ураг орших давст нуур хүрнэ. Дорнод хотгор нь зүүн хойшоо бага зэрэг налуу боловч 830 - 1000 метрийн үнэмлэхүй өндөртэй тус тусдаа орших хэд хэдэн хотгорт хуваагдана. Тэдгээр нь 50 - 100 метрийн харьцангуй өндөртэй ажээ. Дүгнэж үзэхэд дорнод хотгорын дундаж үнэмлэхүй өндөр нь 700- 1000 метр байх бөгөөд харин эргэн тойрны болон ойр орших өндөрлөгүүд нь 1100 - 1200 метрийн өндөртэй байна. Хотгорын өргөн нь ёроолоороо 10- 20 км байна. Элс нь хотгорын ёроолд жижиг арал

байдлаар орших боловч гол төлөв Байшинтын орчмынх шиг хотгорын хажуу бэлээр байдаг байна. Нуурууд нь давстай, дийлэнх нь бүлэг бүлгээр орших боловч цөмөөрөө маш гүйхэн, талбай багатай байна. Нутгийн ардууд говийн хотгорыг хэсэг хэсэгт нь өөр өөрөөр нэрлэх бөгөөд тухайлбал: Далан түрүүний говь, Дулаан харын говь, Үнэгэн тойром, Хятад улстай хил залгаа хэсгүүдийг Галбын говь, Дайчингийн говь гэнэ.

Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог / Г-10/-т уул, толгод нилээн түгээмэл юм. Ялангуяа Говийн Алтайн нурууны орчим уул нилээд байна. Тэндэх уулс нийт Монгол орны уул нуруудын байрлалыг дагаж бараг өргөрөгийн дагуу сунаж тогтсон бол зүүн тийшээгээ баруун урдаас зүүн хойшоо суналтай байна. Говийн Алтайн нурууны ойролцоох уулсыг авч үзвэл хамгийн хойд талд Дэлгэр Хангайн уул оршино. 1913 метр өндөртэй энэ уул богино нурууны байдалтай, хад чулуу элбэгтэй, эгц хажуутай байх бөгөөд гуу жалгаар багагүй хэрчигдсэн байна. Түүнээс урагших Тахилга уул, Хан уул, Цэцэй, Их шанхай зэрэг 1700- 1800 гаруй метр өндөртэй уулс нь төрх байдлын хувьд Дэлгэрхангай уултай төстэй байна. Их шанхай уул орчмын нам уулс, цав толгодын онцлог нь гадаад хүчний үйл явцад ихээхэн элэгдсэнд оршино. Энд түр урсгалтай сайр гадаргыг хэрчиж бартаа үүсгэсний дээр элэгдлийн улмаас үүссэн аараг нилээд түгээмэл юм. Нам уулс, цав толгод зүүн хойш намссаар талархаг буюу хужир марцат хотгоруудад шилжин түүний бэлээр цэрдийн болон гуравдагч галавын элсэнцэр хурдас тархаж, цав толгод зүүн хойш суналтай нэгэн суурь бүхий дэл үүсгэж тогтсон нь олонтой тохиолдоно. Эндээс урагшилбал Могойт, Хан Богд гэх мэт бага шиг уулс байдаг. Тэдгээрийн өндөр нь 1300 метр байдгаас үзэхэд уулс ер нь хойноосоо урагшаа намсдаг ажээ. Дурдсан уулсаас зүүн тийш томхон гэж үзэж болох уулс нь зөвхөн улсын хилд ойролцоо нарийн зурвас газарт төвлөрнө. Тэнд Их Хөвсгөл, Хутаг, Цант зэрэг 1000 - 1400 гаруй метр өндөртэй хэд хэдэн уул тодорхой харагдана. Хутаг уулнаас зүүн хойш Цант уул хүртэл 1200 - гаад метрийн өндөртэй хэд хэдэн уулс оршиж нийлээд үргэлжилсэн шилийг үүсгэнэ. Түүнийг газарзүй, геологийн зарим бүтээлд “Тото - Шаны нуруу” гэж нэрлэсэн ч явдал бий. Энэ уулс хад чулуутай боловч хажуу нь төдий л эгц биш, харин хуурай сайр, гуу жалгаар ихэд хэрчигдсэн байдаг. Дурдсан гол гол уулын орчин тойронд цав толгод тогтсон бөгөөд зарим нь уулсын чиглэлийг дагаж оршсон намхан шилийг бий болгожээ. Толгодын өндөр хойт хэсэгтээ 1200 - 1400 - гаад метр бол урд хэсэгт 900- 1200 орчим метрээс үл хэтрэнэ. Үүнд жишээ болгож Замын - Үүдийн талархуу газрыг дурьдаж болох юм.

Замын - Үүдийн талархуу газар нь Монгол улсын говийн бүсийн хамгийн зүүн урд өнцөгт Замын - Үүдээс эхлэн, өвөр Монголтой залгах хилийн дагуу Номгон уул ба Агуйн сүм хүртэл сунаж оршино. Энэ газрын үнэмлэхүй өндөр нь 1000 - 1400 метр, дундажаар 1000 - 1200 метр байна. Энд жижиг толгод ба гуу жалга элбэгтэй байхаас гадна ухаа гүвээ болсон тал газрууд дийлэнхи байдаг. Ийм тал газрууд нь Замын - Үүд орох их замын орчим улам их болно. Энд мөн эвдлэгдэж тэгширсэн өндөрлөгүүд ч цөөнгүй юм. Уулархаг үндсэн газар нь Хатанбулаг сумаас урагш орших хярууд болно. Түүний хажуу бэлүүд нь эгц биш боловч сайр элбэгтэй. Мөн хад цохио ч олонтоо тааралдана. Тус хярыг хэсэг хэсэг элс хүрээлж орших бөгөөд харин өмнө хэсэгт хилийн орчимд түр зуурын нуурууд бүхий

хужир бүрд, тойромууд байдаг. Энэхүү талархуу газрын цөлөрхөг уур амьсгал болон хүчтэй эвдлэл нь уг нутагт чулуурхаг гадарга бүрдүүлээд зогсохгүй нилээд томхон элсэн тарамцагуудыг үүсгэжээ.

Дорнод говийн цөлөрхөг мужид ухаа гүвээт тал дундах жижиг хотсоос гадна том хэмжээний хотгорууд хотгор гүдгэрт нь чухал суурийг эзэлнэ. Тийм хотгор дорнод говийн зүүн хагаст голчлон оршихдоо нийтдээ зүүн хойноос баруун урагш сунаж тогтсон байна. Түүний ёроол тэгш биш, хэд хэдэн чиглэлд хэвгий учир хоёрдугаар зэргийн хотгорууд бий болно. Хотгорын хажуу нилээн налуу боловч гуу жалгаар хэрчигдэж зарим газарт нь бяцхан оорцог дов, толгод ч үзэгдэнэ. Хоёрдугаар зэргийн хотгоруудын ёроол төв хэсэг рүүгээ хэвлийгээс гадна гадаргад нь бас жижиг гүвээ, толгод хааяа илэрсэн байна. Элс энд тэнд тархана. Хамгийн нам дор газрууддаа бага хэмжээний нуур, хужир марц, шал тойром тогтсон байна.

Уур амьсгалын хувьд энэ мужид жилийн дундаж агаарын температур 2- 4°C орчим байна. Мужийн хойд хэсгээр арай сэрүүн, 2°C байдаг бол өмнө талдаа 4°C ба түүнээс их байна. 7 дугаар сарын дундаж агаарын температур 21.4-22°C, зуны хамгийн их температур 30°C-аас дээш байх өдрийн тоо 24-26 байна. Хавар дунджаар 5 дугаар сарын 10-даар цочир хүйтрэл дуусч, намар 9 дүгээр сарын 25-дын үеэр анхны цочир хүйтрэл болж эхэлнэ. Ийнхүү хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 130 гаруй хоног байна. +10°C-аас дээших идэвхитэй температурын нийлбэр дунджаар 2500с'С байдаг. 1 дүгээр сарын дундаж агаарын температур -16 -18°C орчим байна. Жилийн нийлбэр тунадасны хэмжээ 100-120 мм, үүнээс дулааны улиралд ихэнх нь унана. Дулааны улиралд арав хоног тутам харьцангуй чийгшил 30% ба түүнээс доош байх өдрийн тоо 4-7 өдөр буюу дулааны улирлын нийт хоногийн 50%-д нь хуурай байдаг учир ууршил их явагдах нөхцөлтэй. Дорнод говийн өмнөд тойрог нь нэг өргөрөгт орших цөлийн бусад тойргоос хур тунадас арай ахиу ордог тул бэлчээрийн ургамлын ургац бага зэрэг илүү байдаг. Энэ мужид ургамлын ургах дулааны хангамж сайтай боловч хур чийг дутмаг тул тариалан эрхлэхэд нэн хүндрэлтэй. Зайлшгүй усалгаа хийх шаардлагатай. Энэ зорилгоор булаг, шанд, борооны усыг усалгаанд зориулан ашиглах нь зүйтэй юм.

Ургамлан нөмрөг. Дорноговийн муж ургамалжилтын хувьд тачирхан, сийрэг ургамалтай, өдлөг хялгана-таанат, өдлөг хялгана-боролзойт хээр зонхилно. Шавранцар-хайргархаг, бэлээр баглуурт, бор бударганаас гадна хайргархаг- элсэнцэр хөрстэй газраар нь, ялангуяа өмнөд хэсгийн нутгаар хойргот, тостот, модлог бударганат, тэсэгт цөл зонхилно. Элсэрхэг хөрстэй газраараа сийрэгхэн загийн шугуйтай, эсвэл харгана-шавагт эвшил тааралдана. Шаварлаг марцлаг хотгоруудад гоолиг шар бударгана, Зүүнгарын улаан бударгана, эсвэл луулийн овгийн нэг наст ургамлууд оролцсон эвшлүүд тохиолдоно. Энэ мужийн нутгуудаас Баянзагийн хотгор бол Монголын цөлөрхөг хээр дэх өвөрмөц газрын нэг бөгөөд тэнд говийн бараг бүх элементүүд хуран цуглажээ. Дорноговийн тойрогт Монгол улсын нутаг дэвсгэрийн 9.35%-ийг эзэлнэ. Энд одоогоор 327 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 68 зүйл (мужийн ургамлын 20.8%) модлог, сөөглөг ургамал, 259 зүйл өвслөг (79.2%) ургамал байна. Энэ задлагаас үзэхэд мод, том

сөөг тун цөөн: харин ердийн сөөг, сөөгөнцөр, заримдаг сөөг, сөөгөнцөр бусад өвслөг ургамлынхаа зүйлийн тоогоор Алтайн өвөр говийн мужтай тун ойролцоо юм. Ургамлын экологийн үндсэн бүлгүүдийг авч үзвэл:

- хуурайсаг ургамал 70 зүйл (21.41 %),
- давссаг 4 бүлгийн 64 зүйл ургамал (19.57%),
- элссэг 20 зүйл ургамал (10.93%)
- хуурайсуу-чийгсэг 35 зүйл ургамал (10.7%)
- чийгсэг 24 зүйл ургамал (7.34%)
- хуурайсуу-намагсаг 6 зүйл ургамал (1.84%)

Харин ус, намгийн ба хүйтсэг ургамал байдаггүй. Их хуурай халуун болон давсархаг марцлаг газарт зохилдсон ургамлууд ургамлын нөмрөгт голлох үүрэг гүйцэтгэнэ.

Дорнод говийн хойт хэсгийн тойргийн бүх нутаг нь нэлэнхүйдээ цөлөрхөг хээр, цөлийн хээрийн нунтаг карбонатлаг цайвар хүрэн хөрстэй хялгана-жижиг хялганат, хазаар өвс-жижиг хялганат, чулуурхаг бор хөрстэй бударгана-жижиг хялганат, жижиг хялгана-бударгат, баглуур-жижиг хялганат цав толгод ба тал газрын хуурай хээрийн бэлчээртэй. 4-5 ц/га тэжээлийн нөөцтэй, 250-300 кг/га нэгжтэй. Зун-намар бог мал, тэмээнд тохиромжтой.

Хотос хонхор газраар мараалаг бор, бор саарал хөрстэй бор бударганат, цөлөрхөг хээрийн давсархаг бор хөрстэй, олон наст бударганат, бор саарал ба цөлөрхөг хээрийн давсархаг бор хөрстэй заг-давслаг сөөгт мараалаг, марзлаг бэлчээр зонхилно. Зун-намарт тэмээнд тохиромжтой. 2.0-2.5 ц/га тэжээлийн нөөцтэй, 120-150 кг/га тэжээлийн нэгжтэй.

Дорнод говийн өмнөд хэсгийн тойргийн ихэнх хэсэг болох Заг Сүүжийн говь, Борзонгийн говь, Галбын говь, Өөшийн говь, Борхойн тал нь мараалаг бор, бор саарал хөрстэй бор бударганат, бор саарал ба цөлөрхөг хээрийн давсархаг бор хөрстэй заг-давслаг сөөгт бэлчээртэй зун-намар тэмээнд тохиромжтой. 1.5-2 ц/га тэжээлийн нөөцтэй, 90-120 кг/га тэжээлийн нэгжтэй.

Цөлийн бор саарал хөрстэй чулуусаг бударганат тал, хотгор газрын цөлийн бэлчээртэй. 1.0-1.5 ц/га тэжээлийн нөөцтэй: 50-80 кг/га нэгжтэй.

Тойргийн зүүн хэсэг 1000 м орчим өндөр уулсаар нунтаг карбонатлаг цайвар хүрэн хөрстэй хялганат, хазаар өвс-жижиг хялганат цөлөрхөг хээрийн чулуурхаг бор хөрстэй бударгана-жижиг хялганат, жижиг хялгана-бударганат цөлөрхөг хээрийн, цөлийн бэлчээртэй. 3.0-3.5 ц/га нөөцтэй, 150-200 кг/га тэжээлийн нэгжтэй.

Элсэрхэг газраар хуурай хээрийн ба цөлөрхөг хээрийн харганат, үетэн- харганат, шарилжит элсний бэлчээртэй. 1.0-1.5 ц/га тэжээлийн нөөц бүхий 50- 60 кг/га нэгжтэй.

Хөрсөн бүрхэвч. Энэ мужийн хөрсөн бүрхэвчийн 70 орчим %-д цөлийн болон хээржүү цөлийн, толгодын бор саарал хөрс тархах ба ердийн болон толгодын сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс 20 орчим хувьд нь тархаж байна. Нам хотосуудаар жинхэнэ хужир, шал хөрс тархана. Шал, элсэн хөрс 4 орчим хувийг эзэлж байна. Цөлийн бор саарал хөрсний ургамлан бүрхэвч маш сийрэг үүнээс шалтгаалан энэ хөрсний үржил шим,

агро үйлдвэрлэлийн чадавхи үлэмж муу, усны элэгдлийн нөлөөгөөр гадарга нь ихээхэн атираажиж, өнгөндөө гандаасан хучаас тогтсон байдаг.

Хүснэгт № 3.6. Дорнод говийн цөлөрхөг мужийн хөрсний нөөц

Д/д	Хөрсний нэр	Г-9		Г-10		Мужийн дүн	
		га	%	га	%	га	%
1	Нуур	11651.69	0.08	6641.35	0.05	18293.03	0.07
2	Уулын хар хүрэн/уулын нимгэн хар шороон	20.06	0.00		0.00	20.06	0.00
3	Уулын хүрэн/уулын хар хүрэн	1217.77	0.01		0.00	1217.77	0.00
4	Уулын карбонаттай цавар хүрэн/ уулын нимгэн цавар хүрэн	34111.39	0.24		0.00	34111.39	0.13
5	Уулын цөлөрхөг хээрийн нимгэн бор/сайрын		0.00	20.02	0.00	20.02	0.00
6	Уулын хээржүү цөлийн нимгэн бор/сайрын		0.00	18592.06	0.14	18592.06	0.07
7	Уулын хээржүү цөлийн нимгэн бор саарал/сайрын		0.00	39312.03	0.30	39312.03	0.15
8	Толгодын хүрэн/нимгэн сайр чулуурхаг хүрэн	818093.73	5.86		0.00	818093.73	3.04
9	Сайр чулуурхаг цайвар хүрэн	2025831.77	14.5		0.00	2025831.77	7.53
10	Толгодын цөлөрхөг хээрийн бор	795135.19	5.70	506322.88	3.91	1301458.07	4.83
11	Толгодын хээржүү цөлийн бор/хээржүү цөлийн нимгэн сайр чулуурхаг бор	457927.01	3.28	1703271.71	13.14	2161198.72	8.03
12	Толгодын бор саарал/нимгэн бор саарал		0.00	1108786.69	8.55	1108786.69	4.12
13	Ердийн хүрэн/сайр чулуурхаг хүрэн	83440.26	0.60		0.00	83440.26	0.31
14	Ердийн хүрэн/сайр чулуурхаг болон хужир мараалаг хүрэн	33181.60	0.24		0.00	33181.60	0.12
15	Мараалаг хүрэн/карбонаттай хүрэн ба нугын хужир	18534.31	0.13		0.00	18534.31	0.07
16	Ердийн цайвар хүрэн/сайр чулуурхаг цайвар хүрэн	1183864.42	8.48		0.00	1183864.42	4.40
17	Ердийн цайвар хүрэн/нугат цайвар хүрэн	439222.04	3.15		0.00	439222.04	1.63
18	Ердийн цайвар хүрэн/хужир марааны бүрдэл	64650.26	0.46		0.00	64650.26	0.24
19	Мараалаг цайвар хүрэн/сайр чулуурхаг цайвар хүрэн	596107.30	4.27		0.00	596107.30	2.21
20	Сийрэг элсэн хүрэн	123383.00	0.88		0.00	123383.00	0.46
21	Мараалаг нугат хүрэн/үлдмэл нугат хүрэн/хужир марааны бүрдэл	107105.19	0.77		0.00	107105.19	0.40
22	Цөлөрхөг хээрийн бор	2400144.02	17.2	309668.95	2.39	2709812.97	10.07
23	Цөлөрхөг хээрийн бор/сайрын болон элсэн хучаастай бор	1316016.75	9.43	15976.44	0.12	1331993.19	4.95
24	Цөлөрхөг хээрийн бор/хужир марааны бүрдэл	175748.54	1.26		0.00	175748.54	0.65
25	Цөлөрхөг хээрийн сайр чулуурхаг бор	367677.45	2.63	19077.36	0.15	386754.80	1.44
26	Цөлөрхөг хээрийн мараалаг бор/хужирлаг нугат бор	517846.38	3.71	222409.03	1.72	740255.41	2.75
27	Хээржүү цөлийн бор/хээржүү цөлийн сайр чулуурхаг бор	483175.47	3.46	2079216.34	16.04	2562391.81	9.52
28	Хээржүү цөлийн бор/элсэн хучаастай бор болон хээржүү цөлийн мараалаг бор	540712.43	3.87	1463139.80	11.29	2003852.23	7.44
29	Хээржүү цөлийн мараалаг бор/шалархуу болон хагас бэхэжсэн элс	148511.49	1.06	35657.47	0.28	184168.96	0.68
30	Хээржүү цөлийн гөлтгөнөт бор	4415.77	0.03		0.00	4415.77	0.02
31	Хээржүү цөлийн хужирлаг бор/хээржүү цөлийн сайр чулуурхаг бор		0.00	135443.56	1.04	135443.56	0.50
32	Элсэн хучаастай бор/элсэн хучаастай сийрэг бор	537771.64	3.85	352056.74	2.72	889828.38	3.31
33	Цөлийн бор саарал/мараалаг цөлийн бор саарал		0.00	2053789.26	15.84	2053789.26	7.63
34	Цөлийн мараалаг бор саарал/сайр чулуурхаг бор саарал		0.00	28834.07	0.22	28834.07	0.11
35	Цөлийн гөлтгөнөт бор саарал/мараалаг бор		0.00	132996.35	1.03	132996.35	0.49

	саарал						
36	Цөлийн гөлтгөнөт мараалаг бор саарал ба хужирлаг бор саарал		0.00	1141054.28	8.80	1141054.28	4.24
37	Цөлийн элсэн хучаастай бор саарал ба цөлийн гөлтгөнөт бор саарал		0.00	464252.26	3.58	464252.26	1.72
38	Хэт хуурай цөлийн борзон/шалархуу		0.00	74604.04	0.58	74604.04	0.28
39	Сайрын болон цөлийн бор саарал	17695.87	0.13	44257.99	0.34	61953.86	0.23
40	Нугын хужир/хужирлаг нуга	22968.68	0.16		0.00	22968.68	0.09
41	Аллювийн нугын хужирлаг ба Аллювийнүелсэн тогтоцтой	46212.47	0.33		0.00	46212.47	0.17
42	Хужир марааны бүрдэл	210416.30	1.51	54671.73	0.42	265088.03	0.98
43	Нугын иж бүрдэл	80561.66	0.58	33130.17	0.26	113691.83	0.42
44	Хужир болон хужирлаг нутаг бор	1491.26	0.01		0.00	1491.26	0.01
45	Хужир болон хагас бэхэжсэн элс	132858.25	0.95	137158.62	1.06	270016.87	1.00
46	Шал шалархуу	8614.97	0.06	5850.94	0.05	14465.91	0.05
47	Шалархуу хагас бэхэжсэн элс		0.00	82318.70	0.64	82318.70	0.31
48	Хагас бэхэжсэн элс	149574.71	1.07	436128.22	3.36	585702.92	2.18
49	Хөдөлгөөнт элс		0.00	210622.31	1.62	210622.31	0.78
50	Хад асга		0.00	47798.57	0.37	47798.57	0.18
	Дүн	13955891.09	100	12963059.9	100.00	26918951.02	100.00

Ан амьтан. Энэ мужид нийтдээ 4 ангийн 131 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 20.1 % нь оршин амьдардаг байна.

Хүснэгт № 3.7. Дорнод говийн цөлөрхөг мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Молхог-чид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амтан	Бүгд
Баг	5	10	1	1	-	-	17
Овог	11	22	5	1	-	-	39
Зүйл	44 (31.6%)	76 (18.3%)	10 (47.6%)	1 (16.6%)	-	-	131 (20.1%)

Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтанд бичив.


Дэлэнтэн. Энэ мужид 5 баг, 11 овогт хамаарах 44 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн 31.6 % болно. Дэлэнтний дийлэнх хэсгийг мэрэгчтэний багийн амьтад эзлэх бөгөөд /23 зүйл буюу энэ мужийн дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 52.2%/ үндсэндээ Төв Азийн цөл, хээрийн гаралтай амьтдаас бүрдэнэ. Зүйлийн бүрэлдэхүүний хувьд Алтайн өвөр говийн тойргийн дэлэнтэн амьтдынхтай төстэй.

Олон улсын ба Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хамгаалагдсан юмуу Улаан номонд орсон амьтдаас цоохондой мий, эрэн хүрэн, хар сүүлтий, янгир ямаа, аргаль хонь зэрэг 5 зүйл энэ мужийн нутаг дэвсгэрт амьдарна.


Энэ мужид тархсан байгаль, аж ахуйн чухал холбогдолтой амьтны нэг нь хар сүүлтий юм. 1994 онд агаараас хийсэн тооллогоор Монгол орны хар сүүлтийн дэлхцийн зүүн хэсэг буюу Даланзадгадаас зүүн тийш Дорноговь, Дундговь, Сүхбаатар аймгийн нутгийн 275400 ам.км талбайд 1000 га-д 0.1-15.2 толгой ногдох нягтшилтай 90000 орчим хар сүүлтий байршиж байна /Амгалан, 2000/.

Дорнод говийн цөлөрхөг муж бол цагаан зээрийн нэг үндсэн тархац нутаг юм. Судалгааны дүнгээс үзвэл Дорноговь аймгийн Хатанбулаг чиглэлд 2037 км замлалд 23340 цагаан зээр тоолж 1 км-д 11.4 толгой, Алтанширээ чиглэлд 1750 км замлалд 16676 цагаан

Зураг № 3.8. Дорнод говийн цөлөрхөг мужийн хөрс



Зураг № 3.9. Дорнод говийн цөлөрхөг мужийн ургамалжилт



Зураг№ 3.10. Дорнод говийн цөлөрхөг мужийн газар ашиглалт

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР АШИГЛАЛТЫН БАЙДАЛ

Аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн /ХАА/ зориулалттай газар 11724.3мян.га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 70.89 хувийг эзэлж байгаагаас байгалийн бэлчээр 11363,7мян.га буюу ХАА-н эдэлбэр газрын 68,71%-г хамарч байна. хадлангийн газар 30га байна.

Хүснэгт № 4.1. ХАА-н газрын ангилал

Үзүүлэлт /га/		Хэмжээ /га/
Хөдөө аж ахуйн эдэлбэр газар		11724363
Бэлчээрийн газар		11363760
Үүнээс	Зун намрын бэлчээр	6767375
	Өвөл хаврын бэлчээр	4596384
Хадлангийн талбай		30
Тариалангийн талбай		815
Атаршсан газар		27
ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар		2736

4.1. Малын төрөл, тоо толгой

Аймгийн хэмжээнд 1.653.264 толгой мал тоолуулсан нь бүх сумандаа 5 төрөл дээрээ өссөн үзүүлэлттэй байна.

Сүргийн бүтцийн хувьд авч үзвэл тэмээ 6%, адуу 4%, үхэр 1%, хонь 21%, ямаа 68%-ийг тус тус эзэлж байна. Эндээс дүгнэлт хийхэд малчдын амьдралын гол эх үүсвэр ноолуур учраас ямааг түлхүү өсгөсөн нь харагдаж байна.

Сумдын нэр	2012	2013	2013/2012
Баяндалай	124361	138201	111.1
Баяновоо	75368	89577	118.9
Булган	87519	110534	126.3
Гурвантэс	126318	143640	113.7
Мандал-Овоо	74118	93002	125.5
Манлай	102618	117787	114.8
Номгон	172465	197239	114.4
Ноён	81593	92895	113.9
Сэврэй	104662	119881	114.5
Ханбогд	123291	126003	102.2
Ханхонгор	103148	127966	124.1
Хурмэн	91297	106674	116.8
Цогт-Овоо	50690	61866	122.0
Цогтцэций	53312	65741	123.3
Даланзадгад	48493	62258	128.4
ДҮН	1419253	1653264	116.5

Бэлчээрийн таван төрлийн малыг экологийн янз бүрийн нөхцөл шаардах байдлаар нь олон жилийн судалгааны дүнд тулгуурлан газарзүйн мужлал хийхдээ Бэлчээрийн мал аж ахуйн газар зүйн доктор Д.Базаргүр Монгол улсын мал сүргийг өсгөн үржүүлэх байршилтын нэн зохистой бүс, зохистой бүс, зохис муутай бүс нутаг гэж 3 ангилсан байна. Энэ мужлалын дагуу Өмнөговь аймгийн нутгийг авч үзвэл тэмээний аж ахуй эрхлэхэд бүх сум нь байршилтын нэн зохистой бүс нутагт хамрагдаж байна.

Адуун сүрэгт байршлын зохистой бүс болох Цогт-Овоо, Цогтцэций, Манлай сум орно. Бусад бүх сумын нутаг нь зохис муутай бүс нутагт орж байна.

Үхэр сүргийн хувьд аймгийн нийт нутаг байршилтын зохис муутай бүс нутагт хамрагдаж байхад хонины аж ахуйн хувьд бүх сумын нутаг байршилтын зохистой бүс нутагт хамрагдаж байна.

4.1.1. Эрчимжсэн мал аж ахуйн судалгаа, одоогийн байдал

Хүснэгт № 4.3. Саалийн үнээ.

№	Сум	АА-н нэгж, иргэд	Үүлдэр //Эрлийз/	Бүгд	Бух	Үнээ	Бусад	Нэгж үнээ Саам /л/
1	Баяндалай	“Баянгийн гол” ТББ	симменталль	57	2	21	34	8
2		У.Одгэрэл	алатау	20	1	10	9	7
3		Э.Чулуунарилд	семменталль	2	2			
4	Баян-Овоо	Б.Отгонцэцэг	семменталл	43	1	9	33	4-5
5		О.Цэнд-Аюуш		9	1	3	5	5-6
6	Булган	Ц.Ичинхорол		4	1	3		
7	Гурвантэс	Д.Чулуун	шар тарлан	5	1	2	2	8
8		Баттөмөр		2		2		6
9	Мандаловоо	Б.Ичинхорол	хар тарлан	12		6	6	5-7
10	Манлай	О.Баярдүү	семменталл	7	1	3	3	4-5
11	Номгон	Ө.Жаргал	Хар тарлан	11	1	4	6	5-6
12		А.Уртнасан		7	1	3	3	5-6
13		С.Цогнэмэх		4		4		5-6
14		Н.Мөнхжаргал	семменталл	8	2	2	4	6-7
15		М.Энхбаяр	хар тарлан	4		4		6-7
16		Б.Саранхүү	семменталл	23	1	10	12	6-7
17	Ноён	Ш.Мөхсайхан	семменталл	10	1	6	3	
18	Сэврэй	П.Уламбаяр	семменталл	3	0	3	0	5
19	Сэврэй	С.Эрдэнээ	семменталл	3	1	1	1	8
20	Ханбогд	Т.Цогтбаатар	алатау семменталла	26	1	10	15	7
21	Ханхонгор	Буянт түмэн сүрэг хоршоо	алатау	4		4		6
22		П.Идэр	алатау х монгол	11	1	7	3	6
23		Н.Төмөрбаатар	талын улаан х монгол	3		1	2	
24	Хүрмэн Тулга	Б.Ганжаргал	хар тарлан	6	0	3	3	5-7
25	Хүрмэн	Д.Содном	хар тарлан	12	1	3	8	5-6
26	Хүрмэн	Д.Алтангэрэл	хар тарлан	13	1	7	5	4-5
27	Цогт-Овоо	Р.Отгон	семменталл	5	1	4		5-7
28	Цогтцэций	Н.Батсайхан	сем, хар/та	37	1	20	16	7
29		Ч.Жамсранжав	-“-“-“-“-	8	1	5	2	7
30	Даланзадгад	Р.Пагаажав	алатау сем	9	-	9		8
31		П.Батбаяр	хар тарлан алатау	41	1	2	15	8
32		Б.Тогмид	семменталь	8	1	3	4	7
33		Г.Болд	-“-“-“-	10	-	3	7	6
34		Ж.Буд	хар тарлан	4	-	4		7
35		Ш.Мөнхтогоо	хар тар сем	8	-	4	4	6
36		Хүүнэнгээ	алатау	2	-	2		5
37		Ж.Батжаргал	хар тарлан	6	-	3	3	6
Дүн				423	25	190	208	

Хүснэгт № 4.4. Гахай.

Сум	АА-н нэгж, иргэд	Үүлдэр	Бүгд	Бодон	Үндсэн мэгж	Бусад	Бойжуулсан торой
Булган	Г.Батдорж	нутгийн	15	1	5		9
	С.Баянбилэг	нутгийн	17	1	6		10

Гурвантэс	Хилийн Цэргийн Анги	хятад цагаан	8	1	4		3	
	МАК	нутгийн	8	2	6			
	Ж.Уламбаяр		4	1	1	2		
	Намжилцэрэн	нутгийн	3	1	2			
Мандаловоо	байхгүй							
Манлай	байхгүй							
Номгон	Мааваг	орос цагаан	13	1	2		10	
	Ажрахгүй	нутгийн	30		8		22	
	Ө.Цолмон		6	2	2		2	
	Б.Цацрал		11		1		10	
	Д.Чулуунбат		5	1	1		3	
Ноён	Ш.Мөнхсайхан	хятад	3	1	2			
Ноён	Д.Түмэннасан		4		4			
Сэврэй	Б.Буянтогтох	нутгийн цагаан	11	6	5	0	0	
Ханбогд	“Жороо булаг” ХХК	нутгийн	20	1	2	11	6	
	“ДТМ” ХХК		20	1	3	12	5	
Ханхонгор	Нэргүйбаяр		12		3	3	6	
	Б.Батгэрэл		15	3	4		8	
Хүрмэн	Г.Батбаатар		1		1			
	Д.Гантөгс		8	1	2		5	
	С.Батсайхан		28	1	6	3	18	
Цогт-Овоо	байхгүй							
Цогтцэций	Г.Эрхэмзориг			13		2		11
	У.Түвшинбаяр			12				12
	Б.Эрболд		4				4	
	Н.Батсайхан		52	1	10		41	
Даланзадгад	Тогмид		2		1	1		
	Н.Тунгалагзаяа		10	1	2	3	4	
	Б.Амгаланбаатар	орос эрлийз	126	10	46	34	36	
	Ц.Цэцгээ	америк сиб	24	1	4	13	6	
	АА-ийн 167-р анги	нутгийн	8		2		6	
	ХЦ-ийн 0131-р ан		19	1	3	5	10	
	Э.Батболд		24	1	4	3	16	
	Б.Батбаолд		8	2	2	-	4	
	Э.Дашдолгор		8	-	4	4	-	
Ш.Чулуунбат	30		2	4	14	10		
Бүгд			618	45	159	121	293	

Хүснэгт № 4.5. Тахиа. /гэрийн тэжээмэл шувууд/

Сум	АА-н нэгж иргэд /нэрсээр/	Үүлдэр	Бүгд	Азарган тахиа	Өндөглөгч	Бусад	Нэгжээс авсан ондог
Баян-Овоо	Ц.Энхтөр	нутгийн	60	6	50	4	160
	Ө.Цэцгөлзий	нутгийн	66	6	40	20	160
Булган	Х.Базарчулуун	-“-“-	20	1	19		200
	Д.Батчулуун	-“-“-“-	13	1	12		200
Гурвантэс	Ш.Мэндсайхан	нутгийн	24	1	23		180

	Ш.Мэндсайхан	галуу	6	1	5		
	Н.Мэндбаяр	нутгийн					
	МАК		99	2	97		180
Мандаловоо	байхгүй						
Манлай	Г.Алтанцэцэг	нутгийн	120	2	118		80
Номгон	байхгүй						
Ноён	Д.Түмэнбаяр	хятад	22	7	15		150
Сэврэй	Г.Ваанчиг	нутгийн	10	4	6		
Сэврэй	Б.Бямбасайхан	нутгийн	21	1	2	18	0
Ханбогд							
Ханхонгор	Ц.Батбэх	нутгийн	76	2	50	24	100
Хүрмэн	байхгүй						
Цогт-Овоо	байхгүй						
Цогтцэций	Г.Алтанцэцэг	нутгийн	25	2	23		180
	Н.Батсайхан		99	5	94		180
	Н.Готовдорж		6	1	5		160
Даланзадгад	Ж.Төмөрдүүбаатар	нутгийн	243	6	237		180
		галуу	3			3	
		нугас	2			2	
		цацагт хяруул	2			2	
	Б.Батболд	нутгийн	7	1	6		160
	Хүүнэнгээ		3		3		90
	Ш.Энхмөнх		2		2		

4.2. Бэлчээр, бэлчээрийн газрын төлөв байдал

4.2.1. Бэлчээрийн газрын улирлын хувиарлалт

Өмнөговь аймгийн бэлчээрийн газрын нийт хэмжээ 11363760 га байгаагаас Зун, Намрын бэлчээр 6767375га, Өвөл, хаврын бэлчээр 4596384 га бэлчээр байна.

Хүснэгт № 4.6. Бэлчээрийн газрын хэмжээ /улирал, сумдаар/

Д/д	Сумдын нэр	Өвөл-Хаврын	Зун-Намрын	Нийт бэлчээр
1	Баяндалай	276630.21	414999.13	691629.34
2	Баян-Овоо	215367.2	304900.98	520268.18
3	Булган	229021.64	297066.29	526087.93
4	Гурвантэс	556179.15	856873.43	1413052.58
5	Мандаловоо	231616.67	347449.95	579066.62
6	Манлай	479518.71	718549.62	1198068.33
7	Номгон	408648.9	611543	1020191.89
8	Ноён	372661.67	558877.63	931539.3
9	Сэврэй	69219.57	69204.32	138423.89
10	Ханбогд	447033.58	660774.27	1107807.85
11	Ханхонгор	337681.72	477951.75	815633.47
12	Хүрмэн	422072.14	632588.69	1054660.83
13	Цогтовоо	256932.5	385305.05	642237.59
14	Цогтэций	277838.61	407983.85	685822.47
15	Даланзадгад	15962.6	23307.8	39270.44
Бүгд		4596384.87	6767375.76	11363760.71

4.2.2. Бэлчээрийн ангилал, ургамлын хэв шинж

Тус аймагт 6 анги, 147 хэв шинжийн бэлчээрийн ургамлын төрөл тархсан байна.

/бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны материалаас/

Үүнд:

1. Говь цөлийн ба цөлөрхөг хээрийн уулын бэлчээр
2. Цөлөрхөг хээрийн бэлчээр
3. Говь цөлийн тал хөндийн бэлчээр
4. Говийн сул бэхэжсэн элсний бэлчээр
5. Хужир мараатай нам хотосын бэлчээр
6. Уулын бэл хормойн гуу жалгын бүрдэлтэй сайрын бэлчээр

Говь цөлийн ба цөлөрхөг хээрийн уулын бэлчээр-ийн хэв шинжид монгол өвс-хазаар өвст, хазаар өвс-монгол өвст, монгол өвст, монгол өвс-боролзойт, агь-монгол өвст, монгол өвс-таанат, монгол өвс-шавагт, монгол өвс-бударганат, баглуур-монгол өвст, баглуур-бударганат, тэсэг боролзой-шавагт, исэр мод баглуур-холимог сөөгт, холимог сөөгт-загт зэрэг 39 төрөл зонхилдог

Цөлөрхөг хээрийн бэлчээр. Энэ хэв шинжид монгол өвст, монгол өвс-хазаар өвст, агь хазаар өвс- монгол өвст, монгол өвс-боролзойт, монгол өвс-шавагт, монгол өвс-таана бударганат, монгол өвс-баглуурт, таана- монгол өвст зэрэг 36 төрлийн бэлчээртэй байна.

Говь цөлийн тал хөндийн бэлчээр. Энэ хэв шинжид баглуур-бударганат, бударгана-монгол өвс-таанат, улаан бударгана-бударганат, шавагт, ээргэнэт-холимог сөөгт, холимог сөөг-шарилжит зэрэг 25 төрлийн бэлчээр зонхилж байна.

Говийн сул бэхэжсэн элсний бэлчээр. Энэ хэв шинжид султ, суль үетэнт, суль-агь-шарилжит, үетэн-агь-алаг өвст, элсний шаваг-алаг өвст, загт, холимог сөөгт зэрэг 18 төрлийн бэлчээр зонхилж байна.

Хужир мараатай нам хотосын бэлчээр. Энэ хэв шинжид исэр бударгана-дэрст, шар бударганат, бударганат, бударгана-дэрст, бударгана-хармагт, хармагт, усан хамхаг-хармагт, зэгс, дэрс, сухай, тооройн төгөл зэрэг 24 төрлийн бэлчээр зонхилж байна.

Уулын бэл хормойн гуу жалгын бүрдэлтэй сайрын бэлчээр. Энэ хэв шинжийн бэлчээр нийт бэлчээрийн 16.15%-ийг эзэлж байгаа ба шарилж-шавагт, холимог сөөгт, холимог-сөөг хамхагт, сийрэг заг-зээргэнэт зэрэг 5 төрлийн бэлчээр зонхилж байна.

Хүснэгт № 4.8. Сумдын бэлчээрийн төлөв байдал

№	Сум	Бэлчээрийн, талбай га	Үүнээс хэвийн	Чулуурхаг	Сөөгөрхөг	Довонтой	Эзлэх хувь. Хэвийн	Чулуурхаг	Сөөгөрхөг	Довонтой	Усны эвдрэл, гуу жалгатай	Элсний нүүдэлтэй	Хоргон мэргэчдийн нөлөөлөгтэй
1	Баяндалай	903231	606790	127035	163356	6050	67,2	14,1	18,1	0,7	13860	1292	
2	Баян-овоо	868258	588592	135252	144414	0	67,8	15,6	16,6	0,0			
3	Булган	689287	288555	109994	284694	6043	41,9	16,0	41,3	0,9	0		
4	Гурван тэс	2317377	190351	574868	1543700	8485	8,2	24,8	66,6	0,4	0		
5	Мандал-овоо	592531	344889	115169	126086	6388	58,2	19,4	21,3	1,1	0		
6	Манлай	1221727	581483	341191	242133	56920	47,6	27,9	19,8	4,7	0		
7	Номгон	1664618	1128444	259305	276869		67,8	15,6	16,6	0,0	0	48498	7157
8	Ноён	977694	656814	137508	176823	6549	67,2	14,1	18,1	0,7			

9	Сэрвэй	638334	0	164352	466314	7668	0,0	25,7	73,1	1,2	0		
10	Ханбогд	1300653	296992	420950	537362	45349	22,8	32,4	41,3	3,5	0		
11	Ханхонгор+ДЗ	957810	617291	162270	143181	35068	64,4	16,9	14,9	3,7	0		
12	Хүрэм	1128825	435586	180034	495614	17591	38,6	15,9	43,9	1,6	0	60162	5487
13	Цогт-овоо	644584	463311	97322	81817	2134	71,9	15,1	12,7	0,3	0		
14	Цогтцэций	698671	269639	200115	210640	18277	38,6	28,6	30,1	2,6	0		

Хүснэгт № 4.9. Сумдын бэлчээрийн нөөц, хэрэгцээ, хүрэлцээ, даац

№	Сум	2002-2013 оны эхний малын дундаж тоо, бүгд						Хонин толгойд шилжүүлбэл	Бэлчээрийн тэжээлийн хэрэгцээ, мянган тонн тэжээлийн	100 га бэлчээрт оногдох хонин толгой	Бэлчээрийн нөөц, мянган тонн тэжээлийн:нэгж	Дутагдаж, илүү гарч буй бэлчээрийн нөөц, мянган тонн тэжээлийн даац	Бэлчээрийн даац %	Бэлчээрийн га-гийн ургац, ц/га
		Нийт	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа							
1	Баяндалай	98782	2165	3545	978	20618	71477	138097	45.6	15.3	38.8	-8.2	82.6	0.69
2	Баян-овоо	60493	4144	2810	436	14326	38778	111475	37.1	12.8	30.1	-7.8	79.3	0.56
3	Булган	87404	3393	3737	871	25428	53976	139540	46.2	20.2	38.4	-9.1	80.9	0.90
4	Гурван тэс	95973	4381	1036	113	7117	83327	128557	42.5	5.5	34.3	-9.4	78.5	0.24
5	Мандал-овоо	125251	11666	4921	955	35626	72084	249983	83.4	42.2	70.0	-14.9	82.4	1.91
6	Манлай	85964	6854	5991	928	26373	45818	183537	61.3	15.0	51.4	-11.0	82.3	0.68
7	Номгон	131522	4735	2847	631	15862	107446	179871	59.4	10.8	47.5	-13.6	77.7	0.46
8	Ноён	61540	4124	839	89	5658	50830	94577	31.4	9.7	25.2	-6.9	78.4	0.42
9	Сэрвэй	95544	3184	2861	542	14661	74295	135377	44.8	21.2	37.5	-8.5	81.6	0.95
10	Ханбогд	69713	13195	3150	1258	19128	32981	199923	67.1	15.4	54.2	-13.8	79.8	0.67
11	Ханхонгор+ДЗ	101514	4669	4205	674	28654	63312	165088	54.8	17.2	45.9	-10.3	81.7	0.77
12	Хүрэм	58474	4365	1295	262	11386	41166	98861	32.9	8.8	26.6	-7.0	79.2	0.38
13	Цогт-овоо	44110	4384	2437	282	13937	23069	95444	31.9	14.8	27.0	-5.5	83.1	0.67
14	Цогтцэций	62122	1837	3783	551	19460	36491	102831	34.1	14.7	28.3	-6.7	80.9	0.65

4.3. Бэлчээрийн газрын нөөцөд гарсан өөрчлөлт

Хүснэгт № 4.10. Сумдын бэлчээрийн талбайн өөрчлөлт

№	Сумын нэр	Бэлчээрийн талбай /га/				
		2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
1	Баяндалай	691715.98	691666.37	691647.47	691629.34	691629.34
2	Баян-Овоо	538353.95	520513.78	520339.15	520288.32	520268.18
3	Булган	572587.1	572575.59	526769.13	526692.67	526087.93
4	Гурвантэс	1416337.72	1415566.77	1415488.95	1413057.39	1413052.58
5	Мандаловоо	579169	579146.49	579133.35	579062.65	579066.62
6	Манлай	1198787.86	1198783.66	1198606.92	1198512.84	1198068.33
7	Номгон	1021563.05	1021556.59	1021547.5	1020196.68	1020191.89
8	Ноён	931694.2	931680.45	931674.1	931660.86	931539.3
9	Сэврэй	138442.47	138442.44	138442.42	138428.19	138423.89
10	Ханбогд	1115698.41	1111182.48	1108490.94	1107926.38	1107807.85
11	Ханхонгор	823872.73	815958.36	815870.83	815677.48	815633.47
12	Хүрмэн	1055020.46	1054832.46	1054830.57	1054667.4	1054660.83
13	Цогтовоо	642334.82	642334.1	642333.85	642240.45	642237.59
14	Цогтцэций	697062.92	692272.28	688237.52	686400.24	685822.47
15	Даланзадгад	39627.1	39625.09	39502.69	39379.74	39270.44
ДҮН		11462267.76	11426136.92	11372915.39	11365820.63	11363760.71
Бууралт өмнөх оноос /га-гаар/			36130.84	53221.53	7094.76	2059.92



Зураг № 4.2. Аймгийн 2004-2013 оны хоорондох бэлчээрийн эдэлбэр газрын талбайн өөрчлөлт

4.3.1. Бэлчээрийн газрын талхлагдал ба талхлагдлын зэрэглэл

Бэлчээрийн талхлагдал нь хөрсний бүтэц, шимт чанарыг доройтуулж, цөлжилт үүсгэн, байгалийн унаган төрхийг алдагдуулахын зэрэгцээ экологийн онц ноцтой өөрчлөлт рүү чиглүүлэгч анхдагч хүчин зүйл болохын хувьд нийгэм-эдийн засагт асар их хор хохирол дагуулдаг онцлогтой үйл явц юм. Бэлчээрийн доройтол талхагдалын шалтгаануудыг дурдвал:

- Уламжлалт 5 төрлийн малын хоорондын зохистой харьцаа алдагдсан
- Бэлчээр нийтийн эзэмшилд байгаа
- Бэлчээр ашиглах, эзэмших эрх зүйн зохицуулалтгүй
- Нүүдлийн тоо цөөрч, нүүх зай богиносон зөвхөн зун- намар, өвөл-хавар гэсэн нутагтай болсон
- Бэлчээрийн даацыг зохицуулах талаар малчид ч, төрийн захиргааны байгууллагууд нь ямар нэг арга хэмжээ авахгүй байгаа
- Бэлчээр талхласан, доройтуулсны төлөө хэн ч хариуцлага хүлээдэггүй, хүлээлгэх механизм нь тогтоогүй
- Нэгэнт доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх ажил хийхгүй байгаа
- Бэлчээрийн усан хангамж дутагдалтай
- Хотжилт, үйлдвэржит (уул уурхай) эрчимтэй явагдаж байгаа зэрэг объектив, субъектив олон хүчин зүйлтэй холбоотой.

Бэлчээрийн талхлагдлыг харилцан хамааралтай хоёр бүлэг хүчин зүйлд хамааруулан авч үзэх үндэслэлтэй. Үүнд:


Нэгдүгээрт: Байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн нөлөө буюу дэлхийн уур амьсгалын дулааралт, өөрчлөлт

Хоёрдугаарт: Хүний буруутай үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл зэрэг болно.

Энэ хоёр бүлэг хүчин зүйл нь өөр хоорондоо харилцан хамааралтай боловч байгалийн бэлчээрийн хувьд, хоёр дахь хүчин зүйл нь эхний хүчин зүйлийнхээ анхдагч нөхцлийг нь бүрдүүлж өгдгөөрөө онцлог юм. Үүний нэг хэлбэр нь байгалийн бэлчээрийн талхлагдал бөгөөд МАА-н үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, түүний үр шимийг хүртэж байгаа хүний хүчин зүйлээс үүдэлтэй билээ.

Хүснэгт№ 4.11. Сумдын бэлчээрийн талхлагдлын байдал

№	Сум	Бэлчээрийн, талбай га	Үүнээс : их талхлагдсан	Дунд зэрэг талхлагдсан	Бага зэрэг талхлагдсан	Талхагдаагүй	Их талхлагдсан %	Дунд зэрэг талхлагдсан %	Бага зэрэг талхлагдсан %	Талхагдаагүй %	Худуг усны хүрэлцээгүйгээс ашигдалгүй, га	Алслагдсан га	Хад, асга, ян, сарьдг, га	Бусад шалтгаанаар бэлчээр ашиглах боломжгүй, га
1	Баяндалай	903231	101559	40275	85100	676296	11,2	4,5	9,4	74,9	38558	74619		
2	Баян-овоо	868258			96048	772210	0,0	0,0	11,1	88,9				
3	Булган	689287	95089	111601	41338	441258	13,8	16,2	6,0	64,0	103684	109136		
4	Гурван тэс	2317377		3688	273209	2040479	0,0	0,2	11,8	88,1		981025	78198	6417
5	Мандал-овоо	592531	75030	123667	19870	373965	12,7	20,9	3,4	63,1	69401	42976	0	21042
6	Манлай	1221727	3547	71799	75346	1071035	0,3	5,9	6,2	87,7		83213	4169	49088
7	Номгон	1664618	77303	80504	142026	1364785	4,6	4,8	8,5	82,0	72182	121113	0	
8	Ноён	977694			129331	848363	0,0	0,0	13,2	86,8				
9	Сэрвэй	638334		10086	129236	499012	0,0	1,6	20,2	78,2	24931	59787	41176	36608
10	Ханбогд	1300653		149016	119213	1032424	0,0	11,5	9,2	79,4	97836	30604	1726	17551
11	Ханхонгор+ДЗ	957810	57803	356681	20724	522602	6,0	37,2	2,2	54,6	14661	202068		15653
12	Хүрэм	1128825	35892	57081	92973	942879	3,2	5,1	8,2	83,5	170694	298127		
13	Цогт-овоо	644584		254436	12722	377429	0,0	39,5	2,0	58,6		106308	0	1723
14	Цогтцэций	698671	121841	14345	68093	494392	17,4	2,1	9,7	70,8	58241	28304	0	2071



Зураг№ 4.3. Бэлчээрийн талхлагдлын зураг /сумын нийт бэлчээрийн газрын талхагдалын %-иар/


Мөн бэлчээрийг талхлагдалд хүргэж байгаа зарим хүчин зүйл нь хот суурин газрын орчимд малын бөөгнөрөл ихэссэн, автогений болон техногений нөлөөлөл их улирлын бэлчээрийн хувиар алдагдаж нүүж нутаг сэлгэх, отор хийхээ больсон, мал өссөн, огтоно, хулганы хөнөөл, уст цэг тойрсон малын хэт төвлөрөл бий болсноос голлон шалтгаалж байна.

Тус аймгийн хувьд бэлчээрийн талхлагдал их байна. Бэлчээрийн хуваарь, сэлгээг тууштай нэвтрүүлэх, их талхлагдсан бэлчээрийг малын хөлөөс чөлөөлөх, бэлчээрийг жигд тэнцвэртэй ашиглахад анхаарах, эрчимжсэн сүү болон махны чиглэлийн фермерийн аж ахуйг дэмжиж хөгжүүлэх, бэлчээр хашаалж хуваарьтай ашиглах, сайжруулах арга хэмжээ авахаар төлөвлөлтөд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

4.4. Бэлчээрийн усан хангамжийн өнөөгийн байдал

Бэлчээрийн ачаалалд нөлөөлж байгаа нэг хүчин зүйл бол бэлчээрийн усан хангамжийн асуудал юм. Усжуулагдаагүй бэлчээр бараг ашиглагддаггүй учраас түүний ачаалал нь усжуулагдсан хэсэгтээ ирж бэлчээрийн усжуулагдсан хэсгийн ачаалал хэтэрч талхлагдах явдал их байна.

Говь нутгийн бэлчээрийг бүрэн дүүрэн, зөв зохистой, үр ашигтай ашиглах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тууштай хөгжүүлэх үндсэн нөхцлийн нэг нь бэлчээр усжуулалтын асуудал юм.




Зураг № 4.5 Өмнөговь аймгийн бэлчээр усжуулалтын талбайн зураг

Өмнөговь аймгийн хувьд гүн өрмийн худаг 126, богино яндант 4, бетонон хашлагат 68, энгийн уурхайн худаг 1090 байна. Тус аймгийн хувьд ерөмдмөл худгийн дундаж гүн 100 м, ундрага нь 1.0-1.6 л/с, богино яндант худгийн дундаж гүн 13.8 м, ундрага нь 0.8-1.2 л/с, уурхайн худгийн дундаж гүн 9.0-10.7 м, ундрага нь 0.3-0.48 л/с байна.

Хүснэгт № 4.12. Бэлчээр усжуулалт

№	Сумын нэр	Бэлчээрийн худаг					Усжуулагдсан бэлчээрийн талбай /га/			Нийт бэлчээр /га/	Бэлчээр усжуулалтын хувь
		Нийт хугдгийн тоо	Үүнээс				инженерийн хийцэт худаг /1500 га/	энгийн уурхайн худаг /1000 га/	нийт		
			Бага гүнтэй худаг								
		Өрөмдмөл	Богоно яндант	Бетон хашлагат уурхайн	Энгийн уурхайн						
1	Баяндалай	283	23	0	95	165	177000	165000	342000	691629.34	49.4
2	Баян-Овоо	250	24	19	0	207	64500	207000	271500	520268.18	52.2
3	Булган	173	24	13	35	101	108000	101000	209000	526087.93	39.7
4	Гурвантэс	623	17	6	0	600	34500	600000	634500	1413052.58	44.9
5	Мандаловоо	247	8	0	45	194	79500	194000	273500	579066.62	47.2
6	Манлай	335	35	7	0	293	63000	293000	356000	1198068.33	29.7
7	Ноён	282	26	0	47	209	109500	209000	318500	931539.3	34.2
8	Номгон	502	21	10	0	471	46500	471000	517500	1020191.89	50.7
9	Сэврэй	283	22	7	0	254	43500	254000	297500	138423.89	214.9
10	Ханбогд	360	8	12	0	340	30000	340000	370000	1107807.85	33.4
11	Ханхонгор	340	24	3	0	313	40500	313000	353500	815633.47	43.3
12	Хүрмэн	319	19	0	69	231	132000	231000	363000	1054660.83	34.4
13	Цогтовоо	136	19	2	0	115	31500	115000	146500	642237.59	22.8
14	Цогтэций	194	29	15	0	150	66000	150000	216000	685822.47	31.5
15	Даланзадгад	54	17	5	0	32	33000	32000	65000	39270.44	165.5
	Дүн	4381	316	99	291	3675	1059000	3675000	4734000	11363760.71	41.7

Тайлбар: Сэврэй сумын нийт газар нутгийн 90 хувь нь тусгай хамгаалалттай газарт ордог тул бэлчээрийн тайлбайгаар тооцоход усжуулалтын хувь өндөр гарсан болно.




Зураг № 4.4. Аймгийн бэлчээр усжуулалтын өөрчлөлт

4.5. Газар тариалан

4.5.1. Газар тариалангийн зориулалт бүхий газрын өнөөгийн байдал

Өмнөговь аймаг байгаль цаг уурын нөхцлийнхөө хувьд газар тариалан эрхлэхэд ихээхэн онцлогтой. Агро-уур амьсгалын үндсэн үзүүлэлтээр бүрэн усалгаатай, бүрдийн тариалант бүсэд хамрагдах ба газар тариалангийн үйлдвэрлэлийг үр ашигтай хөгжүүлэхэд дулааны хангамж хүрэлцээтэй боловч хур тунадас маш бага унадаг, чийгийн хангамж муутай, усалгааны нөөц хангалтгүй учир нилээд бэрхшээлтэй байдаг.

Газрын нэгдмэл сангийн тайлангаас харахад тус аймгийн тариалангийн газар нийтдээ 815.44 га байгаа юм. Үүнээс төмс, хүнсний ногоо тариалсан талбай 530.2 га буюу нийт талбайн 61.1%, тэжээлийн ургамал тариалсан талбай 279 га буюу 38.2%, мөн таримал ургамал, жимс жимсгэнэ тариалсан талбай 3.40 га буюу 0.1%, өнжөөсөн талбай 3 буюу 0.4%-ийг тус тус эзэлсэн байна.



Зураг № 4.6. газар тариалангийн талбайд гарсан өөрчлөлт

Хүснэгт№ 4.14. Тариалалт, ургацын судалгаа /сумдаар /

№	Сумын нэр	Төмс хүнсний ногоо			Хүнсний ногоо			Малын тэжээл			Жимс жимсгэнэ	
		Тарьсан талбай га	Ургац тн	Нэгж талбайн ургац цн	Тарьсан талбай га	Ургац тн	Нэгж талбайн ургац цн	Тарьсан талбай га	Ургац тн	Нэгж талбайн ургац цн	Тарьсан талбай га	Ургац тн
1	Баяндалай	3	54.4	181,3	1.41	14.8	99,2	8,85	67.0	75,7	0,20	-
2	Баян-Овоо	3	21	70,	1.5	4.8	30	1,1	8.5	77,2	0,1	-
3	Булган	8.5	107.6	126,5	10	241.9	241	7,5	30	40,	0,8	0,2
4	Гурвантэс	8.8	66,5	75,5	4.2	42,6	101,4	3,2	34	106,2	1,7	0.03
5	Мандал-Овоо	1.5	19	126,6	0.4	4,8	120	0,9	-	-	-	-
6	Манлай	2.4	18	75	2.1	22,8	108,5	3,8	32,6	85,7	0,1	-
7	Номгон	4.7	39,5	84	3.1	29,	93,5	1	12	120	1,2	-
8	Ноён	1.3	6	46,1	1	2.4	240	0,08	-	-	-	-
9	Сэврэй	2	10	50	0.3	3	100	0,5	2	40	0,7	-
10	Ханбогд	1.5	4	26,6	1.8	3,5	19,4	-	-	-	0,25	-
11	Ханхонгор	13.6	115	84,5	2.42	26.4	109	5	40.8	81,6	5,5	1.5
12	Хүрмэн	2.5	15,	60	1.7	12,6	74,1	2	1.5	7,5	0,3	0.1
13	Цогт-Овоо	1.5	15	100	0.5	6	120	-	-	-	-	0.03
14	Цогт-Цэций	4	60	150	4.6	74.7	162,3	1	15	150	1,2	0.5
15	Даланзадгад	12.3	96	78	13.3	112,1	84,2	3	16	53,3	6,1	2.3
	Дүн	70.7	647,	91,5	47.9	601,4	125,4	38	259,4	68,2	18,2	4.65

Хүснэгт № 4.15. Хүнсний ногооны нэгж талбайн ургац

№	Сумын нэр	Байцаа			Манжин			Лууван			Сонгино			Өргөст хэмх			Улаан лооль			Гуатан		
		Хураасан талбай га	Авсан ургац тн	Нэгж талбайн ургац цн	Хураасан талбай га	Авсан ургац тн	Нэгж талбайн ургац цн	Хураасан талбай га	Авсан ургац тн	Нэгж талбайн ургац цн	Хураасан талбай га	Авсан ургац тн	Нэгж талбайн ургац цн	Хураасан талбай га	Авсан ургац тн	Нэгж талбайн ургац цн	Хураасан талбай га	Авсан ургац тн	Нэгж талбайн ургац цн	Хураасан талбай га	Авсан ургац тн	Нэгж талбайн ургац цн
1	Баяндалай		2.3		0,4	3.64	91	0,4	3.3	82,5	0,3	2.6	86,6	0,1	1	100	0,1	1	100	-	0.79	
2	Баян-Овоо		0.6		0,2	0.7	35	0,2	1.2	60	0,5	1.4	28	0,2	0.6	30	0,4	0,3	7	-	-	
3	Булган	0,4	13.5	337	0,5	8.4	168	1,2	30	250	1,6	37	231	0,7	25	71,	4,2	110	262	1,3	18	138
4	Гурвантэс	0,5	5,6	112	0,8	10	125	0,8	7,5	93,7	0,3	4,8	160	0,7	4,2	60	0,7	3,9	557	0,3	3	100
5	Мандал-Овоо		-		0,1	1	100	0,1	1	100	0,05	1,8	360	0,05	0,4	80	-	0,4		-	0,2	
6	Манлай	0,2	2	100	0,2	4,2	210	0,3	3	100	0,3	2,1	70	0,5	5,6	112	0,4	4,1	102	0,2	1,8	90
7	Номгон	0,1	1,5	150	0,6	7,1	118	0,9	8	88,8	0,8	4,5	56,2	0,2	1,8	90	0,3	3,1	103	0,1	2	200
8	Ноён		-		0,3	0.6	20	0,3	0.4	13,3	0,2	0.2	10	0,1	0.2	20	0,1	0.2	20	-	-	
9	Сэврэй		0.1		0,1	0.7	70	0,1	0.6	60	-	0.6		0,1	-		-	0.2		-	0.8	
10	Ханбогд		-		0,1	0,1	10	0,1	0,2	20	0,1	0,2	20	0,5	1	20	0,5	1	20	0,5	1	20
11	Ханхонгор	0,2	1.8	90	0,3	3.5	116	0,4	4.4	110	1,2	12.8	106	0,12	1.3	13	0,3	2.6	86,6	-	-	
12	Хүрмэн	0,1	08	80	0,3	2.4	80	0,4	2,2	55	0,4	3,2	80	0,2	1,6	80	0,2	1,6	80	-	0,1	
13	Цогт-Овоо		-		0,1	1,5	150	0,3	2	66,6	0,1	0,7	70	-	0,8		-	0,5		-	0,5	
14	Цогт-Цэций		-		1	20	200	1	15	150	1	10	100	0,6	7.2	120	0,5	10	200	0,5	12.5	250
15	Даланзадгад	1	9.5	95	3,5	34	97,	3,5	25.1	71,7	2	24	120	1	6.3	63	0,9	4.7	52.2	0,6	6.8	113
	Дүн	2,5	37,7	150,8	8,5	97,84	115	10	103,9	103,9	8,85	105,9	119,6	5,07	57,	112,4	8,6	143,6	166,9	3,5	47,4	135,4

Жич: Ургац алдсан талбай байхгүй.

Хүснэгт № 4.16. Тэжээлийн ургамлын тариалалт ургацын судалгаа

№	Сумын нэр	2009		2010		2011		2012		2013	
		тарьсан талбай га	ургац тн	тарьсан талбай га	ургац тн	тарьсан талбай га	ургац тн	тарьсан талбай га	ургац тн	тарьсан талбай га	ургац тн
1	Баяндалай	6,1	60	4.8	47.2	5.9	34,2	8,8	95	8,85	67.0
2	Баян-Овоо	0,3	1,2	0.5	13	0.5	2	1,0	6,1	1,1	8.5
3	Булган	1	7	1	8.4	3.0	19.5	6,8	20.5	7,5	30
4	Гурвантэс	3	30	3	25	3.5	19	3,6	22,7	3,2	34
5	Мандал-Овоо	0,2	1,3	1.83	13	0.9	1,5	0,2	0,6	0,9	-
6	Манлай	3,1	26,4	3.4	29	3.5	29.4	4,2	25,6	3,8	32,6
7	Номгон	1	15	2	25	4.0	32	12,3	43,6	1	12
8	Ноён	1,5	1	0.5	1			-	0	0,08	-
9	Сэврэй	0,6	0,5	0.5	6.5		0,4	0,02	0.5	0,5	2
10	Ханбогд	-	-	-	-		-	-	0	-	-
11	Ханхонгор	5	34,2	5.4	69	5.7	45,7	5,8	47.2	5	40.8
12	Хүрмэн	1,4	5	0.3	10.5	1.0	14,1	0,9	3	2	1.5
13	Цогт-Овоо	-	-	2	30	0.8	2	0,4	2	-	-
14	Цогт-Цэций	1	-	-	-	1.0	0,5	2,0	5	1	15
15	Даланзадгад	2,5	21	2.5	23.4	3.0	25	-	0	3	16
Дүн		26,7	202,6	27,2	301	32.8	225.3	46,0	271,8	38	259,4

Жич: Цэвэр сортын төмсний үржүүлэгийн хувь 2009 онд 10%, 2010 онд 38%, 2011 онд 52% байсан.

Хүснэгт № 4.17. Усалгаатай талбайгаас хураасан ургац

№	Сумын нэр	Бүгд хураасан ургац тн	Төмс		Хүнсний ногоо		Үүнээс							Жимс жимсгэнэ	Тэжээлийн ургамал	
			Хураасан талбай га	Авсан ургац тн	Хураасан талбай га	Авсан ургац тн	байцаа	манжмн	лууван	сонгино	Өргөст хэмх	улаанлооль	Тарvas гуа			бусад
1	Баяндалай	136,2	3	54.4	1.41	14.8	2.3	3.64	3.3	2.6	1	1	0.79	0.2	-	67.0
2	Баян-Овоо	34.3	3	21	1.5	4.8	0.6	0.7	1.2	1.4	0.6	0.3	-	-	-	8.5
3	Булган	379,7	8.5	107.6	10	241.9	13.5	8.4	30	37	25	110	18	-	0.2	30
4	Гурвантэс	143.1	8.8	66,5	4.2	42,6	5,6	10	7,5	4,8	4,2	3,9	3	3,6	0.03	34
5	Мандал-Овоо	23,8	1.5	19	0.4	4,8	-	1	1	1,8	0,4	0,4	0,2	-	-	-
6	Манлай	73.4	2.4	18	2.1	22,8	2	4,2	3	2,1	5,6	4,1	1,8	-	-	32,6
7	Номгон	80,5	4.7	39,5	3.1	29,	1,5	7,1	8	4,5	1,8	3,1	2	1	-	12
8	Ноён	8,4	1.3	6	1	2,4	-	0.6	0.4	0.2	0.2	0.2	-	0.8	-	-
9	Сэврэй	15	2	10	0.3	3	0.1	0.7	0.6	0.6	-	0.2	0.8	-	-	2
10	Ханбогд	7,5	1.5	4	1.8	3,5	-	0,1	0,2	0,2	1	1	1	-	-	-
11	Ханхонгор	183,7	13.6	115	2.42	26.4	1.8	3.5	4.4	12.8	1.3	2.6	-	-	1.5	40.8
12	Хүрмэн	29,2	2.5	15,	1.7	12,6	08	2.4	2,2	3,2	1,6	1,6	0,1	0,7	0.1	1.5
13	Цогт-Овоо	21.	1.5	15	0.5	6	-	1,5	2	0,7	0,8	0,5	0,5	-	0.03	-
14	Цогт-Цэций	150.2	4	60	4.6	74.7	-	20	15	10	7.2	10	12.5	-	0.5	15
15	Даланзадгад	226.4	12.3	96	13.3	112,1	9.5	34	25.1	24	6.3	4.7	6.8	1.7	2.3	16
Дүн		1512,4	70.7	647,	47.9	601,4	37,7	97,84	103,9	105,9	57	143,6	47,49	8	4.65	259,4
Жилийн хэрэглээ 1 хүний				51,1		73	24,1	30,0		10,6	2,9	5,5			65,7	

Жич: малын тэжээлд голлон эрдэнэ шиш, овъёос, ерхөг, өлөн, согоовор, царгас тариалж ногооноор нь хураан хатааж авсан.

ТАВДУГААР БҮЛЭГ. ХҮН АМ, СУУРЫШЛИЙН БҮС НУТАГ**5.1. Хот тосгон бусад суурин газрын ангилалын газрын өнөөгийн байдал**

Хот тосгон бусад суурин газрын нийт талбай 44719,53га бөгөөд үүнээс уул уурхайн газар 24687,45га, үйлдвэрийн газар 15797,1га болж тус тус нэмэгдсэн байна. Мөн барилга байгууламж бүхий газар 748га-р, нийтийн эдэлбэр газар 1296,6га-р, гэр хороололын газар 1716,7га-р тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт № 5.1. Хот, тосгон, бусад суурин газрын эзлэх талбай

№	Сумын нэр	Нийт талбай	Барилга байгууламжийн дэвсгэр газар	Нийтийн эдэлбэрийн газар	Үйлдвэрийн газар	Уурхайн дэвсгэр газар	Гэр хорооллын газар
1	Баяндалай	109.7	26.7	29.9		0.0	53.2
2	Баян-Овоо	15138.7	23.4	37.8	15031.1	6.9	39.4
3	Булган	224.3	51.2	32.9		100.0	40.2
4	Гурвантэс	3581.6	61.3	12.9	334.5	3040.0	132.8
5	Даланзадгад	1865.9	206.3	799.9	23.9	0.0	835.7
6	Мандал-Овоо	908.6	9.5	45.0	1.5	822.7	29.8
7	Манлай	360.5	6.6	29.2	188.0	10.0	126.8
8	Номгон	1233.8	12.1	45.9	0.6	1131.7	43.5
9	Ноён	184.1	7.2	30.9	2.0	112.0	32.0
10	Сэврэй	76.2	11.8	14.9		0.0	49.6
11	Ханбогд	4268.7	115.0	37.1	111.0	3570.5	435.2
12	Ханхонгор	7790.2	95.8	74.4		7594.1	25.9
13	Хүрмэн	215.3	5.7	36.6	16.0	131.0	25.9
14	Цогт-Овоо	55.0	7.1	28.4		0.3	19.2
15	Цогтцэций	8707.1	108.9	40.8	88.5	8168.2	300.7
	Дүн	44719.5	748.5	1296.6	15797.1	24687.5	2189.8

Хүснэгт № 5.2 Өмнөговь аймгийн суурьшлийн тогтолцоо

Эх сурвалж* Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн яам <<Бүлэг суурингийн тогтолцоо>> төсөл

№	Бүлэг суурингийн төвийн нэр	Хамрагдах сум суурины нэр
1	Даланзадгад	Булган, Мандал-Овоо, Хүрмэн, Ханхонгор, Баяндалай, Цогт-Овоо, Номгон
2	Сэврэй	Ноён, Гурвантэс Нарийн сухайт /Давсны үйлдвэр/
3	Цогтцэций /Тавантолгой/	Манлай
4	Баян-Овоо	Ханбогд /Оюутолгой/

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 6-р сарын 02-ны өдрийн “Тусгай хэрэгцээний газарт хамруулах тухай” 14-р тогтоолоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюутолгой орд газрын орчим орших 7736.1 га, Цогтцэций сумын Тавантолгойн орд газрын орчим орших 3661.3 га газрыг тус тус тусгай хэрэгцээнд доорхи хүснэгтэд заасан зориулалтаар авсан бөгөөд томоохон хот суурин үүсэхээр тооцсон байна.

Хүснэгт № 5.3 Өмнөговь аймагт шинээр үүсэх суурингийн хил зааг

№	Газрын нэр	Солбицол	
		Өргөрөг	Уртраг
1	Өмнөговь аймгийн Ханбогд сум /Хот, тосгон/	43°11'28.456"	107°10'27.279"
		43°11'30.258"	107°12'40.429"
		43°13'28.277"	107°10'27.990"
		43°13'27.042"	107°12'49.530"
2	Өмнөговь аймгийн Цогтцэций сум /Хот, тосгон/	43°42'16.991"	105°32'02.408"
		43°42'11.563"	105°36'17.184"
		43°45'01.883"	105°31'57.057"
		43°45'07.308"	105°36'18.322"

Дээрх хоёр уурхайд ажиллах ажилтан, ажилчид, тэдгээрийн гэр бүлийн ажиллаж амьдрах эрүүл, аюулгүй, тав тухтай орчин бий болсноор Үндсэн хуульд заасан үүргээ Засгийн газар биелүүлнэ, мөн байгалийн баялгийг ашиглаж дууссаны дараа эдгээр хот нь Эрдэнэт, Багануур хот шиг бүсийн төв болон хөгжих боломжтой болно.



Зураг№ 5.2. Тусгай хэрэгцээнд авсан Ханбогд сумын төв орчмын хот байгуулах, өргөжин тэлэх бүс



Зураг№ 5.3. Тусгай хэрэгцээнд авсан Цогтцэций сумын төв орчмын хот байгуулах, өргөжин тэлэх

Хүснэгт № 5.5. Хилийн боомтуудын үйл ажиллагаа, ашиглалтын байдал

№	Байршил аймаг, сум, боомтын нэр	Аль улстай хиллэдэг	Боомтын төрөл ангилал	Экспорт	Импорт
1	Өмнөговь Гурвантэс Шивээ хүрэн	БНХАУ	2 талын, байнгын	Нүүрс экспортлодог /Саус гоби сэндс, Чинхуа-МАК-Нарийн сухайт, Монголын алт (МАК) зэрэг компаниуд нүүрс экспортлодог. Дээрх гурван компани 2012 онд 8 сая тонн нүүрс экспортлосон. Цаашид боомтын нэвтрүүлэх чадвар, зам тээврийн нөхцөл сайжирсан нөхцөлд төмрийн хүдрийн экспортын хэмжээ нэмэгдэнэ/	барилгын материал, техник, тоног төхөөрөмж
2	Өмнөговь Ханбогд Гашуун сухайт	БНХАУ	2 талын, байнгын	Нүүрс, Мал амьтны гаралтай түүхий эд, ашигт малтмал /Энержи Ресурс ХХК, Эрдэнэс Таван толгой ХХК, Таван толгой ХК зэрэг компаниуд нүүрс экспортлодог. Тус компаниуд 2012 онд 10,2 сая тонн нүүрс экспортлосон. Мөн тус боомтоор Хангад эксплоейшн, Мөнх ноён суварга зэрэг компаниуд нүүрс экспортлох бэлтгэлээ ханган ажиллаж байна. Түүнчлэн Оюу толгой ХХК мөн тус боомтоор зэс, алт, мөнгөний хам баяжмалаа экспортлох юм. Цаашид боомтын нэвтрүүлэх чадвар, зам тээврийн нөхцөл сайжирсан нөхцөлд нүүрсний экспортын 70-80%, зэсийн баяжмалын 70%-ийг экспортлох юм/	Хүнс, химийн бодис, ургамалын гаралтай түүхий эд, барилгын материал, техник, тоног төхөөрөмж

5.2. Даланзадгад хотын инженер-геологийн нөхцөл, ул хөрсний геотехникийн шинж чанарын үнэлгээ

Даланзадгад хотын байрлах газар нь Зүүн-Сайхан уулын бэл хормой бөгөөд баруун өмнөөсөө зүүн хойшоо чиглэлийн налуу гадаргуутай. Хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд хамгийн өндөр цэг нь далайн түвшинээс дээш 1051.0 м хамгийн нам цэг нь 1000.1 өндрийн зөрүү 50.5м байдаг. Талбайн хувьд цаашдаа өргөжиж тэлэх бүрэн боломжтой.

Хотын нутаг дэвсгэрт төрлийн 3 уст үе илэрэх бөгөөд эдгээрээс талбайн хэмжээнд өргөн тархалттай бөгөөд хот байгуулалтанд нөлөөлөх гол төрөл нь дээд болон орчин үеийн дөрөвдөгчийн настай Делюви-пролювийн хурдасанд байрлах уст үе юм. Хотын зүүн хэсгээр хөрсний ус 1-3 м-ийн гүнээс, хотын төв болон баруун хэсгээр ихэвчлэн 6 м-ээс доош гүнд илэрдэг. Энэхүү уст үе нь тэжээгдлийн чөлөөт гадаргатай бөгөөд том хэмхдэст шаварлаг хөрсөнд агуулагдана. Усны ундрага нь 1.2 л/сек, бетон эдлэлд идэмхий шинж чанар үзүүлэхгүй.

Делюви-пролювийн гаралтай шавранцар хөрс. Хөрсний найрлаганд хэмхдэс материал 7.7 %, төрөл бүрийн ширхэгтэй элс 37.5 %, тоосорхог хэсэг 30.4 %, шаварлаг хэсэг 24.4 %-ийн агуулагатай. Хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг 5.6.-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт № 5.6. Шавранцар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүд

№	Хөрсний үзүүлэлтүүд	Дундаж утга	Тодорхойлсон дээжний тоо
1	Байгалийн чийг	0.141	33
2	Эзэлхүүний нягт	1.98	35
3	Хувийн жин	1.78	35

4	Хатуулгийн хувийн жин	2.73	38
5	Сүвшил	3665	35
6	Сүвшлийн илтгэлцүүр	0.597	35
7	Чийглэгийн зэрэг	0.71	36
8	Урсалтын хязгаарын чийг	0.319	36
9	Имрэгдлийн хязгаарын чийг	0.163	36
10	Уян налархайн тоо	0.156	36

Механик шинж чанарын норматив үзүүлэлтүүд:

- Зууралдлын хүч $C = 0034$ МПа
- Дотоод үрэлтийн өнцөг $\phi = 24$ Град
- Хэв гажилтын модуль $E = 24$ МПа

Уг хөрсний хэв гажих модулийг лабораторийн туршилтын аргаар топооход байгалийн чийгтэй нөхцөлдөө $E = 10.0-10.6$ МПа усаар ханасан нөхцөлдөө $E = 5-7$ МПа байна. Хөрс бүх дээжинд хатуу констенцтэй тогтоогдсон.

Элсээр чигжигдсэн хайрган хөрс. Тухайн хөрсний 18 ш дээжинд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн дундаж утгаар хөрсний найрлаганд хэмхдэс материал 54.4 %, төрөл бүрийн ширхэгтэй элс 29.0 %, тоосорхог хэсэг 8.0 %, шаварлаг хэсэг 4.6 %-ийн агуулагатай байна. Физик үзүүлэлтүүдийг нэгтгэвэл:

- Хөрсний байгалийн чийг 0.045
- Эзэлхүүний нягт 2.22 г/см³
- Хэлхээдсийн хувийн жин 2.12 г/см³
- Хөрсний хувийн жин 2.72 г/см³
- Сүвшил 22.20 хувь
- Сүвшлийн илтгэлцүүр 0.29
- Чийглэгийн зэрэг 0.42 байна.

Механик шинж чанарын норматив үзүүлэлтүүд:

- Зууралдлын хүч $C = 0.002$ МПа
- Дотоод үрэлтийн өнцөг $\phi = 43$ град
- Хэв гажилтын модуль $E = 50$ МПа

Хайрга агуулсан шавар хөрс. Хөрсний найрлаганд хэмхдэс материал 20.2%, төрөл бүрийн ширхэгтэй элс 29.8%, тоосорхог хэсэг 24.7%, шаварлаг хэсэг 25.3%-ийн агуулагатай. Хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг 5.5-р хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт № 5.7. Хайрга агуулсан шавар хөрсний физик үзүүлэлтүүд

№	Хөрсний үзүүлэлтүүд	Дундаж утга	Тодорхойлсон дээжний тоо
1	Байгалийн чийг	0.171	20
2	Эзэлхүүний нягт	1.93	24
3	Эзэлхүүний нягт	1.64	24
4	Хатуу хэсгийн хувийн жин	2.73	24
5	Сүвшил	36.64	27
6	Сүвшлийн илтгэлцүүр	0.643	23
7	Чийглэгийн зэрэг	0.76	27
8	Урсалтын хязгаарын чийг	0.405	24
9	Имрэгдлийн хязгаарын чийг	0.192	24
10	Уян налархайн тоо	0.213	24

- Зууралдлын хүч $C = 0.069$ МПа

- Дотоод үрэлтийн өнцөг $\Phi = 20$ Град
- Хэв гажилтын модуль $E = 24$ МПа

Уг хөрсний хэв гажих модулийг лабораторийн туршилтын аргаар тогтооход байгалийн чийгтэй нөхцөлдөө $E=27$ МПа, усаар ханасан нөхцөлдөө $E=16$ МПа байна. Хөрс бүх дээжинд хатуу консистенцтэй тогтоогдсон. Уг хөрс нь устай үйлчилэлцэхдээ хөөлт үүсгэх шинж чанартай. Хөөлтийн үндсэн үзүүлэлтийг нэптэн 5.8.-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт № 5.8. Хөөлттэй шавар хөрсний үзүүлэлтүүд

№	Үндсэн үзүүлэлтүүд	Хамгийн их утга	Хамгийн бага утга	Дундаж утга
1	Харьцангуй өлөөт хөөлт	0.08	0.05	0.07
2	Үнэмлэхүй чөлөөт хөөлт	0.021	0.011	0.016
3	Хөөлтийн даралт кг/см ²	1.1	0.4	0.07
4	Хөөлтийн чийг	0.373	0.288	0.310
5	Даралтын утгууд дахь хөөлтийн хэмжээ	0.005	0.001	0.003
	0.5 кг/см ²	0.007	0.002	0.004
	1.0 кг/см ²	0.006	0.004	0.005
	2.0 кг/см ²	0.011	0.006	0.010
	3.0 кг/см ²			

Уг хөрсний харьцангуй чөлөөт хөөлт 0.07, харьцагуй шахагдлын илтгэлцүүр 0.006-0.01 байгаа нь устай харилцан үйлчилцэхдээ норм, дүрмийн дагуу сулавтар хөөлт, дунд зэргийн агшилт үүсгэнэ.

Шавар хөрс. Хөрсний найрлаганд хэмхдэс материал 6.8%, төрөл бүрийн ширхэгтэй элс 30.2%, тоосорхог хэсэг 30.5%, шаварлаг хэсэг 32.5%-ийн агуулагатай. Хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг 5.9.-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт № 5.9. Хөөлттэй шавар хөрсний физик үзүүлэлтүүд

№	Хөрсний үзүүлэлтүүд	Дээжийн тоо	Дундаж утга
1	Байгалийн чийг	21	0.170
2	Эзэлхүүний нягт	27	1.97
3	Хэлхээдсийн хувийн жин	26	1.71
4	Хувийн жин	33	2.73
5	Сүвшил	31	38.88
6	Сүвшлийн илтгэлцүүр	26	0.596
7	Чийглэгийн зэрэг	31	0.77
8	Урсалтын хязгаарын чийг	37	0.385
9	Имрэгдлийн хязгаарын чийг	37	0.188
10	Уян налархайн тоо	37	0.197

Хөрс хатуугаас агилуун консистенцтэй:

- Зууралдлын хүч $C = 0.11$ МПа
- Дотоод үрэлтийн өнцөг $\phi = 11$ Град
- Хэв гажилтын модуль $E = 26$ МПа

Уг хөрсний хэв гажих модулийг лабораторийн туршилтын аргаар тогтооход байгалийн чийгтэй нөхцөлдөө $E = 10.0-10.6$ МПа, усаар ханасан нөхцөлдөө $E = 5-7$ МПа байна. Хөрс бүх дээжинд хатуу консистенцтэй тогтоогдсон.

Шавранцар чигжээстэй хайрган хөрс. Хөрсний найрлаганд хэмхдэс материал 61.9 %, төрөл бүрийн ширхэгтэй элс 23.0 %, тоосорхог хэсэг 7.5 %, шаварлаг хэсэг 7.6 %-ийн агуулагатай. Хөрсний физик шинж чанарын үзүүлэлтүүдийг 5.10.-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт № 5.10. Шавранцар чигжээстэй хайрган хөрсний физик үзүүлэлтүүд

№	Хөрсний үзүүлэлтүүд	Дээжийн тоо	Дундаж утга
1	Байгалийн чийг	60	0.103
2	Эзэлхүүний нягт	47	2.02
3	Хэлхээсийн хувийн жин	49	1.83
4	Хатуу хэсгийн хувийн жин	72	2.74
5	Сүвшил	49	31.15
6	Сүвшлийн илтгэлцүүр	54	0.470
7	Чийглэгийн зэрэг	49	0.61
8	Урсалтын хязгаарын чийг	84	0.304
9	Имрэгдлийн хязгаарын чийг	84	0.160
10	Уян налархайн тоо	84	0.144

Хөрс бүх дээжний шинжилгээнд хатуу констенцтэй. Хээрийн нөхцөлд хийсэн туршилтын үр дүнгээр

Зууралдлын хүч $C = 0.05$ МПа

Дотоод үрэлтийн өнцөг $\phi = 22$ град

Хэв гажилтын модуль $E = 17$ МП

Даланзадгад хотын нутаг дэвсгэрийн геотехникийн нөхцөлийн онцлог:

Хотын нутаг дэвсгэр нь геотехникийн хувьд төвөгтэй нөхцөлд хамрагдана.

Хотын хэмжээнд тархсан шавар хөрс хөөлт үүсгэнэ.

Хотын нутаг дэвсгэр нь газар хөдлөлийн 8-9 балын бүсэд хамрагдана.

Хөрс нь давсжилт, хүлэржилтгүй.


ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР**6.1. Зам, шугам сүлжээний газрын өнөөгийн байдал**

Өмнөговь аймгийн хувьд авто зам тэргүүн зэргийн ач холбогдолтой. Өмнөговь аймгаас Улаанбаатар хот хүртэл зам нь зорчигч тээврийн гол зам бөгөөд 2014 онд хатуу хучилттай замтай болсон. Зам, шугам сүлжээний ангилалын газарт хот, тосгон, бусад суурин газрын тэг гортигийн гадаа байгаа улс, орон нутгийн чанартай замууд, эрчим хүч, холбооны шугамууд, ус дамжуулах хоолой, агаарын тээврийн газар зэрэг инженерийн шугаман байгууламжын доорхи газрууд тэдгээрийн хамгаалалтын зурвас газрууд хамрагддаг.

Газрын нэгдмэл сангийн ангиллаар 2005 онтой харьцуулсан байдлаар 16950.6 га талбайгаар буюу 171.1%-иар өсөн нэмэгдсэн байгаа юм. Энэ нь дэд ангилал тус бүр дээр өссөн дүнтэй байна. Үүнээс авто замын газар 4139.4 га буюу 50.6%–иар, Шугам сүлжээний газар 5478.2 га буюу 451%-иар, агаарын тээврийн газар 406.6 га буюу 86.2 %–иар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт № 6.1. Зам, шугам сүлжээний газрын өөрчлөлт /2005-2013он/

Сумдын нэр	2005	2013	Өөрчлөлт	Өсөлтийн хувь
Баяндалай	579.4	579.4	0.0	0.00
БаянОвоо	318.2	3406.5	3088.3	970.55
Булган	497.85	497.8	0.0	-0.01
Гурвантэс	920	2208.9	1288.9	140.09
Даланзадгад	487.02	545.2	58.2	11.95
Мандал-овоо	658.7	711.8	53.1	8.06
Манлай	810.6	1288.3	477.7	58.93
Номгон	408.1	504.9	96.8	23.71
Ноён	556.7	557.6	0.9	0.16
Сэврэй	483.2	484.0	0.8	0.17
Ханбогд	727.6	7589.6	6862.0	943.10
Ханхонгор	1154.5	1716.9	562.4	48.72
Хүрмэн	680	680.5	0.5	0.08
ЦогтОвоо	676	766.7	90.7	13.41
Цогтцэций	913.68	5284.1	4370.4	478.33
Нийт	9871.55	26822.1	16950.6	171.71



Зураг № 6.1. Зам шугам сүлжээний газрын өөрчлөлт

Аймгийн төв Даланзадгад хотоос сумдуудад хүрэх 1672 км шороон замтай. Харин Таван Толгойгоос Гашуун Сухайтын боомт хүртэл даацын 267 км хатуу хучилттай замыг Энержи ресурс компани өөрийн хөрөнгөөр барьж дуусгасан байна. Нарийн-сухайт-Шивээхүрэнгийн чиглэлд 43.2 км хүнд даацын машин явах боломжтой хатуу хучилттай авто замыг концессын гэрээгээр барьж 2014 оны 9 сард ашиглалтанд оруулжээ. Нийт 466.2 км хатуу хучилттай зам ашиглагдаж байна.

Тус аймагт уул уурхай эрчимтэй хөгжиж байгаа боловч хатуу хучилттай зам тавигдаагүй ердийн хөрсөн замаар хүнд даацын автомашинаар тээвэрлэлт хийж байгаагаас говийн эмзэг хөрс, ургамал авто замын тоос шороонд дарагдан, хөрс их хэмжээгээр эвдэрч, ургамлын бүрхэвч өөрчлөгдөж, байгаль-экологи их хэмжээгээр сүйтгэгдэх болсноос гадна зэрлэг болон ховор ан амьтан орон нутгаас дайжих, хорогдох зэрэг сөрөг нөлөөлүүд гарсаар байна.

Хүснэгт № 6.2. Өмнөговь аймгийн хот хоорондын болон уул уурхайн замуудын одоогийн байдал


Авто замын чиглэл, нэр	Хучилтын төрөл	Хүчин чадал /км/	Төсөвт өртөг тэрбум/төг
Мандалговь-Даланзадгад	Хатуу /хучилт	156.0	2014 онд баригдаж дууссан
Тавантолгой Гашуунсухайт	Хатуу хучилт	267.0	Баригдсан
Нарийнсухайт Шивээхүрэн	Хатуу хучилт	43.2	Концессоор баригдсан
Оюутолгой-Гашуунсухайт	Хатуу хучилт	90.0	Уурхайн хөрөнгөөр баригдсан
		466.2	
Оюунтолгой-Ханбогд-Ханги чиглэл	Ердийн хөрсөн	435.0	Концессийн тендер зарлагдсан
Цогт-Овоо-Цогтцэций	Ердийн хөрсөн	80.0	
Даланзадгад-Цогтцэций /Тавантолгой/	Ердийн хөрсөн	94.8	

Хүснэгт № 6.3. Сумууд аймгийн төвийн хоорондын замуудын одоогийн байдал

№	Авто замын чиглэл	Нийт зай /км/	Хучилтын төрөл
1	Баяндалай	84.0	Ердийн хөрсөн
2	Баян-Овоо	162.0	Ердийн хөрсөн
3	Булган	98.0	Ердийн хөрсөн
4	Гурвантэс	320.0	Ердийн хөрсөн
5	Даланзадгад		
6	Мандал-Овоо	140.0	Ердийн хөрсөн
7	Манлай	224.0	Ердийн хөрсөн
8	Номгон	106.0	Ердийн хөрсөн
9	Ноён	216.0	Ердийн хөрсөн
10	Сэврэй	214.0	Ердийн хөрсөн
11	Ханбогд	250.0	Ердийн хөрсөн
12	Ханхонгор	25.0	Ердийн хөрсөн
13	Хүрмэн	61.0	Ердийн хөрсөн
14	Цогт-Овоо	126.0	Хатуу хучилттай
15	Цогтцэций	98.0	Ердийн хөрсөн
		1672.0	

Үүнээс хатуу хучилттай	126.0	
------------------------	-------	--

Аймгийн төвийг сумын төвүүдтэй холбосон нийт замын урт нь 1672 км бөгөөд үүнээс Цогт-Овоо хатуу хучилттай замаар холбогдсон ба бусад сумдууд нь ердийн хөрсөн замтай байна.



Зураг № 6.2. Авто замын одоогийн байдал

Өмнөговь аймгийн зам тээврийн одоогийн байдлын SWOT шинжилгээ :

Давуу талууд :

- Улаанбаатар болон бусад хотуудтай хатуу хучилттай замаар холбогдсон
- Шинээр байгуулах замын чиглэл нь тодорхой концесс зарлагдсан
- Нутгийн баруун талаар босоо тэнхлэгийн чиглэлийн зам дайран өнгөрдөг
- Улсын чанартай замууд нь сумуудыг аймагтайгаа холбосон замтай давхцдаг
- Уул уурхай хөгжиж байгаас болон аймгийн хэмжээгээр автомашины тоо нэмэгдэж байгаагаас болж замын хөдөлгөөний эрчим жил бүр нэмэгдэж байгаа

Сул талууд :

- Нийслэл хотоос зайтай оршдог
- Ажил гүйцэтгэхэд улирлын чанартай байдаг
- Аймгийн төв нь сумуудтайгаа шороон замаар холбогдсон.
- Говийн эмзэг хөрс, ургамалтай

Боломж :

- Замын бэлэн суурь баазтай
- Байгалийн зам барилгын материалтай элбэгтэй
- Мэргэжлийн байгууллага, боловсон хүчинтэй

Аюул занал :

- Автозамын тоос шороо нь байгаль орчин бохирдуулах, бэлчээр сүйтгэх
- Зэрлэг ан амьтанд сөрөг нөлөө үзүүлэх
- Барьсан зам нь үеэр ус болон бусад байгалийн гэнэтийн аюулд өртөх магадлалтай
- Барьж байгуулахад байгалийн шалгуур өндөр

6.2. Агаарын тээврийн газрын хөгжил

Хувийн хэвшлийн хөрөнгөөр Өмнөговь аймгийн Овоот, Оюутолгойн хатуу хучилттай нисэх буудлууд ашиглалтанд орсон бөгөөд нисэх буух зурвас нь хатуу хучилттай буудлууд юм. Тус аймагт Агаарын тээврийн нислэгийн зурвас болон нислэгийн аюулгүй байдлыг хангах байгууламж бүхий 3 нисэх буудал нь Даланзадгад, Ханхонгор, Ханбогд сумдуудад байрладаг. Эдгээр газар нь нислэгийн стандартын дагуу байгуулагдсан учраас ашиглалт хамгаалалт нь сайн байна.

Хүснэгт№ 6.4. Агаарын тээврийн үзүүлэлт

Агаарын тээврийн компани	Онгоцны төрөл	Суудлын тоо	Өвлийн нислэгийн тоо	Зуны нислэгийн тоо
МИАТ ХХК	АН 24	42	2	2
Изинис эйрвэйс	СААБ	34	2	5-11
Аеромонгол ХХК	Фокер 50	50	Захиалгаар	Захиалгаар

Цаашид УГЗБЕТ-р нэг нисэх буудал шинээр төлөвлөсөн ба нисэх буудлын газар нь онцгой хамгаалалтын бүс, тусгай бүс, ойртолтын бүс газруудаас бүрдэх ба төлбөрөөс шалтгаалан зөвхөн онцгой хамгаалалтын бүсэд газар төлөвлөхийг санал болгож байсан боловч эрх зүйн актыг үндэслэн бүх бүсийг хамруулан газрыг төлөвлөв. Шинээр төлөвлөж буй нисэх буудлын нэг нь Даланзадгад суманд байгуулах юм.

Хүснэгт№ 6.5. Шинээр байгуулахаар төлөвлөж байгаа нисэх буудлын байгууламж

№	Аймгийн нэр	Аюулгүйн бүсийн хэмжээ (га)
1	Өмнөговь	800

6.3. Төмөр замын газрын хөгжил

Төмөр замын газар нь төмөр замын зурвас газар болон төмөр замын аюулгүй байдалд зориулан тогтоосон хамгаалалт (аюулгүйн)-ын бүсийн газраас бүтнэ. Төмөр замын зурвас газарт өртөө хоорондын болон салбар зам шугам, үйлдвэрлэл технологийн барилга төмөр замын холбоо, дохиолол, эрчим хүч, усан хангамж сүлжээний тоног төхөөрөмж замын далан, ул шороо гарам, гүүр, хоолой, хориг хашаа байрлахаас гадна төмөр замын дагуу тээврийн аюулгүй байдлыг хангах технологийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай орон зай багтана. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ийн баримт бичигт Монгол Улсад ойролцоогоор 5683.5 км төмөр замын суурь бүтцийг 3 үе шаттайгаар шинээр барихаар төлөвлөсөн байгаа. Тус аймгийн хувьд Даланзадгад-Таван толгой – Цагаан суварга – Зүүнбаян - 400 км, Нарийнсухайт – Шивээхүрэн - 45.5 км, Ухаа худаг – Гашуунсухайт - 267 км төмөр замыг 1-р ээлжинд барихаар төлөвлөсөн байна.

Хүснэгт№ 6.6. Төлөвлөсөн төмөр замд ашиглагдах газар

Аймгийн	Замын урт (км)	Замын	Өртөөний	Өртөөний
---------	----------------	-------	----------	----------

нэр	Нийт	Үүнээс өртөөний урт (км)	зурвас газар (га)	тоо (ш)	газар (га)
Өмнөговь	839	38	10072	19	1140

Хүснэгт № 6.7. Төлөвлөсөн төмөр зам

№	Сумын нэр	Урт м-ээр	Үүнээс
			Тусгай хамгаалалттай газар
1	Баян-Овоо	78040	
2	Гурвантэс сум	208047	90653
3	Манлай	30421	
4	Ханхонгор сум	60946	
5	Ханбогд	201642	
6	Цогт-Овоо	112210	
7	Цогтцэций	148032	
Дүн		839338	

6.4. Харилцаа, холбоо

Өмнөговь аймагт Монголын цахилгаан холбоо, Монгол шуудан компаниуд шуудангийн үйлчилгээг үзүүлдэг ба эдгээр компаниудын 60 орчим салбарууд үйл ажиллагаа явуулж байна. Бодлого судлалын төвийн судалгаанаас харахад сүүлийн жилүүдэд суурин телефон утас, телефон яриа, цахилгаан мэдээ, албан бичиг болон захидал илгээх зэрэг шуудан холбооны уламжлалт хэрэглээ буурч харин үүрэн телефон утасны хэрэглээ эрс нэмэгдсэн байна. Өмнөговь аймгийн хэмжээнд Мобиком, Скайтел, Юнител, Ж-мобайл, МЦХ зэрэг операторууд үүрэн телефоны үйлчилгээг үзүүлж байна. Аймгийн төвийн хүн амын 20 орчим хувь нь, сумдын хүн амын 2 орчим хувь нь интернэт хэрэглэж байна. Өмнөговь аймагт телевизийн 4 суваг, 2 сонин ажилладаг. Аймгийн телевиз нь 25 км-т нэвтрүүлгээ цацдаг. Малчин өрхүүдийн ихэнх нь радио эсвэл сансрын антенаар дамжуулан үндэсний радио, телевизийн нэвтрүүлгийг хүлээн авч үздэг.

6.5. Эрчим хүч, дулаан хангамжийн байдал

Өмнөговь аймгийн Даланзадгадын Дулааны цахилгаан станц 2000 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд ашиглалтын байдлаас хамаарч 2008 он хүртэл ихээхэн доголдож, осол аваар саатал гарч хүндрэлтэй ажиллаж ирсэн тул 2008 оны 6 сараас Улаанбаатарын 4-р цахилгаан станцад менежментийн гэрээгээр өгч ажиллуулсан. Одоо хэвийн ажиллаж байгаа.


Даланзадгадын дулааны цахилгаан станц жилдээ 16 сая кВт.цаг цахилгаан үйлдвэрлэж, 11.7 сая кВт.цаг цахилгаан, 19.2 мян.Гкал дулааныг хэрэглэгчдэд түгээж байна. Өвлийн оргил ачаалал 3.6 МВт. Суурилагдсан чадал нь 5.4 МВт боловч хэрэглээний өсөлт, станцын ашиглалтын байдал, ажиллагааны хүндрэлээс болж нэг зуух, нэг турбин ажиллуулан их ачаалал, аваргийн үед дизель станц ажиллуулах шаардлага гардаг.

Цаашид бүс нутгийг хэрхэн цахилгаанаар хангах вэ гэдгийг цогцоор нь авч үзэх шаардлагатай. Энэ бүс нутагт шинээр барих эх үүсвэрийг Монгол орны цахилгааны хэрэглээний өсөлт, хэтийн төлөв, уул уурхайн салбарын хэтийн төлөв, цаашдын хөгжил, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн талаар баримтлах хэтийн чиглэл, бодлого хэрэгжүүлэх арга замтай уялдуулан шийдэх нь оновчтой гэж үзэж байна. Үүнд:

- Шинэ эх үүсвэр нь ойрын жилүүдэд зайлшгүй шаардагдаж байгаа цахилгааны хэрэглээг хэрхэн оновчтой хангах вэ гэдгийг тооцох,
- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний тогтвортой, найдвартай ажиллагаа, бие даасан байдлыг хангахад чухал нөлөөтэй байх, баруун зүүн бүсийн системтэй зэрэгцээ ажиллагааг хангахад горимын хувьд хамгийн оновчтой байх,
- Сэргээгдэх эрчим хүчний томоохон эх үүсвэр барьж нэгдсэн сүлжээнд холбох зэрэг зарчмын асуудлуудыг хамгийн зөв шийдэх үүднээс хандах шаардлагатай юм.

Хүснэгт№ 6.8. Эрчим хүчний шугам, станцын эзлэх тайлбайн хэмжээ /га/

Сумдын нэр	2013
Баяндалай	25.0
Баян-Овоо	122.0
Булган	0.1
Гурвантэс	150.3
Даланзадгад	64.3
Мандал-Овоо	52.9
Манлай	412.1
Номгон	91.5
Ноён	0.0
Сэврэй	0.0
Ханбогд	106.6
Ханхонгор	618.0
Хүрмэн	53.4
Цогт-Овоо	0.0
Цогтцэций	629.1
Нийт	2325.3



Зураг № 6.3. Эрчим хүчний шугам, станцын эзлэх тайлбайн өөрчлөлт

Хүснэгт № 8.9. Цахилгаан хангамжийн судалгаа

Аймгийн нэр	Нийт сумдын тоо	Дотоодын төвлөрсөн цахилгаан хангамжийн системд өндөр хүчдэлийн ЦДАШ-р холбогдсон сумд	Нар салхины эрчим хүчний станцаар хангагдаж буй сумд	ОХУ, БНХАУ-ын хил орчмын эрчим хүчний системд ЦДАШ-р холбогдсон сумд	Төвлөрсөн цахилгаан хангамжинд холбогдоогүй дан ганц Дизель станцаар хангагдаж буй сумд	Тайлбар
Өмнөговь	15	8	1	3	-	2 сум ТЭХС-д, 9 сум Даланзадгадын ДЦС-д холбогдсон. Ноён, Сэврэй, Гурвантэс сумд Нарийнсухайтын уурхайн БНХАУ-аас татсан 35 кВ-ын ЦДАШ-д холбогдсон. Цогтцэций сум Тавантолгойн уурхайн хооронд 10 кВ-ын ЦДАШ баригдсан, Ухаахудаг ДЦС-д холбогдоно. Манлай суманд СЭХ-ний эх үүсвэр суурилагдсан. Баян-Овоо, Ханбогд сумын асуудал Оюутолгойн хангамжтай холбогдон шийдэгдэнэ. Эдгээр сумдыг Тавантолгой, Оюутолгойд баригдах 220 кВ-ын дэд станцуудад 35 кВ-ын ЦДАШ-р холбох БУА-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

Хүснэгт № 6.10. Сумдын төвийг цахилгаанаар хангах зорилгоор байгуулсан нар, салхи, усан цахилгаан станцын ашиглалтын одоогийн байдал


Аймгийн нэр	Эрчим хүчний эх үүсвэрийн чадал	Ашиглалтанд орсон огноо	Тайлбар	
СЦС				
1	Сэврэй	80 кВт	11/26/2008	Инвертор нь удаа дараа гэмтэж байсан.
НЦС				
1	Ноён	200 кВт	9/10/2003	Аккумулятор муудсан байгаа
НЦС+СЦС				
1	Манлай	PV(30)/WP (120) 150 кВт	Улсын комисс ажиллаагүй	Инвертор болон контроллер нь ажиллагаагүй болсон.

Хүснэгт № 6.11. Эрчим хүчний төвлөрсөн эх үүсвэрт холбогдоогүй сумдын жагсаалт

2012 онд багтан төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдох сумд	2015 онд багтан төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдох сумд	Төвлөрсөн цахилгаан хангамжид ойрын хугацаанд холбогдохгүй сэргээгдэх эрчим хүчээр хангагдах сум
Ноён, Сэврэй, Эх үүсвэр “УГЗБЕТ-нөөс”	Баян-Овоо, Ханбогд	Манлай,

Оюутолгойн уурхайг цахилгаанаар хангахын тулд Улаанбаатар-Мандалговь-Оюутолгой гэсэн чиглэлд 220 кВ-ын хүчдэлтэй өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах

шугам татах зайлшгүй шаардлагатай. Энэ шугам нь тус уурхайн эхний 3-5 жилийн цахилгааны хэрэгцээг бүрэн хангаж чадах бөгөөд нэгдсэн систем талаас цахилгаанаар хангах нэг эх үүсвэр нөгөө талаас шинээр барих эх үүсвэрийг одоогийн системтэй зэрэгцээ ажиллуулах холбоос шугам болж өгнө.



Зураг№ 6.4. Сумдын төвийг цахилгаанаар хангах зорилгоор байгуулсан нар, салхи, усан цахилгаан станцын ашиглалтын одоогийн байдал

Хүснэгт№ 6.12. Өмнөговь аймгийн эрчим хүч

№	Сумдын нэрс	Эх үүсвэр	Ашиглалтанд орсон хугацаа	Хүчин чадал	Хөрөнгө оруулалт /сая ₮/
1	Ханбогд	Дизель станц	2000	60х2 кВт	
2	Манлай	Нар, салхи хосолсон цахилгаан станц	2011	Нар 30 кВ, салхи 120 кВ	910
3	Баяновоо	Дизель станц	2000	60х2 кВт	
4	Цогтцэций	Тавантолгойгоос 10 кВ-ын 12,4 км ЦДАШ	2008	10/0.4 кВ-ын 1х0.1, 1х0.16 МВА дэд станц	300
5	Номгон	Даланзадгад сумаас 15 кВ-ын 101.2 км ЦДАШ	2007	6/15 кВ-ын 1х0.25 МВА, 15/0.4 кВ-ын 2х0.1 МВА дэд станц	1168.0
6	Цогт-Овоо	Дундговь аймгийн Хулд сумаас 15 кВ-ын 91.922 км ЦДАШ	2008	10/15 кВ-ын 1х0.25 МВА 15/0.4 кВ-ын 1х0.1, 1х0.16 МВА дэд станц	1025
7	Хан-Хонгор	Даланзадгад сумаас 10 кВ-ын 24км ЦДАШ	2009	10/0.4 кВ-ын 1х0.1, 1х0.16 МВА дэд станц	580
8	Даланзадгад	Даланзадгад ДЦС	2000	5,4 МВт	
9	Мандал-Овоо	Дундговь аймгийн Сайхан-Овоо сумаас 15 кВ-ын	2007	0.4/15 кВ-ын 1х0.25 МВА, 15/0.4 кВ-ын 1х0.16, 1х0.1	1140

		99,26 км ЦДАШ		МВА дэд станц	
10	Хүрмэн	Даланзадгад сумаас 35 кВ-ын 48.3 км ЦДАШ	2008	110/35/10кВ-ын дэд станц 2х10МВА 35/6 кВ-ын дэд станц 2х10 МВА	621.3
11	Булган	Жуулчин говиос сумаас 15 кВ-ын 59,75 км ЦДАШ		10/15 кВ-ын 1х0.4, 2х0.25 МВА дэд станц	732.2
12	Баяндалай	Хүрмэн сумаас 10 кВ-ын 49,5 ЦДАШ	2002	10/0.4 кВ-ын 1х0.1, 1х0.16 МВА дэд станц	234.5
13	Сэврэй	Ноён сумаас 15 кВ-ын ЦДАШ дизель станц, Салхин станц	2011	60х2, 1х0.1, 1х0.16 МВА дэд станц, Салхин станц 80 кВт	389,4 /Салхин станц/
14	Ноён	Нарийн сухайтаас 35 кВ-ын 86,1 км ЦДАШ, Нарны ЦС	2011	35/15 кВ-ын 1х0.63 мВА, 2х0.16 МВА дэд станц, Нарны ЦС 200 кВт	1320 ЦДАШ 2 сая \$ /НЦС/
15	Гурвантэс	Нарийнсухайтаас 10 кВ-ын ЦДАШ	2009	10/0.4 кВ-ын 1х0.1, 1х0.16 МВА дэд станц	Хувийн ХО

Даланзадгадын эрчим хүчний систем нь Төвийн эрчим хүчний системтэй харьцуулахад тун жижиг систем юм. Гэхдээ Даланзадгадын эрчим хүчний систем /ДЭХС/, Тавантогой, Оюутолгойн уурхайн улмаас хэрэгцээ хурдан өсөхөөр байна. Цахилгааны хэрэглээ, хэрэгцээний тоо хэмжээг Эрчим хүчний газраас авсан. Эдгээр тоо хэмжээ нь түүхэн чиг хандлагатай харьцуулан загвар гаргаж хэтийн таамаглалыг нарийн гаргах үндэс болсон.


ДОЛООДУГААР БҮЛЭГ. ОЙН САН БҮХИЙ ГАЗАР**7.1. Ой сан бүхий газрын өнөөгийн байдал**

Ойн сан бүхий газар тус аймгийн хувьд заган ой, түүний эзэлж буй талбайн цоорхой, мод үржүүлгийн талбай, ойн аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд олгосон газар зэргээс бүрдэнэ. Аймгийн ойн сангийн эдэлбэр газар 1173.0 мян.га буюу нийт нутгийн 7.1%-г эзэлж байна. Энэ нь улсын заган ойн фондын 26%-тай тэнцэх талбай юм. Заган ойн фондын газар тус аймгийн Цогтцэций, Ханхонгор хоёроос бусад сумдад тодорхой хэмжээгээр байдаг боловч Гурвантэс, Хүрмэн, Ханбогд сумдад нийт заган ойн сан бүхий газрын 68.2% нь байгаа юм. Заган ойн сан бүхий газрын 31.6% нь загаар бүрхэгдсэн талбай байдаг ба үүний 36% нь дунд зэргийн сэргэн ургалттай 63.3% нь хангалтгүй буюу муу ургалттай байна.

Зулзаган загтай газар Мандал-овоо, Булган, Сэврэй, Цогт-овоо сумдын нутгаар, хөгширсөн загтай газар Гурвантэс, Ноён, Баяндалай, Хүрмэн сумдын нутгаар зонхилжээ.

Хүснэгт № 7.1. Өмнөговь аймгийн заган ойн талбай /га/

Д/д	Аймаг сум	Байгалийн заган ой	Тармаг заг	Загжих талбай	Ойн дүн	Үүнээс ТХГ
1	Цогт-овоо	7892	1072		8964	
2	Гурвантэс	458842	124144		582986	316408
3	Сэврэй	64336	3396		67732	67574
4	Мандал-овоо	48848	4132		52980	
5	Ноён	20570	22416		42986	
6	Баяндалай	51532	9972		61504	
7	Булган	20801	2688		23488	
8	Хүрмэн	65164	19232			920
9	Номгон	27572	24700		52272	42335
10	Баян-овоо	55356			55356	55356
11	Манлай	4092	4240		8332	-
12	Ханбогд	96460	36444		132904	2774
13	Даланзадгад			82	82	
Аймгийн дүн		921465	252436	82	1173983	485367



Зураг №7.1. Өмнөговь аймгийн ойн сан бүхий газар

Хүснэгт № 7.2. Өмнөговь аймгийн ойн сангийн нөөц

Сумын нэр	Байгалийн ойн нөөц / м ³ /	Тармаг мод нөөц / м ³ /	Бүлэг модны нөөц / м ³ /	Нийт ургаа нөөц / м ³ /	Хатсан модны нөөц / м ³ /	Нийт нөөц / м ³ /
Баяндалай	79624	11176		90800	124	90924
Баян-овоо	57971	22609		80580		80580
Булган	24072	214		24286		24286
Гурвантэс	288206	52154		340360		340360
Ханбогд	109963	18013		127976	3737	131713
Хүрмэн	188358	28444		216802	12781	229583
Мандал-овоо	26830	2822		29652		29652
Манлай	5766	901		6667	89	6756
Номгон	23261	6508	484	30253		30253
Ноён	42456	10409		52865	1529	54394
Сэврэй	110886	11049		121935		121935
Цогт-овоо	2311	3008		5319		5319
Цогтцэций		0,3		0,3		0,3
	959704	167307,3	484	1127495,3	18260	1145755,3


Ойн нийт нөөцийн 83.76% -ийг байгалийн ой, 14,64%-ийг тармаг мод, 1.60%-ийг хатсан мод тус тус эзэлж байна.

Байгалийн ойн нийт нөөцийг модны төрөл тус бүрээр авч үзвэл 939164 м³ –г заг, 14860 м³-г тоорой, 5680 м³-г хайлаас эзэлнэ.

7.2 Ойн бүс

Тус аймгийн ойн сан “Ойн тухай хууль”-ийн 8.1-д зааснаар бүгд Хамгаалалтын бүсийн ойд хамаарч байна.

Хамгаалалтын бүсийн ой нь “Ойн тухай” болон бусад холбогдох хууль тогтоомжийн заалтуудын дагуу доорх төрлүүдэд ангилагдана.



Зураг № 7.2. Ойн сан бүсээр

Дархан цаазат, Байгалийн цогцолборт болон дурсгалт газрын ойд тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу ашиглалт хамгаалалтын дэглэмийг зохицуулна.

Хүснэгт № 7.3. Ойн сангийн газрын төрлийн нэгтгэл модны төрлөөр /га/

Модны төрөл	Ойгоор бүрхэгдсэн			Ойгоор бүрхэгдээгүй				Ойн талбайн дүн
	Байгалын ой	Сөөг торлог	Дүн	Хатсан	Тармаг	Заг түүсэн	Загжиж байгаа	
Дархан цаазат газрын онгон бүс								
Заг	985		985		5690		949	6639
Тоорой	29		29					29
Хайлаас					642			642
Сухай		32	32					32
Харгана		318	318					318
дүн	1014	350	1364		6332		949	7281
Дархан цаазат газрын хамгаалалтын бүс								
Заг	3962		3962		4142		1352	5494
Хайлаас					249			249
Сухай		43	43					43
Харгана		210	210					210

дүн	3962	253	4215		4391		1352	5743	9958
Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс									
Заг	38908		38908		29321		1248	30569	69477
Хайлаас					81			81	81
дүн	38908		38908		29402		1248	30650	69558
Дархан цаазат газрын орчны бүс									
Заг	6321		6321		5828			5828	12149
Тоорой	101		101						101
Хайлаас					189			189	189
Сухай		190	190						190
Харгана		993	993						993
дүн	6422	1183	7605		6017			6017	13622
Дархан цаазат газрын дүн									
Заг	50176		50176		44981		3549	48530	98706
Тоорой	130		130						130
Хайлаас					1161			1161	1161
Сухай		265	265						265
Харгана		1521	1521						1521
дүн	50306	1786	52092		46142		3549	49691	101783
Байгалын цогцолборт газрын онцгой бүс									
Заг	57249		57249		38965,00			38965	96214
Байгалын цогцолборт газрын хязгаарлалтын бүс									
Заг	73591		73591		105189			105189	178780
Сухай		3	3						3
дүн	73591	3	73594		105189			105189	178783
Байгалын цогцолборт газрын аялал жуулчлалын бүс									
Заг	74877		74877		107293			107293	182170
Байгалын цогцолборт газрын орчны бүс									
Заг	51596		51596		64318			64318	115914


Байгалын цогцолборт газрын дүн									
Заг	257313		257313		315765			315765	573078
Сухай		3	3						3
дүн	257313	3	257316		315765			315765	573081
Баян бүрдийн болон бусад заган ой									
Заг	281559		281559	815	193759	587	308	195469	477028
Тоорой	87		87		102			102	189
Хайлаас	142		142		61			61	203
Сухай		172	172						172
Харгана		10683	10683						10683
Бүйлс		842	842						842
дүн	281788	11697	293485	815	193922	587	308	195632	489117
Улсын хилийн дагуух заган ой									
Заг	15340		15340		9902			9902	25242
Тоорой	3		3						3
дүн	15343		15343		9902			9902	25245
Аймгийн хэмжээгээр									
Заг	604388		604388	815	564407	587	3857	569666	1174054
Тоорой	220		220		102			102	322
Хайлаас	142		142		1222			1222	1364
Сухай		440	440						440
Харгана		12204	12204						12204
Бүйлс		842	842						842

дүн	604750	13486	618236	815	565731	587	3857	570990	1189226
-----	--------	-------	---------------	-----	--------	-----	------	---------------	----------------

7.2.1. Ойн сангийн үндсэн үзүүлэлт

Талбай: Ойн санг ойн талбай, ойн бус талбай гэсэн үндсэн хоёр хэсэгт ангилна. Ойн талбай нь дотроо ойгоор бүрхэгдсэн, ойгоор бүрхэгдээгүй талбай гэж хоёр хуваагдана. Ойгоор бүрхэгдсэн талбайд тухайн судалгааны үед ойтой байгаа (0.3 ба түүнээс дээш өтгөрөлтэй) болон улсын ойн санд шилжүүлсэн таримал ой, бут сөөгөөр битүү хучигдсан талбай орох ба ойгоор бүрхэгдээгүй ойн талбайд одоогийн байдлаар ой байхгүй боловч цаашдаа ой ургах нөхцөл бололцоотой газрууд (ойжиж байгаа газар, тармаг модод, ойжуулсан талбай), урьд өмнө ойтой байсан талбай (шатсан ой, мод бэлтгэсэн талбай г.м) тус тус хамрагдана.

Ойн бус талбайд ойн сан доторх цагаан энгэр, таг царам, хадлан, бэлчээр, гол, жижиг нуур цөөрөм, намаг, элс, мод үржүүлгийн талбай зэрэг газрууд орно.



Зураг№ 7.3. Ойн сангийн талбай газрын төрлөөр ангилагдсан байдал

Ойн сангийн нийт талбайн 51.99%-ийг ойгоор бүрхэгдсэн, 48.01% нь ойгоор бүрхэгдээгүй талбай байна. Ойгоор бүрхэгдсэн талбайн 97.82%-ийг байгалийн ой, 2.18%-ийг бут сөөг, ойгоор бүрхэгдээгүй талбайн 99.08%-ийг тармаг заг, 0,68%-г байгалийн аясаар загжиж, 0,10%-г заг түүсэн, 0,14-ийг хатсан заг бүхий талбай тус тус эзэлж байна.


Тус аймгийн ой гарал үүслийн хувьд өөрөө аясаараа сэргэн ургасан байгалийн ой бөгөөд бүрэлдэхүүний хувьд заг мод бүхий ой зонхилно.

Байгалийн ойн талбайг модны төрлөөр авч үзвэл

Заг(HaIokyIon ammodendron) 604388 га,

Тоорой (Populus Diversifolia) 220 га,

Хайлаас(Ulmus pumila) 142 га талбайг тус тус эзлэн ургаж байна.




Зураг№ 7.4. Байгалийн ойн нөөц модны төрлийн эзлэх хувь

7.2.2. Заган ой, насны анги, бүлэг

Тус аймгийн ойн сангийн байгалийн ойг “Ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх заавар”-т заасан ангилалаар залуу, дунд насны, болц гүйцэж яваа, болц гүйцсэн ой, өтөлсөн хөгшин гэсэн насны бүлгүүдэд ангиллаа. Заган ой нь бусад модны адил тооны ба байгалийн сэргэн ургалтын болцоос гадна тэжээлийн болон хөрс хамгаалах болц байдгаараа онцлог юм.

Сайр садаргын, шал тойрмын, чулуут цөлийн хэвшинжийн заган ойд бэлчээрийн ургац нэмэгдүүлэх, элсний заганд хөрс хамгаалах аж ахуйн хэлбэрийг бий болгох ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх нь тохиромжтой. Насны YI /26-30насанд/ ангийн заган ой нь элс бэхжүүлэх, салхины хүч нөлөөллийг бууруулах дээд зэргийн чадвартай болдог ба үүнийг хамгаалалтын болцын нас гэж үздэг.



Зураг №7.5. Өмнөговь аймгийн ойн тархалтын зураг

Хүснэгт № 7.4. Насны бүлгээр тархах нь

Модны гөрөл	Насны бүлэг											
	Залуу		Дунд насны		БГЯ ой		Болц гүйцсэн		Өгөлсөн хөгшин		Дүн	
	Талбай	нөөц	Талбай	нөөц	Талбай	нөөц	Талбай	нөөц	Талбай	нөөц	Талбай	нөөц
Дархан цаазат газрын онгон бүс												
Заг							985	985			985	985
Тоорой	15	600					14	1120			29	1720
дүн	15	600					999	2105			1014	2705
Дархан цаазат газрын хамгаалалтын бүс												
заг	334	66			569	113	682	794	2377	4229	3962	5202
Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс												
Заг			799	160	2476	1618	11836	17398	23797	40228	38908	59404
Дархан цаазат газрын орчны бүс												
Заг	656	524	97	20			2721	1290	2847	4676	6321	6510
Тоорой					101	8080					101	8080
дүн	656	524	97	20	101	8080	2721	1290	2847	4676	6422	14590
Дархан цаазат газрын дүн												
заг	990	590	896	180	3045	1731	15239	19482	30006	50118	50176	72101
Тоорой	15	600					115	9200			130	9800
дүн	1005	1190	896	180	3045	1731	15354	28682	30006	50118	50306	81901
Байгалын цогцолборт газрын онцгой бүс												
Заг							54450	85924	2799	5417	57249	91341
Байгалын цогцолборт газрын хязгаарлалтын бүс												
Заг	272	55	853	1195	5656	6520	63177	102688	3633	13572	73591	124030
Байгалын цогцолборт газрын аялал жуулчлалын бүс												
Заг	772	155	706	142	3393	678	51014	84134	18992	45818	74877	130927
Байгалын цогцолборт газрын орчны бүс												
Заг					2503	500	38582	18238	10511	23921	51596	42659
Байгалын цогцолборт газрын дүн												
Заг	1044	210	1559	1337	11552	7698	207223	290984	35935	88728	257313	388957
Баян бүрдийн болон бусад заган ой												
Заг	6191	1826	8351	2014	573	1146	85298	77214	181146	381672	281559	463872

Тоорой	4	160			39	3900	44	880			87	4940
Хайлаас	142	5680									142	5680
дүн	6337	7666	8351	2014	612	5046	85342	78094	181146	381672	281788	474492

Улсын хилийн дагуух заган ой

Заг					15340	14234					15340	14234
Тоорой					3	120					3	120
дүн					15343	14354					15343	14354

Аймгийн хэмжээгээр

Заг	8225	2626	10806	3531	30510	24809	307760	387680	247087	520518	604388	939164
Тоорой	19	760			42	4020	159	10080			220	14860
Хайлаас	142	5680									142	5680
нийт	8386	9066	10806	3531	30552	28829	307919	397760	247087	520518	604750	959704

Заган ой 10-25 насандаа малд тэжээллэг чанар сайтай, ногоон мөчир, салмааны ургац өгөх үнэмлэхүй дээд хэмжээндээ хүрч тэжээлийн хамгийн их өгөөжтэй болох тул энэ үеийг тэжээлийн болц гэнэ. Аж ахуйн эдгээр хэлбэрүүдийг зөв зохион байгуулж чадвал заган ойн хөрс хамгаалах ач холбогдол болон тэжээлийн үр өгөөжийг дээшлүүлж чадна.

Улс орон, аймаг, сумын ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайг нийт нутаг дэвсгэрт нь харьцуулж хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг ойрхог чанар гэдэг. Өмнөговь аймгийн ойгоор бүрхэгдсэн талбай /618,2 мян.га/-г аймгийн нийт нутаг дэвсгэр /16500,0 мян.га/-д хувааж гаргахад ойрхог чанар нь 3,75% байна

Загийн модлог нь хатуу, ус чийгэнд өмхөрч чанараа алдах нь бага тул түүгээр худаг доторлох, малын хашаа хороо барих зэргээр ашиглахаас гадна илчлэг чанар нь 4500 ккал хүрдэг тул түлшинд болон модны нүүрс хийхэд ашигладаг.

7.2.3. Заган ойн ойн зохион байгуулалт

БНСУ-ын ойн алба, Монгол улсын Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам хамт ран шар шороог шуурга болог цөлжилтөөс сэргийлэхийн тулд шар шороон шуур ганы эхлэл болсон говь, хээрийн бүсд /Төв аймаг Лүн сум, Өмнөговь аймаг Далан задгад хот/ 2007 оноос эхлэн 2016 он хүртэл 10 жилийн хугацаанд 3000 га ногоон хэрэм байгуулах төсөл юм. Даланзадгад суманд 2006 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн.

Хүснэгт № 7.5. Тарьц, суулгацын тоо

Он	Ногоон хэрмийн Даланзадгад сумын МҮГ-г	
	Бойжиж байгаа тарьц	Стандартын суулгац
2008	67,250	-
2009	143,915	73,250
2010	172.288	77,819
2011	182,719	52,525
2012		
2013		
Дүн	566172	203594

Даланзадгад сум: 33 зүйлийн 470ш мод, сөөг говь цөлийн бүсийн ховордож буй жигд, тоорой, хонхот харгана зэрэг бут сөөгнөөс гадна, ховордож байгаа тэсэг, хависгана болон таана, хөмүүлийг үр болон үндэслэг ишээр тарималжуулж байгаа. Даланзадгад суманд 24 га-МҮГ-тай. Даланзадгад суман дахь Ногоон хэрэм төслийн ойжуулсан талбай:

2007 онд 100 га талбайд хайлаас улиас

2008 онд 50 га талбайд хайлаас

2010 онд 50 га хайлаас

2011 онд 60 га талбайд хайлаас,улиас,харгана

2012 онд 50 га заг 100 га

2013 онд 200 га-д заг тарьсан байна. Нийт ойжуулсан талбай: 610 га

Монгол-Солонгосын Ногоон хэрэм төсөл нь тарьц,суулгац худалддаггүй. Аймгийн иргэд,аж ахуйн нэгжид 14000 ш тарьц ойжуулалтад үнэгүй нийлүүлсэн болно.

Хүснэгт№ 7.6. Өмнөговь аймагт тарьсан мод ургалтын хувь, зардал

№	ААН, байгууллагын нэр	Тарьсан модны тоо	Ургасан модны тоо	Амьдралтын хувь	Зарцуулсан нийт зардал төг
1	“Олон овоот гоулд”ХХК	9734	6312	64.8	8 696 300
2	“Таван толгой”ХК	3020	1496	49.5	1 510 000
3	“Энержи ресурс”ХХК	6574	4676	71.1	55 548 000
4	“Эрдэнэс Таван Толгой”	10400	6825	65	9 200 000
5	МАК	4000	3789	95	3 543500
6	Оюутолгой	1000	756	76	3 514 500
7	Саусгоби Сэндс	1000	870	87	3 415 000
Нийт дүн		35728	32552	91	85 427 300

БОАЖГ-ын Ойн албанаас зарласан Ногоон уул уурхай хөтөлбөрт ажилд Өмнө говь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа дээрхи 7 компани материалаа ирүүл снээс “Олон овоот гоулд “ХХК загийг тарималжуулж ургуулдаг,”Энержи ресурс” ХХК нь говийн унаган ургамлуудыг нөхөн сэргээлтэнд туршиж , 2 мод үржүүлгийн газарт тарьсан, орчноо тохижуулсан,”Эрдэнэс Таван толгой “ХК нь сумын хүү хэд залууст ногоон боловсрол олгох талаар амжилттай ажилласан,Оюутолгой ХК,Саусгоби Сэндс ХХК, МаК ХХК-иуд нь нутгийн ард түмэнтэй хамтарч үрийн нөөц хуримтлуулсан зэрэг нь бусад уул уурхайн компаниудаас онцлог байна

Нийт 23 ААН, байгууллагын 1380 ажилтан оролцож, 33055 ширхэг мод тарьж 117 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Заган ойн ашиглалт. Заган ойг зохистой ашиглахад түүнийг элс бэхжүүлэх, хөрсний элэгдэл эвдрлээс хамгаалах, тэжээлийн арвин эх үүсвэр нөөцийг бий болгох зэрэг байгалийн харилцан нөлөөлөлийг бүрэн дүүрэн тасралтгүй хангахад чиглэгдэх ёстой. Заган ойн хөрс хамгаалах, бэлчээрийн ургац нэмэгдүүлэх чанар нь түүний ургалтын хугацааны үе болох насны ангитай шууд холбоотой юм.

7.3. Ойн сангийн таксацын дундаж үзүүлэлт

Заган ойн таксацын дундаж үзүүлэлтэд ойн гарал үүсэл, бүрэлдэхүүн, нас, өндөр, диаметр, өтгөрөл, 1 га-ийн нөөц, өсвөр мод, хөрс, хэвшинж зэрэг үзүүлэлтүүд хамаарна. Судалгааны ажлын үед дээж талбайнууд дээр заган ойн таксацын дундаж үзүүлэлтийг хэмжилт хийн нарийвчлан тогтоож уг тогтоосон үзүүлэлтийг ашиглан ялгарал тус бүрт таксацын дундаж үзүүлэлтүүдийг тогтоов.

Гарал үүсэл. Судалгаа явагдсан газар нутгийн ой нь зөвхөн байгалийн гарал үүсэлтэй. Ойн бүрэлдэхүүний хувьд дан цэвэр заган ой дангаар тохиолдох ба ул хөрсний ус харьцангуй ойр газруудад сухай тун бага хэмжээгээр холилдон ургасан байна.

Дундаж диаметр. Говийн модлог ургамал ургах орчноосоо хамаараад гол ишнийх нь өндөр зарим нөхцөлд тодорхой мэдэгддэггүй байх нь тохиолдоно.

Ялангуяа сул элсэнд ургасан бол гол иш элсэнд булагдаж ишний голчийг цээжний өндөрт тогтоох боломжгүй байдаг. Нөгөө талаар судалгаа явагдсан газар нутгийн заг нь ихэвчлэн намхан бутлаг хэлбэртэй байв. Иймд голчийг газрын гадарга орчмоор хэмжиж тогтоов. Газрын гадарга орчмоос олон иш салаалсан тохиолдолд бүгдийг хэмжиж арифметик дунджаар тогтоов. Загийн ишний голчийг тогтоох нь техник ажиллагаа ихтэй учраас нөөцийг тогтоох гол үзүүлэлт болгож ишний дундаж диаметрийн оронд титмийн диаметрийг ашигладаг арга зүйг ашигласан болно.

Титмийн диаметрийг баруунаас-зүүн, хойноос-урагш хэмжиж эдгээр үзүүлэлтийн дунджаар тогтоов.

Дундаж нас. Насны анги бүрийн нөөцийг мөн ангийн дундаж насаар нь үржүүлсэн үржвэрүүдийн нийлбэрийг насны ангийн нөөцийн нийлбэрт хувааж гаргасныг дундаж нас гэнэ. Ойн дундаж насыг насны ангийн хүснэгтэд дараах томъёогоор тодорхойлов.

$$A1M1+A2M2+.....+AnMn / M1+M2+...Mn$$

A1, A2, A3 An- Насны бүлгийн дундаж нас

M1, M2, M3 Mn - Насны бүлгийн нөөц

Таксацын дундаж үзүүлэлтийг сум тус тус бүрээр дундаж нас, бонитет, өтгөрөл, жилийн нийт дундаж өсөлт, 1га-гийн нөөц, 1га-гийн өсөлт гэсэн үзүүлэлтээр гаргаж 7- р хүснэгтэд үзүүлэв.

Заган ойн таксацын дундаж үзүүлэлтээс үзэхэд жилийн дундаж өсөлт 30316.41 м³, дундаж бонитет 3.0, дундаж өтгөрөл 0.46, 1 га-ийн нөөц 1.6 м³, 1 га-ийн дундаж өсөлт 0.05 м³, дундаж нас 31. жил байна.

Хүснэгт № 7.9. Ойн таксацын дундаж үзүүлэлт

Модны төрөл	Байгалийн ойн талбай, га	Бүх нөөц ш.м	Бүх дундаж өсөлт ш.м	Дундаж			Ойгоор бүрхэгдсэн Талбайн 1-га-н	
				нас, жил	бонитет	өтгөрөл	Нөөц, ш.м	өсөлт, ш.м
Дархан цаазат газрын онгон бүс								
Заг	985	985	28,1	35	3,00	0,40	1,0	0,03
Тоорой	29	1720	42,0	41	3,00	0,60	59,3	1,45
дүн	1014	2705	70,1		3,00	0,50	2,7	0,07
Дархан цаазат газрын хамгаалалтын бүс								
Заг	3962	5202	157,6	33	2,60	0,36	1,3	0,04
Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс								
Заг	38908	59404	1856,4	32,0	2,70	0,35	1,5	0,05
Дархан цаазат газрын орчны бүс								
Заг	6321	6510	217,0	30	2,30	0,30	1,0	0,03
Тоорой	101	8080	179,6	45	3,00	0,50	80,0	1,78
дүн	6422	14590	396,6		2,65	0,40	2,3	0,06
Дархан цаазат газрын дүн								
Заг	50176	72101	396,6	32	2,65	0,35	1,4	0,01

Тоорой	130	9800	227,9	43	3,00	0,55	75,4	1,75
дүн	50306	81901	624,5		2,83	0,45	1,6	0,01
Байгалын цогцолборт газрын онцгой бүс								
Заг	57249	91341	3653,6	25	3,00	0,36	1,6	0,06
Байгалын цогцолборт газрын хягаарлалтын бүс								
Заг	73591	124030	4961,2	25	3,00	0,36	1,7	0,07
Байгалын цогцолборт газрын аялал жуулчлалын бүс								
Заг	74877	130927	4676,0	28	3,00	0,36	1,7	0,06
Байгалын цогцолборт газрын орчны бүс								
Заг	51596	42659	1422,0	30	2,80	0,37	0,8	0,03
Байгалын цогцолборт газрын дүн								
Заг	257313	388957	14712,77	27	3,0	0,4	1,5	0,1
Баян бүрдийн болон бусад заган ой								
Заг	281559	463872	14056,7	33	2,40	0,36	1,6	0,05
Тоорой	87	4940	109,8	45	3,00	0,38	56,8	1,26
Хайлаас	142	5680	378,7	15	3,00	0,50	40,0	2,67
дүн	281788	474492	14545,2		2,8	0,4	1,7	1,3
Улсын хилийн дагуух заган ой								
Заг	15340	14234	431,3	33	2,40	0,36	0,9	0,03
Тоорой	3	120	2,7	45	3,00	0,30	40,0	0,89
дүн	15343	14354	434,0		2,70	0,33	0,9	0,03
Аймгийн хэмжээгээр								
Заг	604388	939164	30295,61	31	2,7	0,36	1,6	0,05
Тоорой	220	14860	337,73	44	3,00	0,41	67,5	1,55
Хайлаас	142	5680	378,66	15	3,00	0,50	40,0	2,67
дүн	604750	959704	31012,00		2,9	0,46	1,6	0,05

7.4. Ойн хэв шинж

Тус аймгийн нутагт манай орны говь цөлийн бүсээр тархан ургах үндсэн 4 хэв шинжийн заган ой бүгд тохиолдоно.

Хүснэгт № 7.10. Ойн сангийн хэв шинжээр тархсан байдал

Модны төрөл	Хэв шинж					
	Чулуут цөлийн	Элсний	Сайр Садаргын	Шал Тойрмын	дүн	ЭЗЛЭХ хувь
Дархан цаазат газрын бүс						
Заг	7624				7624	88,19
Тоорой		15		14	29	0,34
Хайлаас		642			642	7,43
Бут сөөг		318		32	350	4,05
дүн	7624	975	0	46	8645	100,00
Дархан цаазат газрын хамгаалалтын бүс						
Заг	8039	1399	18		9456	94,96
Хайлаас			249		249	2,50
Бут сөөг		210		43	253	2,54
дүн	8039	1609	267	43	9958	100,00
Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс						
Заг	31697	37057	723		69477	99,88

Хайлаас			81		81	0,12
дүн	31697	37057	804	0	69558	100,00
Дархан цаазат газрын орчны бүс						
Заг	10382	1455	97	215	12149	89,19
Тоорой			101		101	0,74
Хайлаас			189		189	1,39
Бут сөөг		993		190	1183	8,68
дүн	10382	2448	387	405	13622	100
Дархан цаазат газрын дүн						
Заг	57742	39911	838	215	98706	96,98
Тоорой	0	15	101	14	130	0,13
Хайлаас	0	642	519	0	1161	1,14
Бут сөөг	0	1521	0	265	1786	1,75
дүн	57742	42089	1458	494	101783	100,00
Байгалын цогцолборт газрын онцгой бүс						
Заг		39426	56353	435	96214	100,00
Байгалын цогцолборт газрын хягаарлалтын бүс						
Заг		60500	108944	9336	178780	100,00
Бут сөөг				3	3	0,00
дүн	0	60500	108944	9339	178783	100,00
Байгалын цогцолборт газрын аялал жуулчлалын бүс						
Заг		55924	126246		182170	100,00
Байгалын цогцолборт газрын орчны бүс						
Заг		11936	92294	11684,0	115914	100,00
Байгалын цогцолборт газрын дүн						
Заг	0	167786	383837	21455	573078	100,00
Бут сөөг	0	0	0	3	3	0,00
дүн	0	167786	383837	21458	573081	100,00
Баян бүрдийн болон бусад заган ой						
Заг	217331	113975	100277	45445	477028	97,53
Тоорой	15	44	92	38	189	0,04
Хайлаас	61		142		203	0,04
Бут сөөг		11525		172	11697	2,39
дүн	217407	125544	100511	45655	489117	100,00
Улсын хилийн дагуух заган ой						
Заг		3029	22213		25242	99,99
Тоорой		3			3	0,01
дүн	0	3032	22213	0	25245	100,00
Аймгийн хэмжээгээр						
Заг	275073	324701	507165	67115	1174054	98,72
Тоорой	15	62	193	52	322	0,03
Хайлаас	61	642	661	0	1364	0,11
Бут сөөг	0	13046	0	440	13486	1,13
дүн	275149	338451	508019	67607	1189226	100,00

7.5. Ойн сангийн экологи эдийн засгийн үнэлгээ

Тус аймгийн ойн сан бүгд хамгаалалтын бүсэд хамаарч байгаа тул БОСайдын 1996 оны 230-р тушаалын хавсралтад зааснаар 1-р мужид хамааруулж, БОАЖСайдын 2009 оны 394 дугаар тушаалаар баталсан үнэлгээгээр экологи эдийн засгийн үнэлгээг тогтоов.

Хүснэгт № 7.11. Ойн талбай, нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ

Модны төрөл	Ойн талбай					
	талбай			нөөц		
	талбай, га	1 га-н үнэлгээ, мян.төг	Дүн мян.төг	нөөц, шоо метр	1 га-н үнэлгээ, мян. төг	Дүн мян.төг
Заг	1174054	3210,0	3 768 713 340,0	1099939	90,0	98 994 510.0
Тоорой	322	1620,0	521 640,0	15484	81,0	1 254 204.0
Хайлаас	1364	9900,0	13 503 600,0	12845	141,0	1 811 145.0
Бут сөөг	13486	1620,0	21 847 320,0	6571	81.0	532 251.0
дүн	1189226		3 804 585 900.0	1134839.0		102 592 110.0

Ойн талбайн экологи эдийн засгийн үнэлгээ 3 их наяд 804 тэрбум 585 сая 900 мянган төгрөг, нөөцийн үнэлгээ 102 тэрбум 592 сая 110 мянган төгрөг.

7.6. Ойн сангийн өөрчлөлт

Ой зохион байгуулалтын судалгааны дүнг өмнөх 1990 оны судалгааны дүнтэй харьцуулан ойн сангийн талбайн өөрчлөлтийг газрын төрлийн ангилал тус бүрээр, байгалийн ойн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлтийг модны төрөл тус бүрээр гаргав.


Хүснэгт № 7.12. Ойн сангийн өөрчлөлт газрын төрлөөр

Ойн сангийн талбайн төрөл	Газрын төрөл	2011	1991	Зөрүү
Ойгоор бүрхэгдсэн талбай	Байгалийн заг	604,7	921,4	-316,7
	Бут сөөг	13,5		13,5
	Дүн	618,2	921,4	-303,2
Ойгоор бүрхэгдээгүй талбай	Хатсан	0,8		0,8
	Тармаг	565,7	251,5	314,2
	Заг түүсэн	0,6		0,6
	загжиж байгаа	3,9	0,9	3
	Дүн	571	252,4	318,6
Нийт		1189,2	1173,8	15,4

Талбайн дүнгийн өөрчлөлтөөс харахад ойн сангийн нийт талбай 15,4 мян. га –р нэмэгдсэн боловч ойгоор бүрхэгдсэн талбай 303,2 га-р багасаж, ойгоор бүрхэгдээгүй талбай 318,6 мян.га-р нэмэгдэж гарлаа. Өөрчлөлтийг талбайн төрөл тус бүрээр авч үзвэл байгалийн заган ойн эзлэх талбай 316,7 га-р багассан бол тармаг заг 314,2 га-р, хатсан болон заг түүсэн талбай 1,4 мян. га-р нэмэгдсэн нь загийг их хэмжээгээр түлшинд хэрэглэж байгаа болон

сүүлийн жилүүдийн хурайшилттай холбоотойгоор заган ой ихээхэн хэмжээгээр сийрэгжиж байгаатай холбоотой.

Байгалийн аясаараа загжиж байгаа талбай 3,0 мян.га-р, нэмэгдсэн нь заг тохиромжтой нөхцөл бүрдсэн, хамгаалалт сайтай үед сэргэн ургахдаа сайн болохыг харуулж байна. Байгалийн сэргэн ургалт сайн явагдаж байгаа газруудын ихэнхи Тусгай хамгаалалтад авсан газруудад байгаа нь үүнийг баталж байна.



Зураг № 7.11. Заган ойн зөрүү

Талбайн дүнгийн өөрчлөлтөөс харахад ойн сангийн нийт талбай 15,4 мян. га –р нэмэгдсэн боловч ойгоор бүрхэгдсэн талбай 303,2 га-р багасаж, ойгоор бүрхэгдээгүй талбай 318,6 мян.га-р нэмэгдэж гарлаа. Өөрчлөлтийг талбайн төрөл тус бүрээр авч үзвэл байгалийн заган ойн эзлэх талбай 316,7 га-р багассан бол тармаг заг 314,2 га–р, хатсан болон заг түүсэн талбай 1,4 мян. га-р нэмэгдсэн нь загийг их хэмжээгээр түлшинд хэрэглэж байгаа болон сүүлийн жилүүдийн хурайшилттай холбоотойгоор заган ой ихээхэн хэмжээгээр сийрэгжиж байгаатай холбоотой.



Зураг№ 7.12. Хатаж хуурайшин сийрэгжиж байгаа заган ой

Байгалийн аясаараа загжиж байгаа талбай 3,0 мян.га-р, нэмэгдсэн нь заг тохиромжтой нөхцөл бүрдсэн, хамгаалалт сайтай үед сэргэн ургахдаа сайн болохыг харуулж байна. Байгалийн сэргэн ургалт сайн явагдаж байгаа газруудын ихэнхи Тусгай хамгаалалтад авсан газруудад байгаа нь үүнийг баталж байна.

7.6.1. Ойн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлт

Хүснэгт№ 7.13. Таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлт модны төрлөөр

ОЗБ хийсэн он	Модны төрөл	Байгалийн ойн талбай, га	Бүх нөөц ш.м	Бүх дундаж өсөлт ш.м	Дундаж			ойн талбайн 1-га-н	
					нас, жил	Бонитет	Өтгөрөл	Нөөц, ш.м	өсөлт, ш.м
2012	Заг	604388	939164	30295,61	31	2,7	0,36	1,6	0,05
1991		921464	541820	27091,0	20	3,1	0,36	0,59	0,03
Зөрүү		-317076	397344	3204,61	11	-0,5	0	1,01	0,02
2012	Тоорой	220	14860	337,73	44	3,0	0,41	67,5	1,55
1991		-	-	-	-	-	-	-	-
Зөрүү		220	14860	337,73	44	3,0	0,41	67,5	1,55
2012	Хайлаас	142	5680	378,66	15	3,0	0,5	40	2,67
1991		-	-	-	-	-	-	-	-
зөрүү		142	5680	378,66	15	3	0,5	40	2,67
2012	Дүн	604750	959704	31012,00		3,0	0,46	36,03	0,05
1991		921464	541820	27091,0		3,0	0,36	0,59	0,03
зөрүү		-316714	417884	3921,0		0,0	0,10	36,03	0,02

Ойн сангийн төлөв байдал өөрчлөлтөөс үзэхэд талбай, нөөц, таксацын дундаж үзүүлэлт бүгд багасаж, буурч гарсан нилээд тааламжгүй үр дүн харагдаж байна.

Байгалийн ойн талбайн насны бүлгийн бүтцээс харахад болц гүйцсэн, хөгшин ойн нөөц дийлэнх хувийг эзэлж байгаа нь залуу, дунд насны болон болц гүйцэж яваа ой байгалийн жамаар насны дээд бүлэгт шилжиж ой байгалийн аясаараа сэргэн ургах явц муу байгаагаас залуу ойгоор нөхөн сэргэх процесс удаашралтай байгааг харуулж байна. Мөн энэ удаагийн тооллогыг нүдэн баримжааны аргаар биш системчлэн байрлуулсан дээж талбайнуудад хийсэн хэмжилтэд тулгуурлан явуулсантай холбоотой.

Эндээс дараахь дүгнэлтэд хүрч байна.

Тус аймгийн заган ой тархан ургаж байгаа талбайн хувьд багасаагүй боловч маш их хэмжээгээр сийрэгжиж байгаагаас байгаль экологид үзүүлэх ач холбогдолоо алдаж болзошгүй байна.

Заган ойг нөхөн сэргээхэд зориудаар ойжуулахаас илүүтэй байгалийн аясаар сэргэн ургах нөхцөл бололцоог бүрдүүлэх нь илүү үр дүнтэй байж магадгүй

Заган ойг түлшинд ялангуяа төв суурин газрын болоод аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээнд талбайгаар нь хавтгайруулан бэлтгэх явдлыг бүрмөсөн зогсоох шаардлагатай.

7.7. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Иймээс сүүлийн жилүүдэд ойжуулах, ургамалжуулах, хөрсний элэгдэл эвдрэлийг багасгах зорилгоор аймгийн хэмжээнд олон ажлуудыг хийж байна.

Гэхдээ эдгээр ажлын ихэнх нь төв суурин газрыг элсний нүүлтээс хамгаалах, цэцэрлэгжүүлэх чиглэлээр хийгдэж байна. Харин заган ой бүхий газруудын ихэнх нь төв суурин газраас алслагдмал байдалтай байдгаас тэнд ойн аж ахуйн арга хэмжээ мэдэгдэхүйц түлхэц далайцтайгаар хийгдэхгүй байна. Судалгааны дүнгээр ой нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай 569666 га заг түүсэн, хатаж хуурайшсан болон тармаг заг бүхий талбай байна. Өөрөөр хэлбэл ойн сангийн нийт талбайн 50.5 хувьд нь ямар нэг хэмжээгээр ойжуулалт ой нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэсэн үг.

Хүснэгт № 7.14. Заган ойг нөхөн сэргээх арга хэмжээний нэгтгэл

Зориудаар ойжуулах га	Байгалийн сэргэн ургалтад туслах га	
	Үр цацах зэргээр сэргэн ургалтад дэмжлэг үзүүлэх	Өсвөр модыг хамгаалах
Тарьцаар	564407	3857
1402		


НАЙМДУГААР БҮЛЭГ. УСАН САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ САВ ГАЗРУУДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

8.1. Усны сан бүхий газар

Өмнөговь аймгийн гадаргын ус Төв Азийн гадагш урсацгүй ай савд хамаарагддаг. Уур амьсгалын хувьд хур чийг бага гандуу, ууршилт ихтэй учир байнгын урсгалтай гол горхи нуур ховор юм. Хур бороо элбэгтэй жил 320-иод булаг, олон арван нууртай болох ба харин гандуу хуурай жил эдгээрийн тоо эрс багасдаг байна.

Хүснэгт№ 8.1. Өмнөговь аймгийн усан сангийн газар

Өмнөговь аймаг	Усан сан га-гаар
Нийт дүн	15859.500
Мөрөн, гол, горхи, булаг шандны эзлэх хувь	1369.500
Нуур,цөөрөм,тойрмын эзлэх газар	14490.000
Мөнх цас, мөсөн голын эзлэх хувь	-




Зураг№ 8.1. 2005-2013 оны Усан сангийн газрын харьцуулалт /га-аар/

Газрын нэгдмэл сангийн тайлангаас үзэхэд усны сан бүхий газар тус аймагт 15.8 мян. га газар байна. Гадаргын усны эх үүсвэр нь хөрс, хур борооны ус байдаг. Дулааны улиралд хур бороо эрчимтэй ороход уулархаг газрууд, тэдгээрийн ам хөндий, сайраар үер явж сэвсгэр хурдсанд шингэх, улмаар түр нуур тогтох нөхцлийг бүрдүүлдэг. Богино хугацааны хур борооны хоромхон зуурын үер нь байнгын урсгалтай гол горхи үүсэх боломж олгодоггүй байна. Гурвансайхан, түүний салбар уулсад гадаргын урсац 0.5 л/сек км² байхад говь, тал хөндийн бүхий нутгуудад 0.02 л/сек км² буюу түүнээс ч бага байна.

Хүснэгт№ 8.2. Сумдын булаг шандны судалгаа

№	Сумын нэр	Устай	Ус багатай	Ширгэсэн
1	Баяндалай	102	0	4
2	Баян-Овоо	17	0	10
3	Булган	17	19	2
4	Гурвантэс	39	61	1
5	Мандаловоо	7	-	5
6	Манлай	4	5	0
7	Ноён	23	0	3
8	Номгон	72	0	19
9	Сэврэй	5	53	0
10	Ханбогд	22	14	4
11	Ханхонгор	30	24	0
12	Хүрмэн	50	0	4
13	Цогтовоо	11	2	0
14	Цогтцэций	4	9	2
15	Даланзадгад	2	3	1
Дүн		405	190	55



Зураг№ 8.2. Булаг шандны судалгаа /сумдаар/

Улсын уст цэгийн тооллогоор Өмнөговь аймгийн хэмжээнд нийт 650 булаг шанд тоологдсон ба үүнээс 55 булаг буюу нийт булгийн 8.5% ширгэсэн.

Өмнийн говийн бүсэд шинээр томоохон уул уурхайн үйлдвэрүүд (Оюу Толгой - Зэс, Таван Толгой - нүүрс, Овоот Толгой - нүүрс) байгуулагдаж байгаагаас усны шинэ эх үүсвэрийг бий болгох шаардлага тавигдаж байна. Монголын ашигт малтмалын баялаг нь улс орны эдийн засгийн хөгжилд үнэхээр чухал бөгөөд ДНБ-ний гол бүрдүүлэгчийн хувьд эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь улам нэмэгдэж байна.

8.2. Усны сав газрууд

Гүний усны хувьд Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Гурван тэс, Таванзаг, Хонгор гол, Ноён, Тавансухай, Бүгтийн хоолой, Баянтөхөм, Тэсгэнэ, Хүрмэн, Будган, Бянзаг, Мандах, Даланзадгад, Бялгасын улаан нуур, Борзон говь, Дугуй улаан, Гашуун, Үйзэн, Зайрмаг, Нарийн алд, Таван алд, Гүний хоолой, Галбын говь, Заг-сүүжийн говь зэрэг 28 орд газрыг нэрлэж болно.

Нуур тойром: Өмнөговь аймаг нь гадаргын болон гүний усны нөөц багатай бөгөөд гадаргын усны гол нөөц нь нуур, цөөрөм тойром байдаг. Нуур тойрмуудын хамгийн том нь Мандал-Овоо, Булган сумын хилийн орчимд байдаг Улааннуур юм. Улааннуур нь Э.М.Мурзаев, И.Д.Беспалов нарын тогтоосноор 135-175 км² байсан боловч одоо ширгэж усгүй болоод байна. Энэ нуурыг тэжээдэг цорын ганц эх үүсвэр бол Онгийн гол бөгөөд сүүлийн үед шургаж тасалдах явдал ажиглагдаад байгаа юм.

Онги гол: Хангай нурууны өврөөс эх авч 435 км урсахдаа 16027.6 ам км талбайгаас усжин Улаан нуурт цутгана. Онги голын олон жилийн дундаж өнгөрөлт Уянга сумын орчим 1.52, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын орчим 1.30 шоо м/с болно. Онги голын урсац 1988 оны 7 дугаар сард Уянга сумын орчимд 1.20 шоо м/с, Онги, Улаан голын бэлчир Арвайхээр орчимд нэмэгдэж 3.4 шоо м /с хүрээд Сайхан-Овоо сумын орчим ширгэсэн байна.

Онги гол бол 5 дугаар эрэмбийн гол юм. Голдрилын дундаж өндөр 1585 м, ус хагалбарын шугамын урт 1283.82 км, түүний дундаж өндөр 2552.0 м, голуудын нийлбэр урт 5273.71 км, усан сүлжээний нягтшил 0.33 км/ам км, хөндийн гүн дунджаар 967 м, түүний өргөн 55.16 км, Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 4.031, 2.46, 3.154, тус тус байна.

Дугаар, индекс	Нууруудын нэр	Үнэмлэхүй өндөр /м /	Гадаргын талбай /км/	Урт /км/	Өргөн /км/		Гүн /м/		Усны эзэлхүүн /км³/	Эргийн шугам		Ус хураах талбай /км²/	Морфометрийн үзүүлэлтүүд			Ерөнхий эрдэжилт г/л
					Дундаж	Их	Дундаж	Их		Урт /км/	Хөгжлийн коэффициент		Авсаарг а зэрэг	Хэлбэр, суналын зэрэг	Харьцах талбай	
1	Гялаан тойром	1130	1,6	2,2	0,8	1,4	0,2	0,6	0,0003	5,6	1,249		0,52	1,57		
2	Сультын их нуур	1335	0,5	1,8	0,3	0,5				3,6	1,437		1,00	3,60		
3	Зангуугийн тойром	1100	0,5	1,1	0,4	0,9				3,0	1,197		0,51	1,22		
4	Гагалдайн тойром	1120	1,2	2,4	0,5	0,6	0,4	1,0	0,0005	5,2	1,340		0,83	2,33		
5	Довцогийн Урд нуур	1110	0,7	1,6	0,5	1,0				4,2	1,416		0,44	1,60		
6	Тэнхэний нуур	1110	2,1	2,9	0,8	1,2	0,5	1,2	0,0010	6,6	1,285		0,60	2,42		
7	Аргалант нуур	890	0,5	1,2	0,4	0,8				3,2	1,277		0,52	1,50		
8	Улаан нуур	1320	6,2	4,4	1,4	1,9	0,7	1,2	0,0040	10,3	1,167		0,74	2,32		
9	Улаан нуур	1520	6,9	3,9	1,7	2,6	0,6	1,1	0,0040	10,4	1,117		0,68	1,50		
10	Шүлүүт /Чулуут/ нуур	1570	0,8	1,3	0,6	1,2				3,2	1,009		0,51	1,08		
11	Шанаган нуур	860	0,7	1,0	0,7	1,0	0,2	0,9	0,0001	3,0	1,011		0,70	1,00		
12	Хармагтай нуур	1650	0,5	1,6	0,3	0,5	0,4	1,5	0,0002	3,4	1,357		0,63	3,20		
13	Шар тойромын нуур	1270	0,5	1,1	0,4	0,8				3,0	1,197		0,57	1,38		
14	Улаан нуур	1008	175	45,0	29,0	40,0	0,9	1,6	0,1580	87,0	1,855		0,09	1,12		
15	Тэсийн нуур	1345	1,8	2,4	0,7	1,0	0,3	0,9	0,0005	6,4	1,346		0,75	2,40		278,670
16	Элст тойром	1150	3,1	3,3	0,9	1,3	0,4	1,0	0,0012	7,6	1,218		0,72	2,54		
17	Баянтөхөлийн тойром	1420	4,3	3,4	1,2	1,8	0,6	1,3	0,0026	9,2	1,252		0,70	1,89		
18	Олгой тойром	1530	1,4	3,0	0,5	0,8	0,5	1,2	0,0007	5,4	1,288		0,51	3,75		
19	Хан Богдын тойром	1130	0,5	1,4	0,4	0,5				3,0	1,197		0,71	2,80		
20	Сайрын ус нуур	930	0,5	1,4	0,4	0,4				3,4	1,357		0,89	3,50		
21	Зээрэгийн зүүн нуур	1640	0,8	1,4	0,6	1,0				4,8	1,514		0,57	1,40		
22	Хулант улаан нуур	1170	1,2	2,9	0,5	0,8	0,4	1,0	0,0005	9,0	2,318		0,52	3,63		
23	Борзонт нуур	1230	1,9	2,6	0,7	0,9	0,4	0,8	0,0007	6,2	1,269		0,81	2,89		
24	Бухт нуур	1284	0,6	1,2	0,5	1,2				3,8	1,384		0,42	1,00		
25	Өсөхийн улаан толгойн нуур	1170	0,5	1,4	0,3	0,7	0,4	1,3	0,0002	3,2	1,277		0,51	2,00		
26	Сүмбэрийни улаан тойром	1180	0,5	1,4	0,3	0,3				3,0	1,197		1,19	4,67		
27	Цагаан цавын тойром	1140	0,5	1,0	0,5	0,7				2,8	1,117		0,71	1,43		
28	Нэргүй тойром	1050	0,5	1,1	0,4	0,6	0,3	1,0	0,0002	2,8	1,117		0,76	1,83		
29	Элсэн торомт тойром	870	0,5	1,1	0,4	0,5	0,3	1,1	0,0002	2,4	1,000		0,91	2,20		

30	Могойн төгрөг тойром	1310	0,5	0,9	0,5	0,6				2,2	1,000		0,93	1,50		
31	Могойн шаварт тойром	1360	0,5	1,2	0,4	0,6	0,2	0,7	0,0001	2,8	1,117		0,69	2,00		
32	Муруй гүн худгийн нуур	1210	0,5	1,4	0,4	0,6				3,0	1,197		0,60	2,33		
33	Зүүн тойром	1220	0,5	1,5	0,3	0,4	0,3	0,9	0,0002	3,2	1,277		0,83	3,75		
34	Хар тээгийн тойром	1300	0,5	1,5	0,3	0,6	0,3	1,0	0,0002	3,2	1,277		0,56	2,50		
35	Ангирт тойром	1790	0,5	1,2	0,4	0,4				2,4	1,000		1,04	3,00		
36	Загт тойром	920	0,5	1,2	0,4	0,6				3,0	1,197		0,69	2,00		
37	Галбын тойром	890	0,7	1,3	0,5	1,1				3,6	1,214		0,49	1,18		
38	Баруун борзонт тойром	1230	0,8	1,6	0,5	0,9	0,2	0,8	0,0002	3,4	1,073		0,56	1,78		
39	Дунд борзонт тойром	1230	0,7	2,3	0,3	0,5	0,4	1,0	0,0003	4,8	1,618		0,61	4,60		
40	Зүүн борзонт тойром	1240	0,6	1,8	0,3	0,3				3,4	1,238		0,54	6,00		
41	Шандан тормын тойром	1480	0,9	1,8	0,5	0,9				3,8	1,130		0,56	2,00		
42	Шар усны тойром	1311	0,6	1,5	0,4	0,7				4,0	1,457		0,42	2,14		
43	Баянгол нуур	1216	0,5	1,2	0,3	0,4	0,6	1,3	0,0003	2,6	1,160		0,94	3,00		
44	Сайн хөтөлийн тойром	1115	0,5	1,3	0,4	0,8				3,6	1,437		0,48	1,63		

Хүснэгт № 8.3. Өмнөговь аймгийн нуур, тойромын шинж чанарын судалгаа

**Өмнөговь аймгийн 0.5км²-аас дээш талбайтай нуур тус
бүрийн товч тайлбар, тодорхойлолт**

1. Гялаан тойром: Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутагт Сухайн Хоолойн ард 1130 м өндөрт байдаг шорвог нуур. 1.6 км² талбайтай, 2.2 км урт, 1.4 км өргөн, эргийн шугамын урт 5.6 км авч үлэмж тогтворгүй.

2. Сультин Их нуур: Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутагт Хараатын хэцийн өмнөх хөндий дэх бүлэг нуурын баруун хойд шорвог нуур. 0.5 км² талбайтай, 1.8 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 3.6 км.

3. Зангуугийн тойром: Өмнөговь аймгийн Манлай сум, Дорноговь аймгийн Мандах сумын заагт Харганат уулын баруун өмнөх толгодын хоорондох хотост 1100 м өндөрт байдаг шал тойром. Бороо хуртай жилд 0.5 км² талбайтай, 1.1 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км.

4. Гагалдайн тойром, нуур: Өмнөговь аймгийн Манлай сум, Дорноговь аймгийн Мандах сумын заагт Харганат уулын ар хотост 1120 м өндөрт байдаг шорвог нуур. 1.2 км² талбайтай, 2.4 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 5.2 км.

5. Довцогийн урд нуур: Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт талын толгодын хоорондын хотост 1110 м өндөрт байдхг шорвог нуур. 0.7 км² талбайтай, 1.6 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 4.2 км.

6. Тэнхэний нуур: Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт Шавхатын буюу Тэнхэний хөндийд 1110 м өндөрт байдаг тойром. 2.1 км² талбайтай, 2.9 км урт, 1.2 км өргөн, эргийн шугамын урт 6.6 км. Хур бороо, сайр дагаж буух уруйн усаар сэлбэгддэг.

7. Аргалант нуур: Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт Урцын хярын элсэн тарамцагийн зүүн хөндийд 890 м өндөрт байдаг эрдэст нуур. 0.5 км² талбайтай, 1.2 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 3.2 км. Хур бороо элбэг үед сайрын усаар сэлбэгддэг. Эргэн тойрны аарагт бут бургастай.

8. Улаан нуур: Өмнөговь аймгийн Даланзадгад хотоос зүүн урагш 40 км зайд Лагийн хонхорын зүүн хэсэгт 1320 м өндөрт байдаг шорвог нуур. 6.2 км² талбайтай, 4.4 км урт, 1.9 км өргөн, эргийн шугамын урт 10.3 км. Жижиг горхи, булгийн усаар сэлбэгддэг.

9. Шүлүүт /Чулуут/ нуур: Өмнөговь аймгийн Хүрмэн сумын төвийн ойролцоо 1570 м өндөрт байдаг ширгэдэг нуур. 0.8 км² талбайтай, 1.3 км урт, 1.2 км өргөн, эргийн шугамын урт 3.2 км.

10. Шанаган нуур: Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт элсэн дунд 860 м өндөрт байдаг тойром. Хуртай үед 0.7 км² талбайтай, 1.0 км урт, 1.0км өргөн, эргийн шугамын урт 3.0 км.

11. Хармагтай нуур: Өмнөговь аймгийн Номгон сумын Хармагт бригадын нутагт 1650 м өндөрт байдаг ширгэдэг шорвог нуур. 0.5 км² талбайтай, 1.6 км урт, 0.5км өргөн, эргийн шугамын урт 3.4 км.

12. Шар тойром нуур: Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо сумын заагт 1270 м өндөрт байдаг тойром. 0.5 км² талбайтай, 1.1 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км .

13. Улаан нуур: Өмнөговь аймгийн Булган, Мандал-Овоо сумын заагт 1008 м өгдөрт байдаг тектоник гаралтай эрдэст нуур. Хур тунадас элбэг жилд Хангайн нуруунаас усжих Онгийн гол цутгаж талбай нь тэлж ихсэх ба зарим үед хатаж шар тойром болдог. Устай үед 175.0 км² талбайтай, 45.0 км урт, 40.0 км өргөн болдог. Нуурын ёроолын борзонг болон арвин хулс зэгсийг малын эрдэс тэжээлд хэрэглэдэг. Шорвог усны эрдэсжилт 338.05 г/кг, натри хлори, сульфат магни зонхилно.

14. Тэсийн нуур: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг Дунд голын элсэн тарамцагт 1345 м өндөрт байдаг ширгэдэг эрдэст нуур. Хуртай үед 1.8 км² талбайтай, 2.4 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 6.4 км хүрдэг. Усны эрдэсжилт 278.67 г/кг, натри хлор сульфат магни зонхилно. Нуурын давсыг эрт үеэс ашиглаж иржээ. Усны температур зун 35.0°C, өвөл нь 14.3°C байдаг. Эргэн тойрон хулс зэгс ургадаг.

15. Элст тойром: Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутагт 1150 м өндөрт байдаг ширгэдэг шорвог нуур. Эргэн тойрон элсэн хурдастай. Хур тунадас, сайрын усаар сэлбэгддэг. Хур бороотой жилд 3.1 км² талбайтай, 3.3 км урт, 1.3 км өргөн, эргийн шугамын урт 7.6 км.

16. Баян Төхөмийн нуур: Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутагт Хонгорын элсний зүүн сэжүүрт 1420 м өндөрт байдаг шорвог нуур. Хуртай үед 4. км² талбайтай, 3.4 км урт, 1.8 км өргөн, эргийн шугамын урт 9 км.

17. Сайн хөтлийн нуур: Өмнөговь аймгийн Манлай сумын төвөөс зүүн тийш 60-аад км зайд Харганат уулын ард 1115 м өндөрт байдаг шорвог нуур. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай,

1.3 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 3.6 км.

18. Олгой тойром: Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт Хараат Хэцийн өвөрт 1530 м өндөрт байдаг шорвог нуур. 1.4 км² талбайтай, 3.0 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 5.4 км.

19. Ханбогдын тойром нуур: Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт Ханбогд уулын баруун хотост 1130 м өндөрт байдаг ширгэдэг шорвог нуур. 0.5 км² талбайтай, 1.4 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км орчим.

20. Сайрын ус нуур: Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт Ханбогд уулаас урагш өмнөөс хойш цувж байрласан гурван тойромын нэг. Хуртай үед 0.5 км² талбайтай, 1.4 км урт, 0.4 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км.

21. Зээрэнгийн Зүүн тойром нуур: Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт Сагсай Зээрэнгийн хоолойд 1640 м өндөрт байдаг тойром. 0.8 км² талбайтай, 1.4 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 4.8 км.

22. Хулант Улаан нуур: Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт Хонгорын Овооны зүүн хотгорт 1170 м өндөрт байдаг тойром. Хуртай үед 1.2 км² талбайтай, 2.9 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 9.0 км.

23. Борзонт нуур: Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутагт улсын хилийн ойролцоо 1230 м өндөрт байдаг цуваа бүлэг тойромын хамгийн том тойром. Хуртай үед сайрын ус бухад 1.9 км² талбайтай, 2.6 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 6.2 км хүрдэг.

24. Бухт нуур: Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутаг Улаан Суврага уулын өмнөх битүү хотост 1284 м өндөрт байдаг шорвог нуур. Хуртай жилд усжиж 0.6 км² талбайтай, 1.2 км урт, өргөнтэй эргийн шугамын урт 3.8 км хүрдэг.

25. Өсөхийн Улаан Толгойн нуур: Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг халзан овооны ар хөндийд 1170 м өндөрт байдаг эрдэст нуур. 0.5 км² талбайтай, 1.4 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 1.6 км.

26. Сүмбэрийн Улаан тойром: Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг халзан овооны арын хөндийд 1180 м өндөрт байдаг тойром. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 1.4 км урт, 0.3 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км хүрдэг.

27. Цагаан Цавын тойром: Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг Цагаан Цавын ард 1140 м өндөрт байдаг ширгэдэг тойром. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 1.0 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 2.8 км хүрдэг.

28. Нэргүй тойром: Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг Халзан, Зөөвөрийн овооны хоорондох талын хотост 1050 м өндөрт байдаг тойром. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 1.1 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 2.8 км хүрдэг.

29. Элсэн Торомт тойром: Өмнөговь аймгийн Ханбогд сумын Халзан овооны элсэн тарамцагийн зүүн хойно 810 м өндөрт байдаг тойром. Ойр хавьд нь бут бургас ургадаг. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 1.1 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 2.4 км хүрдэг.

30. Могойн Төгрөг тойром: Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Могой бригадын нутагт 1310 м өндөрт байдаг ширгэдэг тойром. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 0.9 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 2.2 км хүрдэг.

31. Муруйн гүн Хүдгийн нуур: өмнөговь аймгийн Хүрмэн, Баяндалай сумдын заагт 1210 м өндөрт байдаг ширгэдэг тойром. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 1.4 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км хүрдэг.

32. Зүүн тойром: Өмнөговь аймгийн Хүрмэн, Баяндалай сумдын заагт Хадан Ус уулын ар хоолойд 1220 м өндөрт байдаг ширгэдэг тойром. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 1.5 км урт, 0.4 км өргөн, эргийн шугамын урт 3.2 км хүрдэг.

33. Хар Тээгийн тойром: Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг Халзан тээг уулын өмнөх хотост 1300 м өндөрт байдаг шорвог нуур. 0.5 км² талбайтай, 1.5 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 3.2 км хүрдэг.

34. Ангирт тойром: Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт 1790 м өндөрт байдаг ширгэдэг тойром. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 1.2 км урт, 0.4 км өргөн, эргийн шугамын урт 2.4 км хүрдэг.

35. Загт тойром: Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо сумдын заагт Галбын говийн ард 920 м өндөрт байдаг ширгэдэг тойром. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 1.2 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км хүрдэг.

36. Галбын тойром: Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо сумдын заагт Галбын Говийн умард захад 890 м өндөрт байдаг тойром. Заримдаа Галбын Улаан шал ч гэдэг. Хур бороотой жилд сайр дагаж буух уруйн ус тогтоож 0.7 км² талбайтай, 1.3 км урт, 1.1 км өргөн, эргийн шугамын урт 3.6 км хүрдэг.

37. Баруун борзонт тойром: Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг Нүхэн загийн хоолой, Баян нурууны хоорондох урд хотост 1230 м өндөрт байдаг бүлэг нуурын нэг. 0.8 км² талбайтай, 1.6 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км хүрдэг.

38. Дунд Борзонт тойром: Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг Баяны нурууны арын хоолойд 1230 м өндөрт байдаг бүлэг тойромын нэг. Тал талаас сайрын уруй буухад 0.7 км² талбайтай, 2.3 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 4.8 км хүрдэг.

39. Зүүн борзонт тойром: Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг Баяны нурууны арын хоолойд 1240 м өндөрт байдаг ширгэдэг тойром. 0.6 км² талбайтай, 1.8 км урт, 0.3 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км хүрдэг.

40. Шандын Торомын тойром: Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Шандын Торомын хөндийд 1480 м өндөрт байдаг тойром. Хур бороотой жилд 0.9 км² талбайтай, 1.8 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 3.8 км хүрдэг.

41. Шар усны тойром: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг Гурвантэсийн давсны үйлдвэрээс баруун тийш Баруун голын элсэн дундах түйрэн хонхорт 1311 м өндөрт байдаг тойром. 0.6 км² талбайтай, 1.5 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 4.0 км хүрдэг.

42. Баян гол нуур: Өмнөговь аймгийн Цогт –Овоо сумын нутаг Өөшийн Хярын ард 1216 м өндөрт байдаг эрдэст нуур. Эргэн тойронд нь олон тойромтгой, ихэвчлэн хатаж ширгэдэг. Хур бороотой жилд 0.5 км² талбайтай, 1.2 км урт, 0.4 км өргөн, эргийн шугамын урт 2.6 км хүрдэг.

Булаг шанд: Өмнөговь аймгийн 2011 оны булаг шандны судалгааны үр дүнд нийт 650 булаг тоологдсоноос устай 405, ус багатай 190, ширгэсэн 55 гэсэн үзүүлэлттэй байна.

8.2.1. Усны сав газрын ашиглалт, хамгаалалт

2007 оноос хойш БОАЖЯамны санхүүжилтээр жилд 5-8 булгийн эхийг хашиж хамгаалж байна. Мөн ТА-2 төсөл, уул уурхайн компани, иргэдийн өөрсдийн хөрөнгөөр хашиж хамгаалж байна. Аймгийн хэмжээнд нийт 77 булгийн эх буюу 11.9% -ийг хашиж хамгаалаад байна.

Хүснэгт № 8.4. Өмнөговь аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж, төслийн хөрөнгөөр хашиж, тохижуулсан булаг шандны судалгаа

№	Булаг шанд, рашааны нэр, байршил	Хөрөнгийн эх үүсвэр	Хөрөнгө оруулалтын хэмжээ сая.төг	Тайлбар
1	Зайрмагтай, Цогтцэций сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
2	Цагаан гол, Хүрмэн сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
3	Уртын булаг, Гурвантэс сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	Тус суман дахь Хадгаламж банкны салбар хашсан талбайг нэмж өргөсгөн мод тарьж, нэрэмжит талбай болгосон.
4	Элгэн булаг, Сэврэй сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
5	Нарийний булаг, Булган сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	Булгийн орчин маш сайн сэргэсэн
6	Шавартай, Ханхонгор сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
7	Далан, Даланзадгад сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	Иргэд хашсан хашааг эвдэж торыг нь авсан.
8	Далай, Баяндалай сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	Үерт эвдэгдэж, тор, шон байхгүй болсон.
9	Нүцгэн, Булган сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
10	Сарын хөндий, Ноён сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
11	Сангийн далай, Номгон сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
12	Элгэн, Номгон сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
13	Эрдэнэбулаг, Сэврэй сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
14	Нарийний булаг, Цогт-Овоо	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
15	Булаг элгэн, Мандал-Овоо сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
16	Баруун дов, Манлай сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
17	Зүүн дов, Манлай сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
18	Сэрүүн булаг, Сэврэй сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
19	Бага булаг, Ханбогд сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
20	Шавартай, Ханхонгор сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
21	Хээрийн булаг, Цогтцэций сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
22	Задгадын булаг, Баян – Овоо сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
23	Шивээгийн булаг, Гурвантэс сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
24	Баян булаг, Манлай сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
25	Замын шандын булаг, Ноён	Улсын төсвийн	2.000.000	

	сум	хөрөнгөөр		
26	Хужир улаан булаг, Номгон сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
27	Элгэн булаг, Сэврэй сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
28	Нарийний булаг, Хүрмэн сум	Улсын төсвийн хөрөнгөөр	2.000.000	
29	Дугантын булаг, Цогтцэций	Баян – Овоо сум	Баян – Овоо сум	
30	Сухайтын булаг, Баяндалай сум	Баян – Овоо сум	Баян – Овоо сум	
31	Довын булаг, Гурвантэс сум	Баян – Овоо сум	Баян – Овоо сум	
32	Хоолт, Сэврэй сум	Баян – Овоо сум	Баян – Овоо сум	
33	Жаргалант, Ханхонгор сум	Баян – Овоо сум	Баян – Овоо сум	
34	Далангийн булаг, Даланзадгад сум	Баян – Овоо сум	Баян – Овоо сум	
35	Зүүн толь, Баян – Овоо сум	Баян – Овоо сум	Баян – Овоо сум	Ан, агнуур зохион байгуулалтын ажлын хүрээнд хашиж хамгаалсан.
36	Баруун толь, Баян – Овоо сум	Баян – Овоо сум	Баян – Овоо сум	Ан, агнуур зохион байгуулалтын ажлын хүрээнд хашиж хамгаалсан.
37	Элгэн задгай, Баян – Овоо сум	Баян – Овоо сум	Баян – Овоо сум	Ан, агнуур зохион байгуулалтын ажлын хүрээнд хашиж хамгаалсан.
38	Улаан хөөврийн задгай, Номгон сум	Баян – Овоо сум	Баян – Овоо сум	Ан, агнуур зохион байгуулалтын ажлын хүрээнд хашиж хамгаалсан.
39	Элгэн, Номгон сум	Баян – Овоо сум	Баян – Овоо сум	Ан, агнуур зохион байгуулалтын ажлын хүрээнд хашиж хамгаалсан.
40	Зүүнэ хуршуут, Гурвантэс	“Саусгоби сэндс”	-	
41	Дунд хуршуут, Гурвантэс	“Саусгоби сэндс”	-	
42	Баруун хуршуут, Гурвантэс	“Саусгоби сэндс”	-	
43	Хацавч, Гурвантэс сум	“Саусгоби сэндс” ХХК	-	2009 онд хашиж хамгаалсанаа 2011 онд дахин сэргээсэн
44	Хайрт, Гурвантэс сум	“Саусгоби сэндс” ХХК	-	
45	Дов, Гурвантэс сум	“Саусгоби сэндс” ХХК	-	
46	Хаяа, Гурвантэс сум	“Саусгоби сэндс” ХХК	-	
47	Зүүн хөв, Гурвантэс сум	“Саусгоби сэндс” ХХК	-	
48	Жигдэн, Гурвантэс сум	“Саусгоби сэндс” ХХК	-	
49	Баруун сухант, Гурвантэс	“Чин хуа- МАК- Нарийн сухайт”	-	
50	Шар хулсан, Мандал- Овоо	“Олон овоот гоулд”	-	
51	Сүүж булаг, Баяндалай сум, Наран баг	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	2627200	

52	Завгийн булаг, Булган сум, Дал баг	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	4577200	Завгийн булаг хамгаалах, энгийн гар худаг гаргах, 0.5 га бэлчээр хаших, мод тарьж, олон наст ургамал тариалах
53	Тосонгийн гол, Номгон сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	3000000	Хажууд нь дэрстэй гол хаших
54	Ганзагад булаг, Ноён сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	2500000	
55	Улаан эргийн булаг, Ханхонгор сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	1445000	
56	Нүдэн булаг, Хүрмэн сум, Жанжин баг	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	1500000	
57	Улаан толгойн нарийн булаг, Цогт-Овоо сум, Найз баг	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	3572800	
58	Эх булаг, Даланзадгад сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	1140000	
59	Ажлын булаг, Баруун толь, Баян – Овоо сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	4957100	
60	Хөөврийн булаг, Манлай сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	1308400	
61	Сайрын булаг, Номгон сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	4800000	
62	Мөнх ундрах, Номгон сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	2694270	Булгийн нэр тодорхойгүй
63	Замын булаг, Номгон сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	2804000	
64	Хонин булаг, Ханхонгор сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	3000000	
65	Эрдэнэ булаг, Хүрмэн сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	5510000	
66	Далан булаг, Даланзадгад сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	2000000	
67	Довын булаг, Манлай сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	1500000	
68	Шинэ ус, Баяндалай сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	3372000	
69	Задгадын булаг, Баян-Овоо сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл		
70	Довын булаг, Манлай сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	1500000	
71	Арвин булаг, Номгон сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	1745000	
72	Цанхийн гол, Номгон сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	3347500	
73	Булаг сүүж, Номгон сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	2341200	
74	Наран булаг, Сэврэй сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	2000000	
75	Ажлын тойром, Цогтцэций сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	2500000	
76	Могойтын рашаан, Манлай сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	2500000	
77	Ариунбулаг, Гурвантэс сум	Тогтвортой амьжиргаа – 2 төсөл	2000000	

Тус аймаг нь гадаргын болон гүний усны нөөц багатай бөгөөд гадаргын усны гол нөөц нь нуур, цөөрөм тойром байдаг. Нуур тойрмуудын хамгийн том нь Мандал-Овоо,

Булган сумын хилийн орчимд байдаг Улааннуур юм. Улааннуур нь Э.М.Мурзаев, И.Д.Беспалов нарын тогтоосноор 135-175 км² байсан боловч одоо ширгэж усгүй болоод байна. Энэ нуурыг тэжээдэг цорын ганц эх үүсвэр бол Онгийн гол бөгөөд сүүлийн үед шургаж тасалдах явдал ажиглагдаад байгаа юм. Тус аймагт байдаг нуур тойрмуудын хамгийн том нь Мандал-Овоо, Булган сумын хилийн орчимд байдаг Улааннуур юм. Улааннуур нь Э.М.Мурзаев, И.Д.Беспалов нарын тогтоосноор 135-175 км² байсан боловч одоо ширгэж усгүй болсон байна. Энэ нуурыг тэжээдэг цорын ганц эх үүсвэр бол Онгийн гол юм.

Онги гол Хангайн нурууны өвөр Хятрууны уулнаас эх авч Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгийн 8 сумын нутгийг дамжин 500 орчим км урсан Өмнөговийн Мандал-Овоо, Булган сумын нутаг дахь Улаан нуурт цутгадаг.

8.3. Гидрогеологийн нөхцөл, гүний усны судалгаа

Өмнөговийн регионы бассейнуудын газар доорхи усны тэжээл нь ерөнхийдөө агаарын хур тунадас боловч, бүх талбайн хэмжээнд нэвчихгүй. Энэ нэг талаас агаарын хур тунадасны хэмжээ багатай холбоотой, нөгөө талаас чулуулаг хурдасны шүүрэлтийн шинж чанар муу тул нэвчихээс өмнө ууршиж алдагдана. Агаарын хур тунадасны шүүрэлт нь гидрогеологийн бассейнуудад гол төлөв түр зуурын борооны ус урсах хуурай сайр жалгуудаар явагдана. Хуурай сайрууд уулын массиваас эх авч бассейн руу чиглэж зарим нь бассейны төв хүрэх боловч ихэнхи нь бассейны хажууд олон сайрууд нийлэн пролювийн шлейф үүсгэдэг. Ан цав-давхаргын усны тэжээл нь гол төлөв усжсан хагарлын ан цав-судлын усаар, мөн кайнозойн хурдасны нүх сүв-давхаргын усаар үл нэвтрүүлэх чулуулаг тасарсан гидрогеологийн цонхоор явагдана. Иймд ан цав-давхаргын усны горим цаг уурын хүчин зүйлсээс дам хамаарч түүний хөдөлгөөн нь даралт даралтгүй шинжтэй байна.

Гидрогеологийн бассейнуудын газар доорхи ус нь янз бүрийн зорилгоор (бэлчээрийн төвийн усан хангамжийн, малын усалгааны, үйлдвэрийн уурхайн) өргөн ашиглагдаж байна.

Даланзадгадын гидрогеологийн бассейн нь зүүн хойшоо сунаж тогтсон уртаашаа 200 км бөгөөд гадаргуу нь толгордорхог тал газар юм. Хажуу хэсгээс төврүү үнэмлэхүй өндөр нь аажмаар буурч 1400-т хүрнэ. Тус бассейныг дотор нь 2 жижиг бассейнд хуваан авч үздэг.

- Мандах
- Даланзадгадын

Даланзадгадын бассейнд тархсан ан цав давхаргын ус агуулах чулуулгийн усжилт харьцангуй бага. Тухайлбал: Зүүнбаянгийн давхаргад усны аж ахуйн контороос өрөмдсөн цооногийн шавхалтаар хувийн ундарга 0.05 л/с, 1983 онд өрөмдсөн цооногийн шавхалтаар хувийн ундарга 1.1л/с байлаа. Энэ цооног уулын хормой хэсэгт өрөмдөгдсөн бөгөөд чулуулгийн усжилт өндөр байгаа нь чулуулгийн контактын дагуу үүссэн давхарга хоорондох тектоник шилжилт эвдрэлтэй холбоотой юм. Харин пролювийн шлейфүүдийн

газар доорхи усыг төвлөрсөн усан хангамжинд ашиглах боломжтой байна. Өмнөговь аймгийн төвийн усан хангамжийн эх үүсвэрийг энэ коллекторын газар доорхи усны ордоор хангаж байна. Гидрогеологийн судалгаагаар тус ордын газар доорхи усны нөөцийг В+С зэрэглэлээр 4000м* хоног (*=3) гэж үнэлсэн байна. Балгасын улаан нуурын гидрогеологийн бассейн регионы зүүн-өмнөт хэсэгт байрлах бөгөөд уулын массиваар хүрээлэгдсэн хаалттай уулс хоорондох хотгор болно. Балгасын улаан нуурын бассейны зүсэлтийн дээд хэсэгт пролюви-делювийн, пролювийн, аллювийн, нуур-аллювийн ба нуурын хурдсын нүх сүв давхаргын коллекторууд байрладаг. Үүнээс усжилтын хувьд пролювийн коллектор өндөр ач холбогдолтой. Үүнээс илэрч буй Хуцын булаг, Нарийн булгийн ундарга нь 2-3 л/с. Цооногийн хувийн ундарга нь 0.8-3 л/с хооронд хэлбэлзэнэ. Газар доорхи ус нь сульфат-гидрокарбонат заримдаа гидрокарбонат сульфат натрий-кальцийн найрлагатай, эрдэжилт нь 0.4-0.7 г/л. Сэвсгэр хурдсын дор дээд цэрдийн сул цементлэгдсэн конгломерат, элсэн чулуу, гравелит, шаврын ба элсний үеүд байрлана. Түүний зузаан нь геофизикийн судалгаагаар 500-600 м байна. Тэд ан цав-давхаргын коллекторын газар доорхи усыг агуулна. Балгасын улаан нуурын гидрогеологийн бассейн эгц налуутай ба давхарга хоорондох шилжилтийн тектоник хагарал, эвдрэлүүдээр хэрчигдэж бассейны дотоод бүтцийг нилээд нийлмэл бүтэцтэй болгосон. Энэхүү тектоник хагарал, суларсан бүсийн дагуу ан цав-судлын газар доорхи ус оршиж өндөр ундаргатай булаг илэрсэн байдаг. Тухайлбал Шавартийн булгийн ундарга 16.2 л/с байсан. Улаан нуурын хагарлыг огтолсон цооногийн ундарга 30 л/с байна. Тус бассейнд газар доорхи усны ордыг илрүүлсэн бөгөөд c_1+c_2 зэрэглэлээр нөөц нь 40178м³/хон байна. Усны эрдэжилт 0.8 г/л.

Өмнөговь аймгийн нутагт Оюу толгойн зэс алтны орд нээгдсэнтэй холбоотой Галбын говь, Гүний хоолойн зэрэг гидрогеологийн бассейнүүдэд судалгаа эрчимтэй явагдаж байна. Геофизикч С.Санждорж, гидрогеологч Н.Мөнхбаатар, Г.Өлзийбаяр нарын судалгааны материалаас доор үзүүлэв. Галбын говийн хотгор урд захаараа Далан шар (1113.6м), Шовын хүрэн (1165.8м), Номгон уул (1161.0м) орчмын бөмбөгөрдүү оройтой аажим налуу гадаргуутай нам уулсаар (гидрогеологийн массивуудаар), гүний хоолой хойд захаараа Улаан уул, зүүн талаараа Алаг баян зэрэг нам уулс, бие биенээсээ тусгаарлагдсан багавтар өргөгдлүүдээр хүрээлэгджээ. Ханбогдын өргөгдөл гүний хоолойн хөндийтэй нилээд огцом байдлаар нийлдэг. Уг хөндийн урд жигүүрээр 70 гаруй км үргэлжилэх томоохон сайр хөндийн суналын дагуу үргэлжилдэг ба уг сайраас хойш тэгшивтэр долгиолог гадаргуу зонхилж, идэгдэх угаагдлын мөргөцөг бүхий тэгшрэлийн үлдэц ухаа цав, толгод гадаргын өвөрмөц бичил хэв шинжийг бүрдүүлнэ. Уг хөндий нь зүүн хойт чигт төлөгийн талын үргэлжилтэй нийлэх ба зүүн чигт Цовчирын говийн чигт үргэлжилнэ. Гадаргуугын өндөршлийн хувьд Галбын говийн хөндийгөөс харьцангуй өндөр байрлалтай ба зүүн урагш аажим намсдаг. Гадаргын хамгийн нам цэгийн үнэмлэхүй өндөр 930-940 м. Галбын говийн бассейн төв хэсгээрээ 870-940 м үнэмлэхүй өндөртэй, нуурын тэгш ёроолт хотгор түүнээс дээш нам уулсын чигт аажим шатлан өндөрсөх (980м)

тэгшрэлийн үлдэц бүхий элэгдэл хуримтлалын гадаргуутай баруун талаараа Заг сүүжийн говь зүүн, зүүн хойш Дуутын тойрмын чигт 150-170 км орчим үргэлжилдэг.

Галбын говь ба Гүний хоолойн гидрогеологийн бассейнуудад газрын доорхи усны тархалт, хөдөлгөөн хуримтлалын онцлогууд, ус агуулагч чулуулгийн литологи-петрографийн найрлага, давхарга зүйн ангиллыг харгалзан дараах уст үе давхарга, цогцолборуудыг ялгаж болно. Үүнд:

1. Дээд дөрөвдөгч сэвсгэр хурдас дахь уст үе давхарга (Q ii-iv)
2. Дунд-дээд дөрөвдөгчийн сэвсгэр хурдас дахь алаг цоог тархалттай газрын доорхи ус (Q ii-iii)
3. Дээд цэрдийн Баян заагийн давхаргадсын тунамал хурдасны уст үе давхарга (K2 bz)
4. Дээд цэрдийн Баян ширээгийн давхаргадсын тунамал хурдасны уст үе давхарга (K2bs)
5. Дээд цэрдийн Сайншандын давхаргадсын тунамал хурдасны уст үе давхарга. (K2ss)

Доод цэрдийн Хөх тээгийн давхаргадсын тунамал хурдасны зузаалаг дахь алаг цоог тархалттай газрын доорхи ус (K1ht)Судалгаагаар Галбын говийн гидрогеологийн бассейнд газар доорхи усны ордыг илрүүлэн ашиглалтын таамаг нөөцийг 31967 м³/хон, Гүний хоолойн гидрогеологийн бассейнд С, зэрэглэлээр 53136 м³/хон нөөцтэй газар доорхи усны ордыг илэрүүлж, цаашид нарийвчилсан гидрогеологийн судалгаа явуулах нь зүйтэй юм.Газар доорхи усны нөөц баялагийн зургийг 1:1000000 масштабтайгаар газрыг үнэлэх, газрын доорхи усныг ашигласны төлбөр тогтоох зэрэг чиглэлээр ашиглахад хялбар байдлаар Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд доктор Н.Жадамбаа үйлдсэн ба үүнээс Өмнөговь аймгийн газар доорхи усны нөөц баялгийн зургийг хавсралтаар үзүүлэв. Энэ зурагт газар доорхи усны нөөц нь олон төрлийн хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд тэдгээр нь нөөц үндсэндээ байхгүй юмуу маш багатайгаас ихтэйг хүртэл нөөцтэй орчныг ангилан ялгах шалгуур болгон үзүүлсэн байна. Доктор Н.Жадамбаагийн боловсруулсан газар доорхи усны нөөц баялагийн шалгуур зарим үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт№ 8.5. Газрын доорх усны нөөц баялгийн нөхцлийн шалгуур

Далайн түвшнээс дээших өндөр, м	Хотгор гүдгэрийн дундаж хэвгий	Геологи-тектоникийн тогтоц /давамгайлах төрлөөр нь /	Хур тунадас, мм	Гадаргуугийн урсац /олон жилийн дундаж/, мм	Газрын доорх урсац /жилийн дундаж/, мм	Газрын доорх усны нөхөн сэргээгдэх чадвар	Зонхилон тархсан уст үеийн				Ашиглалтын нөөцийн модуль л/с.км ²	Газрын доорх цэнгэг усны нөөцийн хангамшлын нөхцөл
							үндсэн төрөл	Усжилт л/с	Уст үеийн зузаан, м	Ус дамжуулах чадвар, м/хон		
1000-1500	1.5-3.0	Хотгор kz-Q	155 - 200	5-10	30-50	Дунд	Q-kz-н ул хөрсний Mz-Kz н үе	0.5-5.0	5-30	200-300	20-3	сайн
1500-2000	3.0-6.0	Q-н элс хайрган хуримтлал	200 - 225	10-50	50-100 >100	Сайн	Q-н зузаан ул хөрсний	1-20.0	10-50	100-500	>3-4	Нэн сайн
2000-5000	6.0-12.0	Q-н хуримтлал, kz-өргөгдөл	225 - 250	50-100	20-50	Дунд	Q-н ба анцавт ул хөрсний	0.5-10.0	1-10	50-100	2-3	Дунд

2500-3000	12.0-20.0	Kz-Mz өргөгдөл	250 - 300	100-200	20-10	Дунд	Q-н ба цавт ул хөрсний, тектоник хагарал, судлын	0.1-5.0	2.5	20-50	0.5-1.0	Дунд юм уу муу
3000-4000	20.0	PZ-Mz-Kz өргөгдөл	300 - 400	200-300	<10	Муу	Ан цавт ул хөрсний, тектоник хагарал судлын	0.1-3.0	1-5	5-20	0.5-аас бага	Муу, маш муу

Газар доорхи усны нөөц баялагийн зурагт (дээрх хүснэгтэд заасан) шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн 4 ангилалд хувааж зурагласан байна. Үүнд:

Үндсэндээ усгүй юмуу маш бага /хавтгай дөрвөлжин нэг километр талбайгаас секундэд 0.1 литрээс бага ус ашиглаж болохоор/ нөөц баялагтай газрын доорхи ус агуулсан хурдас, чулуулаг тархсан талбай:

Бага /хавтгай дөрвөлжин нэг километр талбайгаас секундэд 0.1-1.0 литр ус ашиглаж болохоор/ нөөц баялагтай газрын доорх ус агуулсан хурдас, чулуулаг тархсан талбай:

Дунд зэргийн /хавтгай дөрвөлжин нэг километр талбайгаас секундэд 1.0-5.0 литр ус ашиглаж болохоор/ нөөц баялагтай газрын доорхи ус агуулсан хурдас, чулуулаг тархсан талбай:

Их /хавтгай дөрвөлжин нэг километр талбайгаас секундэд 5 литрээс их ус ашиглаж болохоор/ нөөц баялагтай газрын доорх ус агуулсан хурдас, чулуулаг тархсан талбай

Хүснэгт № 8.6. Газрын доорх ус агуулсан хурдас, чулуулаг тархсан талбай

д/д	Сумын нэр	Нийт талбай /га/	Маш бага	Бага	Дунд зэргийн
1	Баяндалай	1056679	736332	320347	
2	БаянОвоо	1116080	857743	257388	950
3	Булган	752596	279030	466080	7486
4	Гурвантэс	2803379	1158328	1636039	9012
5	Даланзадгад	47080	6886	40194	
6	МандалОвоо	649215	283116	213741	152358
7	Манлай	1244048	750650	493397	
8	Номгон	1767584	1237337	530247	
9	Ноён	1070563	187486	883077	
10	Сэврэй	812832	362583	450249	
11	Ханбогд	1498866	1152419	346413	34
12	Ханхонгор	989618	544581	428118	16919
13	Хүрмэн	1344766	976784	367981	
14	ЦогтОвоо	655811	131899	523912	
15	Цогтэций	728932	465643	263289	

Усан хангамжын эх үүсвэрийн голлох хувийг гүний ус эзэлдэг бөгөөд усны орд газрууд болон усархаг намгархаг газруудыг тусгайлан хамгаалах шаардлагатай байгаа юм. Газрын доорхи эрдэжилт ихтэй усны орд:

- Баяндалай сум Бүгтийн хоолой
- Хүрмэн сумын Таван сухайн хөндий

- Ханбогд сумын Гүний хоолой
- Ханбогд сумын Галбын говь
- Цогтцэцэий сумын Наймантын хөндий

Газрын доорхи усны нөхөн сэргээгдэх байдал: Говийн бүсийн газрын доорхи усны нэг онцлог нь шаврын үе давхрагуудын доорхи ус агуулагч уст үе нь зузаан багатай, ус нь эргэлтэнд орохдоо удаан, уст үе хоорондын харилцан хамаарал багатай, хур тунадас /жилдээ 86,7 мм Ханбогдын цаг уурын харуулын мэдээнээс/ бага ордог учраас нөхөн сэлбэгдэл багатай байдаг. Мөн агаарын хур тунадас, хөрсний хөрөлт халалтын явцад явагдах конденсацын замаар газрын доорхи ус нөхөн сэргээгддэг онцлогтой.

Гүний хоолойн газрын доорхи усны орд: Гүний хоолойн газрын доорхи усны орд нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт оршдог, Оюу толгойн ордын үйлдвэрийн усан хангамжийн зориулалтаар газрын доорхи усны гидрогеологийн гүйцээх хайгуулын ажлыг иж бүрэн цогцолбор аргаар техникийн өндөр түвшинд хийж, урьд өмнөх хийсэн судлаачдын бүтээлийг нэгтгэн дүгнэсэн бөгөөд говийн бүсэд нээн илрүүлж нөөцийг үнэлсэн томоохон газрын доорхи усны ордын нэг болж байна. Тус ордын талбай 438,3 км², урт нь 45 км өргөн нь баруун хэсэгтээ 5-8 км, зүүн хэсэгтээ дундажаар 12 км, газрын доорхи усны эрдэсжилт ихтэй ордын нэг юм.

Газрын доорхи усны зүй тогтол: Энэ орд нь гидрогеологийн нөхцөлийн хувьд маш нийлмэл нөхцөлтэй, үндсэн чулуулгийн өгөршил, идэвхтэй ан цавшилтын бүсэд орших ба талбайн газрын доорхи усны гүний тархалтын хувьд туйлын жигд биш, нөөцийн хувьд хязгаарлагдмал, газрын доорхи уст давхрага нь газрын гадаргаас 115-287 м-т байрлаж, ордын хэмжээнд дундаж зузаан нь баруун хэсэгтээ 88 м, зүүн хэсэгтээ 153 м, түрэлтэт шинж чанарыг агуулах ба түрэлтийн дундаж хэмжээ нь 101,2-106,5 м, ус агуулж буй уст үе нь Цэрдийн галавын Баянширээтийн свитэд агуулагдана. Цооногийн гүн дундажаар 208-400 м. Газрын доорхи усны тэжээгдлийн хувьд гадаад болон дотоод тэжээгдлийн мужаас тэжээгдэнэ.


Хүснэгт № 8.7. Нөөц нь батлагдсан газрын доорх усны ордуудын бүртгэл

№	Ордын нэр	Байршил		Нөөц, м3/хон
		У	Х	
1	Таван сухай	103 28 00	42 46 00	1814
2	Хүрмэн сумын төвийн орд	104 15 00	43 20 00	5432
3	Хувьын орд	102 24 01	43 17 13	360
4	Тэсэгний хоолой	103 53 50	43 20 50	5012
5	Балагасын улаан нуур /2008/	106 10 11	44 30 21	13032.9
6	Борзонгийн говь	104 40 00	42 20 00	29894
7	Дугуй улаан уул	104 52 43	42 07 47	1227
8	Ноён	102 13 00	43 09 00	300
9	Бүгтийн хоолой	103 30 00	42 40 00	11837
10	Байшинтын хоолой	103 29 55	43 29 55	7732
11	Баян төхөмийн хоолой	103 17 47	43 38 42	7732
12	Далай булаг	103 42 40	43 28 01	1331
13	Таван загийн орд	100 30 00	43 45 00	1728
14	Хонгорын гол	102 07 00	43 44 00	3110.4
15	Мандах	103 52 40	43 40 50	3543.2
16	Нарийн заг	106 35 00	43 40 00	6500

17	Баян-Овоо	106 15 00	43 40 00	87.6
18	Гурван тэс	101 04 45	43 15 02	259.2
19	Нарийн уул	100 03 50	43 23 55	613.4
20	Баруун гол	101 08 00	43 19 00	7641.2
21	Ноён	102 07 30	43 07 50	205.6
22	Даланзадгадын булаг	104 23 00	43 50 00	4061
23	Үйзэнгийн орд	105 44 20	43 42 34	143.18
24	Дух толгой	105 44 38	43 42 11	26.5
25	Хүрэн толгой	105 36 11	43 42 53	173.66
26	Ханбогд /1998/	107 11 30	43 11 31	185.12
27	Гурван тэс	101 02 00	43 12 50	498.86
28	Номгон сум	105 38 20	42 50 30	821
29	Баян хошуу	103 40 00	44 15 00	1296
30	Зайрмагтай	106 02 35	43 20 36	1983
31	Наймант	105 15 30	43 50 00	4579.2
32	Гүний хоолой	107 01 00	43 13 00	75168
Дүн				1725773.66

Эх сурвалж: Эх сурвалж: “Усны нөөцийн нэгдсэн менежментийн үндэсний төлөвлөгөө боловруулахад зориулсан судалгааны эмхэтгэл”-ийн Нэгдүгээр дэвтэр [Дөрөвдүгээр бүлэг. Гадаргын доорх усны нөөцийн үнэлгээ]

Услалтын систем.




Зураг № 8.6. “ЭНЕРЖИ РЕСУРС” ХХК Наймантын хотгор

2010 оны 4 сарын 5-ны өдөр ус хангамжийн системийн барилга угсралтын ажил эхэлж, 2011 оны 5 сарын 30-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

Бүтэц:

- Ус татах 12 ш гүний худаг,
- 43.5 км цуглуулах шугам,
- 500 м³ –н усан сан,
- 2-р өргөлтийн насос станц,
- 12 км ус дамжуулах хос гол шугам,
- 500м³ – н түрэлтэт усан сан,
- Үйлдвэрийн тасралтгүй ажиллагааг хангах 2х28000м³ усан сан,

Уурхайн тосгон, сумын төвийг усаар хангах 4,5 км салбар шугам,
 Уурхайн 4.1 км түгээх шугам,
 10, 35кВ-ын ЦДАШ, 35/10 кВ-ын дэд станц,
 Удирдлага хяналтын телеметрийн систем,
 Цогтцэций сум болон уурхайчдын хотхоныг хангах ундны ус цэвэршүүлэх
 байгууламж зэргээс бүрдэнэ.



Зураг№ 8.3. Наймдайн хөндий:

Бүтэц:

Ус татах 18 ш гүний худаг
 43 км цуглуулах шугам
 1000 м³ –н 3 усан сан
 2,3,4-р өргөлтийн насос станцууд
 50 км ус дамжуулах хос гол шугам,
 10, 35кВ-ын ЦДАШ, 35/10 кВ-ын 3 дэд станц
 Удирдлага хяналтын телеметрийн систем

Хийхээр төлөвлөсөн ажлаас Цогтцэций сумын нутагт 8ш худгийг гаргаж 43 км цуглуулах шугамын ажлыг дуусгаж байна. Цогт-Овоо сумын иргэд өөрийн нутагт худаг гаргаж, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглуулахыг зөвшөөрөөгүй байна.

Ашиглалтын худаг тус бүрийн дэргэд хяналтын цооногуудыг өрөмдөж гүний усны түвшинд хяналт хийхэд ашиглаж байна. Үүнээс 2 цооногийг БОНХЯ-аас хяналт тавихаар тоноглож байна.

Худгийн насосны ажиллагаа, усны зарцуулалт, даралт, усны түвшингийн өөрчлөлт, температур, гал болон хөдөлгөөний дохиолол бүхий телеметрийн системээр хяналт тавьдаг байна.

Ухаа худагийн усны хэрэглээг хангахад секундэд 200 м³ ус татах

Оюу толгой ХХК:

Тус байгууллага нь Баяжуулах үйлдвэр болон бусад хэрэгцээнд ашиглах усны эх үүсвэрийн хайгуулыг тасралтгүй хийж, Гүний хоолой, Галбын говийн газрын доорхи усны ордыг тогтоосон.

Гүний хоолойн ус татах байшууламж нь хоногт 77760 шоо.м ус олборлох хүчин чадал бүхий байгууламжтай. **Бүтэц:**

- Ус татах 28 ш гүний худаг
 - 5-н ус өргөх станц
 - 200.000 шоо.м багтаамжтай 2 ширхэг ус
 - Хуримтлуулах цөөрөм
 - 88 км ус цуглуулах шугам
 - 65 км ус дамжуулах шугам
 - 500м³ – н түрэлтэт усан сан,
 - 220кв-ын ЦДАШ
 - Удирдлага хяналтын телеметрийн систем
 - Уурхайчдын хотхоныг хангах ундны ус цэвэршүүлэх байгууламж зэргээс бүрдэнэ.
- Ашиглалтын худаг тус бүрийн дэргэд хяналтын цооногуудыг өрөмдөж гүний усны түвшинд хяналт хийхэд ашиглаж байна. Үүнээс 4 цооногийг БОНХЯ-аас хяналт тавихаар тоноглож дууссан байна.
- Худгийн насосны ажиллагаа, усны зарцуулалт, даралт, усны түвшингийн өөрчлөлт, температур, гал болон хөдөлгөөний дохиолол бүхий телеметрийн системээр хяналт тавьдаг байна.
- Оюу толгойн усны хэрэглээг хангахад секундэд 500 м³ ус шаардагддаг.

ЭНК ХХК-ны кокс химийн үйлдвэр:

Баян-Овоо сумын нутагт кокс химийн үйлдвэртэй ЭНК ХХК-нь 2008 оноос хойш Таван толгой ХК-аас нүүрс худалдан авч коксжуулан экспортолдог

Бүрэн хүчин чадлаараа ажиллахад хоногт 600 м³ ус ашиглах тооцоотой.

Усны хэрэглээг үйлдвэрийн орчимд байрших Зайрмагтай /1983 хоног/м³/ гүний усны нөөц бүхий газарт өөрсдийн хөрөнгөөр гаргасан 3-н гүн өрмийн худгаас ашигладаг.

Хүснэгт № 8.8. Өмнөговь аймгийн 100 м³ ус ашиглагчдын ус ашиглалтын судалгаа

№	Сумын нэр	Аж ахуйн нэгж байгууллага, иргэний нэр	Үйл ажиллагааны чиглэл	Сав газар	Нийт ашиглах усны хэмжээ	Нийт ус ашигласаны төлбөр /төг/
---	-----------	--	------------------------	-----------	--------------------------	---------------------------------

					/м ³ /	
1	Баян - Овоо	“ЭНК” ХХК	Нүүрс баяжуулж кокс, давирхай гарган авах, экспортлох	Галба Өөш долоодын говь	144472	242583894
2	Гурвантэс	“МАК” ХХК	Ашигт малтмал олборлолт	Алтайн өвөр говь	95785	122933031
3		“Чин хуа – МАК – Нарийн сухайт” ХХК	Ашигт малтмал олборлолт	Алтайн өвөр говь	244530	466130615
4		“Саус гоби сэндс” ХХК	Ашигт малтмал олборлолт	Алтайн өвөр говь	433243.5	615749185
5		“Жавхлант орд” ХХК	Ашигт малтмал олборлолт	Алтайн өвөр говь	22755	35151119.2
6	Номгон	“Дун юань” ХХК	Холимог металлын ордоос хар тугалга олборлох	Алтайн өвөр говь	37947.5	52480569.3
7	Ханбогд	“Оюу толгой” ХХК	Алт, зэс баяжуулах, олборлох	Галба Өөш долоодын говь	9476548	16255727202
8	Цогтцэций	“Энержи ресурс” ХХК	Нүүрс баяжуулах	Галба Өөш долоодын говь	2400000	4 219 767 000
9		“Ухаа худаг ус хангамж” ХХК	Унд ахуйн болон үйлдвэрлэл	Галба Өөш долоодын говь	391945	496 221 043
10		“Эрдэнэс таван толгой” ХК	Унд ахуйн болон үйлдвэрлэл	Галба Өөш долоодын говь	89105	95 189 096
11		“Таван толгой” ХК	Унд ахуйн болон үйлдвэрлэл	Галба Өөш долоодын говь	468595	680 328963
12		“Монголын Төмөр Зам” ХХК	Төмөр замын далангийн шороон овоолгыг нягтруулах	Галба Өөш долоодын говь	733886.68	1 287 144 299
13	Даланзадгад	“Гүний ус” ХХК	Нийтийн аж ахуй үйлчилгээ	Онги гол	368044	300087646
Нийт					1036829.3	24869493662.5

Хүснэгт № 8.9. Өмнөговь аймгийн 0-50 м³ ус ашиглах дүгнэлт гаргуулсан иргэн, аж ахуйн нэгжийн бүртгэл /сумдаар/

№	Сумын нэр	Ус ашигалгч иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Ашиглах усны хэмжээ м ³	Ус ашиглах төлбөр
1	Ханбогд	“Трансгоби” ХХК	Тээвэр	65700	7549587
2	Цогтцэций	“Цог - Өрнөх” ОНӨААТҮГ газар	Дулаан үйлдвэрлэл, халуун ус, үсчин	8871.8	11699065.2
3	Булган	“Говийн гурван тэмээ” ХХК	Аялал жуулчлал	702	623922.25
4	Номгон	“Альшаа хайрхан”	Хайгуул	318	599519
5	Булган, Мандал-Овоо	“Жи Эс Би майнинг” ХХК	Хайгуул	1149	1631517
6	Мандал-Овоо	“Ингэн тагш” ХХК	Хайгуул	72	77200
7	Цогтцэций	“ЦАБАС” ХХК	Ус цэвэршүүлэн савлах	2974.75	2589967

8	Гурвантэс	Бласт	Тэсрэх дэлбэрэх үйлдвэр	5521	6214380
9	Ханхонгор	“Удмын өргөө” ХХК	Эсгий үйлдвэр	2490	2670525
10	Цогтцэций	“Мера” ХХК	Тэсэлгээ үйлдвэр	2974.75	2589967
11	Сэврэй	“Говийн анар” ХХК	Аялал жуулчлал	295.24	758346.2
12	Ханхонгор	“Могоул жигүүр” ХХК	Аялал жуулчлал	79	84727.5
13	Гурвантэс	“Би Ди Би Эл” ХХК	Хайгуул	524	6005560.4
14	Ноён	“Би Ди Би Эл” ХХК	Хайгуул	523.52	1311969.34
15	Гурвантэс	“Монгол чадал интернэшнл энерги” ХХК	Хайгуул	317	608850.3
16	Булган	“Жамоторабэрү” ХХК	Аялал жуулчлал	325	295603
17	Гурвантэс	“Говийн их үйлс” ХХК	Зоогийн газар, буудал	1099.2	1608009
18	Гурвантэс	“Нутгийн од” ХХК	Хүнсний дэлгүүр	3.65	5340
19	Гурвантэс	“Шугшаа хайрхан” ХХК	Дэлгүүр	3.65	5340
20	Гурвантэс	“Говьтэгш” ХХК	Цайны газар, буудал, дэлгүүр	430.65	629994
21	Гурвантэс	“Агь ордос” ХХК	Дэлгүүр	3.65	5340
22	Гурвантэс	“Түмэн тэмээний орон” ХХК	Дэлгүүр	3.65	5340
23	Гурвантэс	“Нутгийн итгэл” ХХК	Дэлгүүр	3.65	5340
24	Номгон	Номгон сумын иргэн Д.Батжаргал, Жирмийн 1-1 тоот	Дэлгүүр	3.65	5340
25	Номгон	“Гоёт баян” ХХК	Дэлгүүр	879.57	1286714.1
26	Номгон	“Говийн цэнхэр уулс” ХХК	Дэлгүүр	3.65	5340
27	Номгон	“Найнфон нэн юань”	Хайгуул	316.9	608835.4
28	Цогт-Овоо с	“И Эм Жи Ар” ХХК	Хайгуул	6072	9795972
29	Гурвантэс	Л.Гантөмөр	Бумбат дэлгүүр	3.65	5340
30	Даланзадгад	Сайхны өвөр ХХК	Халуун ус, саун	12959.04	13898570.4
31	Цогтцэций	“Вагнер Ази” ХХК	Тоног төхөөрөмж худалдаа, засвар	2282	1231047.72
32	Номгон, Хүрмэн	“Голден гоби майнинг” ХХК	Хайгуул	1087.5	1867678.3
33	Хүрмэн	“Голден гоби майнинг” ХХК	Хайгуул	2175	3735356.6
34	Хүрмэн	“Голден гоби майнинг” ХХК	Хайгуул	2175	3735356.6

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, АМРАЛТ ЗУГААЛГЫН БҮС НУТГИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

9.1. Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал

Өмнөговь аймаг бол Монгол улсын аялал жуулчлал анхлан хөгжсөн аймгуудын нэг бөгөөд аялал жуулчлалын хамгийн танигдсан газруудын нэг юм. Бидний тооцоолсноор, Өмнөговь аймагт жил бүр 20000-40000 гаруй жуулчид ирдэг. Тус аймагт одоо нийт 1257 ор бүхий 22 жуулчны баазууд ажиллаж байна.

Аялал жуулчлалын нөөцүүд, тэдгээрийн үнэлгээ

Байгалийн нөөц

Хонгорын элс

Өмнөговь аймгийн Сэврэй суманд байдаг. Насны хувьд Монгол орны хамгийн залуу элсэн



хуримтлал юм. Сэврээ, Зөөлөн уулын араар 180 орчим км үргэлжилсэн 3-15 км өргөн өвс ургамалгүй гөлөөн манхат сул элс юм. Манханы өндөр нь 100-300 метр хүрнэ. Энэ элс нь манай орны нутгийн 2,7 хувийг эзэлдэг элсний нэгээхэн хэсэг юм. Дэлхийд ховор, Монгол Улсын Улаан номд тэмдэглэсэн Хулан жороо-*Mongolian Ground Jay-Podoces hendersoni*, Жороо

тоодог-*Houbara Bustard-Chlamydotis veredus*, Ногтруу-*Pallas Sand grouse-Syrhaptes paradoxus*, Загийн бор шувуу-*Saxaul Sparrow-Passer ammodendri* зэрэг шувуудаас гадна жил бүрийн хавар, намарт төрөл бүрийн усны шувууд дайран өнгөрдөг монгол орны томоохон баян бүрдийн нэг.

Хонгорын гол

Хонгорын элсний хойд захаар Хонгорын гол гэдэг баян бүрд үүссэн нь нэн сонирхолтой. Хонгорын элсний зүүн урд орших том уул Зөөлөнгийн нурууны араас буусан үерийн ус



Хонгорын элсний дундуур хойшоо зам гарган нэвт урсаж хөрсөнл шингэнэ. Энэ шингэсэн ус элсний хойд захад Сэрүүн булаг, Аргангын булаг нэртэйгээр газар дээр гарч баруун тийшээ элснийхээ хаяагаар 10 гаруй км урсан Хонгорын гол болно. Энэ голын орчмоор бургас, шугуй, зүлэг, цэцэг ногоо ургасан хангай газар гэлтэй үзэсгэлэнтэй газар юм.

Говь гурван сайхан БЦГ

Анх 1965 онд Ёлын амыг дархалсан бөгөөд 1993 онд өргөтгөж Хонгорын элс, Нэмэгт, Хэрмэн цав, Зулганайн гол зэрэг нутгийг хамарсан нийт 2171307 га талбайтай байгалийн үндэсний цогцолборт газраар баталжээ. 1995 оны УИХ-ын 26-р тогтоолоор ТХГН-ийн



хуулийн дагуу “ үндэсний” гэдэг үгийг хасаж баталгаажуулжээ. 2000 онд Баянхонгор аймгийн Баянлиг, Шинэжинст, Баянговь сумдын нутаг дэвсгэрт орших 523000 га талбай бүхий газар нутгийг нэмж өргөтгөсөн 2694307 га-д хүргэсэн байна. Говь-Алтайн нурууны байгалийн үндсэн төрхийг төлөөлж чадна. Өндөр уул, уулын тайга, хуурай хээр, заримдаг цөл, цөлийн ландшафттай.

Говь гурван сайхныг говь, цөл хүрээлдэг учир нийтдээ хуурай уур амьсгалтай боловч ууландаа арай чийглэг байна. Тус нутаг нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарна. Энд хээрийн ба цөлийн хөрс бүрэлдэх үйл явц зонхилж уулын хүрэн, говийн бор хөрс тархана. Гурван сайханд хамгийн олон буюу нийт 153 зүйлийн ургамал, нэн ховор устаж болзошгүй 18 зүйл, унаган ба завсрын унаган 48 зүйл бүртгэгджээ. Нийт ургамлын 21,7% нь буюу 46 зүйл нь унаган ба ховор ургамал юм. Амьтны аймгийн хувьд нилээд баялаг юм. Энд дэлхийн болон монголын улаан номд орсон аргаль, янгир, ирвэс, хар сүүлт, хадны суусар, шилүүс, мануул, цоохондой, ховордсон бозлог, зурам, цагаан зээр зэрэг хөхтөн амьтадтай. Хэрмийн цав, Нэмэгт уул, түүний ар хоолой, Гурилын цав нь палеонтологийн олдвор, Их баян уул нь түүх, соёлын үнэт өв бүхий шинжлэх ухаан танин мэдэхүйн ач холбогдлоороо үнэлж барашгүй газар нутаг юм.

Ёлын ам

Говь гурван сайхан уулын нэг гайхамшиг нь юм. Ёлын амыг 1965 оноос хойш дархлан хамгаалж байгаа билээ. Энэ ам нь Өмнөговь аймгаас 62 км зайтай орших 2815 метр өндөр оргил бүхий Зүүн сайхан уулын зүүн хойшоо сэтлэн урссан голын тектоник гаралтай бачуу хавцалд үүсчээ. Ёлын ам нь үүгээр урсах горхины хавцал бөгөөд зүүн хойшоо



нарийссаар хэдэн км үргэлжлэн уулаа огтолж талд гарна. Голын арай тавиу хэсэгт цайран байгаа зузаан мөсөн доогуур горхи хоржигнон урсах нүхээр хүн мөлхөж нэвтрэн гардаг. Ам төв хэсэгтээ 200 орчим метр өндөр, цавчим элгэн хадан ханатай. Ёлын аманд Козловын хайруулдай-Mongolian Accentor-Prunella montanella, Алтайн хойлог-Altai

Snowcock-Tetraogallus altaicus, Цармын бялзуухай-Wall Creeper-Tichodroma muraria, Ооч Ёл-Lammergier-Gypaetus barbatus зэрэг дэлхийн хэмжээнд ховордсон болон Монгол улсын Улаан номонд бүртгэгдсэн шувууд байдаг, хавар, намартаа олон зүйлийн шувууд дайран өнгөрдөг. Мөн Янгир ямаа-Siberian or Asiatic Ibex-Capra ibex sibirica-ийн хамгийн их бөөгнөрөл бүхий нутагт тооцогддог ч 2009 оны тооллогоор хорогдсон мэдээ гарсан

байна. Түүнээс гадна дэлхийн хэмжээнд нэн ховордсон Говтын том араатны нэг Ирвэс-Snow Leopard-Uncia uncia, Зэрлэг муур-Pallas s cat or Manul зэрэг амьтдын гол тархац бүхий нутаг болдог учраас Ёлын амны эко системийн байдал, хамгаалалтын дэглэмд онцгойлон анхаарах шаардлагатай.

Төгрөгийн ширээ

Өмнөговь аймгийн Булган сумын төвөөс баруун тийш орших урагшаа эрэглэсэн мөргөцөг. Эргийн өндөр 30-аад метр, энд мөргөцөгийн хананд үлэг гүрвэлийн яс цухуйж байдаг. Эндээс үлэг гүрвэлийн дотроо байгаа зулзаганы араг яс чулуужсан өндөг олддог.



Үлэг гүрвэлийн өлгий Хэрмэн цав

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг, Тосон Бумбын нурууны салбар уул Шаригийн Сондог уулын баруун хойд бэлийн үзүүрт Ингэн Хөөвөрийн хоолой руу хандсан 10 гаруй км урт үргэлжилсэн

100-200 метр гүнзгий жалгатай мөргөцөг юм. Хэрмэн цав нь нар салхи, усны элэгдлийн үйл ажиллагааны улмаас үүсч бий болжээ.

Хэрмэн цав нь Ингэн хөөвөрийн хоолойн үзэсгэлэнт баянбүрдүүдийн нэг бөгөөд Монголын говийн нэгэн гайхамшигт тогтоц учир үзэх хүсэлтэй жуулчдын тоо жил ирэх тутам өсч байна. Хэрмэн цав дунд байх баянбүрдэд хулан, чоно зэрэг амьтдын мөр элбэг таарч байлаа. Заг, хайлаас, тоорой ургахаас гадна, говийн унаган мөлхөгчид болох замба гүрвэл, нохой гүрвэл элбэг тохиолдоно.



Хэрмэн Цав бол Монголын говьд амьдарч динозаврын өлгий нутгуудын нэг юм. Анх 1969 онд академич Р.Барсболд, Л.П.Татаринов, А.Розанов нарын удирдлагаар Монгол-Зөвлөлтийн палеонтологийн хамтарсан экспедици Ингэн хөөвөрийн хоолой орчимд судалгаа хийж Хэрмийн цав, Хайчин уул зэрэг шинэ олдворт газрууд нээн олж динозавр, хөхтөн, шавьж, шувуу, яст мэлхий, матар, нуур усны амьтад болон ургамлын олон шинэ олдворуудыг олжээ. Түүнээс хойш Монголын шинжлэх ухааны академи болон гадаадын палеонтологийн судалгааны экспедицүүдийн хамтарсан судалгааны ажил жил бүр хийгдэж байна.

Хэрмэн цав нь Даланзадгад хотоос 450 км, Хонгорын элснээс 250 км зайтай, замдаа Зулганай, Нарандаац, Гурван тэс, Хайчин уул зэрэг сонин сайхан газруудыг үзэх боломжтой. Хэрмэн цавруу хүрэхэд их хэцүү, огт усгүй, хүн амьдардаггүй, үлэг гүрвэлийн олдвороор баялаг газар юм. Хонхор маягийн газар бөгөөд орох “хаалга” хоёр байдаг

гэгддэг, Төөрөх, магадлал өндөртэй, зундаа +60 хэм хүрдэг айхтар халуун газар тул “Үхлийн цав” гэж ч бас нэрлэдэг.



Баян загийн олдворт газрын тухай

Баянзагийн олдворт газар нь Булган сумын төвөөс зүүн тийш, Дал багийн төвөөс хойшоо 4-5км зайд оршдог улаан хүрэн өнгийн элсжин, шавар, нарийн ширхэг наангиас бүрэлдсэн үзэгдэх зузаан нь зарим газартаа 20-иод метр байдаг. Усны үйл ажиллагаагаар тунаж хуримтлагдсан учраас Нэмэгт, Баруунгоёот давхаргадсууд нь бүгд улаан өнгө зонхилж байдаг.

Харин Булган сумын төвөөс баруун хойшоо 22-25км зайд орших Төгрөгийн ширээ олдворт газар нь насны хувьд Баянзагтай адил Баруунгоёотын цаг үеийнх боловч уг олдворт газар нь цагаан цайвар өнгийн нарийвтар ширхэгтэй элсжингээс тогтсон бөгөөд үзэгдэх зузаан нь 25-30м. Төгрөгийн ширээ олдворт газар нь салхины үйл ажиллагаагаар үүссэн элсний хуримтлал гэж үздэг бөгөөд энд байсан эртний амьтдыг элсэнд дарагдан хадгалагдсан гэж үздэг юм. Энэ олдворт газраас дэлхийн хэмжээний олдворт тооцогддог ноцолдож байгаа махчин үлэг гүрвэл велоцерантор, өвс тэжээлт протоцерантос, дөнгөж өндөгнөөсөө гарч буй протоцерантосын 16 ширхэг зулзага, өндөгөө дарж байгаа юм шиг хадгалагдсан Мононайкус үлэг гүрвэл зэрэг олдвор олдсоноороо энэ олдворт газар дэлхийд нэрд гарсан газрын нэгд тооцогддог юм.

Баянзагийн орчинд Дорнын хиазет-Oriental Plover-Charadrius veredus, Ногтруу-Pallas Sand grouse-Syrhaptes paradoxus, Загийн бор шувуу-Saxaul Sparrow-Passer ammodendri, Хулан жороо-Mongolian Ground Jay-Podoces hendersoni зэрэг шувууд байдгаас гадна 2006 онд нэг бүл Жороо тоодог-Houbara Bustard-Chamydotis undulate хоёр дэгдээхэйн хамт амьдарч байсан баримтууд бий. Эндээс говийн томоохон мэрэгчдийн нэг Морин чичүүл-Grand or Great Gerbil-Rhombomus opimus Lichtenstein, 1823-ийн бүхэл бүтэн бүлүүдийг харж болно.

Түүх соёлын нөөц

Өмнөговь аймагт улсын хамгаалалтанд байх түүх, соёлын дурсгал 8, аймгийн хамгаалалтанд байх түүх, соёлын дурсгал 15, сумын “Түүх соёлын үл хөдлөх дурсгал 112 тус тус байдаг.

Сангийн далай хийд

Сангийн далай хийд бол говийн ард түмний хүч хөдөлмөр, оюун ухаан, хөрөнгө мөнгөөр бий болсон түүх соёлын дурсгалт газар юм. Тус хийдийг 1707 онд Үйзэн Саарав гэгч гэлэн Төвдөөс бадарчилж яваад “Тал хүйтний хөндий” дахь булаг устай газар буудаллаж “Шар дэл” хэмээх газар сан тавьж уг булгийг Сангийн булаг гэж нэрлэн түүний хойд дэнж дээр ганц шавар байшин барьснаар “Сангийн далай” хийдийн эх суурь тавигджээ. 1708 онд

хурлын лам хуврагтай болж хийдийн үйл ажиллагаа эхлэн буян номын ажил явуулсан байна.



1772 онд “Чогчин” дуган барьж энх амгалангийн хаалга хийлгэж уг хийдийг “Рашчойнхордамбадаржаалан” гэж нэрлэжээ. 1835 онд Дуйнхарын дуган барьж, бурхан бүтээх ном судар хэвлэх бичих үйл ажиллагааг эхлүүлж 1843 онд Хайлан дуган, 1847 онд Жүдийн дуган, 1848 онд Сахиусын дуган, 1890 онд Гүүргийн дуган баригдаж “Чогчин, Мамба, Жүд” зэрэг төрөлжсөн сургалтын дацангуудтай болжээ.

“Сангийн далай” хийд нь 500 гаруй лам хуврагтай арван нэгэн дуган сүмтэй, найман дацан, арван жастай, 11000 мянган малтай 1500 сүсэгтэн шавьтай 94:98 – н хэмжээний хэрмэн хашаатай хийд байв. Хамгийн сүүлд “Билигт хувилгаан” гэгч тус хийдийг тэргүүлж байсан бөгөөд шашны эрдэм зэрэгтэй арав шахам хүн тус хийдэд байжээ. 1937 онд шашин сүм хийдийн үйл ажиллагаа зогсоход тус хийдийн барилга байгууламж дээр Хилийн цэргийн 8-р отряд байгуулагдаж өмнөд хилийн амар амгаланг хангаж байгаад, 1953 онд өөр газар шилжин байрлахад одоогийн Өмнөговь аймгийн Номгон сум “Сангийн далайд” суурьшин одоо 56 дахь жилдээ байрлаж байна. Хэзээ ч гал алдахгүй байх үүдтэй эр хүний ташаан дахь “Хэт” хэлбэрийн энэ газарт 1707 оноос хойш 302 дахь жилдээ үйл хэрэг үргэлжлэн өрнөж байна.

Сүм хийдүүдийн үүх түүхээс үзвэл ямар нэг эвдрэл сүйтгэлгүйгээр хатуу цагийн хүнд бэрхийг туулж ирсэн Сангийн далай хийдийн дурсгал нь 1937 оноос өнөөг хүртэл үе дамжин өвлөгдөж ирсэнд байгаа юм. 1990 оноос хойш зах зээлийн шуурганд богино хугацаанд багагүй хэлмэгдэж энэхүү уран барилгын цогцолбор мөхлийн ирмэгт ирсэн боловч түүх соёл бурхан шашиндаа энэрэлтэй ханддаг сайн санаат төрийн түшээ Ц.Оюунбаатарын үүсгэл санаачлагаар “Сангийн далай” хийдийг сэргээн засварлах их үйл хэрэг эхэлж “Сангийн далай сан” байгуулагдаж дотоод гадаадын буяны үйлстнүүдийн дэмжлэгээр 2003 оноос сэргээн засварлах ажил эхэлж 2007 онд дууссан билээ.

Дэмчигийн хийд

Ноён хутагт Д. Данзанравжаагийн говь нутагт байгуулсан олон хүрээ хийдийн нэг /Галбын уулын гурван хийдийн нэг/ болох Дэмчигийн хийдийн туйр Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Галбын уулын байц хадан дунд бий. Энэ хийдийг 19-р зууны үед ноён хутагт Данзан Равжаа ирээдүй цагийг билэгдэн байгуулсан гэдэг бөгөөд Цогцалын хийд ч гэж нэрлэдэг ажээ.

Дэмчигийн хийд бол давхар хэрмэн хашаан дотор есөн жангийн жантан бүхий төвд маягийн хоёр давхар сүмтэй, хойд хэсэгт нь хоёр гэр, эргэн тойрон жижиг дөрвийн зэрэг байшинг өмнө хойно нь барьсан, хэрэм нь том дааман хаалгатай байжээ. Мөн түүний дээд хэсэгт хоёр цонх бүхий гүндэ /сэхээвч/ байшинтай хоёр талд нь суваргатай жижиг хэрэмтэй байжээ. Сүмийн хойд хэсэгт голдоо давхарлиг бүхий их суваргыг тойруулан найман суварга босгож цэцгийн дэлбээ хэлбэртэй хэрмэн ханаар хүрээлжээ.

Дэмчог гэдэг нь түвдээр “Дээд амгалан” гэсэн утгатай үг. Хийдийг дэлгэрч байгаа бадамлянхуа цэцгийг бэлгэдэн барьжээ. Цэцгийн найман дэлбээ тус бүрт нэг суварга байх бөгөөд голдоо мөргөлийн сүмтэй, түүнийх нь оройд Бэлгэ хадтай дүйцэхүйц өндөр төв суварга байжээ. Одоо эдгээрийг сэргээн байгуулсан нь энэ нутагт өнгө үзэмж нэмж, гадаад дотоодын мөргөлчид, аялагчид, жуулчлагчдын сонирхолын зүй ёсоор татсаар байна.

Сүмтэй залгаа эр хүний бэлгэ эрхтэний хэлбэртэй тэрхүү өндөр хадыг бүсгүйчүүдэд илүү ээлтэй, муу муухай бүхнийг арилгах шидтэй, хүсэл биелүүлдэг, гэр бүлийн амьдралыг сайн сайхнаар тэтгэдэг гэж эрхэмлэн шүтэж ирсэн байна. Сүлд хийморио сэргээх гэсэн газар газрын сүсэгтнүүд, ханийн болон үрийн заяа гуйсан ганц бие бүсгүйчүүдийн хөл тэндээс тасардаггүй гэсэн. Энергийн төвийг түшиглэсэн “Дэлхийн энергийн төв” жуулчны бааз ч байгуулагджээ. 2011 оны намар Дэмчог бурхныг шинээр бүтээн залж, түүнд зориулсан томоохон хийдийг Ажнай корпорацийн хөрөнгөөр босгосон.

“Хонгорын элс” орчны түүх соёлын дурсгалууд

Их Сэврэй уулын өвөр бэл дэхь “Сэврэй хадны сүг зураг” нь “Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал”- ийн бүртгэлд албан ёсоор бүртгэгдсэн бөгөөд энэ нь эртний хүн төрөлхтөний 3- 8000 жилийн өмнө урлан бүтээсэн томоохон дурсгалууд бөгөөд тэдгээрээс нутгийнханы “Гурван баатар” нэрт зураг, тэмээн сүргийг морьтой хүн хөөн харваж байгаа зураг, “Салхитын буудал” – ын морин тэрэг, ахуйн амьдралын зургууд нь нэн ховор уран сайхан дүрслэлтэй зургууд юм.

Эндээс эртний хүмүүсийн амьдарч ирсэн олон дурсгалт зүйлсүүд олдсоор байна. Сэврэй сумын зүүн урд 6 км- т, Мандалтын хошууны өвөрт орших 1300 жилийн өмнөх цагаан чулуун гэрэлт хөшөө нь Түрэгийн жанжин Чин тайжид зориулан босгосон хөшөө гэгддэг. Мөн энэ нутгаас олдсон Хүрэл зэвсгийн үеийн 52 см урт хүрэл хутга нь 13- 10- р зууны үеийн хутгануудаас үлэмж бахим бөгөөд ирний урт нь 35 см, мөр нь маш өргөн өвөрмөц хутга билээ. Сэврэй сумын Замын хондоос 1977 онд олдсон Хуягт үлэг гүрвэл – Armoured dinosaur Saichania нь одоогоос 75 сая жилийн өмнөх эртний амьтдын томоохон дурсгал бөгөөд эндээс одоо ч олон төрлийн дурсгалт зүйлүүд олдсоор байгаа юм.

9.2. Өмнөговь аймгийн түүх соёлын дурсгалт газрууд

Хүснэгт № 9.1. Түүх соёлын дурсгалт газрууд


№	Сумын нэр	Түүх соёлын дурсгалт газрууд
1.	Булган сум	Цахиуртын хөндийд орших чулуун зэвсгийн үеийн дархны газар
2.	Номгон сум	Шүүлэн Долоон-Уулын өвөр Бичигт гэдэг газар орших сүг зурагтай ха
3.	Ханбогд сум	Галбын гурван хийд буюу Дэмчигийн хийд, Эрээтийн хийд, Цогцолын хийдийн туурь

4.	Булган сум	Баянзаг гэдэг газар орших хуучин чулуун зэвсгийн үеийн бууц
5	Номгон сум	Цагаан дэрст гэдэг газар орших Бичигтийн усан дахь зурагтай хад
6	Номгон сум	Уртын амралт гэдэг газар орших сүг зурагтай хад, хүн чулуу
7	Номгон сум	Сангийн далай хийдийн дуганууд
8	Номгон сум	Далан уулын өмнө биед орших Түрэг бичээс
9	Ноён сум	Ихэр гашуун гэдэг газар орших сүг зурагтай хад
10.	Хүрмэн сум	Бичигт гэдэг газар орших сүг зурагтай хад
11.	Сэврэй сум	Сэврэй уулын баруун үзүүр, Хар дэлийн бууц гэдэг газар орших сүг зурагтай хад

9.2.1. Түүх, соёлын дурсгалт үзмэрүүдийн хамгаалалтын талаар мэдээлэл

Хүснэгт№ 9.2. Түүх, соёлын дурсгалт үзмэрүүдийн хамгаалалтанд авсан байдал

№	Харъяалал	Үзмэр /газар/-ын нэр	Байгуулагдсан он, сар, өдөр
1.	Өмнөговь аймаг	Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал: /8/ Түүх соёлын үл хөдлөх, дурсгал	Монгол улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14ны өдрийн 175тоот тогтоол.
2.	Өмнөговь аймаг	Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал: /15/ Түүх соёлын үл хөдлөх, дурсгал	Монгол улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14ны өдрийн 175 тоот
3.	Өмнөговь Аймаг	Сумын “ Түүх соёлын үл хөдлөх дурсгал “ - ын жагсаалт /112/	Монгол улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14ны өдрийн 175




Зураг№ 9.2. Түүхийн дурсгалыг хамгаалалтын хувь

Дээрх диаграммаас харахад түүх соёлын дурсгалуудын 83% нь сумын хамгаалалтанд, 11% нь аймгийн хамгаалалтанд, 6% нь улсын хамгаалалтанд байна.

9.3. Зочид буудлын талаарх мэдээлэл

Хүснэгт № 9.3. Зочид буудлууд

№	Харьяалал	Зочид буудлын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил	Утас, факс	Өрөөний тоо	Орны тоо	Үнэ, Тариф
1.	Өмнөговь	Даланзадгад	“Мөнгөн буур”ХХК	ДЗ сумын 3-р баг	23355 99014064	15	25	40 000
2.	Өмнөговь	Говь гурван сайхан	“Монгол байгаль”ХХК	ДЗ сумын 3-р баг	23830 99538098	5	15	10 000
3.	Өмнөговь	Shun shine	“Өмнөд өвлөх урлахуй”ХХК	ДЗ сумын 3-р баг	91617707 91900920 99535323	11	14	20 000
4.	Өмнөговь	Хэрлэн-1	“Арвижих говь”ХХК	ДЗ сумын 2-р баг	23515 88538122	6	12	10 000
5.	Өмнөговь	Хэрлэн-2	“Арвижих говь”ХХК	ДЗ сумын 1-р баг	23515 88538122	4	12	15 000
6.	Өмнөговь	Баян говь	“Ихэр баян говь”ХХК	ДЗ сумын 3-р баг	23130 99089280 99089271	8	15	10 000
7.	Өмнөговь	Оюут	“Баян-уул”ХХК	ДЗ сумын 2-р баг	22543 99532212 99532299	8	15	10 000
8.	Өмнөговь	Гурван оргих		ДЗ сумын 5-р баг	23279 99927300	5	13	8 000
9.	Өмнөговь	Тамир		ДЗ сумын 3-р баг	99079075	3	8	10 000
10.	Өмнөговь	Өргөө		ДЗ сумын 1-р баг	99089928 99187483	4	12	10 000
11.	Өмнөговь	Аянчин	“Фото сафари”ХХК	ДЗ сумын 2-р баг	22101 99539270	3	13	10 000




Зураг№ 9.3. Зочид буудлын тоо, харьцуулалт

Өмнөговь аймгийн хэмжээнд одоогийн байдлаар нийт 11 зочид буудал үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт орны тоо 154, өрөөний тоо 72 байна. Зочид буудлуудын үнэ өртгийн хувьд дунджаар 14000 байна.

Хүснэгт № 9.4. Жуулчны бааз

№	Харьяалал	Жуулчны баазын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил	Утас, факс	Гэрийн тоо	Нийт орны тоо	Үнэ, Тариф	Зэрэглэл /цэцэг/
1.	Өмнөговь	Жуулчин говь-1	“Жуулчин говь”ХК	УБ хотоос 600 км Даланзадгадаас баруун хойш 35 км,	УБ345959 50535355 95144470	50	150	40\$	
2.	Өмнөговь	Нью төвшин	“Нью төвшин”ХХК	УБ хотоос 600 км ДЗ хотоосбаруун хойш 37км	99097824 99088924 99007824	36	110	30\$	
3.	Улаанбаатар хот	Говийн гурван тэмээ	“Говийн гурван тэмээ”ХХК	ДЗ хотоос 70 км Булган сумаас баруун урагш 23 км	УБ327837 98880930 99089514	48	84	80\$	2
4.	Өмнөговь	Говь сайхан	“Монгол байгаль”ХХК	ДЗ-аас баруун зүгт 25 км	Өм.22475 99538098	10	20	30\$	
5.	Өмнөговь	Говь мираж	“Өнөр ХХК” говь	ДЗ-с баруун хойш 50 км	99033988 99084988 Өм23904	28	80	30\$	1
6.	Өмнөговь	Жуулчин говь-2	“Жуулчин говь”ХК	ДЗ-аас 230 км “ЖГ-1”ЖБ-аас195 км Хонгорын голоос хойш 1,5 км	УБ345959 88091377	30	80	40\$	
7.	Улаанбаатар хот	Говийн анар	“Говийн анар”ХХК	Хонгорын голоос зүүн тийш 12 км Нью төвшин ЖБ-аас 160 км	99114811 УБ310455 99118276 88129222	15	40	30\$	
8.	Өмнөговь	Баян заг	“Дал хуудас”ХХК	ДЗ-аас 100 км, Булган сумаас зүүн тийш 12 км	50532555 99539988 99048099	30	60	30\$	
9.	Улаанбаатар хот	Гүег хаан	“Тал нутгийн хаад”ХХК	ДЗ-аас баруун тийш 35 км, Жуулчин ханбогд ЖБ-аас зүүг тийш 3 км	99538370 99280729	16	32	30\$	
10.	Өмнөговь	Сайжрах говь	“Дархан говь”ХХК	ДЗ-аас баруун хойш 16 км	95294139 95189237	20	60	30\$	
11.	Өмнөговь	Дэлхийн энергийн төв	“Дэлхийн энергийн төв”ХХК	Ханбогд сумын төвөөс баруун тийш 6 км	99253040 99085738 99117069	10	40	30\$	
12.	Өмнөговь	Говийн баян бүрд-1	“Төвшин шанхат”ХХК	ДЗ-аас 12 км	99532020 99819779	40	120	30\$	
13.	Өмнөговь	Говийн баян	“Төвшин	ДЗ-аас 996 км Булган сумаас 14	99532020	30	80	30\$	

		бүрд-2	шанхат"ХХК	км	99109889 99819779				
14.	Өмнөговь	Мазаалай	"Өмнийн говь" "ХХК	ДЗ сумын төвийн зүүн хэсэгт	88850966 99080765 95274787	10	40	30\$	
15.	Өмнөговь	Дүнгэнээ	"Вержелэнт" "ХХК	ДЗ-аас 20 км, Жуулчин ханбогд ЖБ-аас зүүн урагш 10 км	99076482 99116482	14	28	30\$	
16.	Өмнөговь	Монгол говь	"Говийн өгөөж"ХХК	Булган сумаас 12 км ДЗ-аас 96 км	99118102 99092302 99193249	40	100	35\$	2
17.	Өмнөговь	Говь тур	"Шонхор говь" "ХХК	ДЗ-аас 88 км, Булган сумаас 17 км	99091285 99539488	25	75	38\$	
18.	Өмнөговь	Говь дисковери	"Говь дисковери"ХХ К	ДЗ-аас баруун хойно 40 км	91917299 99822008	30	80	38\$	
19.	Өмнөговь	Говь дисковери	"Говь дисковери"ХХ К	ДЗ-аас 230 км Сэврэй сумаас 48 км	99157546 96655835	40	100	38\$	
20.	Өмнөговь	Жуулчин ханбогд	"Жуулчин ханбогд"ХХК	ДЗ-аас баруун тийш 36 км Ёлын амнаас зүүн тийш 18 км	99038808 88101955	25	80	30\$	
21.	Улаанбаатар	Говь дисковери	"Зосын хороот"ХХК	ДЗ-аас баруун хойно 23 км	91999414 99159109	20	60	40\$	
22.	Улаанбаатар	Dream gobi	"Жамо трейвэл"ХХК	Булган сумаас Дал багийн хонгор толгой	99116574 99054550	20	38	80\$	



Зураг№ 9.4. Жуулчны баазуудын харьцуулсан байдал

Дээрх диаграммаас харахад 48 гэртэй буюу хамгийн олон гэртэй жуулчны бааз нь “Говийн гурван тэмээ” байна. Харин хамгийн цөөн буюу 10 гэртэй бааз нь Ханбогд сумын нутагт орших “Дэлхийн энергийн төв” бааз байна. Өмнөговь аймгийн ихэнх жуулчны баазууд нь 20-30 гэртэй байна. Аялал жуулчлал цаашид илүү хөгжих нь тодорхой байгаа өнөө үед жуулчны баазууд илүү өргөжин тэлж гэрийнхээ тоог нэмэхийн зэрэгцээ үйлчилгээгээ улам чанаржуулах нь зүйтэй.



Зураг№ 9.5. Жуулчна баазуудан зэрэглэлийн байдал

Энэ диаграммаас харахад цэцгийн зэрэглэлтэй гурван бааз байна. Өмнөговь аймагт нийт 22 жуулчны бааз үйл ажиллагаагаа явуулж багаа тэдгээрээс 3 нь цэцгийн зэрэглэлтэй байна. Мөн 22 баазаас эко баазын үйл ажиллагаа явуулж байгаа нь ховор байдаг. Цаашид энэ тал дээр анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

Хүснэгт № 9.5. Амралт сувиллын газрууд

№	Рашаан сувиллын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил	Эмчилгээний төрөл /зориулалт/	Хүчин чадал	Утас факс	Үнэ, Тариф
1.	Уртын амралт		Номгон сум Богт баг	Рашаан сувилал /ходоод/	20 хүн	99539074	Нэг хүн 8 000
2.	Айргийн сувилал	Хөдөлмөр Халамж үйлчилгээн ий газар	Ханхонгор сум Мандах 1-р баг	Сувилал	17 хүн	99539089	Нэг хоног 3000
3.	Хайрыг харамгүйгээр	“Баяр бахдлаа хуваалцья “ТББ, Христийн цуглаан	Ханхонгор сумын зүүн сайхан уулын Тоонотын амны Харгуй	Тархины саажилттай хүүхдийг хүчил төрөгчөөр хангах, бариа засал, эмчилгээ сувилал	50 хүүхэд	99029818	Өвчтэй хүүхдэд үнэгүй, Сахиур нь нэг хоног 38000 /2009он/
4.	Ахмадын сувилал	Хөдөлмөр Халамж үйлчилгээн ий газар	Даланзадгад сум 3-р баг	Уламжлалт эмчилгээ	18 хүн	99539089	Өдрийн 3000
5.	Тосон	Аймгийн нийтлэг үйлчилгээн ий	Ханхонгор сумын нутаг	Амралт		23884	

Одоогийн байдлаар рашаан сувилал, амралтын газар 5 байна. Энэ нь харьцангуй бага үзүүлэлт юм. Хүчин чадал, үнэ өртгийн хувьд боломжийн байна.

Өмнөговь аймагт одоогоор голдуу дор дурьсан төрөл, чиглэлээр гадаад дотоодын жуулчдад үйлчилж байна. Үүнд:

Уламжлалт аялал / Ёлын ам – Молцог элс – Баянзаг – Тэмээчин айл /

- **Динозовар тур** / Баянзаг – Төгрөгийн ширээ – Хонгорын гол – Боодог – Улаан хонгил – Наран даац – Зулганай – Хэрмэн цав – Шаригийн ганга – Бүгийн цав – Баянхонгорын Шаргалжуут /
- **Байгалийн аялал** / Ёлын ам – Дүнгэнээ – Аргалантын өвөр – Ямаатын рашаан – Гэгээтийн хөндий – Хонгорын гол - Чоно шургуул – Адаг гашуун /
- **Тэмээн аялал** / Сэврэй Хоолт – Гялаан – Уужим – Хонгорын гол - Чоно шургуул /
- **Хатан Сэврэй тур** / Гэгээтийн хөндий – Хонгорын гол - Чоно шургуул – Адаг гашуун
- **Шувуу ажиглах аялал**

Өмнөговь аймгийн “Есөн гайхамшигийн” аялал гэсэн үндсэн программуудаар голчлон жуулчдад үйлчилж байна.

Эдгээрээс гадна 2006 оноос эхлэн Ханбогд сумын Дэмчигийн хийд, Баяжихын агуй зэрэг түүх соёлын дурсгалт газруудаар, мөн Номгон сумын Сангийн далай хийд, Уртын амралт, Борзонгийн говиор аялалын шинэ маршрут нээгдсэн. Гашуун сухайтын хилийн боомтоор БНХАУ-аас жуулчин оруулах эхний алхам хийгдсэн бөгөөд цаашид Гурвантэс сумын Шивээ хүрэнгийн боомтоор ӨМӨЗО-ны Альшаа аймагтай жуулчин солилцох ажлын эхлэл тавигдаж байна.

2002 оноос эхлэн жил бүрийн хаврын тэргүүн сарын шиний 8-нд Тэмээний баярыг зохион байгуулдаг уламжлал тогтоод байгаа бөгөөд энэ баярт оролцох гадаадын жуулчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Мөн үүнээс гадна Ингэний айрагний баяр, Тэмээн поло тэмцээн зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг болсон нь гадаад дотоодын жуулчдыг татах нэг чухал бүтээгдхүүн болоод байна.

9.4. Шинээр аялал жуулчлалын бааз байгуулах бололцоотой газрууд

- Сэврэй сумын Хоолт баг Зөөлөнгийн нурууны Аялдайд нэг ээлжинд 100 хүн хүлээн авах бололцоотой жуулчны нэг бааз уулын бэлээс доош 5 км орчимд байгуулах
- Сэврэй сумын Хоолт баг Хоёр худгийн орчимд нэг ээлжинд 100 орчим хүн хүлээн авах хүчин чадалтай жуулчны нэг бааз байгуулах
- Сэврэй сумын Хоолт баг Эрдэнэбулганд нэг ээлжинд 100 хүн хүлээн авах бололцоотой жуулчны нэг бааз байгуулах
- Хонгорын голын хойд хэсэгт мэдээлэлийн төв, бэлэг дурсгалын дэлгүүр зэргийг нээн ажиллуулж болно. Голын ширгээс 400 м орчим зайд
- Баяндалай сумын Төхөмийн багийн орчимд нэг ээлжинд 200 хүн хүлээн авах бололцоотой нэг жуулчны бааз байгуулах бололцоотой.
- Баяндалай сумын Төхөм багийн Баянцагааны Харангатын аманд нэг ээлжиндээ 100 хүн хүлээн авах хүчин чадалтай нэг жуулчны бааз байгуулах бололцоотой.
- Баяндалай сумын Баян багийн орчимд нэг ээлжинд 200 хүн хүлээн авах бололцоотой нэг жуулчны бааз байгуулах бололцоотой.

- Баяндалай сумын Баян багийн Зүүн сайхан уулын Дүнгэнээгийн ам орчимд хавцлаас баруун тийш 10 км орчимд 100 орчим хүн нэг ээлжинд хүлээн авах хүчин чадалтай нэг жуулчны бааз байгуулах бололцоотой.
- Хүрмэн сумын Хүрмэн багийн Чандманы талд нэг ээлжинд 200 хүн хүлээн авах хүчин чадалтай жуулчны нэг бааз байгуулах бололцоотой.
- Булган сумын Дал багийн орчимд нэг ээлжинд 250 хүн хүлээн авах хүчин чадалтай нэг жуулчны бааз байгуулах бололцоотой.
- Булган сумын Дэн багийн Төгрөгийн ширээ орчимд нэг ээлжинд 200 хүн хүлээн авах жуулчны бааз байгуулах бололцоотой.
- Ханхонгор сумын Мандах багийн Дунд сайханы Тэсгэн худаг орчимд нэг ээлжинд 250 хүн хүлээн авах хүчин чадалтай нэг жуулчны бааз байгуулах бололцоотой.

АРАВДУГААР БҮЛЭГ. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР**10.1. Тусгай хэрэгцээний газар ашиглалтын өнөөгийн байдал**

Тусгай хэрэгцээний газар тус аймгийн хэмжээнд 3979.8мян.га буюу 24,06%-г эзлэж байна. Үүнээс Дархан цаазат газар 1291927 га, Байгалийн цогцолборт газар 2171740.2 га, Байгалийгнөөц газар 27701 га, Улсын хилийн зурвас газар 396100 га, УБХАБ-г хангах зориулалтаар олгосон газар 45970.7 га байна.

10.1.1. Тусгай хамгаалалттай газар

Аймгийн өмнөх ГЗБЕТ-өөр улсын тусгай хамгаалалтад 2005-2020 онуудад авахаар доорхи газруудыг төлөвлөсөн байна.

Их аргалант БНГ-113.8 мян.га, Хүрэн ханы нуруу, Ноён богд БНГ-175.7 мян.га, Номгон уул БНГ 62.6 мян.га, Гурван бамбуу ДГ-110.0 мян.га, Борзонгийн говь БНГ-400 мян.га, Нийт 862.1 мян.га.

Мөн орон нутгийн тусгай хамгаалалтанд 820.4 мян.га газрыг авахаар төлөвлөснийг дараах хүснэгтэнд харуулав.

Хүснэгт№ 10.1. Орон нутгийн тусгай хамгаалалтанд авахаар төлөвлөсөн газрууд


Сумын нэр	Газрын нэр	Талбайн хэмжээ
Цогт-Овоо	Алгуу улаан цав Өөшийн хоолой	48985
Цогтцэций	Цэций уул	15001
Цогтцэций	Шанхай-Дуган Тугийн цохио	31413
Баяндалай	Зурамтай уул-Бүгтийн хоолой	84508
Ханбогд	Ханбогд уул Дэмчигийн хийд	32280
Ханбогд	3-н Зээрдийн агуй	19825
Баян-Овоо	Бага хачиг	32309
Номгон	Бичигтийн уул	632
Номгон	Дууниг уул	93018
Номгон	Бага хачиг	1617
Мандал-Овоо	Зөөлөн уул	1976
Мандал-Овоо	Сайн муу ховор ургамал	1023
Мандал-Овоо	Лидэр товог ховор ургамал	64
Мандал-Овоо	Улаан нуур Онги гол	46983
Гурвантэс	Тост уул	273481
Гурвантэс	Алтан уул	32522
Булган	Улаан нуур Онги гол	14796
Манлай	Шүтээн баян уул	90000
Нийт дүн		820431

Орон нутгийн тусгай хамгаалалтад шинээр хамруулахаар төлөвлөсөн газруудын мэдээллийг хээрийн судалгааны үе шатанд хийгдсэн тодруулалтанд үндэслэн төлөвлөлтийн тайланд тусгасан болно.

10.1.2. Улсын тусгай хэрэгцээний бусад газрууд

Улсын тусгай хэрэгцээнд хамрагдаж буй улсын тусгай хамгаалалт бүхий газраас бусад ангилалын газарт шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 46,3мян.га-р нэмэгдэснээс өөр өөрчлөлтгүй бөгөөд уг өөрчлөлт нь 2010, 2011 онуудад хийгдсэн бөгөөд хамгийн их өөрчлөлт нь 2011 онд 45,8мян.га-р нэмэгдсэн нь юм /Булган суманд/. Тус аймагт улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай, аймаг дундын отрын бэлчээр, чөлөөт бүсийн газар, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай, гадаад улсын дипломат төлөөлөгч,

консулын газар ГНС-н ангилалд байхгүй байна. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хувьд одоогоор ГНС-н ангилалд бүртгэгдээгүй боловч газрын тосны хэрэг эрхлэх газраас 6-н блокт хайгуулын зориулалтаар зөвшөөрөл олгосон байна.



Зураг№9.1. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн байршил

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хувьд 2023 он хүртэлх хугацаанд улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай экологийн чухал ач холбогдол бүхий газруудын жагсаалтыг гарган хамгаалалтад авахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт№10.2. 2023 он хүртэлх хугацаанд улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай, экологийн чухал ач холбогдолтой газруудын жагсаалт /санал/

№	Газрын нэр	Үндэслэл, ангилал	БОНХ-н яамны төлөвлөгөөнд орсон эсэх
1	Тост, Тосон Бумбын нуруу	Улсын хамгаалалтад	
2	Тооройн шанд	Улсын хамгаалалтад	
3	Ноён Богд-Хүрэн ханын чулуу	БНГ	БНГ 160мян.га
4	Зайрмагтай	Газрын доорхи гүний цэнгэг усны нөөц /БНГ/	БНГ 200мян.га
5	Балгасын улаан нуур	Газрын доорхи гүний цэнгэг усны нөөц /БНГ/	БНГ 200мян.га
6	Их Аргалант	БНГ	

7	Гурван бамбуу	ДГ	ДГ 380мян.га
8	Зөөлөн уул	БНГ	
9	Номгон уул	БНГ	
10	Борзонгийн говь	ГБДЦГ-ын “А” хэсгийн өргөтгөл	БНГ 400мян.га
11	Халзан хайрхан	БНГ	
12	Нуцгэн худаг	БНГ	
13	Халзан	БНГ	
14	Сайн тооройн улаан уул	Улсын хамгаалалтад	
15	Дэрсэн ус, Хаяа худаг	ГБДЦГ-ы өргөтгөл	
16	Зурамтай уул Бүгийн хоолой	Улсын хамгаалалтад	
17	Их Шанхын нуруу	Улсын хамгаалалтад	
18	Дайчин заг, Умдайн голын адаг	Улсын хамгаалалтад	

Эх үүсвэр: УГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөнөөс.

Хүснэгт№10.3. “Монгол орны Өмнийн говийн экологийн бүс нутагт уул уурхайн хөгжлийг нөлөө багатай төлөвлөх нь” төслийн хүрээнд сонгосон хамгаалах шаардлагатай газар нутгууд


Д/д	Газрын нэр	Талбай, га	км	Аймаг
1	Говийн Бага "Б" ДЦГ-н өргөтгөл	1144433.44	749.70	Дорноговь, Өмнөговь
2	Загийн Ус БНГ-н өргөтгөл	660721.84	820.76	Дундговь, Өмнөговь, Дорноговь
3	Төлөгийн тал	212301.47	191.82	Өмнөговь
4	Говийн Бага "А" ДЦГ-н өргөтгөл	281556.77	501.29	Өмнөговь
5	Дөшийн тойром	111206.40	131.75	Өмнөговь
6	Баян гол	26726.03	65.59	Өмнөговь
7	Тостын нуруу	648072.49	356.95	Өмнөговь
8	Цагаан толгойн тал	16231.79	48.58	Өмнөговь
9	Говь Гурван Сайхан БЦГ-өргөтгөл	23020.75	62.82	Өмнөговь
10	Хөхөлзөхийн сархиа	12931.13	45.44	Өмнөговь
11	Сэвхүүлийн хөндий	10471.56	39.68	Дорноговь, Өмнөговь
12	Зүүн хоолой	480488.02	465.62	Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь
Бүгд		3966967.43	3782.70	

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ . УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, АШИГТ МАЛТМАЛЫН СУДАЛГАА

11.1. Уул уурхай, үйлдвэрийн газрын хэтийн төлөв

11.1.1. Уул уурхай


Өмнөговь аймаг нь уул уурхай, ашигт малтмалаараа улсдаа дээгүүрт ордог том аймаг юм. Өмнөговь аймаг нь манай улсын ашигт малтмалын нөөц баялгаар хамгийн баян, ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэр хөгжүүлэх хамгийн ирээдүйтэй аймгийн нэг юм. Тус аймгийн нутаг дэвсгэрт 2014 оны 10-р сарын 28-ны байдлаар хайгуулын 170, ашиглалтын 74 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг авч үзвэл нүүрсний 40, алтны 15, холимог металлын 5, алт, зэсийн 2, манганы 2, цайрын 2, давсны 2, төмрийн хүдрийн 1, жоншны 1, агальметолитын 1, барилгын материалын 1 тусгай зөвшөөрөл тус тус хүчин төгөлдөр байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийн нийт талбайн хэмжээ 3.3 орчим сая Га байна. Харин ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ 500 гаруй мянган Га байна. Тус аймгийн нутаг дэвсгэрт улсын төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар явуулсан геологийн судалгаа, эрэл үнэлгээ, хайгуулын ажлын үр дүнгээр 36 нэр төрлийн ашигт малтмалын 256 орд илрэл тогтоогдсон.



Зураг № 11.1. Нүүрсний нөөц баялгийн тархалт


Мөн газрын тосны 46621 км² талбай бүхий Борзон YII, 13991 км² талбай бүхий Галба XI, 45080 км² талбай бүхий Номгон IX талбайг тус тус ялган газрын тосны

бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан ажиллаж байна. Галба XI талбай дээр явуулсан өрөмдлөг болон судалгааны ажлын үр дүнгээр одоо нөөц нь тогтоогдоод байгаа Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Тамсагийн талбайн нөөцөөс багагүй нөөцтэй байж болох магадлалтай нь тогтоогдоод байна. Мөн Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар зэрэг газрын тосны уламжлалт бус эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсны үндсэн дээр явуулах боломжтой.



Зураг № 11.2. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт УИХ-аас тогтоосон стратегийн ач холбогдол бүхий 15 ордоос 3 нь буюу Оюу толгойн зэс, алтны бүлэг орд, Тавантолгойн нүүрсний бүлэг орд, Нарийн сухайтын нүүрсний орд оршдог. Мөн сайн чанарын Баруун наран зэрэг нүүрсний ордууд тус аймгийн нутагт байдаг.



Зураг № 11.3. Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лиценз бүхий талбайн зураг

Хүснэгт № 11.1. Аймгийн нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлтэй талбайн эзлэх хувь

№	Аймаг, нийслэл	Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээ /га/	Үүнээс:		Аймгийн нутаг дэвсгэрт эзлэх хувь	Үүнээс:	
			Ашиглалт	Хайгуул		Ашиглалт	Хайгуул
	Өмнөговь	16,517,762.8	479,590.1	5,092,133.8	33.7	2.9	30.8

Хүснэгт № 11.2. Ашигт малтмалын төрөл, тусгай зөвшөөрлийн тоо

Д/д	Ашигт малтмалын төрөл	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо
1	Нүүрс	38
2	Алт	15
3	Алт, зэс	2
4	Төмөр	1
5	Давс	2
6	Мөнгө, хар тугалга	1
7	Агальматолит	1
8	Барилгын материал	1
9	Мангани	1
10	Жонш	1
11	Полиметалл	1
12	Холимог металл	3
13	Цайр	2
	Бүгд	69

Хүснэгт № 11.3. Нийт тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээг сум тус бүрээр авч үзвэл:

Аймаг	Сум	Тусгай зөвшөөрлийн талбай, га
Өмнөговь	Баяндалай	1502.3

	Баян-Овоо	154754.0
	Гурвантэс	95611.9
	Мандал-Овоо	6290.2
	Манлай	1498.4
	Ноён	51139.0
	Номгон	1413.2
	Ханбогд	14785.9
	Ханхонгор	35723.2
	Хүрмэн	2966.4
	Цогт-Овоо	2036.6
	Цогтцэций	92804.3
	Бүгд	460525.4

Хүснэгт № 11.4. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хэмжээг аж ахуй нэгж тус бүрээр

Д/д	Аж ахуй нэгж	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	Талбай, га
1	Олон-Овоот гоулд	8	4275.7
2	Монголын алт МАК	5	1161.5
3	Эрдэнэс МГЛ	8	68481.5
4	Агммайнинг	2	17717.8
5	Дун-Юань	3	1019.5
6	Оюу толгой	3	14785.9
7	Саусгоби сэндс	3	30846.2
8	ОНТРЭ	2	74979.9
9	Болдфорда	2	108.9
10	Таван толгойн нүүрсний уурхай	1	261.9
11	Алагтэвш	1	13382.8
12	Азигоулд	2	5588.2
13	Аурум Ауруг	1	37354.9
14	Гурван зам	1	2657.9
15	Жинхаовэйеэ	1	816.6
16	Дөчин дэлгэр	1	146.2
17	Зүрийн булан	1	35.3
18	Жавхлант орд	1	29100.1
19	Рэмет	1	506.3
20	Ивээл өлзий	1	279.2
21	Сондог	1	28.5
22	Хангад-Эксплорэйшн	2	12821.8
23	Ирмүүн зээрд	1	1189.2
24	Марк импекс	2	1508.2
25	Энержиресурс	1	2960.2
26	Алтан эрдэнэ газар	1	1459.0
27	Монлайхад	1	435.5
28	Мөнх ноён суварга	1	69233.0
29	Оюут улаан	1	6647.0
30.	Өсөх зоос	1	350.1
31.	Хотгор минералс	1	2036.6
32	Хур эрдэний баялаг	1	1085.2
33	Цагаан өвөлжөө	1	17431.9
34	Чинхуа МАК	1	70.4
35	Шинэлонгда	1	1498.4
36	Энержиресурс Монголиа	1	335.0
37	Этүгэн Эе	1	393.6
38	Саусгоби коэл транс	1	37221.4
39	Монгол манганейз натурал ресурс	1	313.2

Хүснэгт № 11.5. Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн улс, орон нутгийн төсөвт оруулсан орлогын хүснэгтээр үзүүлэв.

Аж ахуйн нэгжийн нэр	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, сая төг	Нийт улсын төсөвт оруулсан орлого, сая төг
Оюу толгой ХХК	7915.3	26173.3
Цагаан өвөлжөө ХХК	0	1788.5
Энержи ресурс ХХК	37822.7	75965.0
Саусгоби сэнде ХХК	4263.0	75965.0
Монголын Алт (МАК) ХХК	14854.4	47582.9
Чинхуа-МАК-Нарийн сухайт ХХК	1473.8	8175.9
Таван толгой ХК	20571.8	47582.9
Эрдэс таван толгой ХК	16339.3	30437.2
Хангад Эксплорейшн ХХК	174.2	994.21
Мөнхноён суварга ХХК	88.9	2236.3

Хүснэгт № 11.6. Өмнөговь аймгийн хэмжээнд 2013 онд үйлдвэрлэл бүтээгдэхүүн гаргалт

Аж ахуйн нэгжийн нэр	Хөрс хуулалт	Хүдэр олборлолт / бүтээгдэхүүн гаргалт
Оюу толгой ХХК		
Цагаан өвөлжөө ХХК	2187.2	21.44
Энержи ресурс ХХК	52744.0	9177.0
Саусгоби сэнде ХХК	8449.8	3057.2
Монголын Алт (МАК) ХХК	11249.2	3210.0
Чинхуа-МАК-Нарийн сухайт	4300.8	674.4
Таван толгой ХК	9355.2	3123.8
Эрдэс таван толгой ХК	19474.4	5300.7
Хангад Эксплорейшн ХХК	997.1	494.3
Мөнхноён суварга ХХК	0	3.75

11.2. Уул уурхайн ордууд, дэд бүтэц

11.2.1. Дэд бүтцийн байдал

Автозам. Улаанбаатараас Мандалговь хотоор дамжуулан Даланзадгад хүртэл хатуу хучилттай автозамаар холбогдсон. Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрсний ордоос Ханбогд сумын нутагт орших Гашуунсухайтын хилийн боомт хүртэл мөн хатуу хучилттай автозамаар холбогдсон. Гурвантэс сумын нутагт орших Нарийнсухайтын нүүрсний ордоос тус сумын нутагт орших Шивээ хүрэнгийн хилийн боомт хүртэл 45 км өндөр даацын хатуу хучилттай замаар холбогдсон.

Агаарын зам. Улаанбаатараас Өмнөговь аймгийн төв Даланзадгад, Ханбогд сумын Ханбумбат, Цогтцэций сумын төв хүртэл агаарын шугамаар холбогдож Аэро Монголиа, Хүннү эйр компаниуд нислэг үйлддэг.

Цахилгаан хангамж. Мандалговь-Даланзадгад-Цогтцэций сумын хооронд 110 кВ-ын агаарын шугамаар холбогдсон. Харин Оюу толгойн орд хүртэл БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур аймгаас 110 кВ-ын агаарын шугамаар холбож Оюу толгойн уулын баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэсэн. Мөн Оюу толгойгоос Ханбогд сум, Баян-Овоо сум хүртэл 35 кВ-ын агаарын шугам татаж цахилгаан хангамжийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэсэн. Нарийнсухайтын нүүрсний

орд руу БНХАУ-аас 35 кВ-ын агаарын шугам татаж тус ордод олборлолт явуулдаг Монголын алт (МАК) ХХК, Чинхуа-МАК-Нарийнсухайт ХХК, Соус Гоби Сэндс ХХК болон Гурвантэс сум, Ноён сумын цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэсэн. Өмнөговь аймгийн бусад сумдын төвийг төвийн эрчим хүчний системийн эх үүсвэртэй холбосон.

11.2.2. Уул уурхайн ордууд

Нарийн сухайтын нүүрсний орд

Нарийн сухайтын нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг, Даланзадгад хотоос баруун зүгт 296 км, Улаанбаатар хотоос баруун урагш 849 км, Гурвантэс сумаас 34 км-т оршдог. Нүүрсний чийг 7.32%, үнслэг 13.96%, дэгдэмхий 30.2%, хүхрийн агуулга 1.84%, 6750 ккал/кг илчлэгтэй. Тус нүүрсний ордод “Монголын Алт”(МАК) ХХК, “Чин Хуа-Мак-Нарийнсухайт” ХХК, “Саусгоби Сэндс” ХХК зэрэг компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

Хятадын зах зээлд Нарийн Сухайтын нүүрсийг таниулах, уг орд газарт дэд бүтцийн орчныг бүрдүүлэх зорилгоор 2002 онд “Монголын Алт” (МАК) ХХК БНХАУ-ын ӨМӨЗО-ны Чин Хуа корпорацитай хамтран Монгол-Хятадын хамтарсан “Чинхуа-МАК-Нарийн Сухайт” ХХК-ийг үүсгэн байгуулсан

Нарийн сухайтын нүүрсний ордод “Чинхуа МАК-Нарийн сухайт” ХХК, “МАК” ХХК, “Саусгоби сэндс” ХХК-иуд тус бүр 2,0 сая, 3,0 сая, 5,0 сая.тн нүүрс олборлох хүчин чадалтай уурхай байгуулан, 2008 онд нийт 3176,0 мян.тн, 2009 онд 1438,3 мян.тн нүүрс олборлосон байна Овоот (Нарийн сухайт)-ын ордын ил уурхайгаар ашиглах нүүрсний нөөцийг “Баруун” хэсэгт 39.5 сая.тн, “Зүүн-Өмнөд” хэсэгт нь 19.11 сая.тн-оор баталсан. Тус компани 2013 онд 3057.2 олборлосон байна.

Бүтээгдэхүүнд ямар нэг боловсруулалт хийдэггүй. Ордын үлдэгдэл нөөц 915999 мян.тн

2013 онд 3210.0 мян.тн нүүрс экспортолсон.. “Чинхуа-МАК-Нарийн Сухайт” ХХК нь Монгол Улсын ЗГ-тай Тогтвортой байдлын гэрээ байгуулан Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дахь Нарийн Сухайтын орд газрын нүүрсийг экспортлох анхны гарцыг нээсэн. “Чинхуа-МАК-Нарийн Сухайт” ХХК-ийн нүүрсний уурхайн төслийн хүчин чадал 1500 мян.тн бөгөөд 2013 онд 674.45 мян.тн нүүрс олборлон, экспортолсон байна.

“Саусгоби Сэндс” ХХК нь тус ордыг түшиглүүлэн хуурай баяжуулах үйлдвэрийг байгуулан ашиглалтад оруулаад байна.

Мөн тус бүлэг ордын хэсэгт “Өсөх Зоос” ХХК 2014 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Ингэснээр тус бүлэг ордоос жилд ойролцоогоор 10 орчим сая тонн нүүрс олборлож БНХАУ-д экспортлох боломжтой.

Нэгэнт дээр дурдсанчлан Шивээ хүрэнгийн боомтоос тус орд хүртэл сайн чанарын автозамтай болсон тул нүүрсний олборлолт, экспорт нэмэгдэх боломжтой.

БНХАУ-аас Нарийн сухайт хүртэл 35кВт-ын өндөр хүчдлийн шугамаар эрчим хүчний хэрэглээгээ хангадаг. Нарийн сухайт-Гурвантэс хүртэл 6кВт-ын өндөр хүчдлийн шугам байгуулсан.

Үйлдвэрлэлийн усны нарийвчилсан хайгуул гүйцэтгэх шаардлагатай. Одоо гүний худгаас хангагдаж байгаа.

Уурхай тус бүр ажилчдын сууц, уурхайн барилга байгууламж бүхий хотхонтой. “Чинхуа-МАК-Нарийн сухайт” ХХК-ий уурхайд одоо 300 гаруй хүн ажилладаг.

“Саус гоби сэнде” ХХК Нарийн сухайтын ордын Овоотын хэсгийг ашиглалтад оруулснаар 360 ажлын байр шинээр бий болоод байна.

Ордын ашиглалтын байдал

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Чин Хуа-МАК-Нарийн сухайт” ХХК, “Саус гоби сэнде” ХХК. Монгол улсын Засгийн газар, “Чин Хуа-МАК-Нарийн сухайт” ХХК-ийн хооронд 2005 онд байгуулсан тогтвортой байдлын гэрээнд 2005-2008 оны 3 жилийн хугацаанд нийт 5.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн.

“Саус гоби сэнде” ХХК Овоотын хэсгийг ашиглалтад оруулах эхний жилд 32 сая ам.доллар, нийтдээ 125 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 3.6 жил. Олборлолтын 17 жилийн хугацаанд улсын төсөвт татвар, төлбөрийн хэлбэрээр нийт 263.3 сая ам.доллар оруулахаар тооцсон.

Таван толгойн нүүрсний орд

Таван толгойн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос өмнө зүгт 600 км, Даланзадгад хотоос зүүн тийш 100 км, хамгийн ойролцоо орших төмөр замын Чойр өртөөнөөс баруун урагш 438 км-т оршдог.

Дэд бүтэц

Зам харилцаа: Таван толгойн ордын Ухаа худаг хэсгээс Гашуун сухайт боомтын гаалийн талбай хүртэл ойролцоогоор 245 км-т орших Цагаан хадны нүүрсний гаалийн талбай хүртэл хатуу хучилттай автозамаар тээвэрлэж байна.

2012 онд Эрдэнэс-Таван Толгой ХК Гашуун сухайт хүртэл Энержиресурс ХХК-ий барьсан хатуу хучилттай автозамтай зэрэгцүүлэн хатуу хучилттай зам барихаар шийдвэрлэгдээд байгаа бөгөөд одоогийн байдлаар зураг төслийн ажил хийгдэж байна. Ингэснээр боомт хүртэл тус бүр нь 2 эгнээтэй 2 урсгал замтай болох юм.

Ухаахудаг – Оюутолгой – Гашуун сухайтын боомтын чиглэлд төмөр зам тавих ба Тавантолгой - Оюутолгой –Цагаан суварга–Зүүн баян чиглэлд төмөр зам баригдахад Монгол улсын төмөр замын төв шугамтай холбогдоно.

Эрчим хүч:

Тавантолгойн орд газарт 300 МВт-аас доошгүй хүчин чадалтай цахилгаан станц байгуулж, Оюутолгойн үйлдвэрийг эрчим хүчээр найдвартай хангахаар тусгагдсан боловч одоогийн байдлаар Энержиресурс ХХК ордын Ухаа худаг хэсэг дээр 18 мВт-ын цахилгаан станц барьж уурхайгаа болон Цогтцэций сумыг хангаж байна. Эрдэнэс Тавантолгой ХК 2012 онд 300 мВт-ын цахилгаан станц барьж эхлэхээр төлөвлөөд байгаа.

Даланзадгадыг Тавантолгойн цахилгаан станцтай холбох асуудлыг Тавантолгойн нүүрсний уурхайн цахилгаан хангамжийг шийдвэрлэсний дараа шийдэхээр төлөвлөсөн байна.

Усан хангамжийн эх үүсвэр нь Балгасын улаан нуурын газар доорх усны орд байх болно. Тус газарт 15 ширхэг гүний усны худаг өрөмдөж, нийт 60 гаруй километр урттай 600 мм-ийн диаметртай ус дамжуулах хоолой татна. Тус шугамын дагуу ус өргөлтийн 3 ширхэг шахуургын станцыг 2012 онд барьж байгуулсан. Таван толгойн цогцолборын усны хэрэглээ урдчилсан тооцоогоор 36.0 мян. м³/хоног байна. Энержи ресурс ХХК гүний усыг цэвэршүүлэх байгууламж барьж, улмаар Цогтцэций сумын иргэдийг цэвэр усаар хангах 4,5 км шугам татаж ашиглалтад өгөх гэж байна.

Хот байгуулалт: Тавантолгойн нүүрсний ордыг ашиглахтай холбогдон байгуулагдах үйлдвэр, үйлчилгээний байгууллага, аж ахуйн газарт ажиллах хүчний хэрэгцээ болон бий болох хотын хүн амын тоог холбогдох норм тооцоогоор эхний ээлжинд 5000 хүнтэй суурин, цаашид өргөжин тэлж, 9000-10000 хүнтэй хот буй болохоор төлөвлөж байгаа юм. Одоогийн байдлаар Энержи ресурс ХХК Цэций нэртэй орон сууцны хороолол бага сургууль цэцэрлэг шинээр барьж эхний ээлжийг ашиглалтад оруулаад байна.

Ордын ашиглалтын өнөөгийн байдал

Орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Эрдэнэс МГЛ” ХХК, “Тавантолгой” ХК, “Дайцуки” ХХК, “Энержи ресурс” ХХК.

“Таван толгой” ХК нь Цанхийн 1 дүгээр талбайд нүүрсний 4, 8 дугаар давхраас нүүрс олборлож орон нутгийн хэрэгцээг хангахаас гадна БНХАУ-руу авто тээврээр экспортлож байна. Эрдэнэс Тавантолгой ХК 1 сая.тн/жилд олборлож байгаа бөгөөд 2015 оноос 15 сая.тн/жил олборлоно.

“Энержи Ресурс” ХХК нь “Ухаа худаг”-ийн нүүрсний талбайн 11952А ашиглалтын тусгай зөвшөөрлийн 2962 га талбайд 2009 оны 4 сараас олборлолт явуулж эхлээд байгаа бөгөөд одоогийн байдлаар 12,5 сая тонн орчим нүүрс олборлоод байна. 6,3 тэрбум.тн нүүрсний нөөцтэй.

Оюу толгойн бүлэг орд

Оюу толгойн бүлэг орд нь Төвийн бүсэд, Өмнөговь аймаг, Ханбогд сумын төвөөс зүүн хойд зүгт 40 км-ийн зайд оршино. Орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Айвенхоу майнз Монголиа инк ХХК.

Дэд бүтэц

Зам харилцаа: АММИ компанийн хөрөнгөөр Оюу Толгой–Гашуун сухайтын чиглэл 105 км-т эхний удаад хайрган зам тавьж, дараа нь хатуу хучилттай болгож барихаар ЗТАЖЯ, АММИ компанийн хооронд 2007 оны 5 сард санамж бичиг байгуулсан. Оюу толгой–Ханбогдын чиглэлд 40 км хатуу хучилттай зам барина. Монгол улсын авто замын ерөнхий сүлжээний дагуу Улаанбаатар–Мандалговь–Даланзадгад–Тавантолгой–Оюу толгойн хатуу хучилттай зам тавигдахаар төлөвлөгдөөд байна.

Ухаахудаг–Оюу толгой–Гашуун сухайтын боомт, Тавантолгой–Оюу толгой – Цагаан суварга–Зүүн баян чиглэлд төмөр зам тавьж, Монгол улсын төмөр замын төв шугамтай холбохоор шийдвэрлэгдээд байгаа.

Эрчим хүч: УИХ-ын 2007 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөрт Улаанбаатар–Мандалговь– Оюутолгойн чиглэлээр 2007-2012 онд 220 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан шугам барих ажлын сонгон шалгаруулалтад Эм Си Эс компани шалгарч, ТЭЗҮ боловсруулах ажлыг хийж байгаа. Түүнчлэн Айвенхоу Майнз Монголиа Инк /АММИ/ ХХК нь өөрийн хөрөнгөөр Оюу Толгойн орд дээр 3х150 Мвт-ын дулааны станц барьж дотоодын хэрэгцээгээ хангаж байна. 2012 онд цахилгаан станц барих үүрэг өгөгдсөн боловч, хятадаас эрчим хүч импортлохоор шугамыг татаад байгаа.

Усан хангамж: АММИ ХХК-ийн хийсэн судалгаагаар Оюу Толгойн ордоос 60 км-т орших Галбын говьд 870 л/сек усны ундаргатай Гүний хоолойн орд илрүүлжээ. Гүний хоолойн ордын усыг Оюутолгой тийш 67 км гаруй урттай 900 мм голчтой ган яндан хоолойгоор дамжуулж авахаар барилгын ажлыг гүйцэтгээд байна. 36 худаг гаргаж, 5 багц болгон нэгдсэн шугаманд холбох ба төв шугаман дээр байрлуулсан нэг насос станцаар дамжуулан усаа Оюутолгойн ойролцоох хиймэл нуурт хийх юм. Яндан хоолойн дагуу 110 кВ агаарын шугам татахаас гадна бүх худаг тийш цахилгааны шугам татаж холбоно.

Орд дээр хийгдэж байгаа ажлууд

Жилд 26,0-43,0 сая тн хүдэр олборлох ил ба далд уурхай, хоногт 100000-150000 тн хүдэр боловсруулах хучин чадалтай баяжуулах үйлдвэр болон дэд бүтцийг барьж байгуулах асуудлыг нарийвчлан тусгасан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, ЭБМЗ-өөр хэлэлцүүлсэн байна. Агааржуулалт, геологи хайгуулын зорилгоор 1385 м гүнтэй босоо ам №1-ийн газрын дээрхи барилга, байгууламжийг барьж дууссан. Одоогийн байдлаар далд уурхайн 2 дугаар босоо амны 96 м өндөр толгойн барилга, 75000 тн багтаамжтай хүдрийн агуулах болон баяжуулах үйлдвэрийг барьсан.

Хүснэгт № 11.7. 2012-2013 онуудад шинээр ашиглалтанд орж буй томоохон уурхай болон баяжуулах үйлдвэрүүд:

Д/д	Аймаг	Уурхайн чиглэл	Хариуцагч
1	Өмнөговь аймаг	<ul style="list-style-type: none"> - Манлайн нүүрсний уурхай - Сүмбэрийн нүүрсний уурхай - Зангат уулын нүүрсний уурхай - Овоот толгойн нүүрсний баяжуулах үйлдвэр - Баянтэсийн чулуун нүүрсний ордын Хөвд гашуу толгойн уурхай - Зайрмагтайн хөндийн нүүрсний баяжуулах үйлдвэр - Ноён уулын нүүрсний уурхай - Хүрээ дэл-1 нүүрсний уурхай - Хүрээ дэлийн нүүрсний уурхай - Баруун нарангийн нүүрсний уурхай - Наранбулагийн алтны үндсэн ордын уурхай 	<ul style="list-style-type: none"> “Шинэ лонгда” ХХК “Саус гоби сэнде” ХХК “Жавхлант орд” ХХК “Саус гоби сэнде” ХХК Саус гоби сэнде” ХХК “ЭНК” ХХК “Терра энержи” ХХК “Жунхаовэйеэ” ХХК “Болд фо ар да” ХХК “Хангад эксплорэйшн” ХХК “Азиагоулд Монголиа” ХХК

11.3. Геологи, ашигт малтмалын судалгаа

11.3.1. Геологийн тогтоц

